



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

Vol 10, №2 (26)

2025 Spring

IUU JOURNAL
ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

УЛААНБААТАР ХОТ

2025 он



2003 оноос эхлэн Улаанбаатар дээд сургуулийн эрдэм шинжилгээний бичиг,
2015 оноос эхлэн Олон улсын Улаанбаатарын их сургуулийн эрдэм
шинжилгээний сэтгүүл болон хэвлэгдэн гарч байна.

IUU Journal Vol.10, №2 (26), 2025 Spring

International University of Ulaanbaatar

*Олон улсын Улаанбаатарын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл
11 дэх хэвлэл*

Цаасны хэмжээ: B5

Хэвлэлийн хуудас: 36 х.х

Хэвлэсэн тоо: 100ш

ISSN: 2411-2534

© Энэхүү сэтгүүлийг эрхлэгч, найруулагчдын зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх,
цахим хайлтад оруулах, зураг болгон хэвлэх зэргээр олируулахыг хориглоно.

Зохиогч бүтээлийнхээ шинжлэх ухааны үнэнийг батлан хариуцна.

“МАЙЖИК КОЛОР” ХХК-д хэвлэв.

Хэвлэсэн: 2025 он

International University of Ulaanbaatar



Эрхэлсэн:

КАН ЮУ ЁЛЬ

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн
Ректор доктор (Ph.D), профессор

Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүд:

Б. СУМЪЯАБААТАР

Чингис Хаан судлалын хүрээлэнгийн захирал,
Доктор (Sc.D), профессор

Г.ГЭРЭЛМАА

Суурь боловсролын тэнхимийн дэд профессор,
доктор (Ph.D)

О. АМАРСАНАА

Эрдэм шинжилгээ, багшийн хөгжлийн албаны
дарга, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн
захирал, доктор (Ph.D)

КИМ ГЁН ЧОЛ

Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

Сэтгүүлийн редакцын зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга:

М. БОЛОРМАА

Хууль зүйн сургуулийн Эрх зүйн тэнхимийн ахлах
багш, магистр

Редакцын зөвлөлийн гишүүд:

АГУУЛГА

ХЭЛ ШИНЖЛЭЛ

Б.ПҮРЭВЖАРГАЛ

Хүний нүд, чихтэй холбоотой Монгол
Солонгосчуудын сэтгэлгээний онцлог..... 6

С.ЭНХ-АМГАЛАН

Пархэгийн талаарх судалгааны тойм..... 16

ХҮМҮҮНЛЭГ НИЙГМИЙН УХААН

А.МӨНХЖИН, Ө.БАЙГАЛЬ

Орчны ялгаатай байдлаас үүсэх сэтгэц ассоциацийн онцлогт
туршилт хийсэн үр дүн..... 32

Ц.ЭНХТҮВШИН

Төрөөс залуучуудын талаарх баримтлах бодлого үйл
ажиллагаа, нийгмийн тулгамдсан заримасуудлууд..... 39

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Б.АРИУНБААТАР

Ментал лексикон ба үг эзэмших зүй тогтолд суурилсан
гадаад хэлний үг заах аргын онол-арга зүйн загвар..... 54

Т.МЯГМАРСҮРЭН

Холимог сургалтын арга ба багшийн хандлагын хамаарал..... 67

ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

Б.БАЛЖИН

Мөнх хааны гэрэлт хөшөө Уран бичлэгийн
дурсгал болох нь..... 84

БИЗНЕСИЙН УДИРДЛАГА

Б.БҮЖИДМАА

Компанийн ашигт ажиллагаанд ажлын капиталын
агрессив бодлогын үзүүлэх нөлөө..... 98

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Ц.ОЮУНАА

Орон сууц худалдах – худалдан авах гэрээнд заасан орон сууцны
талбайн хэмжээнээс үүссэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн
шийдвэрт хийсэн шинжилгээ..... 110

ХЭЛ ШИНЖЛЭЛ



Б.ПҮРЭВЖАРГАЛ

Хүний нүд, чихтэй холбоотой Монгол Солонгосчуудын
сэтгэлгээний онцлог



С.ЭНХ-АМГАЛАН

Пархэгийн талаарх судалгааны тойм

ХҮНИЙ НҮД, ЧИХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ СОЛОНГОСЧУУДЫН СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГ (“НҮД, ЧИХ” ХЭМЭЭХ ҮГ ОРСОН ХЭЛЦ ҮГИЙН ЖИШЭЭГЭЭР)

Магистр, Б.Пүрэвжаргал

(ОУУБИС. ХНУС)

purevjargal.b@ulaanbaatar.edu.mn

Хураангуй

When learning a native or foreign language, a learner not only learns words and phrases but also learns about the history, customs, lifestyles and thinking characteristics of the people (Nansalmaa.N, Dolgor.S, 2021:79). In any language, the idioms have a unique solidified structure that reflects the characteristics of the people's life, living environment, customs, culture, and thinking developed and established as a result of thousands of years of development. Therefore, in this study, Mongolian-Korean idioms with “eyes, ear “, were selected, and compared the features of the culture and thought of the country's people embedded in them were examined. The idioms with eyes, ears are classified as idioms with the same expression and meaning, idioms with expression is different same meaning, and idioms with different expression and how the culture and thinking of Korean Mongolians are emerged through the idioms based on cognitive linguistic.

Хураангуй (Монгол)

Эх болон гадаад хэл сурахдаа суралцагч зөвхөн үг хэллэг сурахаас гадна тухайн ард түмний түүх, зан заншил, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлогтой танилцдаг (Нансалмаа.Н, Долгор.С, 2021:79). Аль ч хэлэнд хэлц үгс нь олон зуун жилийн хөгжлийн үр дүнд бий болж, тогтсон ард түмний ахуй амьдрал, амьдрах орчин, зан заншил, соёл, сэтгэлгээний онцлогийг тусгасан өвөрмөц хэвшмэл бүтэцтэй байдаг. Иймд энэхүү судалгаанд “нүд, чих” хэмээх үг орсон Монгол-Солонгос хэлний хэлц үгсийг сонгож, тэдгээрт шингэсэн тухайн орны ард түмний соёл, сэтгэлгээний онцлогийг харьцуулан судалсан болно. Нүд, чих орсон хэлц үгийг Зөвхөн монгол хэлэнд байдаг хэлц, зөвхөн солонгос хэлэнд байдаг хэлц хэмээн ангилж хоёр ард түмний сэтгэлгээний онцлог талаас тайлбарлахыг зорив.

Түлхүүр үг: Танихуйн хэл шинжлэл, ангилал, цогц ойлголт, орон зай

ОРШИЛ

Танихуйн хэл шинжлэл – Танихуй гэдэг нь ойлгосон агуулгад тайлбар өгөх үйл ажиллагаа бөгөөд танихуйн үйл явц нь дэс дараа, бодтой тооцоолох үндэслэлээс ялгаатай бие махбодын болон хувь хүний сэтгэл зүйн үйл явцыг хэлнэ. Танихуйн үйл явцын хамгийн үндсэн суурь нь хүний бие махбодын мэдрэхүйн эрхтнээр дамжуулан олж авсан туршлага юм. Танихуйн хэл шинжлэлийн суурь онолуудын нэг “сэтгэлгээний орон зайн онол”-ын гол төлөөлөгч Ж. Фоконье “Сэтгэлгээний орон зай бол” аливаа юм үзэгдлийг хүртэн мэдрээд оюунчлах арга буюу сэтгэхүйн арга юм. Өөрөөр хэлбэл танин мэдэхүйн хийсвэр загвар юм. Хүүхэд ярьж сурахдаа хэлний бүтцийг бус юм үзэгдлийн тусгал, тэдгээрийн холимог орон зай, хүрээний тогтолцоо болон хэлний хэрэглүүрийг эзэмшдэг. Хэл бол зөвхөн тэмдгийн тогтолцоо бус бөгөөд хэл гэсэн ойлголтод хэлний тэмдгээр илэрч буй утга санааны цаана хүний оюун ухаанд хадгалагдаж буй далд мэдээллийн орон зайг бүхэлд нь авч үздэг. Эрдэмтэн Ц. Өнөрбаян энэ талаар хэлэхдээ аливаа хэлний нэгжүүд нь тухайн үндэстний танин мэдэхүй, сэтгэлгээний онцлогийг агуулсан дурсгалын сан хөмрөг болдог гэжээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Аливаа хэлэнд хэлц нь олон зуун жилийн хөгжлийн үр дүнд боловсрон бий болж хэвшин тогтдог тухайн ард түмний аж амьдрал, ахуй орчин, зан заншил, соёл, сэтгэлгээний онцлогийг тусгадаг нэг төрлийн өвөрмөц бэхжмэл цул бүтэцтэй байдаг. Монгол хэлний хэлц нэгжүүд түүний дотор хэлц үг хэллэгийг сүүлийн жилүүдэд нэлээд эрчимтэй судлаж байгааг судалгааны бүтээлүүдээс харж болно. Судлаач М. Базаррагчаа бүтэц, утга, хэлбэр талаас, Д. Бадамдорж, Ж. Баянсан, Б.Пүрэв-Очирр, Б. Баттогтох нар голдуу хэрэглээ, утга орны талаас, Г. Аким, Л. Дашням, Ж. Бат-Ирээдүй нар толилох, зүйлчлэх талаас нь тус тус судлажээ. Хэлц үгийн талаар Судлаач Д. Бадамдорж “Өвөрмөц хэлц гэдэг бол утгын хувьд бүрдүүлж байгаа үг тус бүрийн цөм утга алдарч нийлэн нэгдэн, нэгэн ухагдахуун, утга санааг илэрхийлсэн, тухайн ард түмний сэтгэхүй, сэтгэлгээ нэвт шингэсэн аж ахуй бодит амьдрал, хэв ёс, зан заншил, шашин шүтлэг, үзэл бодол гэх зэргийн гүн тусгал болсон тогтвортой нийлэмж үг” тодорхойлсон байна. (Бадамдорж.Д, 2001:127).

Солонгос хэлний өвөрмөц хэлцийн судалгааны хувьд авч үзвэл

Ким Мүн Чан хэлц үгийн тухай судалгааны ажил хийж олон бүтээл хэвлүүлжээ. Тэдгээрээс дурдвал “Солонгос хэлний судалгаа” (“국어관용어연구 ^ 국어연구” 서울대 국어연구원 1974), “Гар”-ын үгийн сангийн бүтцийн тухай-өвөрмөц хэлцийн тухай ойлголт (“(“손”의 어체계에 대하여 – 속어생상론의 관점에서-, 국어 교육29. 1976), өвөрмөц хэлцийн тухай ойлголт (“(“ 속어개념론” 한국학연구2, 인하대 한국학연구소. 1990), “хэлц үг” солонгос хэлний судалгаа ямар шатандаа явж байна. Солонгос хэл мөн л хэлц үгээр баян бөгөөд “Солонгос үндэстний соёлын их тайлбар толь”-д “Хэлц үг (관용어) нь аль нэг хэлний энгийн утга зүйгээс өвөрмөц өөр бүтэц буюу утгыг агуулсан үг нийлэмж юм хэмээн тодорхойлжээ” (한국민족문화대백과사전, 2001:106). Харин Солонгос монгол хэлц үгийн харьцуулсан судалгааг Хван Хьи Ёнг (황희영, 1978), Б. Энхсаруул (영흐사를, 2003), Х. Уянга (Солонгос монгол хэлний сэтгэл хөдлөл илэрхийлсэн хэлц үгийн харьцуулсан судалгаа, 2008), КимЫнжон (김은정 2020). 한국어, 몽골어 신체 관용어 의미 확장 대조 연구 (Ч. Лодойдамба “Тунгалаг тамир” романы монгол солонгос хэлний “Нүд”орсон жишээгээр). “Ази судлал 6”

Солонгос монгол хэлний хувьд хэлцээр маш баян хэл юм. Тиймээс монгол солонгос хэлний хэлц үг тэр дундаа “Нүд, Чих” орсон жишээг голлон түүвэрлэж, түүнд шингэсэн тус орны ард түмний сэтгэлгээний онцлогыг, танихуйн үүднээс зэрэгцүүлэн үзэхийг зорив.

Өмнөх судалгаанд танихуйн үүднээс хийсэн зүйрлэл, төлөөллийн аргаар бүтсэн нүд хэмээх жишээн дээр нүдний үүрэг, сав зүйрлэл, сэтгэл хөдлөл илэрхийлсэн, цаг хугацаа гэх мэтээр ангилан судалсан бол энэхүү судалгаандаа хоёр хэлний хэлц үгийг (нүд, чих) голлон илэрхийлж буй үг, утга Зөвхөн монгол хэлэнд байдаг хэлц, зөвхөн солонгос хэлэнд байдаг хэлц хэмээн ангилж хоёр ард түмний сэтгэлгээний онцлог талаас тайлбарлахыг зорив.

Нүд - Нүд бол орчлон хорвоог тэр чигээр тусгах гол эрхтэн юм. Нүдээр харж мэдрэх мэдрэмжинд тулгуурлан дүгнэсэн оюуны дүгнэлт хийх, танин мэдэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг. Мөн нүд нь бидний нүүр царайны хамгийн гол төвд байрладаг ба зарим тохиолдолд үг хэлэхээс илүү олон зүйлийг дамжуулан “хэлэх” ч үүрэг гүйцэтгэдэг.

Хүснэгт 1. Илэрхийлэл ба утга адил хэлц

№	Монгол	Солонгос
1	Нүд аних	눈을 감다
2	Нүд ирмэх зуур	눈 깜짝할 사이



3	Нүдний цөцгий мэт хайрлах	눈동자와 같이 아끼고 사랑하다 / 눈에 넣어도 아프지 않다
---	---------------------------	----------------------------------

① **Нүд аних** - Үхэх гэсэн утга нь хоёр хэлэнд адил байна. Жишээ: Цэ ноён бас Янжинхорлоо руу хандаж толгойг нь ... Аав чинь чамд олон жил хань болж чадахгүй, нэг мэдэхэд нүд аньсан байх вий гэж хэлэхэд “아버지는 모든 말씀을 마치시고 오이 눈을 감으셨다”.

Танихуйн үүднээс тайлбарлавал хүн амьдрах хугацаандаа эргэн тойронд нь хүн, амьтан үхэхдээ эцсийн удаа нүдээ аниад эргэн нээлгүйгээр насан эцэслэдэг болохыг мэдэж хүн энэ туршлагад тулгуурлан бий болсон хэлц юм.

② **Нүд ирмэх зуур** - маш богино хугацаа, агшин зуурыг хэлнэ. Жишээ нь Нүд ирмэхийн зуур хүн, мал, ус гурав дээр дороо орон тэмцэлдэж жихүүдэс хүрэм үзэгдэл боллоо. (*Л. Түдэв, Нүүдэл суудал*.) “강아지가 눈 깜짝할 사이에 고깃덩이를 훌쩍 삼켜 버렸다”. Хүний үйлдлээс хамгийн хурдан богино хугацаанд хийж болох үйл бол харах, мөн нүд цавчих, нүд ирмэх үйл нь хоёр орны ард түмний сэтгэлгээ адил болохыг дээрх хэлцээс харагдаж байна. Хүн өөрийн энэ үйлдлээр асар богино цаг хугацааг зүйрлэн илэрхийлсэн байна.

③ **Нүдний цөцгий мэт хайрлах** - Үлэмж нандинаар хайрлах, гамнах гэсэн утга хоёр хэлэнд адилхан байна. Жишээ: -За Должин гуай. Бид нүдний цөцгий мэт хайртай ганц охиноо ханьтай болсонд баярлаж байна. (*Ц. Дамдинсүрэн. Хачин хурим*.) “우리 선화는 눈에 넣어도 아프지 않을 만큼 이뻐”. Нүдний цөцгий бол маш эмзэг чухал эрхтэн. Тиймээс төдий чинээ чухал эмзэг эрхэм нандин зүйлээ зүйрлэж байгаа нь хоёр хэлэнд адил байна.

Хүснэгт 2. Илэрхийлэл өөр утга адил хэлц

№	Монгол	Солонгос
1	Нүдээ хөхөртөл / ширгэтэл / чилтэл харуулдах	눈이 빠지도록 기다리다 /нүдээ унатал хүлээх/
2	Нүд халтирах	눈을 뜨고 볼 수가 없다 /нүдээ нээж харж чадахгүй/

① **Нүдээ хөхөртөл / ширгэтэл / чилтэл харуулдах** - Машид сэтгэл зовнин удаан хугацаа хүлээх, харуулдах гэдэг илэрхийллийг монгол хэлэнд [нүдээ хөхөртөл / ширгэтэл / чилтэл / харуулдах] гэдэг байхад солонгос хэлэнд [нүдээ унатал хүлээх] гэсэн илэрхийллийг хэрэглэдэг. Жишээ: Цэрэг халагдаж байна гэсэн сургаар би хүүгээ хүлээж өдөр бүр Тахилтын зам руу нүдээ чилтэл дурандаж

суудаг байлаа. “눈이 빠지도록 기다렸지만 구조대는 오지 않았다.”

Монгол хэлэнд чилгэл, хөхөртөл, ширгэтэл гэж удаан хугацааг илэрхийлсэн олон үгээр илэрхийлдэг бол солонгос хэлэнд “눈이 빠지도록” буюу нүдээ унатал гэсэн нь монгол солонгос хүмүүсийн сэтгэлгээний ялгааг харуулж байна.

② **Нүд халтирах** - Эгцлэн харахын аргагүй байх. Жишээ: Болд хүн болсоор ийм юм үзсэнгүй тул үнэхээр нүд хальтарч сэтгэл сэрчигнэн, зүүд зэрэглээ үлгэр домог мэт болж гайхна. (*Д. Нацагдорж. Үзэгдээгүй юм.*) “전쟁이 휩쓸고 지나간 참살 현장은 눈을 뜨고 볼 수 없었다.”

Монгол хэлэнд эгцлэн харж зүрхлэхгүй гэсэн санааг цэх зогсож явж чадалгүй гулгаж хальтрах хөдөлгөөнтэй зүйрлэн хэлсэн бол солонгос хэлэнд нүдээ нээж харж чадахгүй гэсэн утгаар илэрхийлсэн байна.

Хүснэгт 3. Утга өөр илэрхийлэл адил хэлц

№	Монгол хэл	Солонгос хэл
1	Нүднээс гарах	눈 밖에 나다 /нүднээс гарах /(신임을 잃고 미움을 받게 되다)
2	Нүднээс гал гарах	눈에 불이 나다 /нүднээс гал гарах/(밖에 몹시 화가 나는 일을 당하여 감정이 격렬해지다)

① **Нүднээс гарах** -Монгол хэлэнд голдуу өвчин туссанаас болж зүс царай алдах үед хэрэглэдэг байхад солонгос хэлэнд итгэлийг нь алдаж хөсөрдүүлэх үед дургүйцсэнээ илэрхийлэхэд хэрэглэдэг байна. Жишээ: Охин минь улам дордоод, улам л нүднээс гараад байдаг. (*Ш. Гаадамба. Хоёр эрдэмтэн*)

② **Нүднээс гал гарах** -Монгол хэлэнд нүд рүү цохих буюу нүд рүү ямар нэг юм хатгах үед хэрэглэдэг. Энэ нь хэсэг хугацаанд манас хийн хором зуур манарахыг хэлнэ. Солонгос хэлэнд гэнэт их уурлах үеийн сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлдэг. Учир нь хүн уурлахад цус хөөрч нүүр, нүд улаан болж хүний биеийн өөрчлөлтөд тулгуурлан ийнхүү хэлдэг байна.

Хүснэгт 4. +Зөвхөн Монгол хэлэнд байдаг хэлц

№	Монгол хэл	Утга
1	Нүд бэлчээх /눈을 기이다/	байн байн Хараад салахгүй байх
2	Нүд хариулах 눈을 기이다	Далдуур, сэм ажиглах

① **Нүд бэлчээх** - Хэсэг хугацаанд нүдээрээ ажиглан харахыг монгол хэлэнд [нүд бэлчээх] гэж илэрхийлэх ба энэ нь мал аж ахуй эрхэлдэг учраас малын



бэлчээрт хараагаа бэлчээх гэсэн монгол хүний амьдралаас үүдэлтэй байна.

② **Нүд хариулах** - Бусдын хараанаас далдуур, бусдыг сэрэмжгүй, анзааргагүй байх үеийг ашиглах. Жишээ: “Багшийн нүдийг хариулж байгаад номыг нь авчихсан.” Хариулах гэдэг нь малыг бэлчээх буюу мал сүргээ бэлчээр сайтай газар, эсвэл харуй бүрий болонгуут хашаа руугаа хариулах гэсэн утгаар хэрэглэдэг. Гэвч нүдийг мал шиг хариулах боломжгүй боловч нэг газраас нөгөө тийш шилжих гэдэг утгаар нь нүд өөр тийш шилжих хооронд гэсэн утгаар оюуншуулан илэрхийлсэн хэлц үг юм.

Хүснэгт 5. +Зөвхөн Солонгос хэлэнд -байдаг хэлц

№	Солонгос хэл	Утга
1	눈에 황달이 떴다 /Нүд нь шарлах/	Нэг ажилд улайраад байсан чинь бусад зүйл ч тийм мэт харагдах
2	눈에서 딱정벌레가 왔다 갔다 하다/ нүдэнд хар хорхой нааш цааш гүйх/	Гэнэт толгой эргэн, дүйрэн нүд эрээлжлэхэд хэлдэг үг

① [눈에 황달이 떴다] гийн утга нь нэг төрлийн ажилд улайраад үзсэн чинь бусад зүйл ч тийм мэт харагдахад хэлдэг үг бөгөөд “달-сар”тай холбоотой үндэсний дуу, шүлэг их байдгаас харахад саранд их анхаардаг дуртай байгаа нь харагдаж байна. Мөн ② [눈에서 딱정벌레가 왔다 갔다 하다] нь гэнэт толгой эргэж дүйрэн, нүд эрээлжлэх гэсэн утгатай. Газар тариалан эрхэлдэг учраас ногооны талбай ба хорхой шавьжтай маш ойрхон байгааг илэрхийлж байхад монгол хэлэнд энэ нь нүдэнд од гялалзах гэдэг илэрхийлэлтэй дүйцэж болох юм. Учир нь монголын өргөн уудам талаас шөнийн тэнгэрийн түг түмэн од тов тод харагддагтай холбоотой.

Чих

Чих бол сонсох сонорын эрхтэн. Холыг чихээр сонсож, ойрыг нүдээр харна гэдэг. Монгол хэлэнд “чих” нь сонсох үүрэгтэй холбоотой орсон хэлц ихэнх хувийг эзлэх төдийгүй дуу чимээтэй холбоотойгоор сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг илэрхийлэх талаас солонгос хэлтэй адил байна. Мөн чихний үүргээс үүдсэн зөн мэдрэхүйн утга, анхаарал, ойлгох, сэтгэл хөдлөл, олон дахин сонсохоос үүссэн залхах уйдах утгыг илэрхийлэхээс гадна хэлний авиа, сайн муу дохиог ялган таньж мэддэг байна.

Хүснэгт 1. Илэрхийлэл ба утга адил хэлц

№	Монгол	Солонгос
1	Чих тавих (귀를 놓다)	귀를 기울이다
2	Чих нээгдэх (귀가 열린다)	귀가 열린다

① “**чих тавих**” нь хоёр утгатай. а) сураг мэдээ сонсохыг хичээх, хүлээх Ж нь: Дорж тайж ойрдоо хол ойрын чимээ чагнан чих тавьдаг болжээ. Л. Чойжилсүрэн. Морин төвөргөөн. б)анхаарах, анзаарах Ж нь: Догоо ойртон очиж түүний үгийг чих тавин чагнаж толгой дохин байснаа... С. Дашдооров “Өндөр ээжий”

“Тавих” гэдэг үгийн бодит утга нь аливаа юмыг нэг газар байрлуулах (МХИТТ) гэсэн утгатай. Харин хүний чихийг хаа нэг газар байрлуулна гэдэг нь анхаарч сонсохыг хүссэн гэсэн шилжсэн утга илтгэнэ.

Монгол хэлний уг үгийн утгатай дүйх солонгос хэлц үг бол “귀를 기울이다” юм. Хоёр хэлэнд адилхан “чих-귀” чих гэдэг орсон байна. Харин үйл үг нь монгол хэлэнд “тавих”, солонгос хэлэнд “기울이다-기울다” хазайх, хэвийх, хэлбийх гэсэн утгатай бөгөөд энэ мөн л анхаарал хандуулах гэсэн утга үүсгэсэн байна.

② “**чих нээгдэх**” Энэ хэлцийг голдуу гадаад хэл сурч буй хүмүүс тухайн хэлийг ойлгож эхлэх үедээ чих нээгдэж байна гэх нь мөн хоёр хэлэнд адил байна. Бодит байдал дээр хүний чих нээж, хаах боломжгүй ч гадаад хэлийг сонсоод ойлгодог болохыг “нээх” гэж зүйрлэн илэрхийлсэн нь хоёр хэлэнд адил байна.

Хүснэгт 2. Зөвхөн Монгол хэлэнд байдаг хэлц

№	Монгол хэл	Утга
1	Чих нь алт болох (귀가 금이 되다)	Сонсох ёсгүй юмыг сонсох
2	Чихний чимэг (귀의 장식)	Сонсоход сайхан таатай зүйл
3	Чихнээс хонх уях (귀에 종을 달다)	Олон дахин хэлүүлэх

Дээрх хэлцүүд нь монгол хэлэнд л байдаг бөгөөд солонгос хүн ойлгож хэрэглэхэд хэцүү илэрхийлэл юм. Тухайлбал ① “**чих нь алт болох**” гэдэг нь сонсох ёсгүй юмыг сонсоод байхаар чих нь алт боллоо гэдэг. Жишээ нь хүүхэд мөртлөө том хүний үг сонсоод байгаа хүүхдийг чих чинь алт боллоо явж үз гэж хэлдэг. Солонгос хэлэнд үүнтэй адил утга илэрхийлсэн хэлц үг бол “귀가 솔깃하다” гэж бий. Энэ нь чих сонин содон зүйлийг сонсох гэж тэр зүг рүү хандах гэсэн утгатай үгээр уг санааг илэрхийлдэг байна.



② **“Чихний чимэг”** энэ нь сонсоход сайхан гэсэн утгатай ба сайн үгийг сонсох үед голдуу хэрэглэдэг илэрхийлэл бөгөөд солонгос хэлний “귀가 즐겁다”-тай төстэй. Ж нь: Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл,

Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ. *Б. Ринчен. Монгол хэл.*

Хүн сайхан үг сонслоо гээд чих түүгээр гоёж, чихийг чимэхгүй. Гэвч үнэхээр гоёж байгаа мэт, хүний хэлсэн үгийг нүдээр харж барих боломжгүй ч нүдэнд харагдаж чихийг гоёж байгаа мэт сайхан үгсийг хийсвэрлэн сэтгэж буйгаа уг хэлц үгээр илэрхийлсэн байна.

③ **“Чихнээс хонх уях”** нь сонсмооргүй үгийг үргэлж сонсох юмуу зэмлүүлэх үедээ хэлдэг илэрхийлэл. Хүн үнэхээр чихэндээ хонх уявал хөдлөх бүрт жингэнэж сүүлдээ тээртэй хэцүү санагдана. Тэгвэл яг энэ туршлага, мэдрэмжинд тулгуурлан уг үгийг утга шилжүүлэн байн байн сонсох нь таагүй санагдах гэсэн утга илэрхийлдэг байна.

Хүснэгт 3. Зөвхөн Солонгос хэлэнд байдаг хэлц

№	Солонгос хэл	Утга
1	귀를 씻다 (чихээ угаах)	Сэтгэлийг амраах, сэтгэлийг ариусгах
2	귀를 팔다(чихээ зарах)	Нэг зүйл анхаарах, чихээ өгөх

① **귀를 씻다 (чихээ угаах)** муу муухайг сонссон чихээ угаана гэсэн утгаар муу бохироос салах гэснийг зүйрлүүлэн хэлдэг. Жишээ нь: ‘가끔씩 전화로 듣는 그녀의 목소리는 언제나 내 귀를 씻어 주었다. Хааяа утсаар сонсож байгаа тэр бүсгүйн дуу хоолой ямагт миний сэтгэлийг ариусган тайвшруулдаг. ②**귀를 팔다 (чихээ зарах)** сайн сонсохгүй байна, анхаараагүй, ухаан санаа нь өөр газар байх үеийг ингэж хэлэх бөгөөд “чихээ зарах” гэдэг үгээр илэрхийлдэг нь монгол хэлнээс өөр байгаа нь юмс үзэгдлийг хүлээн авах сэтгэлгээ өөр байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Илэрхийлэл өөр утга адил хэлц

№	Монгол хэл	Солонгос хэл
1	Чих хангинах (귀가 울리다)	귀가 가렵다 (чих загатнах)
2	Чих зөөлөнтэй (귀가 부드럽다)	귀가 얇다(чих нимгэн)

① **“Чих хангинах” (귀가 가렵다)** нь өөрийн тухай бусад хүн сайн муугаар ярих үед хэлдэг илэрхийлэл бөгөөд солонгос хэлэнд “귀가 가렵다” буюу чих загатнах гэх үгээр илэрхийлдэг нь сонин. Монголчууд баруун чих хангинавал хэн нэг хүн сайнаар ярьж байна, зүүн чих хангинавал хэн нэгэн муу хэлж байна

гэдэг. Ж нь: баруун чих хангиналаа, нэг хүн намайг дурсаж байх шиг байна ② Чих зөөлөнтэй бусдын үгийг сайн сонсдог, дуулгавартай гэсэн утгыг монгол хэлэнд “зөөлөн” гэх үгээр илэрхийлдэг бол солонгос хэлнээ “нимгэн” гэх үгээр илэрхийлдэг байна. Хэдийгээр хоёр хэлэнд өөр өөр үгээр илэрхийлсэн байгаа ч утгаа хүний чих зөөлөн буюу уян хатан, мөн нимгэн гэдэг нь ч уян хатан гэсэн ойлголтыг өгч байгаагаараа сэтгэн бодож буй адил гэж үзэж болно.

Хүснэгт 5. Утга өөр илэрхийлэл адил хэлц

№	Монгол	Солонгос
1	Чих халууцуулах (귀를 덥게하다)	귀가 따갑다

① “**Чих халууцуулах**” гэдэг нь монгол хэлэнд муу юм сонсгох гэсэн утга илэрхийлж байхад солонгос хэлэнд чимээ шуугианаас болоод сонсоход хэцүү, мөн сонсмооргүй үгийг байнга сонсдог гэсэн утгаар 귀가 따갑다 гэж хэрэглэдэг. Жишээ нь : 내가 자라오면서 귀 따갑도록 들은 이야기는 ‘여자는 모름지기’란 말이었다. Намайг том болоход чихэнд ян хийх мэт сонссон яриа нь ‘эмэгтэй хүн эрхбиш тийм байх ёстой’ гэсэн үг байлаа. Харин монгол хэлэнд өөр утгаар муу юм сонсгох гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

ДҮГНЭЛТ

Дээрх монгол солонгос хэлний нүд, чих гэх үг орсон хэлц үгийг илэрхийлэл, утгаар нь тав ангилан утга ба жишээнд тулгуурлан танин мэдэхүйн сэтгэлгээ талаас тайлбарлахыг хичээлээ.

Нүд гэдэг үг орсон хэлцээс **илэрхийлэл өөр, утга ижил** хэлцүүдийн дийлэнх нь хүний үйл хөдлөл, амьдралын туршлагатай холбоотойгоор үүссэн хэлц үг зонхилсон байна. Жишээлбэл: Нүд хорсох, нүд халтирах, нүдээ чилтэл харуулдах гэх мэтийг дурдаж болно. Мөн “눈엣가시” (нүдэнд орсон өргөс), малд нүдтэй, нүд бэлчээх, нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах, нүд хариулах гэх зэрэг хэлцээс харахад тус хоёр орны ард түмний эрхэлдэг аж ахуйтай холбоотойгоор тархиндаа хүлээн авч бодож сэтгэдэг нь үндэсний онцлогтой үгсээр илэрч байна.

Утга өөр илэрхийлэл ижил хэлц үг нь адилхан үгээр илэрхийлж байгаа ч өөр өөр утга гаргаж байгаа нь сэтгэлгээ ялгаатайг харуулж болно.

Мөн чих гэдэг үг орсон хэлцээс **илэрхийлэл ба утга адил хэлц** нь чихний үндсэн үүрэг, бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой сонсох үүргээс гадна анхаарах, тавих, чагнах, зэрэг үгс орсон хэлц үг нь хоёр хэлэнд адил утга илэрхийлсэн хэлц



үгээр илэрч байна. Мөн “чих нээгдэх, 귀가 열린다” ойлгохгүй зүйлээ чих нь хаагдсан мэт, ойлгодог болсныг чих нээгдсэн мэтээр зүйрлэн сэтгэж буй нь хоёр хэлэнд адил байна.

Зөвхөн монгол хэлэнд байдаг хэлц, зөвхөн солонгос хэлэнд байдаг хэлцүүдийг харвал, амьдралын туршлагатай холбоотойгоор үүссэн хэлц үг зонхилсон байна. Мөн тус хоёр орны ард түмний эрхэлдэг аж ахуйтай холбоотойгоор тархиндаа хүлээн авч бодож сэтгэдэг нь үндэсний онцлогтой үгсээр илэрч байна.

НОМ ЗҮЙ

1. Бадамдорж.Д. (2018). *Танин мэдэхүйн утга зүйн удиртгал*. УБ: Удам соёл ХХК.
2. КимЫнжон. (2020). 한국어, 몽골어 신체 관용어 의미 확장 대조 연구 (Ч.Лодойдамба)
3. “Тунгалаг тамир” романы монгол солонгос хэлний “нүд” орсон жишээгээр). “Ази судлал 6”.
4. Нансалмаа.Н, Д. (2014). *Танихуйн хэлишинжлэл*. УБ: Антоон мостаэрт МС.
5. Нансалмаа.Н, Д. (2021). *Танихуйн хэл шинжлэл*. УБ: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
6. 국립국어원. (2001). “한국민족문화대백과사전 3.”
7. 옹흐사를. (2003). 한국어와 몽골어의 신체관련 관용구 대조 연구.”연세대학교
8. 대학원.석사논문 황희영. (1978). 한국 관용어 연구. “성곡학술문화 재단”.
9. Лхагваа.Б. (2021). Монгол солонгос өвөрмөц хэлний толь. УБ. Сэлэнгэ пресс
10. 최경봉. (2017). 우리말 관용어 사전, 일조각
11. Бат-Ирээдүй. Ж.(2007). Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга, хэрэглээ. УБ. Мон эдьюкашн пресс
12. Цог-Очир.А(2016).Зүйрлэлийн танин мэдэхүйн онол. Монгол судлалын чуулган. ЭШС. 2016/2.15тал

ПАРХЭГИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТОЙМ

(Солонгос, Монгол улсын жишээн дээр)

Магистр, С.Энх-Амгалан

(ОУУБИС. ХНУС)

enkhamgalan.s@ulaanbaatar.edu.mn

Хураангуй

Пархэ нь 698-926 оны хооронд 228 жил оршин тогтносон солонгосын эртний улс билээ. (Г.Эрдэнэчимэг, 2006, хуудсд. 79-80) Хятадын Хожуу Жинь улсын үед 945 онд “Хуучин Тан улсын бичиг (舊唐書, 구당서) хэмээх сударт Пархэ улсын үүсэл, төрийн тогтолцоо, Тан улстай харилцаж байсан харилцааны талаар нарийн мэдээ хадгалагдсан байна. Мөн Японд 797 онд бичиж дуусгасан “Шёкүнихонги (続日本紀, 속일본기) хэмээх түүхэн сурвалжид Пархэг тусгаар улс гэж үзэн, Япон-Пархэ хоёрын харилцаа, элч солилцоо, Пархэ улсын дотоод бүтэц, вангийн тухай тэмдэглэсэн байдаг.

Харин Солонгос болон Монгол улсад Пархэ улсын талаар хэрхэн судалсан болохыг судалж, дүн шинжилгээ хийхэд тус судалгааны ажлын зорилго оршиж байна.

Судалгааны үр дүнгээс харахад Пархэгийн түүхийг Солонгос улсад Хятад, Японоос хожуу буюу 1784 онд тэмдэглэсэн болох нь ажиглагдсан бөгөөд солонгос судлаачид Пархэгийн талаарх судалгаа хийхдээ Хятад, Япон эх сурвалжийг гол эх сурвалжаа болгосон байна. Монгол эрдэмтдийн хувьд Пархэ Хятан, Хятан Корйё улстай харилцаж байсан харилцаан дээр тулгуурлан судалсан байна.

Түлхүүр үг: Пархэ, эх сурвалж, Когүрйөгийн залгамжлагч

ОРШИЛ

Пархэ улсыг 698 онд Тэй Жойөн Хятаны толгойлогч Ли Цзиньчжун, Сунь Ваньжун нар Тан улсын эсрэг бослого гаргасан завшааныг ашиглан Пархэг байгуулжээ. Пархэгийн анх байгуулагдсан нэр Жинь бөгөөд Тан улстай найрсаг харилцаа тогтоосон 713 оноос хойш Пархэ гэж нэрлэгдэх болжээ. Пархэ улсын дийлэнх иргэд когүрйөчүүд, бусад иргэд нь мохэ, зүрчид зэрэг олон үндэстнээс



бүрдэж байжээ.

Пархэ улс нь Тэй Жойөн вангийн үед хүчирхэгжин, Мү вангийн үед газар нутгаа тэлж, Мүнъ вангийн үед засаглалаа шинэтгэж, Сөнъ вангийн үед соёл, боловсрол хөгжиж, (Шинь Йёнбөм, 2015, хууд. 69) Инъсөнъ вангийн үед 926 онд Хятан улсын дайралтад эзлэгдэн мөхжээ.

Пархэгийн талаар солонгос талаас Юү Дыггон (유득공, 柳得恭) /1748-1807/, Ким Жонху, И Жонхви (이종휘, 李鍾輝) /1731-1797/, Жон Ягюун (정약용, 丁若鏞) /1762-1836/, Хань Чиюүнъ (한치윤, 韓致堧) /1765- 814), Хун Согжү (홍석주, 洪奭周) /1774-1842/ нарын эрдэмтэд 1784-1866 оны хооронд судалж байсан бол 1980 оноос Ну Тайдунъ (노태돈, 盧泰敦) /1949-), Сун Гихой (송기호) /1956-/, Хань Гючол (한규철) /1951-/ зэрэг нийт 15 эрдэмтэд судалгаа хийж байна.

Монголд Ч.Далай, Б.Сумьяабаатар, Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, А.Очир нарын эрдэмтэд Пархэ болон Хятан улсын харилцаа, соёл, археологийн судалгаа хийсэн байна.

СОЛОНГОС ДАХЬ ПАРХЭГИЙН СУДАЛГАА

1784 онд Юү Дыггон “Пархэгийн шинжлэл” (발해고, 渤海考) зохиолоо бичсэнээр Солонгос улсад Пархэгийн судалгаа эхэлсэн түүхтэй. “Пархэгийн шинжлэл” нь Пархэгийн түүхийг судлах үндсэн эх сурвалж болж, Солонгосын эрдэмтэд олон арван судалгааны эх сурвалжаа болгожээ. Тухайлбал Ким Жонху “Зүүн зүгийн их улсын газарзүйн тэмдэглэл” (대동지지, 大東地志)¹ 1862-1866 он, И Жонхви (이종휘, 李鍾輝) “Зүүн улсын түүх” (동사, 東史) 1731-1797 он, Жон Ягюун (정약용, 丁若鏞) “Газар нутгийн шинжлэл” (강역고, 疆域考) 1811 он, Хань Чиюүн (한치윤, 韓致堧) “Дорно зүгт цэцэглэсэн улсын түүх” (해동역사, 海東譯史) 1823 он, Хун Согжү (홍석주, 洪奭周) “Пархэгийн ертөнц болон гэр” (발해세가, 渤海世家) зэрэг бүтээлүүд гарч байв. Эдгээр судалгаа нь Пархэгийн түүхийг нарийн ойлгоход чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Солонгосын түүхчид энэ сэдвээр өргөн судалгаа хийжээ. (김은국권은주, 2019, 페이지: 277-278)

¹ Солонгосын газар зүйн нарийвчилсан толь бичиг юм. Энэ бүтээл нь Солонгосын бүс нутгийн газар зүй, хилийн зааг, иргэдийн амьдрал, улс төрийн бүтэц, түүхийг нарийвчлан судалсан байдаг.

*Хүснэгт 1. Солонгост Пархэгийн талаар судалгаа
хийсэн эхэн үеийн эрдэмтдийн бүтээл*

№	Зохиолч	Бүлэг	Агуулга
1	Юү Дыггон “Пархэгийн шинжлэл” (발해고, 渤海考) 1784 он	Нийт 9 бүлэгтэй. Эзэн хаадын шинжлэл (君考, 군고)	“Эзэн хаадын шинжлэл” нь уламжлалт түүх бичлэгийн нэг арга болох “Уг тэмдэглэл (本紀, 본기)”-тэй дүйх бөгөөд Пархэ улсын вангуудын талаар тэмдэглэжээ.
		Түшмэдийн шинжлэл (臣考, 신고)	Овог нэр нь тодорхойгүй хүмүүсийг эс тооцвол, Пархэ улсын бичиг, цэргийн түшмэл, эрдэмтэн, дипломатч зэрэг 83 хүний талаар бичсэн нэг төрлийн “олон шастир (列記, 열전)” болой.
		Газарзүйн шинжлэл (地理考, 지리고)	5 нийслэл 15 пү, 62 чү хийгээд күнь, гол мөрөн, хот балгад зэргийн талаар өгүүлжээ.
		Албан газар хийгээд албан тушаалын шинжлэл (職官考, 식관고)	Бичиг, цэргийн түшмэл, тэдний орон тооны талаар өгүүлжээ.
		Ёслол хувцас хэрэглэлийн шинжлэл (儀章考, 의장고)	Хэргэм зэргээс хамаараад харилцан ялгаатай хувцас зүүсгэл болон Зүүн нийслэлийн хүндэт харуулын талаар бичжээ.
		Эд барааны шинжлэл (物産考, 물산고)	Нутгаас гарах хэд хэдэн онцгой эд таваарын талаар өгүүлжээ.
		Эх хэлний шинжлэл (國語考, 국어고)	Пархэ-д хэрэглэж байсан зарим нэг нэр томъёо, цол хэргэмийг танилцуулжээ.
		Улсын бичгийн шинжлэл (國書考, 국서고)	Голцуу Японд илгээж байсан төрийн бичгүүдийг танилцуулсан агаад Мү ван хийгээд Мүнъ вангаас Японы эзэн хаан Шёомү тэнноо-д, Кан вангаас Японы эзэн хаан Канмү тэнноо-д тус тус илгээсэн захидал багтжээ.



1	Юү Дыггон “Пархэгийн шинжлэл” (발해고, 渤海考) 1784 он	“Хойч удмын улсын шинжлэл (屬國考, 속국고)	“Чөнанъ улс угтаа Маханъ-ы төрөл бөгөөд Пархэ [Хятанд] эзлэгдсэнд түүний баруун хилийг сахих болжээ” хэмээн бичсэн бөгөөд Чөнанъ улсын ван О Хйөнъмйөн “Түшмэл би угтаа Когүйө-гийн нутагт сууж байсан Пархэ-гийн үлдэгдэл иргэн бөлгөө” гэх мэтээр тэмдэглэжээ. (Дыггон, Пархэгийн шинжлэл Ц.Цэрэндорж, 2014, хуудсд. 7-8)
2	Ким Жонху “Зүүн зүгийн их улсын газарзүйн тэмдэглэл” (대동지지, 大東地志) 1862 - 1866 оны хооронд 3 жил бичсэн газарзүйн болон түүх-географийн судар юм. Бүрэн эх хувь буюу Ким Жонху өөрийн гараар бичсэн эх бичмэл Корйө их сургуулийн номын санд хадгалагдаж байгаа ажээ.	Нийт 32 боть 15 дэвтэр	Кёндө (경도, 京都) болон Хансонбу (한성부, 漢城府) – 1-р боть, Кёнги муж (경기도) 2–4-р ботид, Чүнчон муж (충청도) 5–6-р ботид, Кёнсан муж (경상도) 7–10-р ботид, Чолла муж (전라도) 11–14-р ботид, Канвон муж (강원도) 15–16-р ботид, Хуанхэ муж (황해도) 17–18-р ботид, Хамгён муж (함경도) 19–20-р ботид, Пёнан муж (평안도) 21–24-р ботид тус тус багтсан байна. Мөн гол мөрөн, ус судлалын тухай агуулсан «Уул усны судар» (산수고, Сансүго) нь 25-р боть, улсын хил хязгаар, батлан хамгаалалтын тухай “Хилийн судар” (변방고, Пёнбанго) нь 26-р ботид багтсан боловч 26-р боть бүрэн дуусаагүй буюу дутуу байгаа юм.² (한국민족대백과사전, 날짜 정보 없음)

² <https://encykorea.aks.ac.kr/Article/E0014282>

3	И Жонхви Зүүн улсын түүх (동사, 東史) 1731-1797 он	Үндсэн 5 хэсгээс бүрддэг.	Ко Чесонъ, Гурван Ханъ, Пүйө, Когүрйө зэрэг эртний төрт улсуудын түүх, соёлын тухай өгүүлдэг. Энэхүү бүтээлийн онцлог нь Тангүний шүтлэг, түүхийг “Шинсажи»(神事志) хэмээх бие даасан бүлгээр нэгтгэн тусгасан явдал юм. Пүйө, Йэмайг, Когүрйө, Огжө, Пайгжэ зэрэг улс, аймгуудыг Тангүний үр сад хэмээн үзэж, Тангүний угсааг илүү өндөр түвшинд гаргажээ. Мөн Пархэ улсыг Когүрйөгийн шууд залгамжлагч хэмээн тодорхойлж, Пархэгийн түүхийг Солонгосын түүхийн нэг хэсэг болгон, нэгтгэсэн нь чухал ач холбогдолтой билээ. Пархэ улсыг үндэслэгч Тэй Жойөн Кижлагаас хойших хамгийн агуу удирдагч хэмээн үнэлсэн байдаг. И Жонхвигийн ийм үнэлгээ, хандлага хожим Ко Чесонъ- Пүйө-Когүрйө-Пархэ хэмээх умард угсааны төрт улсуудын онцлон дээдэлдэг үндсэрхэг түүхчдийн үзэл сурталын үндэс болж өгсөн юм. (민족대백과사전)
---	---	------------------------------	---



4	Жон Ягюун Газар нутгийн шинжлэл (『강 역고, 疆域考』) 1811 он	Нийт 10 боть.	Чөсонъ улсын үед Солонгосын газар нутгийн түүхийг эртний ном судар дээр үндэслэн судалсан түүх-географийн бүтээл бөгөөд 4-р ботид Пархэгийн газар нутгийг солонгосын эртний түүхэн сурвалж бичгүүдийн мэдээнд тулгуурлан шүүж, газар нутгийн өөрчлөлт, түүхэн угсааг нарийвчлан тайлбарласан байна. (한국민족대백과사전, 한국민족대백과사전, 날짜 정보 없음)
5	Хань Чиюүн “Дорно зүгт цэцэглэсэн улсын түүх” (해 동역사, 海東 繹史) 1823 он		Хань Чиюүн-ы зохиосон үндсэн хэсэг (본편) 70 боть бөгөөд түүний зээ хүү Жинсогийн нөхөж бичсэн 15 боть нийлээд нийт 85 ботийн бүтээл билээ. Тангүний Чөсонъ-ы үеэс Корёгийн үе хүртэл түүхэн баримтуудыг эмхэтгэн бичсэн түүхэн судар юм. (한국민족대백과사전, 날짜 정보 없음)

Гэвч Японы дарангуйлалын үед Пархэгийн судалгаа эрс удааширч, зогсонги байдалд оржээ. Харин 1980 онд Ну Тайдунъ, Сун Гихой, Хань Гюүчол нарын судалгааны ажлууд олонд танигдсанаар судалгаа дахин сэргэж, эрдэмтэд Пархэгийн түүхийг сонирхож эхэлсэн. Хятад улстай дипломат харилцаа тогтоосноор Хятад болон Орос улсад хийгдсэн археологийн судалгааны үр дүнг Солонгост танилцуулж, түүхийн сурвалж бичиг, археологийн судалгааны үр дүнд тулгуурласан салбар салбарын судалгаа хөгжиж эхэлсэн. Одоогийн байдлаар Пархэгийн түүхийн талаар судалгаа хийж буй 15 гаруй судлаачид түүх, улс төр, эдийн засаг, соёл, хувцас, архитектур, харилцаа гэх мэт олон чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийж, Пархэгийн түүхийг гүнзгийрүүлэн судалсаар байна. Ийнхүү Пархэгийн түүхийг судлах ажил өнөө цагийн эрдэмтдийн хүчээр идэвхжиж, олон улсын хэмжээнд судлагдаж байгаа билээ. (김진광, 2009, 페이지: 277-278) Солонгос улсад Пархэ судалгаа нь Пархэ-г Когүрёо улсын залгамжлагч хэмээн Юү Дыгтон бичсэн цагаас эхэлсэн. Пархэ нь Когүрёо улсын хойч үе бөгөөд когүрёочүүдийн соёл, улс төрийн уламжлалыг хадгалсан улс байв.

Нэгдүгээрт, үндэстний хандлага: Пархэ нь Когүрьё улсын өв залгамжлагч тул Солонгосын үндэстний бие даасан байдлыг хадгалсан чухал улс гэж үздэг. Пархэгийн түүхийг дахин сэргээх нь Солонгосын түүхийн хувьд онцгой ач холбогдолтой.

Хоёрдугаарт, улс төрийн тогтолцоо ба хөгжил: Пархэ нь төвлөрсөн засаглал болон өөрийнхөө цэрэг, хууль эрх зүйн тогтолцоог хөгжүүлсэн. Пархэгийн улс төр, цэрэг, хууль, эрх зүйн бүтэц зэрэг асуудлууд нь Солонгосын судалгаанд өргөнөөр хөндөгдөж байна.

Гуравдугаарт, соёл ба урлаг: Пархэгийн буддын урлаг, барилга байгууламж, археологийн олдворууд нь Солонгосын соёлын судалгаанд чухал байр суурь эзэлдэг. Тухайлбал буддын шашны дурсгал болон бунхан нь судлаачдын анхаарлыг татдаг.

Солонгосын түүх судлалын хүрээнд Пархэ ба Хятан улсын түүх, соёл, улс төрийн харилцаа болон эдгээр улсуудын нөлөөлөл нь чухал судалгааны сэдэв болж байна. Энэ хүрээнд хэд хэдэн нэрт судлаачид болон судалгааны бүтээлүүд гарсан байдаг. Доор Солонгос дахь Хятан, Пархэ судлалын зарим гол бүтээлүүдийг танилцуулъя. Солонгост Пархэ болон Хятаны түүхийг дараах судлаачид судалж үзжээ. Үүнд :

1. Юү Дыггон “Пархэгийн шинжлэл” (발해고, 渤海考). Пархэгийн талаар анхны судалгааг хийсэн эрдэмтдийн нэг бөгөөд Солонгосын түүхэнд Пархэ улсын түүхийг огт тэмдэглээгүй байсныг эрдэмтэн Юү Дыггон шүүмжилж, Хятад, мөн Япон, Солонгосын нийт 22 сурвалжийг ашиглан Пархэгийн түүхийг бичжээ.
2. 2009 онд Ким Чунбуг “Пархэгийн улс төр ба харилцааны түүх” хэмээх судалгаандаа Пархэгийн түүхийг судлахад тулгарч буй хамгийн том саад нь Пархэ улсын нутаг дэвсгэр Солонгос, Хятад, Орос зэрэг гэсэн гурван улсын нутагт дэвсгэрт хуваагдсан явдал гэдгийг онцлон дурджээ. Мөн Пархэ болон Пархэгийн түүхийг Хятад, Орос, Япон улсууд өөрийн түүхэнд багтаан бичих хандлагаас үүдэн Пархэгийн түүхийг судлахад бэрхшээл үүсч, Пархэгийн түүхийг хэн нэгний заавраар бичих эсвэл дуурайлган бичиж байсныг хөнддөг. Энэ хязгаар, бэрхшээлийг даван туулахын тулд Пархэгийн түүхийг нарийвчлан судлах шаардлагатай гэж Ким Чунбуг тэмдэглэжээ. Юуны өмнө Пархэ-гийн түүхийг сурвалжид тэмдэглэгдэж үлдээсэн баримт хангалтгүй, байгаа баримтыг “бусдын үзэл бодол”-оор бичсэн тул зохиолч уг бүтээлээ Пархэгийн оюун санааг сэргээх зорилгоор бичжээ. Түүний энэхүү хүчин чармайлт Пархэгийн оюун санааг сэргээхэд үнэтэй тулгын чулуу болсоныг үгүйсгэх аргагүй юм. (김종복, 2009, 페이지: 278)



3. Сун Гихой Хятдад 22 удаа, Оросын Приморт 18 удаа очиж, археологийн судалгаа хийж байжээ. Пархэ болон Хятаны археологийн судалгаагаар хоёр улсын соёлын өв болон түүхийн хамаарлыг судалсан. Хятан Пархэ Когүрйөгийн улс төрийн харилцаа, олон улсын харилцааны талаар судалгаа хийсэн. (송기호, 2007, 페이지: 10) Түүний судалгаанаас хоёр улсын хооронд ямар нэгэн цэргийн холбоо, худалдааны харилцаа байсан талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.
4. Хан Гюүчол Пархэ улсыг судлахдаа Хятан, зүрчидийн иргэд болон хаад Солонгост хэрхэн нөлөөлж байсныг өргөн хүрээнд судалсан. (한규철, 1982.2. 50쪽) Түүний “Зүүн хойд Азийн түүхийн маргаан” хэмээх ном бий.

Эдгээр эрдэмтэд нь Пархэ болон Хятаны түүх, улс төр, нийгмийн бүтэц, соёлын өөрчлөлт болон тэдний хоорондын харилцааг судалж, хоёр улсын дорно Азийн түүхэнд эзлэх байр суурийг тодруулжээ.

МОНГОЛ ДАХЬ ПАРХЭГИЙН СУДАЛГАА

Монголд Пархэ улс Хятаны түүхтэй холбогдон судлагдсан байна. 1959 онд Х.Пэрлээ “Хятан нар, тэдний монголчуудтай холбогдох нь” хэмээх бүтээл нь Х.Пэрлээгийн түүхийн гүн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан судалгааны ажил билээ. Тус судалгааны ажил Хятан судлалын хувьд хамгийн анхны жинтэй бүтээл болж чаджээ. Уг судалгаанд Хятан улсыг монгол аймгууд төдийгүй Түрэг, Тан, Суй, Пархэ зэрэг улсуудтай хэрхэн харилцаж байсныг нарийн судалжээ. Үүнд хятанчууд Пархэ улс руу довтолсон довтолгооны талаар бичсэн байна. (Х.Пэрлээ, 1959) Х.Пэрлээ судалгааны ажлаа бичихдээ сурвалж бичгээс гадна манай улсын нутаг дэвсгэрт байгаа Хятаны холбогдол бүхий хот сууринд эртний археологийн шинжилгээ хийж, олон материалыг ашигласан нь их сонирхолтой болсон байна. (хүрээлэн, 2020, хууд. 138)

1961 онд Ч.Далайн “Монгол Солонгосын эртний түүхэн харилцаа” өгүүлэлд дурдсанаар 1216 онд Хятан улсын цэрэг Корйө улсын нутаг дэвсгэрт нэвтэрч, үймээн самуун дэгдээхэд Чингис хааны Хажин, Жала хоёр жанжин уг үймээнийг дарж, Чингис хаанаас олгосон эрхийн дагуу Корйө улстай ах дүүгийн найрамдлын гэрээ байгуулсан гэж бий. (хүрээлэн, 2020, хуудсд. 174-175) Уг өгүүллээс сая дурдсан хэсгийг танилцуулъя.

“1218 оны өвөл (12-р сард) Хажин, Жала хоёр жанжны удирдсан 10000 шахам цэрэг Солонгос дахь Киданы цэргийн хүчийг даралцахаар Солонгосын умард нутаг Хуа, Мэн, Сун, Док дөрвөн хотын чиглэлээр орж ирэв. (Б.Лхагва, 1966) Тэр үед

Корё нутгийн умардад цас их унаж хүйтэн өвөл болсон тул монгол цэрэг хоол хүнсээр дутагдсан тул Хажин жанжин Корёгийн цэргийн ерөнхий командлагч Жо Чунд элч илгээж тусламж хүссэнд Жо Чун жанжин сайн агт морь болон 1000 шуудай амуу будаа хүргүүлснээс гадна найрамдлын гэрээ байгуулах гэсэн Хажин жанжны саналыг хүлээн авсан хэмээн солонгос сурвалжид тэмдэглэжээ.³ Монгол, Солонгосын хамтарсан цэргийн хүч Киданы үлдэгдэл цэргийн дэгдээсэн самууныг богино хугацаанд амархан даржээ. Кидан цэргийн толгойлогч нь амиа хорлож, 50000 шахам кидан цэрэг бууж өгчээ. Солонгосын тал бууж өгсөн кидан цэргийг чанд хяналтад цагдан харгалзжээ. Дайнд олон хүний амь үрэгдэж И овогт нэгэн солонгос жанжин алагдсан гэж “Гуулин улсын сударт”-т тэмдэглэжээ. 1219 оны 1-р сард Хажин жанжин монгол дайны журам ёсоор олзны кидан хүмүүсийг тарааж хуваарилах ажил хийжээ. Ингээд кидан эмэгтэй, хүүхэд нийлсэн 700 шахам хүнийг Солонгосын талд хүлээлгэн өгч 200 кидан хүнийг Ляодун тийш авч буцахаар тогтжээ. Монголын цэргийн жанжин Хажин, Жала нар цэргээ авч буцахын өмнө Чингис хаанаас эрх олгосны дагуу Солонгосын их жанжин Жо Чун, Ким Чируо нартай хэлэлцээ хийж, Монгол Солонгосын хооронд энхийн гэрээ байгуулах зэрэг олон чухал асуудал ярилцжээ. Хэлэлцээ хийх төлөөлөгчдийг Чингис хаан, Ко Жон ван нарын итгэлийг тус тус хүлээсэн монгол цэргийн жанжин Хажин, Солонгос цэргийг жанжин “бид түмэн газрын тэртээгээс хүрэлцэн ирж эрхмийн улстай хүч хавсран дайсныг дарсан нь тэнгэрийн таалал биз ээ” хэмээснийг Жо Чун жанжин баяртай хүлээн авч санал нийлжээ. Ингээд хоёр талын хэлэлцээ амжилттай явагдаж, энхийн гэрээ маань энэ өдрийг үл умардаг” гэж дурджээ. Гэрээ байгуулсны дараа монгол, солонгос жанжин нар дайллага хийж, харилцан найрсаг үгс ярилцаж байсныг “Гуулин улсын судар”-т дэлгэрэнгүй тэмдэглэжээ. Тэр үеэр Солонгосын ван баяр хүргэсэн захидал гэрээ байгуулж, харилцан ойлголцож, ёс заншлаа харилцан хүндэтгэж, аливаа асуудлаа газар дээр нь шийдсэнээс үзвэл эвийн харилцааг хурдан тогтоох нэн чухал шаардлагатай байсанд оршино. Хэдийгээр эл гэрээ нь энхийн аргаар Солонгосыг эрхэндээ оруулах гэсэн Чингис хааны бодлогын илрэл боловч хоёр улсын харилцааны түүхэнд гарсан гадаад харилцааны нэн чухал баримт бичиг мөн ажээ.

Уг хэсгээс миний бие нэгэн цагт Пархэ улсыг мөхөөж байсан Хятаны цэргийн үлдэгдлийг Чингис хаан дарсныхаа дараа Корйё улстай найрамдлын байгуулсан болохыг ажиглан харлаа.

1975 онд Б.Сумьяабаатар “Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал” хэмээх судалгаанд Корйё улсаас Хятан руу Хятан хэл сургахаар арван хүүхэд илгээж байсан мэдээг солонгосын Гуулин улсын сударт “(Хөхөгчин

³ “Зүүн гүрний толь”, Пхеньян, 1961 он, 63-34-р тал



хонин жил. 995 он. Намрын 9 сар ‘Хятан хэл сургахаар арван хүүхэд илгээв. Гуулин улсын судар. Пхеньян. 1962. 1-р боть. 174-р тал’)” (Б.Сумьяабаатар, 1975, хуудсд. 11-12) гэж тэмдэглэгдсэнийг олны хүртээл болгожээ.

2000 онд Ц.Цэрэндорж “Эртний Монгол-Солонгосын харилцаа” хэмээх эрдэм шинжилгээний бүтээлдээ “Пархэ улс хятанчуудын ачаар байгуулагдаж, хятанчуудын улмаас мөхсөн билээ” гэж бичжээ. Судлаачийн үзэл бодлыг тусган харуулсан хэсгийг номноос тасалж оруулав.

‘925 оны өвлийн сүүл сард Ляо улсын Абаоцзи хаан Пархэгийн Тэ Иньсөн-д жуу бичиг буулган, “Хоёр зүйлийн хэрэг⁴ гэгчийн дотроос нэгийг нь хэдийн дуусгажсүхуй. Гагцхүү Пархэ нь үе улиран /бидний/ дайсан атал, хариугаа авч чадаагүй тул хэрхэн амар тайван сууж чадах билээ.” хэмээн мэдэгджээ. Тэгээд Абаоцзи өөрийн хатан, хөвгүүн хун тайж [Елюй] Бэй, жанжсин Яогу нарын хамт Пархэ улсыг дайлаар мордов. Хятаны цэрэг мөн оны өвлийн илүү сүүл сард Гаолин Пархэ улсыг дайлаар мордов. Хятаны цэрэг мөн оны өвлийн илүү сүүл сард Гаолин даваанд хүрч, шөнө нь Пархэгийн Пүйө нү⁵-г бүслэн хаажээ. 926 оны хавар Пүйө хотыг эзлэн авав. Түүний дараа Пархэгийн Тонххён нү-г довтлон эзэлжээ.

Улмаар хунтайж Бэй, жанжсин Яогу (хожмын Ляо улсын хаан) нар Пархэгийн нийслэл Хухань хотыг⁶ бүслэн 3 хоногийн дараа тус улсын ванг буулган авчээ. Дараа өдөр нь Пархэгийн ван хотоос гарч ирж Хятаны хаанд дагаар оров. Түүний дараа Ляо улсын хаан шадар түшмэл Кан Мода нарын 13 хүнийг хотод оруулж, Пархэгийн цэргийн зэвсгийг хураалгах үед Пархэгийн харуулын цэргүүд тэднийг хороосон тул Пархэгийн ван дахин хотыг сахин хамгаалсан байна. Тиймээс Хятаны Сенечи нар дахин хотыг довтлон эвдсэний дараа Абаоцзи хотод орж, Пархэгийн ван хийгээд вангийн угсааныхныг цэргээр харгалзуулан хотоос авч оджээ.

Ийнхүү хятанчууд Пархэг онцын эсэргүүцэлгүйгээр буулган авч, тус улсын Зүүн Дань⁷ хэмээн нэрлээд, нийслэл Хухань хотын нэрийг Тяньфу хэмээн өөрчилжээ. Тэгээд хунтайж Бэй-г Рэнхуан ван өргөмжлөөд, Зүүн Дань улсын хаан болгожээ.

Абаоцзи Пархэгийн ван хийгээд вангийн угсааныхныг дагуулан буцах замдаа Линьхуан⁸-гийн баруун талд хот барьж, ванг тэнд суулгаад, ван хатан хоёрт

⁴ Хоёр зүйлийн хэрэг гэдэг нь нэгдүгээрт, Хятаны баруун талын эсэргүүцэл хүчийг зайлуулах, нөгөө нь Хятаны зүүн талын аюул учруулж буй Пархэг зайлуулах явдал байжээ. Энд хэдийн дуусгасан гэж буй хэрэг нь баруун талын этгээдийг зайлуулсныг хэлж байна.

⁵ Одоогийн Хятадын Гирийн мужийн Нунань хавийн бүс нутаг болно.

⁶ Хухань хот гэж Пархэгийн нийслэл Сангхён хотыг хэлж байна. Эдүгээгийн Хятадын Хар мөрөн мужийн Нинань сянь-ы Бохай чжэнь-д туурь нь бий.

⁷ Зүүн Дань улс нь зүүн зүгийн Хятан гэсэн утгатай.

⁸ Ляо улсын Дээд нийслэл Линьхуан фу-г байгуулсан агаад Ляо улсын нийслэлийг ийн хэлдэг. Одоогийн Өвөр Монголын Зуу удын чуулганы Баарин зүүн хошууны урд талд байх Бор балгас болбоос тухайн үеийн хотын туурь болно.

өөрийн унаж явсан хоёр морины нэрийг өгчээ. Ийнхүү Пархэ улс мөхсөн билээ., (Ц.Цэрэндорж, Эртний Монгол-Солонгосын харилцаа, 2020, хуудсд. 35-36)

Ц.Цэрэндоржийн судалгаанд Пархэгийн түүхэнд Хятан чухал байр суурьж эзэлж, томоохон үүрэг гүйцэтгэж байсныг хөнджээ.

2008 онд А.Очирын “Монгол ба Зүүн Азийн хэлхээ харилцаа (X-XI зуун) “Пархэ ба Зүүн Ази” хэмээх өгүүлэлд, мөн 2021 онд Л.Эрдэнэболдын “Хятан улс ба Дундад зууны үеийн Зүүн Азийн соёлын харилцаа” хэмээх өгүүлэлд тус тус Монголын нутаг дэвсгэрээс олдсон Хятан улсын дурсгалуудыг судалсан археологийн судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулжээ. Энэ судалгаанд Туул голын сав газраас Пархэ нар өөрсдийн ваар сав үйлдэх, зоорь хийх арга, тоглоом наадмын зүйлс, уран барилгын арга ухааныг монгол нутагт дэлгэрүүлж байсан олдвор илэрсэн байна. (Л.Эрдэнэболд, 2021, хуудсд. 99-120) Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Хятаны үед холбогдох Чин толгой, Эмгэнтийн хэрэм нь Пархэгийн үлдэгдэл иргэдийг Пархэ улс мөхсөний дараа хятанчууд энд шилжүүлэн суулгасны ул мөр үлдэж хоцорсон ажээ. (А.Очир, 2021, хуудсд. 117-118) Тухайлбал Чин толгой балгаснаас ваар савны бариул, хөлөгт тоглоомын морь, янз бүрийн ваарын хагархай, түүнчлэн халаалтын систем зэрэг пархэ маягийн дурсгал олджээ. Бас Эмгэнтийн хэрэм нь Хятаны эцэс үед байгуулагдсан агаад энэ хотын хэрмийг Пархэ маягийн арга барилаар барьсан болохыг тогтоожээ. Хоёр эгнээ өрсөн чулуун хананы шавар дэлдэх ийм арга бүхий дурсгал Монгол улсын нутаг дэвсгэрээс үүнээс өмнө олдож байгаагүй юм. (A.어치르L에르덴볼드, 2011, 페이지: 321-344) Эдгээр судалгааны явцад Пархэгийн соёлын нөлөө болон ваар хийх, зоорь болон уран барилга барих арга тактикийг харуулсан олдворуудыг олсон байдаг.

2021 онд Ч.Ундрах Юань улсын үед хятанчуудын түүхийг тэмдэглэн үлдээсэн сурвалж бичиг болох “Ляо улсын судар”-ыг монгол хэлнээ орчуулжээ. Энэхүү судрын “Уг тэмдэглэл”-д хаадын төр барьсан он жилүүдийн түүх, хаадын намтар, үйл явдлыг багтаан өгүүлсэн нийт гучин дэвтэр багтсан нь Хятанчуудын төр оршсон хугацааг бүрэн хамарч буй юм. (Тогтоочинсан, 2021, хууд. 12) Энхбатын “Монголын VI-IXовог аймгуудын түүх” судалгаа олж уншаагүй тул дараагийн судалгаандаа оруулах болно.

ДҮГНЭЛТ

Солонгос дахь Пархэгийн судалгаа нь XVIII зуунаас эхлэлтэй бөгөөд Юү Дыгтоны “Пархэгийн шинжлэл” хэмээх бүтээлээс улбаалан улам өргөжин гүнзгийрсэн байна. Тус бүтээл нь Пархэг Когүрйөгийн шууд залгамжлагч хэмээн үзэж, Солонгосын үндэстний түүхийн салшгүй хэсэг болгон авч үзсэн нь дараа дараагийн судлаачдад үзэл санааны үндэс болсон. XIX зууны түүхчид болон газарзүйчид Пархэгийн газар нутгийн хүрээ, соёл иргэншил, төрийн бүтэц зэрэг олон талаас нь судалгаа хийсэн нь тус улсын түүхийн ойлголтыг улам гүнзгийрүүлжээ.

XX зуунд Японы колончлолын улмаас Пархэгийн судалгаа удааширсан боловч 1980-аад оноос хойш эргэн сэргэж, Солонгос, Хятад, Орос улсуудын хамтарсан судалгаа, археологийн олдворуудад үндэслэн Пархэг олон талт өнцгөөс шинжлэх болсон. Судлаачид тус улсын түүх, улс төр, соёл, архитектур, олон улсын харилцаа зэрэг олон чиглэлээр өргөн хүрээнд судалгаа хийж, Солонгосын үндэстний түүх дэх Пархэгийн гүйцэтгэсэн үүрэг, соёлын нөлөөг дахин үнэлэх болсон байна.

Түүнчлэн, Солонгосын эрдэмтдийн судалгаанаас харахад Пархэ нь зөвхөн Когүрйөгийн үргэлжлэл төдийгүй дорно зүгийн олон улс хоорондын харилцаанд чухал байр суурь эзэлж байсныг нотолдог. Ялангуяа Хятан, Зүрчид зэрэг хөрш улсуудын харилцаа, сөргөлдөөн нь бүс нутгийн түүхэнд тодорхой ул мөр үлдээжээ. Энэ бүхнээс үзэхэд, Пархэ судлал нь зөвхөн нэг улсын түүхийн асуудал бус, Зүүн Хойд Азийн түүх, соёлын харилцааны томоохон салбар болох нь тодорхой байна.

Монгол дахь Пархэ судалгаа нь Монголын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан Хятан улс Пархэ улсын түүхтэй хэрхэн холбогдож байсныг түүхэн эх сурвалж, археологийн олдвор, судлаачдын бүтээлд тулгуурлан шинжлэн үзлээ. Судалгаанд Х.Пэрлээ, Ч.Далай, Б.Сумьяабаатар, Ц.Цэрэндорж, А.Очир, Л.Эрдэнэболд зэрэг эрдэмтдийн бүтээлд тулгуурлан Хятан-Пархэгийн харилцаа, Хятанчуудын Пархэ улсыг мөхөөсөн үйл явц, Пархэгийн соёлын Монголд үлдээсэн ул мөр, түүхэн гэрээ хэлэлцээрийн ач холбогдлыг тодотгон харуулсан юм.

Судалгаанаас харахад, Пархэ улсыг мөхөөсөн үйл явц нь зөвхөн нэг удаагийн цэргийн ажиллагаа бус, Хятаны олон жил төлөвлөсөн стратегийн үр дүн байсан бөгөөд улмаар Зүүн Дань хэмээх захиргааны нэгжийг байгуулж, соёл, архитектурын олон элемент Монголын нутагт нутагшсан нь археологийн олдворуудаар батлагдаж байна. Мөн Пархэгийн үлдэгдэл иргэдийг хятанчууд Монголын нутагт шилжүүлэн суурьшуулсан нь Чин толгой, Эмгэнтийн хэрмийн

дурсгалаар нотлогдож байна.

Түүнчлэн Чингис хааны үед Пархэг мөхөөсөн хятанчуудын үлдэгдэл хүчийг дарж, Солонгостой найрамдлын гэрээ байгуулсан нь тухайн үеийн гадаад бодлогын чухал жишээ болж, Хятаны түүхтэй шууд болон шууд бус хэлбэрээр холбогдсон түүхэн үзэгдэл юм.

Иймд Хятан-Пархэ-Монголын харилцаа нь Зүүн Азийн түүхэнд чухал нөлөө үзүүлсэн бөгөөд цаашдын судалгаанд түүхийн эх сурвалжийг нарийвчлан уншиж, түүхэн үнэнийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Ном:

- 1) Б.Сумьяабаатар. (1975). *Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал*. УБ хот: Шинжлэх ухааны Академий хэвлэл.
- 2) Г.Эрдэнэчимэг. (2006). *Солонгосын түүх тэргүүн дэвтэр*. УБ хот: Адмон.
- 3) Дыгтон, Ю. (2014). *Пархэгийн шинжлэл Ц.Цэрэндорж*. УБ хот: Мөнхийн үсэг.
- 4) Тогтоо чинсан. (2021). *Ляо улсын судар орчуулсан Д.Ундрах*. УБ хот: Соёмбо принтинг.
- 5) Х.Пэрлээ. (1959). *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдох нь*. УБ хот.
- 6) хүрээлэн, Ш.-ы. О. (2020). *Академич Чулууны Далайн бүтээлийн эмхэтгэл VIII 138-р тал*. УБ хот: Бэмби сан.
- 7) Ц.Цэрэндорж. (2020). *Эртний Монгол-Солонгосын харилцаа*. УБ хот: Мөнхийн үсэг.
- 8) Шинь Йёнбөм, Ч. П. (2015). *Солонгосын түүх Йё Пйөнмү, Д.Азаяа, Д.Алтанчимэг, З.Хэрлэн*. УБ хот.
- 9) 송기호. (2007). “동아시아역사 분쟁.” 서울: 송출판사.

Эрдэм шинжилгээний өгүүлэл:

- 1) А.어치르L에르텐볼드. (2011). 몽골국 내 발해 고고유적. “동북아시아역사는 총, 31호 동북아역사재단”, 321-344.
- 2) А.Очир. (2021). Монгол ба Зүүн Азийн хэлхээ харилцаа (X-XI зуун) // «Пархэ ба Зүүн Ази». *Зүүн Хойд Азийн Түүхийн сан*, 117-118.
- 3) Б.Лхагва. (1966). Монгол Солонгосын харилцааны уламжлалаас. *Сөүл*, 65-р тал.



- 4) Л.Эрдэнэболд. (2021). Хятан улс ба Дундад зууны үеийн Зүүн Азийн соёлын харилцаа. *Зүүн Хойд Азийн Түүхийн сан*, 117-118.
- 5) 김은국, 김진광권은주,. (2019). “해동성국, 고구려를 품은 발해.” 서울.
- 6) 김진광. (2009). 발해사 연구의 새로운 지평을 향해 . 일지사, 277-278.
- 7) 김종복. (2009). 발해사 연구의 새로운 지평을 향해 /발해 정치외교사/. 일지사, 278.
- 8) 한규철. (1982.2. 50쪽). 10-12 세기 발해유민 연구-거란-여진의 고려 내투 내왕을 중심으로. 서울: 고려대학교석사학위논문.

Цахим эх сурвалж:

- 3) 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0062539-ээс> Гаргасан
- 4) 한국민족대백과사전. (огноо байхгүй). 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0034316-ээс> Гаргасан
- 5) 한국민족대백과사전. (налза 정보 없음). “한국민족대백과사전”. 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0014282>에서 검색됨

Bibliography

- (n.d.). Retrieved from 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0062539>
- A.어치르L에르덴볼드. (2011). 몽골국 내 발해 고고유적. “동북아시아역사논총, 31호 동북아역사재단”, 321-344.
- A.Очир. (2021). Монгол ба Зүүн Азийн хэлхээ харилцаа (X-XI зуун) // «Пархэ ба Зүүн Ази». *Зүүн Хойд Азийн Түүхийн сан*, 117-118.
- Б.Лхагва. (1966). Монгол Солонгосын харилцааны уламжлалаас. *Сөүл*, 65-р тал.
- Б.Сумьяабаатар. (1975). *Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал*. УБ хот: Шинжлэх ухааны Академий хэвлэл.
- Г.Эрдэнэчимэг. (2006). *Солонгосын түүх тэргүүн дэвтэр*. УБ хот: Адмон.
- Дыггон, Ю. (2014). *Пархэгийн шинжлэл Ц.Цэрэндорж*. УБ хот: Мөнхийн үсэг.
- Дыггон, Ю. (2014). *Пархэгийн шинжлэл Ц.Цэрэндорж*. УБ хот: Мөнхийн үсэг.
- Л.Эрдэнэболд. (2021). Хятан улс ба Дундад зууны үеийн Зүүн Азийн соёлын харилцаа. *Зүүн Хойд Азийн Түүхийн сан*, 117-118.
- Тогтоочинсан. (2021). *Ляо улсын судар орчуулсан Д.Ундрах*. УБ хот: Соёмбо принтинг.
- Х.Пэрлээ. (1959). *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдох нь* . УБ хот.

- хүрээлэн, Ш.-ы. О. (2020). *Академич Чулууны Далайн бүтээлийн эмхэтгэл VIII 138-р тал*. УБ хот: Бэмби сан.
- Ц.Цэрэндорж. (2020). *Эртний Монгол-Солонгосын харилцаа*. УБ хот: Мөнхийн үсэг.
- Ц.Цэрэндорж. (2020). *Эртний Монгол-Солонгосын харилцаа*. УБ хот : Мөнхийн үсэг.
- Ц.Цэрэндорж. (2020). *Эртний Монгол-Солонгосын харилцаа*. УБ хот: Мөнхийн үсэг.
- Шинь Йөнбөм, Ч. П. (2015). *Солонгосын түүх Йө Пйөнмү, Д.Аззаяа, Д.Алтанчимэг, З.Хэрлэн*. УБ хот.
- 김은국김진광권은주, (2019). “해동성국, 고구려를 품은 발해.” 서울.
- 김종복. (2009). 발해사 연구의 새로운 지평을 향해 /발해 정치외교사/. 일지사, 278.
- 김진광. (2009). 발해사 연구의 새로운 지평을 향해 . 일지사, 277-278.
- 송기호. (2007). “동아시아역사 분쟁.” 서울: 송출판사.
- 한국민족대백과사전. (n.d.). Retrieved from 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0034316>
- 한국민족대백과사전. (날짜 정보 없음). “한국민족대백과사전”. 한국민족대백과사전: <https://encykorea.aks.ac.kr/Article/E0014282>에서 검색됨
- 한규철. (1982.2. 50쪽). 10-12 세기 발해유민 연구-거란-여진의 고려 내투 내왕을 중심으로. 서울: 고려대학교석사학위논문.

ХҮМҮҮНЛЭГ НИЙГМИЙН УХААН



А.МӨНХЖИН, Ө.БАЙГАЛЬ

Орчны ялгаатай байдлаас үүсэх сэтгэц
ассоцицийн онцлогт туршилт хийсэн
үр дүн



Ц.ЭНХТҮВШИН

Төрөөс залуучуудын талаарх баримтлах бодлого үйл
ажиллагаа, нийгмийн тулгамдсан зарим асуудлууд

ОРЧНЫ ЯЛГААТАЙ БАЙДЛААС ҮҮСЭХ СЭТГЭЦ АССОЦИОЦИЙН ОНЦЛОГТ ТУРШИЛТ ХИЙСЭН ҮР ДҮН

Магистр, А.Мөнхжин (ОУУБИС. ХНУС)

munkhjin.a@ulaanbaatar.edu.mn

Доктор, дэд профессор, Ө.Байгаль (ОУУБИС. ХНУС)

baigal.u@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үг: Сэтгэц, ассоциаци, нийлэмж, холбоос, зөвлөгөө

Keywords: psyche, association, free association, connection, counseling

Abstract:

This study aims to examine how different environmental conditions influence the outcomes of the psychological association test. A total of 32 voluntary participants were divided into two groups and placed in contrasting settings: one in a naturally lit, calming environment with soft music, and the other in a dark room illuminated by bright neon-blue lights accompanied by fast-paced electronic music. The experiment employed Carl Jung's Free Word Association Method to observe how participants' responses varied under differing environmental stimuli.

Findings revealed that the high-stimulus environment featuring electronic music and neon lighting evoked more emotionally intense and aggressive words, whereas the calming environment induced responses that were more positive, introspective, and emotionally balanced. Moreover, the simultaneous influence of three main stimuli—light, music, and trigger words—elicited associative responses from all participants, indicating that each element played a significant role in shaping psychological reactions. The results suggest that environmental variables can significantly affect the outcome of psychodiagnostic tools, underlining the importance of considering sensory context when conducting psychological assessments and therapeutic interventions.

Хураангуй:

Энэхүү судалгааны зорилго нь орчны ялгаатай байдал нь сэтгэц ассоциацийн (association) тестийн үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох явдал байв. Судалгаанд нийт 32 сайн дурын оролцогч хамрагдаж, тэднийг хоёр бүлэгт хуваан, байгалийн гэрэлтэй намуухан ая бүхий орчин болон тод цэнхэр неон гэрэлтэй, хурц хэмнэлтэй электро хөгжмийн орчинд хуваарилан туршилт хийжээ. Туршилтад К.



Юнгийн үгийн чөлөөт нийлэмжийн аргыг ашиглаж, орчны нөхцөл өөрчлөгдөх үед оролцогчдын өгсөн үгсийн агуулга, хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг ажигласан байна.

Судалгааны үр дүнгээс харахад электро хөгжмийн хурц орчин нь сэтгэл хөдлөлийн идэвхжил, түрэмгий шинжтэй үгсийг өдөөж байсан бол тайван орчин нь илүү эерэг, гүн ухааны, дотоод мэдрэмжтэй холбоотой хариу үгсийг идэвхжүүлж байв. Мөн гэрлийн байдал, хөгжмийн аяс, өдөөгч үгс гэсэн гурван хүчин зүйл зэрэг нөлөөлөх үед оролцогчид бүгдээс нь сэтгэцийн холбоо үүсгэж байгааг харуулсан. Судалгааны үр дүн нь орчны хүчин зүйлс сэтгэц оношилгооны аргуудын үр дүнд нөлөөлөх боломжтойг харуулж, сэтгэл зүйн зөвлөгөө, оношилгооны орчинг оновчтой зохион байгуулахад практик ач холбогдолтойг нотолж байна.

УДИРТГАЛ

Сэтгэл судлалын шинжлэх ухаан дэлхий дахинд хамгийн эрт үүссэн бөгөөд хамгийн залуу шинжлэх ухаан хэмээн тодорхойлогддог. Хамгийн анх эртний өрнө дахины философичид ухамсарыг сүнс хэмээн тодорхойлсноор хүний сэтгэцийн мөн чанар, түүний зүй тогтлыг хайж эхэлснээр сэтгэл судлалын суурь тавигдсан байдаг. Харин 1879 онд Германы эрдэмтэн В.М.Вундт сэтгэл судлалын анхны өөр өөрийгөө судлах зориулалттай /Интроспекци/ лабораторийг бий болгосноор орчин цагийн сэтгэл судлалын шинжлэх ухааны эхлэлийг тавьсан байдаг /Төрбурам, 2013/. Ийнхүү сэтгэл судлал хөгжин тэлсээр сэтгэл судлалын үйл ажиллагааны чиглэл нь судалгааны болон практик гэсэн хоёр үндсэн чиглэлд хуваагдах болсон. Сэтгэл судлалын судалгааны чиглэл нь сэтгэл судлалын онолын хэрэглээ, нийгэм сэтгэл зүйн өргөн хүрээний асуудлыг судалдаг бол практик салбар нь хувь хүн, нийгмийн бага бүлэг рүү чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээнд суурилсан байдаг. Практик сэтгэл судлаачийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд сэтгэц оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэц заслын нөлөөлөл, залруулан хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанууд багтаж байна /Сарантуяа, 2017/. Иймд практик сэтгэл судлаачид мэргэжлийн хэрэглэгдэхүүн, арга зүйн хүрээнд баталгаат чанар хангагдсан сэтгэц оношилгооны арга ашигладаг байх, зөвлөгөө заслын өндөр ур чадвартай байхыг шаарддаг. Тиймээс практик сэтгэл судлаачид олон улсад өргөн ашиглагдаж буй оношилгоо, зөвлөгөөний аргыг нутагшуулах, сэтгэц оношилгоо, зөвлөгөө засал явуулах үед үүсэх хөндлөгийн нөлөө, эффект зэргийг судалж, мэргэжлийн арга зүй, хэрэглэгдэхүүний хүрээнд гарч буй алдаа дутагдлыг засч сайжруулах сэтгэл зүйн үйл ажиллагааг явуулахад чухал нөлөөтэй. Сэтгэц

Сэтгэц ассоциаци гэдэг нь хүний аливаа сэтгэцийн хариу үйлдэл гадны ямар нэгэн цочроогчтой холбогдох процессийг хэлнэ. Хүн аливаа зүйлд хариу үйлдэл үзүүлэхдээ өөрийн амьдралын туршлага, танин мэдэхүйн онцлог, зан төлөвийн хэв шинжийн хүрээнд хариу үйлдэл үзүүлдэг. Сэтгэц ассоциацийн ойлголтыг сэтгэл судлалын онолууд өөр өөрсдийн чиглэлээр тайлбарладаг. Сэтгэл судлалын бихевиорист онолын төлөөлөгч Жон Уотсон /1878-1958/ хүний сэтгэц зан үйлийн холбоо хамаарлыг S-R гэх томъёогоор томъёолсон байдаг. S нь *stimul* буюу өдөөгч, R нь *response* буюу хариу үйлдэл юм. Бид аливаа цочроогчдод хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээс шалтгаалж бидний зан үйл тодорхойлогддог гэж тэрээр үзсэн юм /Мягмар, 2012/. Жон Уотсон хүний бүх л зан үйл, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлүүд нөхцөлт рефлексийн үр дүнд бүрэлддэг гэж тодорхойлсон. Энэхүү санаагаа батлахын тулд “Бяцхан Алберт хүү” хэмээх туршилтыг хийсэн. Энэхүү туршилтын хүрээнд 9 сартай Алберт хүүгийн урд цагаан өнгөтэй амьд туулай тавьсан бөгөөд хүү эхэндээ туулайнд хүрч, сонирхож байх үед туршилт хийж буй хүн ардаас нь алхны хүчтэй цохих чимээг сонсгох үед хүү гэнэт цочсон. Хүүг цагаан туулай руу ойртох сонирхох болгонд алхны хүчтэй цохих чимээг давталттай сонсгож байсан бөгөөд хожим Алберт хүү насаараа цагаан өнгийн үслэг хувцас, чихмэл харах болгондоо айж түгшдэг болсон байв. Алберт хүүгийн туршилтаар тэрээр Ямар нэгэн тааламжгүй цочроол, ямар нэгэн зүйлийг хүртэх, мэдрэх үетэй давхцах үед, тухайн хүртэж мэдэрч буй зүйл нь тухайн тааламжгүй цочроолтой холбогдож, хүртэж буй зүйлийг тааламжгүй болгон хүлээн авах үзэгдлийг нээсэн юм. Харин психоанализ онолыг үндэслэгч Зигмунд Фройд нь хүний сэтгэцийн ухамсарт бус, ухамсарын өмнөх, ухамсарт гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгт хувааж ухамсарт бус сэтгэгцэд хүний ханагдаагүй хэрэгцээ, сэтгэл зүйн гэмтэл, таагүй дурсамж зэрэг нь шахан зайлуулагдаж /репресс/ ухамсарт сэтгэгцэд илрэхдээ хувирах зарчмаар хүний зан үйл, сэтгэл хөдлөлийн мэдрэмжийг үүсгэдэг гэж тодорхойлсон байдаг /Энхтүшиг, 2019/. Хүний санамсаргүй хийсэн үйлдэл, хэлсэн үг бүхэн цаанаа учир шалтгаантай байдаг бөгөөд тэдгээр учир шалтгааныг олохын тулд ухамсарт бус сэтгэц руу нэвтрэх шаардлагатай гэж байдаг. Энэ хүрээнд Фройд 3 төрлийн заслын аргыг ашигладаг байсан бөгөөд үүнд нь ховсын арга, зүүдний анализ, чөлөөт нийлэмжийн аргууд багтана. Ховсын арга нь ухамсарт бус сэтгэц рүү нэвтрэх найдвартай арга ч эрсдэл өндөр, хэрэгжүүлэхэд төвөгтэй арга учир Фройд зүүдний анализ, чөлөөт нийлэмжийн аргыг ашиглаж хүний ухамсарт бус сэтгэц дэх ханагдаагүй хүсэл, таагүй мэдрэмжийг дам байдлаар судлах болсон /Бямбасүрэн, 2019/.


ОРЧНЫ ЯЛГААТАЙ БАЙДАЛД СЭТГЭЦ АССОЦИОЦ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэхүү судалгаанд нийт 32 хүн сайн дурын үндсэн дээр оролцсон бөгөөд туршилтын судалгааг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. Эхний шатанд оролцогчдыг санамсаргүй байдлаар хоёр бүлэгт хуваан, сэтгэл зүйн зөвлөгөөний өрөөг хоёр өөр орчинд тохижуулснаар орчны ялгааг үүсгэхийг зорьсон юм. Эхний тохижилтод зөвлөгөөний өрөөний бүх цонхыг хааж, тод цэнхэр неон гэрэл ашиглан хурц гэрэлтүүлэг үүсгэсэн бөгөөд электро буюу текно хөгжмийн хурдан хэмнэлтэй ая тоглуулсан. Харин дараагийн тохижилтод өрөөг байгалийн гэрэлтэй хэвийн орчинд оруулж, тайвшруулах зориулалттай намуухан ая эгшиглүүлсэн. Эдгээр хоёр өөр орчны нөхцөлд сэтгэцийн ассоциацийн тестийг ижил өдөөгч үгсээр авч, дараах байдлаар туршилтыг гүйцэтгэсэн болно:

1-р бүлэг: Эхлээд оролцогчдыг байгалийн гэрэлтэй, тайвшруулах ая бүхий орчинд 2 минут байршуулсны дараа сэтгэцийн ассоциацийн тестийг авч, дараа нь өрөөг харанхуй, тод цэнхэр гэрэлтэй болгож, хурц хэмнэлтэй электро ая 2 минут сонсгосны дараа дахин ижил тестийг авсан.

2-р бүлэг: Эсрэг дараалалтайгаар туршилтыг явуулсан. Эхлээд оролцогчдыг тод цэнхэр гэрэлтэй, электро хөгжимтэй орчинд 2 минут байршуулсны дараа тестийг авч, дараа нь байгалийн гэрэл, намуухан ая бүхий тайван орчинд 2 минут байлгаж, тестийг дахин авсан.

Хоёр бүлэгт ажиглагдсан хамгийн их үгс \давтамжтай тоогоор



Хоёр бүлгийн насны онцлогоос илэрсэн ялгаа

1-р бүлэг	2-р бүлэг
1-р бүлэгт насны онцлогоос хамаарч оролцогчдын үгийн нийлэмж харьцангуй ялгаатай байсан. Үүнд 18-19 настай оролцогчдын тайвшруулах аяны нийлэмж илүү нэр үг орсон /ээж, аав, би, ах, гэр г.м/, Харин 20-25 насныханд дээр дурдсанчлан дотоод мэдрэмжийг илэрхийлэх үг байхаас гадна санхүү, мөнгө, мөнгө дэвсгэрт гэсэн үгнүүд давхцаж, үйл хөдлөл буюу идэвхтэй хөдөлгөөнийг илэрхийлэх үгнүүд тусгагдсан байна.	2-р бүлгийн судалгаанд хамрагдсан хүмүүсийг насаар нь ажиглаад харвал 17-18 насныхан электро аяны үед илүү эрч хүчтэй, сэтгэл хөдлөлтэй хариу үйлдэл өгсөн бол 20-25 насныхан тайвшруулах аяны үед илүү төлөвшсөн, гүнзгий сэтгэцийн хариуг илэрхийлжээ.

Хоёр бүлгийн чөлөөт нийлэмж ялгаа

1-р бүлэг	2-р бүлэг
Тайвшруулах аяыг эхэлж сонссон бүлэгт байгаль, орчин, амьтны талаар нэр, тэмдэгт төлөөний үгнүүдийг буюу /нуур, өвс, далай, мод байшин, далай огторгуй, ертөнц, сар, санхүү, ус г.м/ ажиглагдсан бөгөөд мөн дотоод мэдрэмжүүдэд, нийгмийн харилцааны талаарх үгнүүд мөн ажиглагдсан /итгэл найдвар, гэрэл, мөрөөдөл, инээд, ганцаардал, амжилт, хүч г.м/. Мөн тайвшруулах аяыг эхэлж сонссон бүлгийн чөлөөт нийлэмжийн тест дээрээ сэтгэл хөдлөл, мэдрэмж, ирээдүйд чиглэсэн үгнүүд ашигласан бол үүний дараа электро аяыг сонсоход үгнүүд ямар нэг байдлаар дэс дараалал солигдох, давхцах, мөн өмнөх нэр үгнүүд үйл хөдлөлийг илэрхийлэх идэвхтэй үг болсон нь аяны нөлөө тодорхой хэмжээнд байн гэж үзэж байна.	Электро аяыг эхэлж сонссон хүмүүсийн сэтгэл зүйн идэвхжил, хүчтэй мэдрэмжүүдийг \зовлон, гуниглал, уйлах, харанхуй...г.м\ илүү өдөөж байхад, тайвшруулах ая сонссоны дараа илүү намдуу, уян зөөлөн, гүн ухааны, дотоод мэдрэмжтэй холбоотой үгсийг \инээмсэглэл, нөхөрлөл, баяр, тэврэлт...г.м\ өдөөж байгаа хэдий ч мөн л электро ая дээр ажиглагдсан үгс тодорхой хэмжээнд байсаар байна. Энэ нь хөгжим, дуу авиа нь хүний сэтгэхүй, дотоод мэдрэмжид хэрхэн нөлөөлдгийн нэг илрэл гэж дүгнэж болно.



Хоёр бүлгийн онцлох өдөөгч үгэнд хариулсан үгс:

№	Үгс	1-р бүлэг	2-р бүлэг
1	Дайн, тулаан, буу, сэлэм, хутга, зэвсэг	10	23
2	Тэмцээн, өрсөлдөөн, өрсөлдөх, ялалт, ял, ялах, шагнал, хүч, хүчтэй	21	38

Энэ хүснэгтээс харвал эдгээр хоёр үгс нь түрэмгийллийн болон тэмцлийн шинжтэй үгс байх бөгөөд хоёр бүлгийнхэнд аль алинд нь ялгаагүй байх боловч 2-р бүлэг буюу электро аяыг эхэлж сонссон бүлгийнхэнд дээрх үгс илүү олноор ажиглагдаж байгаа нь электро аягийг түрүүлж сонсох нь илүү хүчтэй өдөөгч болж өгч байгааг харж болохоор байна.

Электро аяыг цэнхэр неон гэрэлд, харин тайвшруулах аяыг байгалийн гэрэлд сонгосон бөгөөд үүнд тайвшруулах аяыг эхэлж сонссон 1-р бүлгийнхэнд, чөлөөт нийлэмжид нь ямар нэгэн байдлаар гэрлийн талаарх үгс 3 хүн дээр 7 удаагийн давтамжтайгаар илэрсэн бол, электро аяыг эхэлж сонгосон 2-р бүлгийн нийт 16 хүний 8 хүн нь 15 удаагийн давтамжтайгаар чөлөөт нийлэмжийн тест дээрээ “гэрэл” болон “гэгээ” гэх үгийг давтамжтайгаар бичсэн байгаа нь неон гэрэл тусган электро аяыг эхэнд сонгох нь судалгаанд хамрагдсан хүмүүст байгалийн гэрэл тусган тайвшруулах аяыг эхэнд сонгосноос илүү нөлөө үзүүлж байгаа нь ажиглагдаж байна.

Үүнээс гадна өдөөгч үгс нь судалгаанд хамрагдсан хүн бүрийн чөлөөт нийлэмжийн тестэд ихээр нөлөөлсөн бөгөөд электро болон тайвшруулах аянаас гадна нэлээд хүчтэй ассоциаци үзүүлж байгаа нь харагдана. Энэ нь нэг талаараа электро болон тайвшруулах аяны дараа судалгаанд хамрагдсан хүмүүс бичихдээ өдөөгч үгс болон түүнтэй төстэй үгсийг электро болон тайвшруулах аяны чөлөөт нийлэмж дээр давтамжтай болоод үгийн байрлал адил бичигдсэн байгаа нь хоёр нийлэмжийн тестийн хугацаа богино байсантай холбоотой гэж дүгнэж байгаа бөгөөд нөгөө талаараа судалгааг учир дутагдалтай болгож болох юм.

ДҮГНЭЛТ

Энэ бүхнийг дүгнээд үзвэл судалгааг явуулахад “ая”, “гэрэл”, “өдөөгч үгс” гэх ерөнхий гурван өдөөгчийг судалгаанд хамрагдсан хүмүүст өгсөн бөгөөд энэ бүгдэд оролцогчид идэхтэй хариу үйлдэл үзүүлж байгааг харж болно. Хамгийн сонирхолтой богино хугацаанд гурван өдөөгчийг зэрэг өгч чөлөөт нийлэмжийн тестийн судалгааг явуулахад дийлэнх оролцогчид тодорхой хэмжээгээр гурван өдөөгчид гурвууланд ассоциаци хариу үйлдэл өгч байна. Тухайн гурван өдөөгчөөс хамгийн хүчтэй ассоциаци үзүүлсэн нь “өдөөгч үгс” байсан бөгөөд бүх судалгаанд оролцогчдын чөлөөт нийлэмжийн тест дээр өдөөгч үгс болон түүнтэй болбоотой үгсийг бичсэн байгаа нь ажиглагдсан. Тиймээс орчны ялгаатай байдал нь хүмүүсийн ялгаатай хариу үйлдэл үзүүлэхэд нөлөөлдөг болохыг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Сарануяа, Г. (2017). Сэтгэц оношилгоо. УБ
2. Төрбурам, Л. (2013). Сэтгэл судлалын түүхийн жимээр. УБ
3. Энхтүшиг, Л. (2019). Психоанализ. УБ
4. Мягмар, О. (2012). Бие хүний сэтгэл зүйн лекцүүд. УБ
5. Бямбасүрэн, С. (2019). Сэтгэцийн эмгэг судлал. УБ

ТӨРӨӨС ЗАЛУУЧУУДЫН ТАЛААРХ БАРИМТЛАХ БОДЛОГО ҮЙЛ АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДЛУУД

Магистр Ц.Энхтүвшин

(ОУУБИС. ХНУС)

enkhtuvshin.ts@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үг: бодлого хөтөлбөр, тулгамдсан асуудлууд, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт

Хураангуй:

Улс орны хөгжлийн хөдөлгөгч хүч нь өсвөр үе, залуучууд байдаг. Мөн улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл бэрхшээл нь нийгмийн бүлгүүд тэр дундаа залуучуудад хүндхэн сорилт болдог байна. Тиймээс төрөөс залуучуудын хөгжлийг, тулгамдсан суурь асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хөгжилд идэвхтэй оролцуулахын тулд төрөөс бодлого үйл ажиллагааг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага гардаг.

Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого үйл ажиллагааны зорилго, агуулга, гарч буй үр нөлөө, үр дүнд шинжилгээ хийж залуучуудын нийгмийн байдал, тулгамдаж буй асуудалтай харьцуулан судлах хэрэгцээ шаардлага гарч байна. Залуучуудын талаарх сүүлийн 10 жилийн бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн үндсэн зорилго, агуулга нь эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залуучуудын оролцоо, хөгжил гэсэн чиглэл зонхилж иржээ.

Abstract

The main force of a country's development is its youth. The country's socio-economic difficulties pose a severe challenge to social groups, especially youth. Therefore, the government needs to implement policies and activities to address the development of youth, solve the basic problems facing them, and actively participate in social development.

There is a need to analyze the goals, content, effects, and results of the government's youth policies and activities and compare them with the social situation of young people.

The main goals and content of policy documents and national programs on youth in the last 10 years have been health, education, employment, youth participation, and development.

ҮНДЭСЛЭЛ

Аливаа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын гол зорилго нь ард иргэд, хүн амын сайн сайхан байдлыг бэхжүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг бий болгоход чиглэгдэж байдаг. Нийгэм, эдийн засгийн хөгжилд тухайн улсын хүн амд эзлэх залуучууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн улс орнууд залуучуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, тэдний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэхэд төр, иргэний нийгмийн зүгээс тусгайлан бодлого, хөтөлбөр боловсруулж анхаарч ажилладаг.

Манай улсын хувьд хүн амын 3/1 өсвөр үе залуучууд эзлэж байгаа бөгөөд цаашид ч энэ үзүүлэлт ирэх 30 жилд тогтмол хадгалагдахаар байгаа юм. Хүн амын бүтцийн таатай үе тохиож буй энэ хугацаанд нийгэм улс орны хөгжлийн хурдасгах, ард иргэдийн өмнө тулгамдаж буй томоохон асуудлыг доривтой шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Монгол улс 1990 оноос өмнөх социалист, төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед улс орны хөгжилд залуусын оролцоо, хүчийг оновчтой ашиглаж зөв бодлого, үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж залуусад тулгамдаж буй асуудлыг давхар шийдвэрлэж ирсэн арвин туршлагатай.

Зах зээл, шилжилтийн үеэс эхлэж нийгмийн суурь дэд бүтэц сулрах, улс төрийн тогтолцооны хямрал зэргээс шалтгаалж шинэ сорилт, бэрхшээлүүд үүсэж, нийгмийн бүлгүүдэд олон талт асуудлыг дагуулах болсон байдаг.

Түүний үр дагавар нь одоо ч нийгмийн суурь үзүүлэлт болох эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орчны аюулгүй байдал зэрэг нь хүн амын залуу бүлэгт тулгамдсан асуудал хэвээр байгаа нь суурь судалгаануудаар нотлогдож байгаа билээ.

Тиймээс залуучуудад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хууль эрхзүйн баримт бичиг, томоохон хөтөлбөрүүдийн тавьсан зорилт, хэрэгжилт зэрэгт анализ шинжилгээ хийх шаардлага гарч байна.

Судалгааны зорилго

Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрөөс баримтлаж буй бодлого, эрхзүйн баримт бичиг, хөтөлбөр үйл ажиллагаанд агуулгын шинжилгээ хийж зөвлөмж боловсруулах.

Зорилт

- 1990 оноос хойш өсвөр үе залуучуудын талаар баримтласан бодлогын баримт бичгүүдийн агуулгыг судлах
- Залуучуудад тулгамдаж буй эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн талаарх тоон мэдээлэл, нөхцөл байдлыг судлах
- Бодлогын баримт бичгүүдийн шинжилгээг үндэслэж зөвлөмж, дүгнэлт боловсруулах

Судлагдсан байдал

Монголын өсвөр, үе залуучуудын нийгмийн хэрэгцээ, төлөв хандлага, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, ёс суртахуун, нийгэм улс төрийн оролцоо зэрэг сэдвүүдээр суурь судалгааны материалуудыг сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны төвүүд эрчимтэй хийх болжээ. Залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны талаар судалгааны хувьд доктор С.Мөнхбат, докторант Б.Бат-Эрдэнэ нар “Залуучуудын талаар баримтлах төрийн бодлогод хийсэн бодлогын шинжилгээ” (2015) сэдэвт судалгааны ажилдаа залуучуудын орлого, амьжиргааны эх үүсвэр /шилжилтийн үеийн “архаг ядуурал”/, залуучуудын хөдөлмөр эрхлэлт /хөдөлмөр эрхлээгүй хүн амын 60-70 хувь нь залуучууд/, залуучуудын сууцны төрөл /10 залуу тутмын 1 нь түрээс, түр сууцанд/ зэрэг тулгамдсан асуудлыг хөндөж залуучуудын талаарх авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ болон бодит нөхцөл байдлыг харьцуулсан судалгааг хийсэн байна.

Судалгааны арга зүй

Баримт бичгийн анализ агуулгын шинжилгээ (content analysis), харьцуулсан шинжилгээ (comparative analysis) зэрэг аргачлалыг ашиглав.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол улс 20-р зууны дунд үеэс эдийн засаг, нийгмийн хөгжил, аж үйлдвэржилт, хотжилт, дэд бүтэц, нийгмийн тогтолцоо, соёлын хувьд үсрэнгүй ахиц дэвшил гарахад залуучуудын оролцоо өндөр байжээ. 1990 оноос өмнө Монгол Улс социалист системийн бусад орнуудын нэгэн адил залуучууд коммунист үзэл суртлаар хүмүүжиж, социалист нийгэм дэх ажилчин, малчин, сэхээтэн ангийн залгамж халаа, үйлдвэрлэх хүчний нөөцийн түүчээ, гол сэлбэх хүчин болж байлаа

Монгол улсын хүн ам 2023 оны байдлаар 3 сая 504.7 мянга байгаагаас 68.4 % нь хот суурин газар, 31.5% нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод нийт

хүн амын 49.5% нь харъяалагдаж байгаа бол хүйсийн хувьд 49% нь эрэгтэйчүүд, 51.0% нь эмэгтэйчүүд, насны бүтцээр 15 хүртлэх насны хүүхэд 31.6% ийг, 15-34 насны хүн ам 29% ийг, 35-64 насны хүн ам 33 % ийг, 65 дээш насны хүн ам 5.0% ийг эзлэж байгаа бөгөөд дийлэнх нь хүүхэд өсвөр үе, залуучууд эзлэж байна.

Хүснэгт 1.1 Хүн амын насны бүтэц дэхь залуучуудын эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн зарим үзүүлэлт өнгөрсөн, одоо, хэтийн төлөв /15-34 насныхан/

	Тоогоор	Хувиар	Хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх %	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүй иргэд	Бусад тайлбар
1997	843.900	37%	-	-	-	1991-2005 онд төрөлт хамгийн бага үе тохисон / жилд дунджаар 45-50 мянга/
2000	-	29.5%	-	-	-	-
2004		39.5%	-	-	-	-
2010	926.523	38.9%	-	-	-	-
2012	-	33,8%	-	-	-	-
2014	-	-	-	-	56,320	-
2015	-	-	-	-	52,748	-
2016	-	-	-	-	74,733	-
2017	-	34.6%	50%	-	-	-
2018	1072071	33.7%	46.5%	-	-	-
2019		32,8%	-	-	-	-
2020	1,030,709	31,7%	49.2%	-	-	15-29 насны залуусын 41.2% нь хөдөлмөр эрхлэж байна
2021	-	30,7%	-	-	-	-
2022	1.012.167	29.2%	-	-	-	Нийт ажиллах хүчний оролцоо түвшин 58.6%
2023	1.011.958	29%	42.2%	47.7%	-	УБ хот -445.819 47% Орон нутаг-507.829 53% амьдарч байна
2025	-	-	-	-	-	-
2030	1.048.665	27.1%	-	-	-	-

2035	1.210.665	29.1%	-	-	-	Хүн амын 73% нь уг бүлгийн хөдөлмөрийн насны хүн ам эзлэхээр байна
2040	1.386.013	30.8%	-	-	-	-
2045	1.494.301	30.5%	-	-	-	-

Шилжилтийн хүндрэл бэрхшээл, сорилтын он жилүүдээс хойш төрөөс залуучуудын бодлогын орчныг бий болгож, түүнд хамаарах бодлогын баримт бичгүүд болон хөтөлбөрүүдийг батлан гаргаж, хэрэгжүүлж ирсэн байна.

Шилжилтийн зааг үе болох 1991 онд “Төрөөс хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргасан бол шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш анх удаа 1998 онд МУЗГ-аас “Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр” буюу зургаан жилийн хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийг боловсруулан баталжээ.

Хүснэгт 2.1 Төрөөс хэрэгжүүлсэн бодлого, эрхзүйн баримт бичиг, томоохон хөтөлбөрүүд

Бодлого, хөтөлбөр, эрхзүйн орчин	Он	Зорилго, агуулга
Төрөөс хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлого	1991.VI	Өсвөр, залуу үеэ эрүүл чийрэг өсгөн бойжуулж, эрдэм боловсрол эзэмшүүлэх, эх орноо хөгжүүлэх чин эрмэлзэл, үндэсний эв нэгдэл, хүнлэг энэрэнгүй үзлээр хүмүүжүүлж, монгол зан заншил үндэсний уламжлалыг өвлүүлэх, бие дааж аж төрөх нөхцөлийг хангах, XXI зууны босгоор дэлхийн соёл иргэншилтэй хөл нийлүүлэн алхан орох нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн баталгаа бий болгоход төрийн бодлого чиглэнэ.

Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр	1998-2005	Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр» нь дараахь бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд 1/ Залуучууд ба боловсрол, мэдээлэл, оюутан залуучуудын асуудал 2/Залуучууд ба хөдөлмөр эрхлэлт 3/Залуучууд ба чөлөөт цаг 4/ Залуу гэр бүл, залуучуудын эрүүл мэнд 5/Хөдөөгийн залуучуудын нийгэм, соёлын асуудал 6/Залуучууд ба эх орон, хүрээлэн байгаа орчин 7/ Залуучууд ба олон улсын залуучуудын хөдөлгөөн. МУ засгийн газраас 1998 оныг “Залуучуудын жил” 2002 оныг “Оюутны жил”
Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2006-2015	Залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх
Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	2017.5 сар	7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна: 7.1.1.хувь хүний хөгжил; 7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; 7.1.3.эрүүл мэнд 7.1.4.хөдөлмөр эрхлэлт; 7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин.
Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр	2019.5 сар	Залуучуудын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх замаар эх оронч үзэлтэй, тусгаар тогтнол, түүх, хэл, өв соёлоороо бахархдаг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг өрсөлдөх чадвартай иргэн болоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.



Залуучуудын хөгжлийг дэмжих стратеги 2025-2030	2024	Монголын залуучуудын боловсрол, хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлт, орон сууц, эрүүл мэнд, амьдралын хэв маягт амжилт гаргахыг дэмжин, өсөлт хөгжлийг хурдасгаж, соёлын өвийг хадгалах, хүртээмжтэй тогтвортой орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. 6 зорилго, 18 зорилт, 104 арга хэмжээ Чанартай, хүртээмжтэй боловсрол, Хөдөлмөр эрхлэлт ба боломж Эрүүл мэнд ба зөв дадал, Эрүүл аюулгүй, ая тухай амьдрах, хөгжих орчин Улс төр ба нийгмийн оролцоо дэлхийн монгол залуучууд эх орондоо МУ засгийн газраас “Залуучуудын жил-2025” болгон зарласан
--	------	--

Залуучуудын талаарх сүүлийн 10 жилийн бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн үндсэн зорилго, агуулга нь эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залуучуудын оролцоо, хөгжил гэсэн чиглэл зонхилж иржээ. Үүнээс харахад бодлогын баримт бичгүүд нь он цагийн хувьд харьцангуй тогтвортой, залгамж шинжээ хадгалж ирсэн давуу талтай байна. Гэвч бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дагалдах журам, хэрэгжүүлэх тогтолцоо, хөтөлбөрийн үр дүн, үнэлгээ хийх зэрэгтэй холбогдох арга хэмжээ хангалтгүй түвшинд байгаа юм.

Монгол улсын засгийн газраас залуучуудын нийгмийн оролцоо, тулгамдсан асуудлын талаарх үндэсний хэд хэдэн чуулга уулзалтуудыг зохион байгуулсан байна.

Хүснэгт 2.2 Залуучуудын хөгжил, тулгамдсан асуудлын талаарх үндэсний хэмжээний чуулга уулзалтууд /2013-2023/

Үндэсний хэмжээний болон ОУ чуулга уулзалтууд	Тулгамдсан асуудал, хэлэлцүүлгийн агуулга	Дэвшүүлсэн зорилтууд
Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого, зорилт үндэсний чуулган 2013.5 сар	-	Залуучуудын хөгжлийн талаар баримтлах шинэчлэлийн бодлого, зорилтуудыг тэдний оролцоотойгоор тодорхойлох зор

“Тогтвортой хөгжил залуучуудын оролцоо” үндэсний чуулга уулзалт 2017.XII сар Ерөнхий сайд У.Хүрэлсүх	-Залуучуудын 3/1 ямар нэг хорт зуршилтай, өвчлөл нэмэгдсэн -Хөдөлмөр эрхлэх боломж хаалттай Залуучуудын 50% хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Залуу гэр бүлийн 60 хувь нь эцэг эхтэй хамт амьдарч байна -Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөрийг танилцуулах төслийн санал авах -Тогтвортой хөгжлийн 17 зорилт ба залуучуудын оролцоо	1.2020 он гэхэд эрүүл мэнд, өвчлөлийн төрөл бүрийг бууруулах чиглэл болгосон 2 . Х ө д ө л м ө р э р х л э л т и й г н э м э г д ү ү л э х чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах
“Залуучуудын хөгжил-оролцоо” үндэсний чуулган 2015.V сар Ерөнхий сайд. Ч.Сайханбилэг	“Залуучуудын хөгжлийг дэмжих жил-2015” • Залуучуудын хөдөлмөрлөх зөв зан үйлийг хэвшүүлэх, амьдрах ухааны мэдлэг олгох, хөгжих таатай орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүх түвшний бодлого үйл ажиллагааг чиглүүлэх	-
Хүчээ нэгтгэ-Залуучуудын манлайлал үндэсний чуулган 2019.VII сар Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд хувь хүний хөгжил, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжил, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн үндсэн 5 чиглэлээр залуучуудын хөгжлийг дэмжих	З а л у у ч у у д ы н хөгжлийг дэмжих үндэсний тогтолцоог бэхжүүлэх Залуучуудын асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг байгуулах, Аймаг дүүрэг бүрт хөгжлийн төвтэй болох Залуучуудын үндэсний зөвлөл, орон нутагт аймаг, сумын Засаг даргаар ахлуулах



Залуучуудын хөгжлийн үндэсний чуулган-2021 2021.08.25 цахим Монголын Залуучуудын байгууллагын 100 жил Е сайд Л.Оюун-Эрдэнэ	Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоо, сайн дурын ажил, эрүүл аюулгүй хөгжих, орчныг бүрдүүлэх, орон сууцаар хангах зэрэг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих олон талт арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, сорил, бэрхшээл	-
Залуучуудын хөгжлийн үндэсний 9 дүгээр чуулган 2023.8 сар Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хэлэлцэх; - Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх; - Залуучуудын хөгжлийн талаар 2027 он хүртэлх тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны санал хэлэлцэх; - Залуучуудын ардчилсан, иргэний орон зайг тэлэх сайн туршлага түгээх.	- Ногоон хөгжил, ногоон ажлын байр, ур чадвар, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор залуучуудын эдийн засаг, нийгмийн байдлыг сайжруулахад тэдний оролцоог тодорхойлох; - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх;

Сүүлийн арван жилд төрөөс залуучуудын тулгамдсан асуудлын талаарх үндэсний уулзалт хэлэлцүүлгийг 2 жил тутамд явуулжээ. Чуулга уулзалтуудын үндсэн агуулга нь залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа болон тогтолцоог бэхжүүлэх, залуучуудын эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог сайжруулах зорилт дэвшүүлж хэлэлцүүлэгэ өрнүүлжээ.

Хүснэгт 2.3 Хэрэгжүүлэгч тогтолцоо, зарим төсөл хөтөлбөрүүд /2014-2023/

Үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд	Хэрэгжүүлэн он	Үйл ажиллагааны агуулга
----------------------------------	----------------	-------------------------

Залуучуудын хөгжлийн төв	2014 оноос	Залуучуудын хөгжлийн дэмжих, зорилтод бүлэг болон нийт залуучуудад чиглэсэн хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах 11 аймаг 3 дүүрэг 2 сум Хэрэгжүүлэгч байгууллага: ХНХЯ, НҮБ хүн амын сан, 2018 оны байдлаар нийт залуучуудын 42% нь хандаж үйлчилгээ авсан Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны дүрэм 2018.01.16
Өсвөр үе залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага	2023.06.30	Стандарт хэмжил зүйн газар. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй /өмчийн бүх хэлбэрийн/ өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаа хамаарна
Залуучуудын гарааны бизнес хөтөлбөр “Старт апп”	2016-2018	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрхүйн орчин, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, Старт апп гарааны бизнес дэмжих , Эргэн төлөх нөхцөлтэй /10 сая хүртэл/
Залуучуудын үндэсний зөвлөл	2018.01.03 Монгол улсын ерөнхий сайдын захирамж	Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2018.01.03 өдрийн Монгол улсын ерөнхий сайдын захирамжаар баталсан байна.
Залуучуудын хөгжлийн зөвлөл	МУ ерөнхий сайдын 2021 оны 01 тогтоол	Улсын болон орон нутгийн бүх шатны байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагуудад залуучуудын сайн дурын үүсэл, санаачлагаар нэгдсэн Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулах шийдвэр гаргаж 21 аймаг,8 дүүрэг, 56 сум, 124 хороо, Төрийн захиргааны байгууллагын дэргэд 78, аж ахуйн нэгжүүдэд 133, сонирхолын 3, нийт 436 зөвлөлд 7000 гаруй залуучууд ажиллаж байна /2024 оны байдлаар/



Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2021.02.09	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, ажилд дадлагажуулан зуучлах цогц үйлчилгээг туршин нэвтрүүлэх болон аж ахуйн эрхлэх бүтээлч, шинэлэг санал, санаачлагыг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино
--	------------	---

Залуучуудад тулгамдаж буй нийтлэг асуудлуудад эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэмт хэрэг, ёс суртахуун төлөвшил, нийгэм соёлын асуудлууд зонхилсон хэвээр байгаа нь суурь судалгаанаас харагдаж байна (ЮНИСКО, 2022, хууд. 17). Мөн сүүлийн үеийн судалгаанд залуучуудын амьдралын буруу дадал зуршил, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд болох сэтгэл гутрал, хорт зуршлын хэрэглээ болон өсвөр үе залуучуудын дундах амиа хорлолт буурахгүй байна.

Амиа хорлож нас барсан тохиолдлын тоо 2023 онд 498 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 24 нэмэгджээ. Үүнээс 20-24 насны залуучуудын /нийт нас баралт 175 тохиолдол/ 27,4 % нь буюу 4 хүн тутмын 1, 25-29 насны залуучуудын 20.6% нь буюу 5 хүн тутмын 1, 15-19 насныханы 23.6% буюу 4 хүн тутмын 1 нь амиа хорлон нас барсан байна (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2023, хууд. 42).

Залуучуудын боловсролын хувьд мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд 40,906 суралцагч суралцаж байгаагаас 29,248 буюу 71,5 хувь нь төрийн өмчийн, 11,658 буюу 28,5 хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна. (Боловсролын салбарын статистик 2024-2025, 2025, хууд. 92)

Сүүлийн 5 жилийн статистик мэдээлэлийн дундажаас дүгнэхэд мэргэжлийн боловсролын салбарт жил бүр ойролцоогоор 40-45 мянган залуучууд суралцаж байгаа бол хүйсийн хувьд дунджаар 25 мянга орчим нь эрэгтэй, 15 мянга орчим нь эмэгтэйчүүд эзлэж байна.

2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын 65 байгууллагад нийт 150828 оюутан, суралцагчид байгаагаас 2,620 буюу 1.7% нь диплом, 117,344 буюу 78.1% нь бакалвр, 24,830 буюу 16.1% нь магистр, 5,488 буюу 3.7% нь докторын хөтөлбөрийн сургалтанд хамрагдаж байна.

Сүүлийн 5 жилийн статистик мэдээллийн дундажаас үзэхэд дээд боловсролын сургалтанд жил бүр ойролцоогоор 145-150 мянган оюутанууд суралцаж байгаа бол шинээр элсэгчдын хувьд тухайн жилийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөөс хамаарч дунджаар 22-30 мянган гэсэн үзүүлэлтэй байна. Төгсөгчдийн

хувьд сүүлийн 3 жилийн дундажаар жилд 27 мянган суралцагч төгсөж байгаагаас дунджаар 63.4% нь эмэгтэй 35.6% нь эрэгтэй төгсөгчид эзлэж (Боловсролын салбарын статистик 2024-2025, 2025, хууд. 121) байгаа нь хүйсийн хувьд тэнцвэргүй үзүүлэлт юм.

Ажиллах хүчний судалгааны 2024 оны 3-р улирлын байдлаар ажилгүй иргэдийн тоо 88.1 мянган хүн байгааг насны бүлгээр авч үзвэл 21.2 мянга /24.1%/ нь 15-24 насны, 24.8 мянга нь /28.1%/ нь 25-34 насны, 22.0 мянга /25.0%/ нь 35-44 насны, 13.4% нь /15.2%/ нь 45-54 насны, 6.7 мянга /7.6%/ нь 55 ба түүнээс дээш насны хүн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15-24 насны ажилгүй иргэдийн тоо 5.4 мянгаар нэмэгдсэн үзүүлэлт гарч байгаа нь анхаарах асуудал болжээ.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хувьд 2024 оны байдлаар 44,5 хувь нь дотоодын ажиллах хүчийг бүрдүүлж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн салбарын 29,8 хувийг, уул уурхайн салбарын 45,2 хувийг нь, барилгын салбарын 44,6 хувийг, харилцаа холбооны салбарын 60,9 хувийг, боловсролын салбарын 34,2 хувийг, эрүүл мэнд, нийгмийн салбарын 40,1 хувийг тус тус 34 хүртэлх насны залуучууд эзэлж байна. Салбар бүрт ажиллаж, хөдөлмөрлөж буй залуу мэргэжилтэн, албан хаагчдыг дэмжих тусгайлсан бодлого, үйл ажиллагаа дутмаг байдаг учраас тухайн ажлын байран дээр хөгжих, дэвших боломж хязгаарлагдмал байхын зэрэгцээ бусад салбартай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулдаггүй сул талтай байна.

Монгол улсын хувьд тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах үйл явцыг хурдасгахад залуучуудын хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадвартай ажлын болгож бэлтгэх хөрөнгө оруулалт хийх нь чухал юм.

Залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахуун, соён гэгээрүүлэх ажлуудад зайлшгүй анхаарал хандуулах хэрэгтэй асуудал болжээ. Тоон мэдээлэлүүдээс харахад гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2024 онд 25,291 байснаас нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 1675 (6.6%) нь 18 хүртэлх насны хүүхэд, дийлэнх буюу 11,548 (45.7%) нь 18-29 насныхан, 6967 нь 30-39 байгаа нь анхаарал татсан асуудал юм. (ҮСХ, 2024, хууд. 2)

Залуус сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх идэвхтэй насан дээрээ нийгмийн эрсдэл, сөрөг үзэгдэлд өртөж байгаа үндсэн шалтгааныг судлах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Төрөөс залуучуудын талаарх баримтлаж ирсэн буй бодлого, үйл ажиллагаа арга хэмжээний агуулгын бодит тулгамдаж буй асуудалтай харьцуулсан шинжилгээ хийснээр дараах дүгнэлтэнд хүрч болохоор байна.

- Монгол улсын хүн амын бүтцэд өсвөр үе, залуучуудын эзлэх хувь ойрын жилд хадгалагдах хандлагатай байгаа нь улс орны хөгжилд чухал нөлөө үзүүлэхээр байна.
- Сүүлийн 10 жилийн хугацаанд төрөөс хэрэгжүүлж буй залуучуудын талаарх баримтлах бодлогын баримт бичиг, эрхзүйн орчин хөтөлбөр, үндэсний хэмжээний уулзалт хэлэлцүүлийг эрчимтэй явуулж нэлээд ахиц гарчээ. Агуулгын хувьд залуучуудын хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэгджээ.
- Бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтэнд онцгойлон анхаарахгүй байгааас залуучуудад тулгамдсан асуудлууд тэр дундаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, хөгжил зэрэг тулгамдсан асуудлууд нэмэгдсээр байна.
- Бодлогын хэрэгжилттэй холбоотой төрийн бүтэц дамжуулах тогтолцоо, механизмыг сайжруулахад онцгойлон анхаарах шаардлагатай болсон байна.
- Цаашид залуучуудад тулгамдаж буй асуудлыг нарийвчлан судлаж залуучууд судлалын чиглэлээр бодлогын болон суурь судалгааны ажлыг дэмжих, эрчимжүүлэх шаардлагатай.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Төрөөс залуучуудын хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих цогц бодлогуудын хэрэгжүүлэх механизм, тогтолцоог бүрдүүлэх

Залуучуудын эрүүл мэндийн боловсролын нэмэгдүүлэх, техник мэргэжлийн сургалтыг онцгойлон дэмжих, дээд боловсролын сургалтын чанарыг сайжруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг идэвхжүүлэх

Тухайн бүс нутгийн онцлог, төв суурин болон малчин залуучуудын хэрэгцээнд чиглэсэн тухайлсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулж залуусыг ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх

Залуучуудад тулгамдаж буй асуудлууд, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох чиглэлээр судлаач, мэргэжилтнүүдийн суурь болон төрөлжсөн судалгааны ажлуудыг дэмжин цаашдын бодлого хөтөлбөрүүдэд тусгах

НОМ ЗҮЙ

1. Боловсролын яам . Боловсролын салбарын статистик 2024-2025. УБ. 2025
2. Үндэсний Статистийн Хороо. Гэмт хэрэг. УБ.2024
3. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ. Эрүүл мэндийн үзүүлэлт. УБ.2023
4. ЮНИСКО. Залуучуудын дуу хоолой судалгааны тайлан. УБ.2022
5. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт.Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдлын судалгаа.УБ 2017.
6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар. Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандарт боловсруулах төсөл, зөвлөх үйлчилгээний тайлан.УБ.2020
7. Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. (IRIM). Залуучуудын санал бодлын судалгаа.УБ. 2020
8. Монгол улсын засгийн газар.НҮБ Хөгжлийн хөтөлбөр.Залуучдад чиглэсэн зарлагын шинжилгээ.УБ.2021
9. Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн ажлын байрны эрэлт, нийлэлтийг тодорхойлох нь” судалгааны тайлан. УБ.2021
10. Лоринэт сан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал.УБ.2022
11. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны инстиут. Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал судалгааны таамаглал. УБ.2024
12. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам. Залуучуудын хөгжлийг дэмжих стратеги 2025-2030 бодлогын баримт бичиг

Цахим эх сурвалж

1. [https://legalinfo.mn/mn/detail?lawId=201609\](https://legalinfo.mn/mn/detail?lawId=201609)
2. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=200082&showType=1>
3. <https://www.facebook.com/CognosResearchEvaluation>
4. <https://gogo.mn/r/0qdl1>
5. https://www.itoim.mn/a/2024/05/15/society/ffq?utm_source=chatgpt.com

БОЛОВСРОЛ СУДЛАЛ



Б.АРИУНБААТАР

Ментал лексикон ба үг эзэмших зүй тогтолд суурилсан
гадаад хэлний үг заах аргын онол-арга зүйн загвар



Т.МЯГМАРСҮРЭН

Холимог сургалтын арга ба багшийн хандлагын хамаарал

МЕНТАЛ ЛЕКСИКОН БА ҮГ ЭЗЭМШИХ ЗҮЙ ТОГТОЛД СУУРИЛСАН ГАДААД ХЭЛНИЙ ҮГ ЗААХ АРГЫН ОНОЛ-АРГА ЗҮЙН ЗАГВАР

(A theoretical model for teaching foreign language vocabulary based on the mental lexicon and vocabulary acquisition)

Доктор, Б.Ариунбаатар
(ОУУБИС. ХНУС)

ariunbaatar.b@ulaanbaatar.edu.mn

Хураангуй

Энэхүү өгүүлэлд ментал лексикон буюу хүний оюун санаанд үг тогтох механизм, гадаад хэлний үг эзэмших зүй тогтолд тулгуурлан боловсруулсан солонгос хэлний үг, үгийн сан заах онол-арга зүйн загварыг боловсруулж энэхүү заах аргыг практикт хэрэгжүүлсэн жишээ, сургалтын үр дүнг тодорхойлсон тестийн дүнг танилцууллаа. Өгүүллийн эхэн хэсэгт үг цээжлэх болон үг эзэмших гэсэн хоёр ойлголтын ялгааг онолын үүднээс тайлбарлаж, үг заах арга зүй нь зөвхөн хүчээр цээжлүүлэхэд бус үг эзэмшүүлэхэд чиглэх шаардлагатай болохыг онцолсон. Ментал лексикон, үг эзэмших зүй тогтлыг танин мэдэхүй болон тархи судлалын үндсэн ойлголтууд, утгын сүлжээний онол, дуал кодчлолын онолын санаатай холбон тайлбарлаж, гадаад хэлний сургалтын практикт тусган хэрэгжүүлэх тодорхой арга техникийг “Содар сургалт”-ын анхан шатны 200 үг заах аргын загвараар жишээлэн үзүүлээ. Энэ заах аргын үр дүнг үнэлэх зорилгоор 2024 оны 4 сараас 12 сарын хооронд 65 суралцагчдаас авсан тестийн дүнг шинжилж үзэхэд, дундаж оноо 90.38 байсан нь тус арга зүй нь өндөр үр дүнтэй болохыг илтгэж байна. Үг эзэмшихтэй холбоотой онолын үзэл баримтлал, “Содар” сургалтын практик, тестийн үр дүнг нэгтгэн дүгнэхэд энэхүү арга зүйд үндэслэн боловсруулсан гадаад хэлний үг заах аргын загвар үр дүнтэй болох нь харагдаж байна.

Түлхүүр үг: үг эзэмшихүй, ментал лексикон, семантик холбоос, анхлан суралцагч

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Үг цээжлэх болон үг эзэмшихүйн ялгаа

Үг эзэмших зүй тогтлын талаар ярихын тулд эхлээд үг цээжлэх болон үг эзэмших гэсэн хоёр ойлголтын ялгааг тодорхой болгох хэрэгтэй. Цээжлэх (memorization) гэдэг нь шинэ үгийг механик давталтын идэвхгүй аргаар хүний ой санамжид түр хадгалах үйл явц бөгөөд утгыг гүн ойлгож, хэрэглээ болголгүйгээр үгийг хүчээр тогтоох гэсэн оролдлого юм. Цээжлэх нь үгийн гүн утга, үг хоорондын холбоо, хэрэглээний контекст зэргийг үл харгалзан дахин дахин давтаж хүчээр тогтоодог тул богино хугацааны дараа эргээд мартах шинж давамгайлна. Цээжлэхэд ихэвчлэн үгийн жагсаалт, үгийн карт (flashcards), давталтын аргыг хэрэглэх бөгөөд үгийн тест, шалгалтад зориулан богино хугацаанд сэргээн санаж болох ч утга учир бүхий хэрэглээ болж чаддаггүй.

Харин үг эзэмших (word acquisition) нь тухайн үгийг өөрийн болгон тогтоож шаардлагатай үедээ сэргэн санаж, бодит харилцаанд хэрэглэх боломж бүрдүүлэх явдал юм. Үг эзэмших нь үгийн утга учир бүхий “илэрц” (exposure), контекст бүхий ойлголт (contextual understanding), идэвхтэй хэрэглээ зэргээр дамжуулан үгийг ментал лексиконы нэг хэсэг болгох илүү гүн бөгөөд жам ёсны процесс юм. Үүнд авиаг кодлох, утгыг зураглах, өгүүлбэр болгох зэрэг танин мэдэхүйн нарийн процесс багтах бөгөөд тухайн үг өөрийн туршлага болон өмнөх мэдлэг, харилцаан дахь хэрэглээтэй холбогдсон байдаг тул урт хугацаанд сэргээн санах боломжтой. Тиймээс үг эзэмших нь үгийг өөрийн болгон ойлгож хэрэгтэй үедээ төвөггүй сэргээн санаж чаддаг тул бодит чадвар болдог.

Үг эзэмших нь үгийг тухайн үгийн илрэх байдал (exposure), тодорхой утга бүх харилцаа, контекстыг ойлгох зэргээр үгийн санг өөрийн болгох алгуур, албадан бус (subconscious) шинжтэй процесс. Гүн суралцахуй (утгыг ойлгох, үгийн холбоо бий болгох, үгийг хэрэглэх), идэвхтэй суралцахуй (унших, сонсох, ярих, бичих, хэрэглээнд оруулах), урт хугацааны ой санамж (харилцаанд хэрэглэхэд бэлэн идэвхтэй үгийн сангийн элемент) зэрэг нь үг эзэмшихүйн гол шинж юм. Үг цээжлэх болон эзэмшихүйн ялгааг дараахь байдлаар харууллаа.

Хүснэгт 1. Үг цээжлэх болон эзэмшихүйн ялгаа

Үзүүлэлт	Үг цээжлэх	Үг эзэмших
Танин мэдэхүйн процесс	Давтах процесс	Үгийг таних, ойлгох, холбох
Сэргээн санах үйл явц	Богино хугацааны	Урт хугацааны

Хэрэглээ	Хязгаарлагдмал хэрэглээ	Харилцаа, бодит хэрэглээ
Сурах арга	Давтах, үгийн жагсаалт, карт	Унших, сонсох, харилцан ярих
Үр дүн	Хэрэглээ болохгүй	Өөрийн болгох, хэрэглэх

Дүгнэвэл цээжлэх нь богино хугацааны идэвхгүй үйл бол, үг эзэмших нь тухайн үг ментал тогтолцооны идэвхтэй элементүүдтэй холбогдон урт хугацааны ой тогтоолтод байршин бодит хэрэглээ болох явдал юм. Тийм ч учраас Craik & Lockhart's (1972) нар цээжлэхийг давталтад суурилсан гүехэн процесс харин үг эзэмшихийг утгад суурилсан танин мэдэхүйн гүн процесс гэж ялган тодорхойлсон байна.

Ментал лексикон

Үгийг эзэмшихэд танин мэдэхүй, нийгэм, хэл шинжлэлийн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлөх нь тодорхой ч үг эзэмших үндсэн зүй тогтлыг ойлгох нь нэн чухал. Үг эзэмших нь суралцагч оюун санаандаа (уураг тархи суурьтай оюуны хийсвэр тогтолцоо) шинэ үгийн мэдээллийг хэрхэн хүлээн авч ямар арга замаар зохион байгуулалтад оруулан хадгалдаг вэ гэсэн асуулттай нягт холбоотой бөгөөд энэ нь үг болон утгыг хүлээн авах танин мэдэхүйн дотоод систем (internalized network) болох ментал лексиконы (mental lexicon) тухай ойлголтоор тайлбарлаж болно.

Ментал лексиконы талаарх хамгийн түгээмэл тодорхойлолт нь Аитчисоны тодорхойлолт бөгөөд тэрээр 1987 онд анх хэвлэгдсэн “Сэтгэхүй дэх үг” номондоо “ментал лексикон гэдэг нь үгсийн утга, дуудлага, өгүүлбэр зүйн мэдээллийг агуулсан сэтгэхүй дэх үгийн агуулах (store) юм” гэж тодорхойлсон (Aitchison (1987). Харин Levelt (1989) ментал лексикон гэдэг нь урт хугацааны ой санамждахь үгсийн агуулах гэж тодорхойлоод харилцааны явцад тэдгээр үгсийн авиазүй, бүтээвэр зүй, өгүүлбэрзүй, утга зүйн мэдээллээр хангадаг авиа, утга, өгүүлбэр зүйн холимог элемент бүхий танин мэдэхүйн систем болохыг онцолсон (Levelt, 1989, х.181). Kuperman & Van Dyke (2013) нар «Ментал лексикон бол үгийн мэдээллийг хадгалах, буцаан хэрэглэхэд зориулалттай туршлагад суурилсан динамик систем бөгөөд энэ систем дэх үгийн зохион байгуулалт нь хэлний элемент, ой тогтоолт, анхаарал танин мэдэхүйн процессын аль алийг тусгадаг хэмээн ментал лексиконы динамик шинжийг онцолсон.

Nicol нар (2005) “Ментал лексикон бол хэлний үгсийг сонсож ойлго, хэрэглэх явцад утга, авиа, хэлзүй, бүтээвэр зүй болон өгүүлбэр зүйн мэдээллийг үр дүнтэй



сэргээн санах боломжийг олгодог танин мэдэхүйн систем гэж тодорхойлжээ. McClelland & Seidenberg (2017) нар тархи төвт коннекшинист (connectionism) онолын үүднээс ментал лексикон бол үгийг тогтонго байдлаар хадгалах сав биш үгийн хэрэглээгээр дамжин бий болдог харилцан уялдаа холбоо бүхий элементүүдийн өөрийгөө бүтээх тогтолцоо бөгөөд үгийн мэдлэг, үгийн илрэх байдал (exposure), хэлний хэрэглээ, ойлголтын сүлжээн дэх идэвхжилт (activation spreading across the network) зэргийн үр дүнд бий болдог гэж үзсэн.

Суралцахуйн үр дүнд бий болох үгсийн холбоос нь (learned associations) үгийн сангийн сүлжээг үүсгэснээр лексик тогтолцоонд нэвтрэх (lexical access) буюу үгсийг богино хугацаанд таньж мэдэх, эргэн санах боломжтой болгоно. Сурсан үг тархинд тодорхой холбоосыг бий болгосноор сүлжээг идэвхжүүлэх харилцан уялдаа бүхий зангилаа (nodes) идэвхжсэнээр шинэ үг тархины сүлжээнд нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.

Орчин үеийн эрдэмтдийн ихэнх нь ментал лексиконыг тодорхой утга зүйн холбоосоор өөр хоорондоо холбогдсон элементүүдийн сүлжээ бөгөөд үгийг сурах, сэргээн санах боломжийг бүрдүүлдэг үндсэн механизм гэдэгтэй санал нийлж байгаа бөгөөд сүүлийн үеийн зарим судалгаанууд ч энэ санааг дэмжиж байгаа юм (De Deyne et al., 2016; González-Fernández, B., & Schmitt, N. 2019; Stella et al., 2024; Agustín-Llach and Rubio, 2024). Эдгээр тодорхойлолтуудаас харахад ментал лексикон бол үгийн утга, авиа, өгүүлбэр зүйн шинж, хэрэглээ зэргийн мэдээллийг хэлний үйлдлийн явцад тогтоон хадгалдаг нарийн зохион байгуулалт бүхий динамик систем гэсэн гол санаа давтагдаж байгаа бөгөөд ментал тогтолцооны дараах шинжүүдийг онцолж байна. Үүнд:

Танин мэдэхүйн шинж: ментал лексикон бол үгсийн хэл шинжлэлийн мэдээллийг ой тогтоолт, анхаарал, мэдээлэл боловсруулалт зэрэг танин мэдэхүйн функцтай нэгтгэдэг өргөн хүрээ бүхий танин мэдэхүйн тогтолцооны нэг хэсэг гэж үзэж байна.

Динамик буюу бодит хэрэглээний шинж: Өнөөгийн үзэл баримтлалууд ментал лексикон бол туршлага буюу бодит хэрэглээн дээр суурилан тасарлтгүй хөгждөг тул үгийн илэрц, давтамж чухал гэдгийг онцолж байна.

Уялдаа бүхий сүлжээ (Interconnected Network): Ихэнх тодорхойлолтууд ментал лексиконыг үгийн сангийн сүлжээнд суурилсан тогтолцоо гээд, үг өөр хоорондоо утга зүйн, авиа зүйн, өгүүлбэр зүйн шинжээр холбогддогийг онцолж байна.

Үг эзэмших зүй тогтол

Гадаад хэлний үгсийг үр дүнтэй эзэмшүүлэхийн тулд тухайн үгс хэрхэн хоорондоо холбогдож тархин дахь утгын сүлжээнд хадгалагддагийг ойлгох шаардлагатай. Энэхүү утгын сүлжээ нь утга зүйн (семантик), авиа зүйн (фонологийн), дүрслэл, мэдрэхүйн зэрэг олон арга замаар холбогдон шинэ үг тогтоох, сэргээн санах, хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлдэг байна. Семантик сүлжээний онолууд, тухайлбал Collins & Quillian (1969), Collins & Loftus (1975) нарын дэвшүүлсэн онолын санаанууд үгс утга зүйн холбоосоор дамжин хэрхэн идэвхжиж, өөр хоорондоо уялдан тогтдог болохыг тайлбарласан. Мөн дуал кодчиллын (dual coding) онол, далд семантик шинжилгээ зэрэг онолууд үгийг зөвхөн хэлбэрээр бус, дүрс ба танин мэдэхүйн процессуудаар давхар холбодог болохыг харуулдаг.

Гадаад хэлний шинэ үгийг суралцагчийн ментал тогтолцоонд холбох аргыг дээрх онолуудын санаан дээр үндэслэн ассосиатив сүлжээ (Associative Networks), утгын сүлжээ (Semantic network) зэрэг ойлголтуудыг ашиглаж тайлбарлаж болно. Ассосиатив сүлжээний онол нь үг ментал лексикон тогтолцоонд үг олон талт холбоос бүхий нягт сүлжээ байдлаар хадгалагддаг бөгөөд үг дангаар хадгалагдах бус утгын болон авианы холбоосоор бэхжих байдлаар тогтоно гэж үздэг. Тиймээс шинэ үг сурна гэдэг нь тухайн үг бидний аль хэдийн мэддэг үгтэй холбогдож тухайн үгийг сэргээн санах, хэлийг ойлгоход туслах тодорхой сүлжээг бий болгох гүн нарийн процессыг хэлэх юм. Утгын сүлжээний онолын үзэж буйгаар аливаа үг дундын утга (shared meaning) байдлаар өөр хоорондоор холбогдоно.

Yamada & Sato (2004) нар үг тодорхой авиагаар холбогдож авианы сүлжээ буюу нетворк үүсгэх замаар ижил дуудлага бүхий үгтэй холбогдон тухайн үгийг сэргээн санах боломжийг бүрдүүлдэг гэж үзсэн бөгөөд энэ санааг дэмсэн судалгаанууд арвин бий.⁹ Жишээ нь англи хэлний «cat» гэсэн үг «bat», «hat», and «rat» зэрэг үгтэй дуудлагын төстэй шинжээр нь холбон илүү хялбар тогтоох боломжтой.

Үгсийг тэдгээрийн утга (семантик холбоо үүсгэх байдлаар) болон бусад үгтэй харьцуулан холбох байдлаар тогтоодог. Ландауэр ба Дюмайс (1997) ментал лексикон буюу хүний тархин дахь үгийн сүлжээ хэрхэн бүрэлдэн тогтдогийг статистик загвараар дүрслэх оролдлого хийсэн бөгөөд ижил төстэй орчинд давтагдан гарч ирдэг үгс (жишээлбэл, «ширээ» ба «сандал») тархинд илүү нягт

⁹ Vitevitch, M. S., & Luce, P. A. (1998). "Probabilistic phonotactics and neighborhood effects in spoken word recognition." *Journal of Memory and Language*, 39(4), 457–479. This work discusses how phonological similarity influences word recognition, supporting the idea that phonologically related words are interconnected in the mental lexicon.

Roodenrys, S., Hulme, C., & Brown, G. D. A. (2002). "The role of phonological similarity in verbal short-term memory." *Journal of Memory and Language*, 46(3), 411-430.



холбогддог болохыг харуулсан. Коллинс, Куиллиан нарын семантик сүлжээний загвар нь холбоост сүлжээнүүдийн ойлголтын үндэс суурийг тавьсан анхны загваруудын нэг юм. Энэ загвар нь үгс шаталсан бүтэцтэйгээр зохион байгуулагддаг бөгөөд хоорондоо утга зүйн хувьд холбоотой үгс сүлжээнд ойр байрладаг гэж үздэг. Жишээлбэл, «шувуу» гэсэн ойлголт нь «амьтан» гэсэн ерөнхий ангилалд багтах бөгөөд «бор шувуу», «болжмор» зэрэг тодорхой төрлүүдтэйгээ илүү ойр холбоотой байна. Энэхүү загвар нь үгс ой санамжид хэрхэн бүтэцлэгдэж, харилцан уялдаатай хадгалагддагийг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Дуал кодчиллын онолоор (Dual Coding Theory) бид үгсийг зөвхөн үгээр бус, мөн дүрслэл, мэдрэхүй зэрэг олон төрлийн мэдээлэлтэй хамтатган хадгалдаг гэж үздэг. Үгс нь зөвхөн бусад үгстэй холбогдохоос гадна дүрс, мэдрэмж, туршлагатай уялдана. Жишээлбэл, «алим» гэсэн үг нь зөвхөн түүний семантик холбоосуудыг (жишээ нь, жимс, улаан, бөөрөнхий гэх мэт) бус, бас алимыг харах, барих үеийн мэдрэхүйг ч мөн адил сэргээнэ. Энэхүү онолоор шинэ үг сурна гэдэг зөвхөн утгын холбоо төдийгүй бусад олон төрлийн давхар холбоосууд ментал сүлжээнд бий болох явдал юм.

Коллинс, Лофтус (1975) нарын тархмал идэвхжлийн онол (Spreading Activation Theory) утгын сүлжээний онолын санааг өргөжүүлж, нэг үг идэвхжих үед (жишээ нь, сонсох эсвэл бодох үед) уг идэвхжил нь тухайн сүлжээнд холбогдсон бусад үгс рүү тархдаг гэж үздэг. Жишээлбэл, “нохой” гэдэг үг идэвхжихэд “муур”, “тэжээвэр амьтан”, “хуцах” гэх мэт холбогдох үгс мөн идэвхждэг. Энэ нь хүмүүс хамаарал бүхий үгсийг түүнтэй үл хамаарах үгсээс хэрхэн ялгаж сэргээн санах зүй тогтлыг тайлбарлахад тусалдаг.

МакНамарагийн (2005) семантик өдөөлтийн судалгаа² нь ой санамж дахь үгсийн харилцан хамаарал болон холбогдсон сүлжээнүүдийн үйл ажиллагааг судалсан. Энэхүү судалгаагаар, холбоотой үгийг саяхан харсан эсвэл сонссон тохиолдолд дараагийн үгийг илүү хурдан таньдаг болохыг харуулсан. Жишээлбэл, «талх» гэдэг үгийг сонссоны дараа «цөцгийн тос» гэсэн үгийг илүү хурдан таньж, боловсруулж чаддаг. Учир нь эдгээр үгс семантик хувьд холбоотой бөгөөд ментал сүлжээнд илүү хялбар хадгалагддаг. Энэхүү судалгаа үг олон талт холбоос бүхий нарийн сүлжээнд холбогдох байдлаар тогтоогддог, мөн тархи утга зүйн хувьд ойрхон үгсийг идэвхжүүлдэг гэсэн ойлголтыг дэмжиж байна.

Hulstijn (2003) судалгааны үр дүнгээр санаандгүй буюу хүчээр бус (incidental-ly) сурсан үг албаар цээжлүүлсэн үгнээс илүү ментал лексиконд бат холбогддогыг тогтоожээ. Ингэж тогтсон үгс утгын сүлжээнд бат холбогдож, буцаан санахад

¹⁰ ² МакНамара семантик өдөөлт нь зүгээр нэг холбооны (association) үр дагавар бус, харин танин мэдэхүйн систем дэх тодорхой бүтэц, утга агуулгын холболт гэсэн санааг онцолсон.

хялбар болдог байна. Практик дээр багш нар шинэ үгийг мэддэг үгтэй нь холбож тогтоолгох аргыг түгээмэл хэрэглэдэг. Жишээ нь англи хэлний сургалтад “dog” гэдэг үгийг “cat,” “pet,” гэдэг үгтэй холбох буюу “tail” үгтэй холбох нь утгын сүлжээг өргөтгөж, эргэн санахад тус болдог байна.

Үгийн энэхүү холбогдох зарчмыг мэдсэнээр суралцагч өөрийн өмнөх мэдлэгийг шинэ үг ойлгох, шинэ үгийг хурдан тогтоон хэрэглэж сурахад үр дүнтэй ашиглаж болно. Үг хэрхэн ментал тогтолцооны сүлжээнд холбогдож, ой санамжид тогтдогыг ойлгох нь гадаад хэлний үг заах үр дүнтэй арга хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Үг тогтоох зүй тогтолтой холбоотой онолын санааг дүгнэвэл:

Нэгдүгээрт, үг цээжлэх байдлаар сурах нь үр дүнгүй. Учир нь цээжлэсэн үг богино хугацааны ой санамжид түр хугацаанд хадгалагдахаас биш ментал тогтолцооны идэвхтэй элемент болж бодит хэрэглээтэй холбогддоггүй.

Хоёрдугаарт, үг тогтооно гэдэг суралцагч тухайн үгийг авиа зүй, үг зүй, утга зүйн хувьд кодчлон өөрийн ментал тогтолцооны идэвхтэй элемент болгон бүртгэж шаардлагатай үед сэргээн санаж, хэрэглэх боломжтой болно гэсэн үг юм.

Гуравдугаарт, хэл сурах үндсэн зорилго бол тухайн хэлэнд түгээмэл хэрэглэгдэх үгсийг эзэмшин хэрэглэж сурах явдал болохоос биш үг цээжлэх биш. Тиймээс гадаад хэлний сургалтын үйл ажиллагаа үг цээжлэхэд биш үг эзэмшихэд чиглэгдэх ёстой.

ОНОЛЫН САНААГ ҮГИЙН САН ЗААХ АРГАД ТУСГАХ НЬ

Үгийн сан заах аргыг процессын хувьд ерөнхийд нь 1) тайлбарлаж ойлгуулах (input/exposure), 2) тогтоолгох (memorizing or acquisition), 3) хэрэглүүлэх гэсэн үе шатад хувааж үзвэл уламжлалт заах арга энэ процессын эхний хэсэг буюу ойлгуулахад түлхүү анхаарч тогтоолгох процессыг орхигдуулах буюу хэт хөнгөн хандаж (цээжлүүлэх) ирсэн. Эдгээр процесс өөр хоорондоо харилцан хамааралтай учраас тогтоолгох процесс бүтэлгүйтвэл дараагийн процесс болох хэрэглээ болж чадахгүй. Тиймээс өнөөгийн үгийн сангийн сургалт энэхүү шатанд үгийг өнгөцхөн цээжлүүлээд өнгөрөх бус шинэ үгийг өөрийн болгож эзэмшүүлэхэд илүү анхаарах ёстой.

Өмнөх бүлэгт дурдсан онолын үзэл баримтлалуудын дүгнэлтээс харвал үгийн сан заах арга үг цээжлэх биш үг эзэмшихэд чиглэгдэх ёстой бөгөөд үг эзэмших гол зүй тогтол нь шинэ үгийг ментал тогтолцооны идэвхтэй элемент болгон холбож тогтоох явдал болж байна. Тэгвэл гадаад хэлний шинэ үгийг ментал тогтолцооны

сүлжээнд хэрхэн холбож амжилттай тогтоох вэ? Аливаа хэлний үг өөрийн үндсэн шинжүүдээр өөр хоорондоо холбогдож ментал тогтолцооны бүтцэд багтах бөгөөд аливаа үг дараах үндсэн шинжийг агуулна.

Нэгдүгээрт, үг бүр өөрийн дуудлага, бичиглэлтэй байна. Шинэ үг авиа зүйн энэ шинжээрээ ментал тогтолцооны үндсэн элементтэй холбогдож байж тогтоогдоно.

Хоёрдугаарт, үг бүр өөрийн гэсэн тодорхой утга, дүрслэлтэй байна. Үг өөрийн утгын дүрслэл, төсөөлөлөөр буюу утга зүйн шинжээр давхар холбогдох ёстой.

Гуравдугаарт, үг бүр тодорхой үгтэй нийлэн холбоо үг байдлаар хэрэглэгдэж, өгүүлбэрийн тодорхой гишүүн болох өгүүлбэр зүйн шинжийг агуулна.

Гадаад хэлний шинэ үг заах (тодорхой хэлбэл шинэ үг тогтоолгон хэрэглэж сургах) дараах үе шатад хуваан үзэж болно.

Хүснэгт 2. Үг эзэмших үе шат

Үе шат	Танин мэдэхүйн үйлдэл
Утгын илэрц (exposure)	Таних, мэдэх, ойлгох
Эзэмших, өөрийн болгох	Тогтоох, сэргээн санах
Хэрэглээ, дадал болгох	Сонсох, унших, ярих, бичих

Дээрх процесс дундаас бидний анхаарал хандуулж байгаа хэсэг бол хоёрдох түвшин бөгөөд энэ түвшинд сургалт цээжлүүлэх байдлаар гүехэн мэдлэг олгохоос бус үгийг бат тогтоож, сэргээн санах үйлдэл болтол эзэмшүүлж чадахгүй байна. Үг тогтоох гол зүй тогтол бол шинэ үгийг оролцуулсан үгийн сангийн буюу утга зүйн сүлжээг (semantic network) бий болгох явдал юм. Сүлжээ үүсгэх эхний алхам нь элементүүдийг холбох явдал юм. Анхлан суралцагч шинэ үгийг тогтоох эхний алхам нь тухайн үгийг 1) дуудлагаар, 2) утгаар, 3) дүрслэл буюу имиджээр холбон тогтоож аажмаар бэхжүүлэн ментал тогтолцооны утгын сүлжээнд нэгтгэх байдлаар хэлний хэрэглээнд суралцана.

Анхлан суралцагчдад өгөгдөх үгийн анхны элемент бол дуудлага болон утгын төсөөлөл (жинхэнэ нэрийн хувьд зураг, дүрслэл). Тиймээс ментал холбоос энэ хоёр өгөгдөл дээр үндэслэхээс өөр арга үгүй. Жишээ нь: **가방** гэдэг үгийн жишээгээр авч үзвэл авиа зүйн элемент нь ‘ка-бан’, дүрслэл нь цүнхний зураг буюу имидж байна.

Хүснэгт 3. Дуудлага, дүрслэлээр семантик холбоо үүсгэх арга

Шинэ үг	Зураг, дүрслэл	Дуудлагаар холбох	Семантик холбоос
가방		Гай байна	Цүнх гэж ГАЙ байна аа
감기		Гамгүй	ГАМГҮЙ байвал ханиад хүрнэ

Хэрэглээний туршлага огт байхгүй анхлан суралцагчийн хувьд ка-бан гэсэн авианы элементийг “цүнх” гэсэн дүрслэл/зурагтай шууд холбон тогтоох боломжгүй. Тиймээс энэхүү дуудлагын элементийг суралцагчийн ментал тогтолцооны утга зүйн (semantic) элементтэй холбох бяцан “заль” хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл ка-бан гэсэн дуудлага төстэй “гай байна” гэсэн төсөөллийг бий болгоод (холболтыг өдөөх зорилгоор) “ка-бан гэж ёстой нэг гай байна аа” гэсэн утгын холбоос үүсгэн өөрийн бодол, амьдралын бодит төсөөлөлтэй холбоно. Суралцагч цааш нь “нээрээ, сургуульд орж байгаа 6 настай хүүхдэд цүнх гэж “гай байдаг” шүү “ка-бан” байх нь гэх зэргээр лавшруулан төсөөлж холболтыг бататган бэхжүүлэх боломжтой.

Энэхүү арыг Содар заах аргад нэг төрлийн оюуны заль (mnemonic) байдлаар хэрэглэдэг бөгөөд үгийн сангийн ямар ч суурь мэдлэггүй учир үг хоорондын холбоос үүсгэх боломжгүй анхан шатны суралцагчддаг хэрэглэдэг. Тодорхой хэлбэл анхан шатны 400 үгийн 200 жинхэнэ нэрийг тогтоолгоход энэ аргыг хэрэглэхэд тохиромжтой. Уг аргаар тогтоолгох үгсийн зарим жишээг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Анхан шатны үгийг дуудлагааар холбосон жишээ

№	Шинэ үг	Төстэй дуудлага	Холбох төсөөлөл, утга
1	가족	гажиг	Жаахан “гажиг” гэр бүл
2	강	ган	Ган болбол гол, мөрөн ширгэнэ
3	거울	гоё л	Толинд хараад “гоё л байна”
4	공부	кунфү	Хятад кунфу, солонгос кунбү
5	공항	гунхан	Онгоцны буудал руу гунхан гунхан алхаад
6	교회	гуй хө	Сүмд очиж гуй хө. Хэл сургаад өгөөч гэж
7	꽃	гүүд, good	Цэцэг өгдөг good boy .



8	꿈	гүй ээ мөн	Гүй ээ мөн сонин зүүд ээ
9	나이	ная	Нас хэд вэ? Ная.
10	달	тал	Тал сар

Үг эзэмших процессын дараагийн алхам нь тогтоосон үгээ сэргээн санаж, хэрэглээнд оруулах, хэрэглэх дадал суулгах. Нэгэнт тогтоочихсон үгийг өөр үгтэй холбох, өгүүлбэр болгох зэргээр хэрэглээнд оруулах боломжтой.

Хүснэгт 5. Шинэ үг холболтын түвшин

	ж.нэр + ж.нэр	ж.нэр + үйл үг	өгүүлбэр	Текст
가게 дэлгүүр	옷 가게 Хувцасны дэлгүүр	가게에 가다 Дэлгүүр явах	가게에 가요. Дэлгүүр явна.	오후에 가게에 가요. 우리 가게 앞에서 만나요. 그리고 가게에서 우유를 사고 집에 가요. 그래서 5시쯤 가게로 오세요! Үдээс хойш дэлгүүр явна. Бид (хоёулаа) дэлгүүрийн өмнө уулзъя. Тэгээд дэлгүүрээс өндөг сүү аваад гэр лүүгээ явна. Тийм учраас 5 цагт дэлгүүр лүү ирээрэй.
	신발 가게 Гутлын дэлгүүр	가게에서 사다 Дэлгүүрээс худалдаж авах	가게에서 우유를 사요. Дэлгүүрээс сүү худалдаж авна.	
	가게 문 Дэлгүүрийн хаалга	가가로 오다 Дэлгүүр лүү ирэх	가게로 오세요. Дэлгүүр лүү ирээрэй.	

Дээрх байдлаар нэгэнт тогтоож чадсан үгийг тодорхой шат дараалалтай холбоос үүсгэн өгүүлбэр, текстийн түвшинд хэрэглэх боломж бүрдэнэ. Жишээ нь: дэлгүүр гэсэн үгийг тогтоочихсон суралцагч хувцасны дэлгүүр, гутлын дэлгүүр, дэлгүүрийн хаалга (үг тус бүрийг уг аргаар тогтооно) зэрэг үгсийг төвөггүй холбож эдгээр үгсийн хооронд семантик нетворк үүсэн батжина. Үүгээр зогсохгүй практик дээр дэлгүүр гэдэг үгтэй хамгийн их хэрэглэдэг явах, авах (дэлгүүр явах, дэлгүүрээс авах) зэрэг үйл үгтэй холбох замаар практик хэрэглээнд ойртуулна. Ийнхүү гол холболтуудыг хийж сурахын зэрэгцээ солонгос хэлний өгүүлбэрийн бүтцийн ерөнхий ойлголттой (өгүүлбэрийн бүтэц, төгсгөл зэрэг) болчихсон

суралцагч тогтоосон үгээ текстийн түвшинд төвөггүй хэрэглэж эхлэнэ.

Заах аргын практик, үр дүн

Ментал лексикон буюу суралцагчийн шинэ үг тогтоох зүй тогтолд тулгуурласан дээрх аргыг ашиглан солонгос хэлний 100 жинхэнэ нэрийг зааж, сургалтын үр дүнг нь тестээр үнэлэв. Энэхүү тестийг 2024 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хүртэл давхардсан тоогоор 65 хүн, давхардаагүй тоогоор 55 хүн бөглөсөн. 2025 оны 2 сарын 19-нд нэг хүн нэмж бөглөсөн. Эдгээр тоо танхим болон онлайн сургалтын аль алийг нь хамруулсан бөгөөд ихэнх нь онлайн сургалт буюу хичээлийг бичлэг байдлаар үзсэн болно. Тестийн үр дүнгээс харахад нийт суралцагчдын дундаж оноо 90.38 хувь байна. Тестийн дүнд нарийвчилсан анализ хийж үзэхэд 60 хувиас доош оноо авсан таван суралцагч байна. 17 оноо нэг, 37, 40, 51, 59 оноо тус бүр нэг байна. 17 оноо авсан суралцагч эхний 17 асуултыг бүгдийг зөв хийсэн боловч үлдсэн асуулт хийгээгүй орхисон. 37 болон 40 оноо авсан суралцагчдын хувьд асуултаа бүгдийг нь хийсэн боловч 50-иас доош оноо авсан байна. 59 оноо авсан оролцогчийн хувьд мөн адил тест бүрэн ажилласан боловч 60-с доош оноо авсан бөгөөд 51 оноо авсан суралцагч бөглөөгүйгээс болж оноо алдсан байна. Магадгүй өөрийн тогтоож амжаагүй үгээ орхисон гэж таамаглаж байна.

Тест дахин бөглөсөн 6-7 суралцагч 1-7 хоногийн дотор тест дахиж ажиллахдаа оноогоо 1-13 оноогоор өсгөсөн байна. Тестийн дүнд дүгнэлт хийвэл суралцагчдын ихэнх нь 60-с дээш буюу 19 хүн 100 оноо, 30 хүн 91-100 оноо, 6 хүн 81-90 оноо, 4 хүн 60-80 оноо авсан байна. Харин 5 хүн 60-с доош оноо авсан бөгөөд тэднээс хоёр нь тест гүйцэд бөглөөгүйгээс болсон байна.

Дээрх суралцагчид ихэнх нь онлайн суралцагч тул хүн ам зүйн мэдээллийг нарийвчлан гаргах боломжгүй хэдий ч өсвөр наснаас эхлээд ахмад насны буюу нийт массыг хамарсан бөгөөд энэ нь өсвөр насныхан болон оюутан зэрэг суралцах онцлог бүхий бүлгийг тусгайлан хамруулахгүй ямар ч насны, ямар ч түвшний суралцагчдад энэхүү аргыг хэрэгжүүлэх бүрэн боломжтойг давхар харуулж байна.

ДҮГНЭЛТ

Ментал лексикон буюу оюуны үгийн сангийн тухай ойлголт, үг эзэмших зүй тогтолтой холбоотой эрдэмтдийн санаа, саналууд дээр үндэслэн солонгос хэлний үг заах аргын онол, арга зүйн үндэслэлийг боловсруулах, “Содар” сургалтад хэрэгжүүлсэн үг заах аргын үр дүнг тестийн үнэлгээ ашиглан тандах зорилго бүхий энэхүү судалгаагаар дараах дүгнэлтүүдийг хийж байна.



Нэгдүгээрт, өнөөдөр гадаад хэл заахдаа цээжлүүлэх аргыг түлхүү хэрэглэж байгаа ч хэл эзэмшихүйн онол болон үг эзэмших зүй тогтлыг тайлбарлаж буй эрдэмтдийн үзэж буйгаар цээжлэх нь ментал холбоо үүсгэх байдлаар мэдлэг, ойлголт, хэрэглээ болоогүй тохиолдолд оюуны үгийн сангийн идэвхтэй элемент болж чаддаггүй тул энэ аргаар хичээл заах нь үр дүн багатай. Тиймээс гадаад хэлний сургалтын цөм болсон үг, үгийн сан заах арга үг цээжлүүлэх биш үг эзэмшүүлэхэд чиглэгдэх ёстой.

Хоёрдугаарт, үг эзэмшихүйн онолын үүднээс авч үзвэл үг сурах эхний алхам нь ментал лексикон буюу оюуны үгийн санд шинэ үгийг холбон тогтоох явдал бөгөөд үг тогтоох гол түлхүүр нь шинэ үгийн үндсэн элементийг суралцагчийн ментал тогтолцооны элементүүдтэй холбох байдлаар утгын сүлжээ (semantic network) үүсгэх явдал юм. Үг эзэмшин хэрэглээ болоход хамгийн чухал үүрэг гүйцэтгэх энэ алхмыг амжилттай гүйцэтгэж байж дараа дараагийн алхмууд (сэргээн санах, дадал, хэрэглээ гэх мэт) амжилттай явагдана.

Гуравдугаарт, шинэ үгийг үгийн сангийн аргаар холбох боломжгүй анхлан суралцагчдад солонгос хэлний үг заахдаа авиа зүйн элемент болон утга зүйн элементүүдийг ашиглан холбоо үүсгэх зорилгоор тухайн үгийн дуудлагыг эх хэлнийх нь төстэй дуудлага бүхий үгтэй холбож, утгажуулан, зураг дүрслэлтэй нь хамт холбож өгөх нь үр дүнтэй байна.

Дөрөвдүгээрт, үг эзэмших зүй тогтолд суурилсан үг заах аргын үр дүнг тандах зорилгоор зорилгоор 2024 оны 4 сараас 12 сар хүртэлх 9 сарын хугацаанд авсан 100 үгийн тестийн дүнд анализ хийж үзэхэд нийт 65 суралцагчдын дундаж 90.38 хувь, 90-с дээш үгийг зөв тогтоосон суралцагч 49 байгаа нь заах аргын үр дүн сайн болохыг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Agustín-Llach, M. P., & Rubio, J. (2024). Navigating the mental lexicon: Network structures, lexical search and lexical retrieval. *Journal of Psycholinguistic Research*, 53(1), 21.
2. Aitchison, J. (1987). *Words in the Mind: An Introduction to the Mental Lexicon*. Oxford: Blackwell.
3. Collins, A. M., & Loftus, E. F. (1975). A spreading-activation theory of semantic processing. *Psychological Review*, 82(6), 407–428.
4. Craik, F. I., & Lockhart, R. S. (1972). “Levels of processing: A framework for memory research.” *Journal of Verbal Learning and Verbal Behavior*, 11(6), 671-684.

5. De Deyne, S., Kenett, Y. N., Anaki, D., Faust, M., & Navarro, D. J. (2016). Large-scale network representations of semantics in the mental lexicon. In T. T. Rogers, M. Rau, & J. Frank (Eds.), *Big data in cognitive science: From methods to insights* (pp. 174–202). Routledge.
6. González-Fernández, B., & Schmitt, N. (2019). Word knowledge: Exploring the relationships and order of acquisition of vocabulary knowledge components. *Applied Linguistics*, 41(4), 481–505.
7. Hulstijn, J. H. (2003). Incidental and intentional learning. In C. Doughty & M. H. Long (Eds.), *The Handbook of Second Language Acquisition* (pp. 349-381). Blackwell.
8. Landauer, T. K., & Dumais, S. T. (1997). A solution to Plato’s problem: The Latent Semantic Analysis theory of acquisition, induction, and representation of knowledge. *Psychological Review*, 104(2), 211–240.
9. McNamara, T. P. (2005). *Semantic priming: Perspectives from memory and word recognition*. Psychology Press.
10. Nicol, J., et al. (2005). “Lexical Access and Word Production.” *Psychological Science*, 16(4), 267-272.
11. Schreuder, R., & Baayen, H. R. (2006). Morphological processing and the mental lexicon in language teaching. *Language and Cognitive Processes*, 21(3), 219-240.
12. Schriefers, H., et al. (2010). “Lexical Access and Production in Language Processing.” *Language and Cognitive Processes*, 25(4), 432-448.
13. Stella, M., Citraro, S., Rossetti, G., Marinazzo, D., Kenett, Y. N., & Vitevitch, M. S. (2024). Cognitive modelling of concepts in the mental lexicon with multilayer networks: Insights, advancements, and future challenges. *Psychonomic Bulletin & Review*, 31(5), 1981–2004. <https://doi.org/10.3758/s13423-024-02412-3>
14. Van Heuven, W. J. B., & Dijkstra, T. (2020). Phonological processing and the L2 mental lexicon: Implications for second language teaching. *Journal of Memory and Language*, 113, 104134.
15. Yamada, Y., & Sato, S. (2004). “Phonological priming effects in lexical decision tasks.” *Psychological Research*, 68(4), 245–250.
16. Zhan, Z., & Li, D. (2019). The mental lexicon and English vocabulary teaching: Implications for vocabulary acquisition. *Theory and Practice in Language Studies*, 9(5), 634-640.
17. Ариунбаатар, Б. (2023). Солонгос хэлний анхан шатны 400 үг тогтоох, хэрэглэх арга, Содар, Сэлэнгэ пресс
18. Содар. (2024). Уншиж сурах+400 үг тогтоох арга, онлайн цуврал хичээл

ХОЛИМОГ СУРГАЛТЫН АРГА БА БАГШИЙН ХАНДЛАГЫН ХАМААРАЛ

Доктор, дэд профессор, Т.Мягмарсүрэн
(ОУУБИС. ХНУС)

myagmarsuren.t@ulaanbaatar.edu.mn

Abstract: The purpose of this study is to examine the relationship between Blended Learning (BL) and general education school teachers' perception towards BL. The study involved 43 teachers from the General Education School No.31 in Ulaanbaatar. The data was collected through surveys regarding the teacher's perception towards blended learning using a framework based on Model of Personal Computer Utilization (MPCU) theory. The statistical analysis of frequency was used to determine whether teachers are using the BL, and the descriptive and correlation analysis were conducted to identify the general patterns of teachers' perception to BL. In addition, a one-way ANOVO was used to determine whether the use of the BL differs based on teachers' age and professional field. The results of this study show that 50% of the teachers conduct their classes using a combination of face-to-face and online mode of teaching and learning, while the remaining 50% use only face-to-face instruction. Overall, teachers have a positive attitude toward the blended learning approach. Furthermore, the use of this approach does not significantly differ based on teachers' age or professional field.

Түлхүүр үг: ЕБС, багш, хосолсон сургалтын хэлбэр

УДИРТГАЛ

Монгол улсад 2021 оноос хойш ковид цар тахлын тархалт хумигдаж эхэлсэн тэр цаг үеэс хойш багш нар хичээлээ танхим, цахим, зайн, цахим танхим хосолсон буюу холимог (Blended learning) зэрэг янз янзын хэлбэрээр зохион байгуулж байна. Үүн дотроос холимог сургалтын аргыг өдөр тутмын хичээлдээ ашиглах байдал нилээд түгээмэл боллоо. Учир нь багш нар холимог сургалтын аргыг суралцагчдынхаа сурах чадварыг сайжруулахын тулд хичээл сургалтын үйл ажиллагаандаа техник технологийг ашиглахын зэрэгцээ тодорхой мэдлэг солилцох, мэдээллийн хэрэгцээгээ хангах, улмаар олон төрлийн сургалтын технологид тулгуурлан заах арга барилаа шинэчилж байна (Bokolo, 2021). Түүнчлэн өнөө

үед мэдээлэл технологийн хөгжил, оюутан суралцагчдын хэрэгцээ, сонирхол, даяаршсан нийгмийн зохион байгуулалт зэрэг олон хүчин зүйлсийн улмаас сургалтын энэ хэлбэрийг ашиглах хэрэгцээ шаардлага улам нэмэгдсээр байна. Тус аргыг онлайн болон уламжлалт орчинг хослуулсан сурган хүмүүжүүлэх шинэ арга ухаан хэмээн тооцож байгаа бөгөөд суралцагч багш хоорондын харилцааг дэмжих боломжтой сургалтын хэлбэр хэмээн зарим эрдэмтэд онцлон дурьджээ (Lopez-Perez et al, 2011).

2023 оны 07 сарын 07-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 8-р зүйлд боловсрол эзэмшүүлэх сургалтын хэлбэрийг дараах байдлаар заасан.

8.1 Сургалт нь танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрийн зохион байгуулалттай байна.

8.2 Танхимын бус сургалтад зайн, хувилбарт болон цахим, дадлага сургалт хамаарна.

Техник, технологийн эрин үеийн өнөөгийн нөхцөл байдал, боловсролын хуулиа дагаж мөрдөх багш нарын үүрэг хариуцлагын аль аль нь багш нарыг ийнхүү хичээл сургалтаа дан бус давхар хосолсон хэлбэрээр зайлшгүй зохион байгуулахад хүргэж байна. Тиймээс энэ судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн багш нар хичээлээ хосолсон сургалтын хэлбэрээр зохион байгуулж байна уу, холимог сургалтын аргыг хэр ойлгож хүлээн авч байна вэ гэдгийг олж тодруулах нь зүйтэй гэж үзээд дараах судалгааны зорилгыг тавив.

Судалгааны зорилго: Холимог сургалтын арга болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын тус сургалтын аргыг ойлгож хүлээн авч байгаа хандлага хоорондын хамаарлыг судална.

Судалгааны зорилгын дагуу дараах гурван судалгааны асуултыг дэвшүүллээ.

1. ЕБС-ийн багш нар холимог сургалтын аргыг сургалтандаа хэрхэн ашиглаж байна вэ?
2. ЕБС-ийн багш нар холимог сургалтын аргыг хэрхэн ойлгож хүлээн авч байна вэ?
3. ЕБС-ийн багш нарын холимог сургалтын аргад хандах хандлага болон нас, мэргэжлийн чиглэл хооронд ялгаа байна уу?

ХОЛИМОГ СУРГАЛТЫН АРГА

Холимог сургалтын арга нь шинэ үеийн суралцагчдын хөгжиж буй хэрэгцээг хангахын тулд уламжлалт “нүүр тулан суралцах” ба “цахим сургалт” гэсэн хоёр сургалтын орчинг хослуулдаг. Холимог сургалтын үед ангиас гадуур суралцах шаардлага тулгарах бөгөөд ингэснээр онлайн болон офлайн байдлаар сургалтын агуулгыг хэрэгжүүлэхийг багш болон суралцагчид эрмэлздэг. Судлаач Грахам *“Холимог сургалт нь хүн хоорондын шууд харилцаагаар тодорхойлогддог уламжлалт буюу “хам цагийн” сургалтын орчинг бичвэр (ном сурах бичиг, гарын авлага гэх мэт) болон мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан суралцагч хувь хүний бие даан суралцах “цуваа цагийн” сургалтын орчинтой хослуулсан сургалтын нэг хэлбэр.”* хэмээн тодорхойлжээ. Хартман болон бусад эрдэмтэд *“Холимог сургалт гэдэг нь танхимын сургалтын үр ашигтай байдал, тухайн сургалтаар нийгэмшүүлэх боломж зэргийг онлайн сургалтын технологийн дэвшилтэй хослуулсан сурган хүмүүжүүлэх арга ухааны нэгдэл юм.”* гэж тодорхойлсон (Roop, 2012).

Холимог сургалтын аргыг ашиглах нь сургалтын нөөцийн уян хатан байдал, хүртээмжийг нэмэгдүүлдэг, зардал бууруулдаг зэрэг тустайн дээр багшийн хичээлд зарцуулдаг цагийг багасгаж, улмаар багшаас гарах зардлыг ч хэмнэж байна (Graham, 2013), мөн сургуулиудад техник технологи ашиглах боломжийг бий болгож, судалгаа шинжилгээний нийгэмлэгийг дэмжин, идэвхитэй суралцах боломжийг олгож байна (Roop, 2012). Холимог сургалтын арга нь уламжлалт орчинд илүү сайн суралцдаг суралцагч болон цахимд суурилсан сургалтаар илүү сайн суралцдаг суралцагчдад адил тэнцүү боломж олгодог. Цаашилбал холимог сургалтын арга нь илүү уян хатан цагийн хуваарь гаргаж багш нарт танхимын хичээлээрээ дамжуулан чухал ур чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг болохын зэрэгцээ тэдэнд сурган хүмүүжүүлэх арга зүйгээ ч эргэцүүлэн бодох боломжийг олгож байгаа учраас багш нарыг хэрэгцээ шаардлагаа тодорхойлох, заах арга барилаа сайжруулах нэгэн үр дүнтэй арга зам мөн (Carbonell, 2013).

2000 оноос хойшхи уламжлалт болон холимог сургалтын аргын талаар хийсэн судалгаануудаас (Malone, 2020), (Manghirmalani-Mishra, 2020), (Bokolo, 2021), (Т. Мягмарсүрэн, Т. Амармэнд, 2024) үзэхэд багш нар дан сургалтын хэлбэрээс илүүтэйгээр хосолсон сургалтын хэлбэрийг илүүд үзэж байгаа нь илэрхий байна.

КОМПЬЮТЕРИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАГВАР ОНОЛ

(Thompson, 1991) бусад эрдэмтдийн хамтран боловсруулсан “Компьютерийн хэрэглээний загвар” (КХЗ) /Model of Personal Computer Utilization Theory/ онол нь (Triands, 1979)-ын нийгмийн сэтгэл судлал талаас боловсруулсан хувийн зан төлвийн модель дээр үндэслэн боловсруулагджээ. КХЗ нь хувь хүний зүгээс техник технологийг хэрэглэх явцад илэрдэг эерэг болон сөрөг хандлагыг судалдаг онол юм (Thompson R. L., 1994). КХЗ онолыг боловсролын нөхцөл байдалд тохируулан багш нарын холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авч үнэлэмжийг судлах боломжтой (Taherdoost, 2018).

КХЗ онолд холимог сургалтын аргыг хэрэгжүүлэхэд сургалтанд нийцэх байдал, төвөгтэй байдал, хамт олны нөлөө, техник технологийн мэдлэг, үр дагавар, сургуулийн дэмжлэг, нөлөөлөл, холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах байдал гэсэн найман хүчин зүйлс багтдаг.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хэмжилтийн загвар: Тус судалгааны ажлаар холимог сургалтын арга болон ЕБС-ийн багш нарын холимог сургалтын аргыг хэрэгжүүлэхэд хандаж буй хандлага хоорондын хамаарлыг олж тодорхойлохыг зорьсон. Энэ зорилгын дагуу компьютерийн хэрэглээний загварын онолд тулгуурлан боловсруулсан холимог сургалтын аргад хандах хандлагыг илрүүлдэг хэмжилтийн загвар (Thompson R. L., 1994)-ыг ашиглалаа. Энэхүү хэмжилтийн загвар 1) хамт олны нөлөө-3 айтем, 2) нөлөөлөл-3 айтем, 3) төвөгтэй байдал-3 айтем, 4) үр дагавар-3 айтем, 5) сургалтанд нийцэх байдал-4 айтем, 6) сургуулийн дэмжлэг-4 айтем, 7) техник технологийн мэдлэг-4 айтем, 8) хүлээн авах байдал-4 айтем гэсэн нийт найман хүчин зүйл, 28 айтемтай. Айтемын хариултад 1-огт санал нийлэхгүй, 2-санал нийлэхгүй, 3-санал нийлж байна, 4-бүрэн санал нийлж байна гэсэн лайкертын дөрвөн сонголтот шкал ашигласан. Гарсан онооны дундажийг 1.00-1.74 хангалтгүй, 1.75-2.49 дунд, 2.50-3.24 сайн, 3.25-4 маш сайн түвшинд байна (Alico, Guimba, 2015) гэж тайлбарлалаа.

Тус хэмжилтийн загварт багтсан холимог сургалтын аргыг хүлээн авах байдал буюу үнэлэмжийг тодорхойлох найман хүчин зүйлсийг доор тайлбарлая.



1. Хамт олны нөлөө /Social factor/

Хамт олны нөлөө хүчин зүйл нь зөвхөн сургууль дотроо хамт олноороо холимог сургалтын аргыг хичээлдээ хэрхэн ашиглаж байгаа, удирдлагын зүгээс тус аргыг сургалтад ашиглахад нь хэрхэн хариуцлага хүлээж ажиллаж байгаагаар холбогдоно (Thompson R. L., 1994). Энэхүү хүчин зүйл нь хамт ажилладаг багш, хамт олных нь зүгээс багш нарт дарамт ирж буй эсэхийг мөн хэмжинэ (Brand, 2011). Түүнчлэн холимог сургалтын аргаар хичээл заах нь чухал гэж үзэж байгаа хамт олон, найз нөхөд, хамтран ажилладаг хүмүүс, удирдлага, засгийн газрын нөлөөллийг багш нар хэр хэмжээнд ойлгож хүлээн авч байгааг хэмжинэ (Jng, 2021), (Kocaleva, 2014), (Tarhini, 2017).

2. Нөлөөлөл (холимог сургалтын арга (ХСА)-ын одоогийн үзүүлж буй нөлөөлөл) /Affect towards use/

Нөлөөлөл хүчин зүйл нь багш нар холимог сургалтын аргыг хэрэглэхдээ дуртай байна уу, дургүй байна уу гэдгийг хэмжинэ (Anthony, 2019). Холимог сургалтын аргын нөлөөг хэмжихэд багш нарын нөлөөллийг харгалзах нь чухал, учир нь холимог сургалтын аргыг багш нар хэрхэн ойлгож хүлээж авч байгаа, энэ аргын талаар ямар мэдлэгтэй байгааг нь хэмжихээс гадна хичээлдээ энэ аргыг ашиглахдаа ямар хандлагатай байгааг нь тодорхойлдог (Bervell, 2020).

3. Төвөгтэй байдал /Complexity/

Төвөгтэй байдал хүчин зүйлээр уламжлалт танхимын болон онлайн хичээлийн аль алиныг нь заахад тулгарч байгаа бэрхшээлийг олж тодорхойлно (Kocaleva, 2014). Энэ хүчин зүйл нь холимог сургалтын аргыг ашиглахад хэр төвөгтэй байна, бэрхшээл нь хэр удаан үргэлжилж байна вэ гэсэн агуулгатай (Al-Khaldi, 1999).

4. Үр дагавар (ХСА-ын урт хугацаанд бий болгосон үр дагавар) /Long term consequences/

(Desman, 2015) нарын судлаачид үр дагавар хүчин зүйлийг багш нар өөрсдийнхөө зан үйлийн үр дагаварыг хэрхэн үнэлж дүгнэж байгаа тэр үнэлэмжтэй холбож тайлбарладаг, мөн энэ нь ирээдүйд бий болох шагнал, урамшуулалтай холбоотой байдаг гэжээ. Үр дагавар нь эерэг, сөрөг, их, бага ямар ч байж болно (Saleem, 2016). Холимог сургалтын аргаар ашиглаад бий болсон үр дагавар нь тус аргыг хэрэглэсэн тэр даруйд ч илэрсэн байж болно буюу урт ба богино ямар ч хугацаанд бий болсон үр нөлөө байж болно (Kocaleva, 2014).

5. Сургалтанд нийцэх байдал /Job fit/

Сургалтанд нийцэх байдал хүчин зүйл нь холимог сургалтын аргаар багшийн заах арга зүйг дээшлүүлж байгаа байдалтай холбогдоно (Bath, 2011). Хэрвээ багш

холимог сургалтын аргыг хичээлдээ ашиглахад хялбар байна гэж үзвэл холимог сургалтын аргад сэтгэл ханамжтай байх ба энэ нь холимог сургалтын аргыг үнэлэх үнэлэмжид нь нөлөөлнө (Kocaleva, 2014). Багш нар хэрвээ холимог сургалтын аргыг өөрийнх нь одоогийн заах арга зүйг сайжруулна гэж үзвэл хичээлдээ ашиглаад л явна (Gawanda, 2015).

6. Сургуулийн дэмжлэг /Facilitating conditions/

Сургуулийн дэмжлэг хүчин зүйл нь сургуулийн удирдлагын зүгээс холимог сургалтын аргыг сургалтад ашиглахтай холбоотойгоор бий болох санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө мөнгө гаргаж шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг бэлэн болгож бэлтгэх, багш нарт холимог сургалтын аргаар хичээл заахтай холбоотой сургалт явуулах зэрэг дэмжлэгийн үйл ажиллагаатай холбогдоно (Radovan, 2017). Өөрөөр хэлбэл энэ хүчин зүйлээр багш нарт холимог сургалтын аргаар хичээлээ заахад биет болон биет бус нөөц тухайлбал техник хэрэгсэл, мэдлэг туршлага байна уу, үгүй юу гэдгийг хэмжинэ (Lakhal, 2013).

7. Техник, технологийн мэдлэг /Experience in technology use/

Техник технологийн мэдлэг хүчин зүйл нь багшийн техник технологийн талаар эзэмшсэн мэдлэг, чадвартай холбоотой (Deng, 2019). Багшийн техник технологийн чадвар болоод мэдлэгийн өнөөгийн түвшин нь холимог сургалтын аргыг ашиглах урам зоригийг нь нэмэгдүүлэх эсвэл эсрэгээрээ мохоож бууруулж ч болно (Bowyer, J., Chambers, L., 2017). Ийм учраас багшийн ноу-хаугийн өмнөх мэдлэг нь холимог сургалтын аргыг ашиглахад нь нөлөө үзүүлнэ (Ghazal, 2017).

8. Хүлээн авах байдал (холимог сургалтын арга (ХСА)-ыг ойлгож хүлээн авч байгаа байдал) /Perception towards Blended Learning/

Энэ хүчин зүйл нь багшийн зүгээс холимог сургалтын аргыг ашиглах, эс ашиглах тухай ухамсартайгаар төлөвлөсөн төлөвлөгөө хэр хэмжээнд байна вэ гэдэгтэй холбогдоно (Saleem, 2016). Тиймээс холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах байдал буюу багшийн зүгээс энэ аргад өгч байгаа үнэлэмж гэсэн энэхүү хүчин зүйлээр холимог сургалтын аргад багшийн зүгээс гаргаж буй зан үйлд нөлөөлөх мотивацийг олж илрүүлдэг (Desman, 2015). Түүнчлэн тус хүчин зүйл нь багшийн зүгээс холимог сургалтын аргыг хичээлдээ хэрэглэж үзэх үү, яах уу гэсэн ирээдүйн шийдвэрийг ч тодорхойлдог (Anthony, 2019).

Судалгааны түүвэр: Судалгаанд нийслэлийн ерөнхий боловсролын 31-р сургуулийн нийт 14 мэргэжлийн 43 багшийг санаандгүй түүврийн аргаар оролцууллаа. Судалгаанд хамрагдсан багш нарын 16,3% (7) нь эрэгтэй, 83,7% нь

(36) эмэгтэй байна. Багш нарын 13% буюу 6 багш 25-с доош настай, 13% буюу 6 багш 26-30 настай, 34% буюу 15 багш 31-35 настай, 27% буюу 12 багш 36-40 настай, 0.09% буюу 41-с дээш настай 4 багш байна. Мэргэжлийн зэргийн хувьд багш нарын 25% (11) багш зэрэггүй, 23% (10) багш заах аргач, 48% (21) багш тэргүүлэх, 0.02% (1) зөвлөх багш ажиллаж байна. Багш нарын улсад ажилласан нийт жилийг харахад 20% (9) багш 1-5 жил, 30% (13) багш 6-10 жил, 13% (6) багш 11-15 жил, 27% (12) багш 16-20 жил, 0.06% (3) багш 21-с дээш байна.

Судалгааны өгөгдөл цуглуулах процесс: 31-р сургуулийн удирдлага, сургалтын менежер, багш нарт судалгааны зорилго, агуулгын талаар мэдэгдэж тайлбарлаж судалгааны өгөгдлийг цуглуулсан. 2024 оны 4 сарын 03-ны өдрөөс 05-ын хооронд асуулгын хуудсыг багш нарт тараан өгч, хариултыг тэмдэглүүлж авсан. Мөн уг асуулгын судалгаагаар оролцогчдын хүйс, төрсөн он, мэргэжил, эрхэлж буй албан тушаал, мэргэжлийн зэрэг, боловсролын салбарт ажилласан жил гэсэн хүн ам зүйн өгөгдлийг нэгтгэн цуглуулж, нэрлэсэн ба дэс дараалсан хэмжигдэхүүний утгаар хэмжилт хийсэн. Холимог сургалтын аргыг хүлээн авах хандлагын хувьсагчдыг интервал утгаар хэмжсэн. Судалгаанд оролцсон 43 оролцогч бүх асуулт, айтемд бүрэн хариулсан тулд хасагдах өгөгдөл гараагүй.

Судалгааны **өгөгдлийг боловсруулсан арга зүй**: Цуглуулсан өгөгдлийг боловсруулахад Excel, SPSS 21 программ ашигласан. Судалгаанд ашиглаж байгаа хэмжилтийн загварын найдвартай байдлыг кронбахын альфа коэффициент, багш нарын холимог сургалтын аргыг ашиглаж байгаа эсэхийг давтамж, холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авч ерөнхий дүр төрхийг дискриптив, корреляци, багш нарын холимог сургалтын аргыг ашиглаж байгаа нь тэдний нас болон мэргэжлийн чиглэлээс хамааран ялгаатай байгаа эсэхийг шалгахад нэг замын анаво шинжилгээ хийв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Үр дүн 1: Найдвартай байдлын шинжилгээ

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын холимог сургалтын аргад хандах хандлагыг тодорхойлох хэмжилтийн загварын найдвартай байдлыг кронбах альфа коэффициентээр шалгасныг Хүснэгт 1-д харуулж байна.

Хүчин зүйлийн тоо	Кронбахын альфа	Айтемын тоо
8	.95	28

Хүснэгт 1. Найдвартай байдлын шинжилгээний үр дүн

Хүснэгт 1-ээс харахад 8 фактор бүхий 28 айтемаас бүрдсэн хэмжилтийн загварын найдвартай байдал ($\alpha=951$) буюу маш сайн байна.

Үр дүн 2: Давтамжийн шинжилгээ

Ерөнхий боловсролын сургуулийн багш нар холимог сургалтын аргыг ашиглаж байна уу үгүй юу, ашиглаж байгаа бол хэрхэн ашиглаж байна вэ гэдэг талаарх ерөнхий дүр төрхийг гаргахдаа давтамжийн шинжилгээ хийж үр дүнг График 1, 2, 3-д үзүүллээ.

Асуулт 1: Би хичээлээ ...

а) дан танхимаар заадаг. б) дан цахимаар заадаг. в) танхим, цахим хослуулж заадаг.




График 1. Хичээлийн хэлбэр

Хичээлээ ямар хэлбэрээр явуулж байгааг олж тодорхойлохын тулд багш нарын нэгж хичээл төлөвлөлтөд үндэслэн өгөгдлийг цуглуулсан. График 1-ээс харахад багш нарын 50% нь танхим, цахим хослуулсан хэлбэрээр, 50% нь дан танхимаар хичээлээ төлөвлөн зааж байна. Хичээлээ дан цахимаар зааж байгаа багш байхгүй байна.

Асуулт 2: Та танхим цахим хослуулан зааж байгаа бол ямар цахим платформ (сургалт удирдлах систем) ашиглаж байна вэ?

Асуулт 3: Та цахимаар хичээлээ заахдаа ямар ямар апп ашиглаж байна вэ?

Асуулт 4: Та цахим хичээлдээ ямар ямар хэрэглэгдэхүүн ашиглаж байна вэ?




График 2. Цахим хэрэгсэл

Танхим, цахим хосолсон холимог сургалтын аргаар хичээлээ зааж байгаа багш нар eschool.mn сургалт удирдах системийг сургалтандаа 100% ашиглаж байна. Холимог сургалтын арга ашиглаж байгаа эдгээр багш нарын 30% нь medlee.mn сайтыг, 30% нь socrative аппыг, 10% нь kahoot аппыг, 10% нь canva аппыг тус тус ашиглаж байгаа бол 10% нь ямар ч апп ашиглахгүй байна. Мөн багш нар PPT, audio, video, янз бүрийн link-ийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна.

Асуулт 5: Та нэгж хичээлийн төлөвлөгөөнд хичээлийн цагийг хэрхэн төлөвлөснөө бичиж өгнө үү. Нэг хичээлээ сонгон бичнэ үү.



График 3. Нэгж хичээлийн төлөвлөлтийн танхим болон онлайн цаг зарцуулалт

Судалгаанд оролцсон багш нар танхимд 72%, онлайнд 28% нэгж хичээлээ төлөвлөж байна. Багш нар шинэ хичээлийн агуулгыг хүргэхдээ 27% нь танхимд, 17% нь онлайнд цагаа төлөвлөдөг бол суралцагчаар шинэ хичээлийн агуулгыг давтуулах дадлага ажилд төлөвлөдөг цаг нь 30% нь танхимд, 11% нь онлайнд байна. Багш хичээлийн үнэлгээг хийхэд төлөвлөдөг цаг нь 15% байна.

Үр дүн 3: Дискриптив шинжилгээ

Холимог сургалтын аргаар хичээлээ удирдан зохион байгуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн багш нар энэ аргаа ямар түвшинд хүлээн авч байгааг судлахын тулд дискриптив шинжилгээ хийснийг Хүснэгт 2-д үзүүлж байна.

	Тоо	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж	Стандарт хазайлт	Түвшин
Хамт олны нөлөө	43	1.00	4.00	2.9922	0.70193	Сайн

Нөлөөлөл	43	1.00	4.00	2.8992	0.60266	Сайн
Төвөгтэй байдал	43	1.00	4.00	2.9457	0.65431	Сайн
Үр дагавар	43	1.00	4.00	3.062	0.66332	Сайн
Сургалтанд нийцэх байдал	43	1.00	4.00	2.9941	0.62079	Сайн
Сургуулийн дэмжлэг	43	1.00	4.00	3.0523	0.64301	Сайн
Техник, технологийн мэдлэг	43	1.00	4.00	3.1221	0.63736	Сайн
Хүлээн авах байдал	43	1.00	4.00	3.0174	0.63736	Сайн

Хүснэгт 2. Дискриптив шинжилгээний үр дүн

Холимог сургалтын аргаар хичээл зааж байгаа багш нарын хамт олны нөлөө ($M=2.99$, $SD=0.70$), холимог сургалтын аргын одоогийн үзүүлж буй нөлөөлөл ($M=2.89$, $SD=0.60$), ХСА-ын төвөгтэй байдал ($M=2.94$, $SD=0.65$), сургалтанд нийцэх байдал ($M=2.99$, $SD=0.62$) дунд түвшинд байгаа бол ХСА-ын урт хугацаанд бий болгосон үр дагавар ($M=3.06$, $SD=0.66$), сургуулийн дэмжлэг ($M=3.05$, $SD=0.64$), техник, технологийн мэдлэг ($M=3.12$, $SD=0.63$), ХСА-ыг хүлээн авах байдал ($M=3.01$, $SD=0.63$) байна. Холимог сургалтын аргад хандах багш нарын хандлагын түвшин сайн байна.

Үр дүн 4: Корреляцын шинжилгээ

Багш нар холимог сургалтын аргыг сургалтандаа ашиглахдаа эерэг ба сөрөг ямар хандлагатай байгааг тодруулахын тулд дараах 7 таамаглалыг дэвшүүлж, **корреляцын шинжилгээ** хийв. Корреляцын шинжилгээ нь харилцан хамааралтай буюу хоорондоо уялдаа холбоо бүхий хоёроос дээш хувьсагчдын хоорондын хамаарлыг үнэлнэ (Басбиш, 2022).

Таамаглал: Багш нарын холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах хандлага нь ...

1. Хамт олны нөлөөтэй эерэг хамааралтай.
2. Нөлөөлөлтэй эерэг хамааралтай.
3. Төвөгтэй байдалтай эерэг хамааралтай.
4. Үр дагавартай эерэг хамааралтай.



5. Сургалтанд нийцэх байдалтай эерэг хамааралтай.
6. Сургуулийн дэмжлэгтэй эерэг хамааралтай.
7. Техник, технологийн мэдлэгтэй эерэг хамааралтай.

Хамаарал	Хамаарлын тодорхойлолт	r	p	Үр дүн
H1	Хамт олны нөлөө	.72**	.00	Батлагдсан
H2	Нөлөөлөл	.60**	.00	Батлагдсан
H3	Төвөгтэй байдал	.67**	.00	Батлагдсан
H4	Үр дагавар	.59**	.00	Батлагдсан
H5	Сургалтанд нийцэх байдал	.77**	.00	Батлагдсан
H6	Сургуулийн дэмжлэг	.75**	.00	Батлагдсан
H7	Техник, технологийн мэдлэг	.72**	.00	Батлагдсан

***. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).*

Хүснэгт 3. Корреляцийн шинжилгээний үр дүн

Пийрсоны корреляцийн тестээс харахад холимог сургалтын аргыг хүлээн авах багш нарын хандлага тус аргыг ашиглахтай холбоотой бүх хувьсагчтай эерэг, хүчтэй хамааралтай байна (Burns, N. Grove, S.K., 2005). Тухайлбал хамт олны нөлөө ($r=.724^{**}$, $p=0.00$), нөлөөлөл ($r=.604^{**}$, $p=0.00$), төвөгтэй байдал ($r=.679^{**}$, $p=0.00$), үр дагавар ($r=.599^{**}$, $p=0.00$), сургалтанд нийцэх байдал ($r=.779^{**}$, $p=0.00$), сургуулийн дэмжлэг ($r=.752^{**}$, $p=0.00$), техник, технологийн мэдлэг ($r=.729^{**}$, $p=0.00$) байна.

Үр дүн 5: Нэг замын аново шинжилгээ

Хамааралт хувьсагч болох холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага нь үл хамааралт хувьсагч болох багш нарын насны ангилалаас хамааран ялгаатай байна уу, үгүй юу гэдгийг тодруулахын тулд нэг замын аново тест хийв. Тус тестээр эдгээр бүлгүүд хоорондоо ялгаатай байна уу, ялгаагүй байна уу, ялгаатай байвал аль бүлэг хооронд ялгаа байна вэ гэдгийг мөн тодорхойлдог.

Таамаглал 8:

Но: Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага, нас хооронд ач холбогдлын зөрүү байхгүй.

H1 Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага, нас хооронд ач холбогдлын зөрүү бий.

Хамааралт хувьсагч: Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн

хандлага

Үл хамааралт хувьсагчид: Багшийн нас (25-с доош, 26-30, 31-35, 36-40, 41-с дээш,)

	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Бүлгүүд хоорондох	100.005	4	25.001	.162	.956
Бүлгүүд доторх	5850.600	38	153.963		
Total	5950.605	42			

Хүснэгт 4. Нэг замын анова тестийг үр дүн-1

Анова тест нь F статистикийн утгыг тооцоолдог. Түүнчлэн тус шинжилгээнд бүлгүүд хоорондох ялгааг тайлбарлахдаа ач холбогдол буюу p утгыг тайлбарлана. Дээрх хүснэгтээс харахад [$F=.162$, $P=.95$] буюу $p>0.05$ гарсан бөгөөд ХСА-д хандах багшийн хандлагыг илэрхийлсэн бүх хувьсагч болон багшийн нас хооронд ялгаа байхгүй байна.

Таамаглал 9:

Но: Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага, мэргэжлийн чиглэл хооронд ач холбогдлын зөрүү байхгүй.

H1 Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага, мэргэжлийн чиглэл хооронд ач холбогдлын зөрүү бий.

Хамааралт хувьсагч: Холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах багшийн хандлага

Үл хамааралт хувьсагчид: Багшийн мэргэжлийн чиглэл (гадаад хэл, математик, мэдээлэл зүй, түүх, нийгэм, монгол хэл, бичиг, уран зохиол, физик, биеийн тамир, технологи, эрүүл мэнд, биологи, газарзүй, бага анги)

	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Бүлгүүд хоорондох	1200.285	9	133.365	1.375	.239
Бүлгүүд доторх	3201.761	33	97.023		
Total	4402.047	42			

Хүснэгт 5. Нэг замын анова тестийн үр дүн-2

Хүснэгт 5-аас харахад ХСА-д хандах багшийн хандлагыг илэрхийлсэн бүх хувьсагч болон багшийн мэргэжлийн чиглэл хооронд ялгаа байхгүй байна. [$F=1,375$, $p=.23$]

СУДАЛГААНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮГНЭЛТ

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын танхим, цахим хосолсон холимог сургалтын аргын талаарх үнэлэмж сайн (Mean 3.05, St.D 0.63470) байна.

Багш нарын холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авч буй хандлага нь холимог сургалтын аргыг ашиглахтай холбоотой бүх хувьсагчидтай эерэг хамааралтай, хамаарлын түвшин нь хүчтэй байна (Cohen, 1988). Ингэснээр дэвшүүлсэн 7 таамаглал батлагдлаа. Өөрөөр хэлбэл тус судалгаанд хамрагдсан НЕБ-ийн 31-р сургуулийн багш нар холимог сургалтын аргыг хичээл, сургалтдаа эерэгээр хүлээн авч ашиглаж байна. Энэ нь тус сургуулийн багш удирдлагууд энэ аргыг сургалтанд ашиглахдаа нэг нэгнээ туслан дэмжиж байгаа, багш нар энэ аргыг хичээлдээ ашиглах дуртай, энэ арга нь ашиглахад бэрхшээл багатай, энэ аргыг хэрэглэсний сайн үр нөлөө урт хугацаандаа бий болж байгаа, багш нарын хичээл заах арга зүйгээ сайжруулж байгаа, сургуулийн зүгээс багш нарт техник хэрэгсэлтэй болоход тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа, багш нарын техник технологийн мэдлэг боломжийн байгаа зэрэгтэй холбоотой юм.

Судалгаанд хамрагдсан багш нарын холимог сургалтын аргад хандах хандлага болон нас хоорондын ач холбогдол нь $p > .05$ түвшинд [$F = .162$, $p = .95$], мөн багш нарын холимог сургалтын аргад хандах хандлага мэргэжил хоорондын ач холбогдол нь $p > .05$ түвшинд [$F(1.375, p = .23)$] тус тус статистикийн хамааралгүй болох нь тогтоогдлоо. Энэ нь p утга 0.05-с их буюу 0.95, 0.23 гарсан тул үл хамааралт хувьсагчид нь хамааралт хувьсагчтай нөлөөлөлгүй болохыг харуулсанаар “Таамаглал 8, 9”-ын тэг таамаглал батлагдаж, алтернатив таамаглал няцаагдлаа. Энэ үр дүн нь багш нарын нас болон мэргэжлийн чиглэл нь холимог сургалтын аргыг ойлгож хүлээн авах байдалд ялгаатай байдал үүсгэхгүй байгааг харуулж байна.

Энэхүү судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн багш нар холимог сургалтын аргыг хэрхэн ашиглаж байгаа, хэрхэн ойлгож хүлээн авч байгаа, тэдний нас болон мэргэжлийн чиглэл нь тус аргыг хичээлдээ ашиглахад нөлөөлж байна уу, үгүй юу гэсэн асуултыг тавьсан судалгааг хийснээр ерөнхий боловсролын сургуулийн багш нар холимог сургалтын аргыг хичээлдээ амжилттай сайн ашиглаж байгааг ерөнхий дүр төрхийг олж илрүүллээ. Гэхдээ цаашид холимог сургалтын аргыг амжилттай ашиглаж байгаа багш нар болон тэдний сурагчдынх нь сурлагын амжилт хооронд нөлөөлөл бий эсэхийг мөн холимог сургалтын аргыг ашиглахгүй байгаа багш нар яагаад энэ аргыг ашиглахгүй байгаа зэргийг үргэлжлүүлэн судалж тайлбарлах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

1. Al-Khaldi, M. A. (1999). The influence of attitudes on personal computer utilization among knowledge workers: The case of Saudi Arabia. *Information & Management*, 36 (4), 185-204.
2. Alico, Guimba. (2015). Reading Anxiety and Comprehension of Grade 8 Filipino Learners. *International Journal of Humanities and Social Science*, 44-59.
3. Anthony, B. ., (2019). Exploring the role of blended learning for teaching and learning effectiveness in institutions of higher learning: An empirical investigation. *Education and Information Technologies*, 24 (6), 3433-3466.
4. Bath, D. ., (2011). The blending of blended learning: An experimental approach to academic staff development. *ASCILITE* , 4-7.
5. Bervell, B. ., (2020). Blended learning or face to face? Does Tutor anxiety prevent the adoption of Learning Management Systems for distance education in Ghana? . *Open Learning: The Journal of Open, Distance and e-Learning*, 35 (2), 159-177.
6. Bokolo, A. J. (2021). Examining the adoption of emergency remote teaching and virtual learning during and after COVID-19 pandemic. *International Journal of Educational Management*. <https://doi.org/10.1108/IJEM-08-2020-0370>.
7. Bowyer, J. , Chambers, L. (2017). Evaluating blended learning: Bringing the elements together. *Research Matters: A Cambridge Assessment Publication*, 23, 17-26.
8. Brand, J. K. (2011). iWant does not equal iWill: Correlates of mobile learning with iPads, e-textbooks, BlackBoard Mobile Learn and a blended learning experience. *University of Tasmania* (хуудсд. In Proceedings ASCILITE 2011: 28th annual conference of the Australian society for computers in learning in tertiary education: Changing demands, changing directions). 168-178.
9. Burns, N. Grove, S.K. (2005). *The Practice of Nursing Research: Conduct, Critique and Utilization*. 5th edition. Missouri: Elsevier Saunders.
10. Carbonell, K. B.-H. (2013). Unleashing the creative potential of faculty to create blended learning. *The internet and Higher Education*, 18, 29-37.
11. Cohen, J. (1988). *Statistical Power Analysis for the Behavioral Sciences (2nd ed)*. Hillsdale : NJ: Lawrence Erlbaum Associates, Publishers .
12. Decman, M. (2015). Modeling the acceptance of e-learning in mandatory environments of higher education: The influence of previous education and gender. *Com-*



- puters in Human Behaviour*, 49, 272-281.
13. Deng, F. . (2019). Progress and new directions for teaching and learning in MOOCs. *Computers & Education*, 129, 48-60.
 14. Gawanda, V. (2015). Development of blended learning model based on the perceptions of students at higher education institutes in Oman. *International Journal of Computer Applications*, 114 (1), 38-45.
 15. Ghazal, S. . (2017). Critical factors to learning management system acceptance and satisfaction in a blended learning environment. *International conference of reliable information and communication technology. Springer* , 688-198.
 16. Graham, C. R. (2013). A framework for institutional adoption and implementation of blended learning in higher education. *The Internet and Higher Education*, 18, 4-14.
 17. Ibrahim. (2011). Students Perceptions of Using Educational Games to Learn Introductory Programming. *Computer and Information Science*, 205-216.
 18. Jnr, B. A. (2021). Institutional factors for faculty members' implementation of blended learning in higher education. *Education+Training*, 63 (5), 278-291.
 19. Kocaleva, M. . (2014). Research on UTAUT application in higher education institutions. *International conference on information technology and development of education* , 34-38.
 20. Lakhal, S. . (2013). Student behavioural intentions to use desktop video conferencing in a distance course: Integration of autonomy to the UTAUT model. *Journal of Computing in Higher Education*, 25 (2), 93-121.
 21. Lopez-Perez et al. (2011). Blended learning in higher education: Students' perceptions and their relation to outcomes. *Computers & Education*, 56 (3), 818-826.
 22. Malone, O. Y. (2020). Preservice teachers perceptions about the use of blended learning in a science education methods course. *Smart Learning Environments* 7: 18, 2-21.
 23. Manghirmalani-Mishra, R. S. (2020). Perception of In-Service Teachers Towards Blended Learning as the New Normal in Teaching-Learning Process Post COVID-19 Pandemic . *Research Square*.
 24. Poon, J. (2012). Use of blended learning to enhance the student learning experience and engagement in property education. *Property management*, 30 (2), 129-156.
 25. Radovan, M. . (2017). Acceptance of technology and its impact on teacher's activities in virtual classroom: Integrating UTAUT and CoI into a combined model. *Turkish Online Journal of Educational Technology-TOJET*, 163 (3), 11-22.

26. Saleem, N. E.-S. (2016). Acceptance of Moodle as a teaching/learning tool by the faculty of the department of information studies at Sultan Qaboos University, Oman based on UTAUT. *International Journal of Knowledge Content Development & Technology*, 6 (2), 5-27.
27. Taherdoost, H. (2018). A review of technology acceptance and adoption models and theories. *Procedia Manufacturing*, 22, 960-967.
28. Tarhini, A. ,.-B. (2017). Factors influencing students' adoption of e-learning: a structural equation modeling approach. *Journal of International Education in Business*, 10, 164.v
29. Thompson, R. L. (1991). Personal computing: Toward a conceptual model of utilization . *MIS Quarterly*, 15, 125-143.
30. Thompson, R. L. (1994). Influence of expertise on personal computer utilization: Testing a conceptual model. *Journal of Management Information Systems*, 11 (1), 167-187.
31. Triandis, H. S. (1979). Values, attitudes, and interpersonal behaviour . *University of Nebraska Press*.
32. Басбиш, Ц. (2022 оны 11 17). Судалгааны статистик боловсруулалт. Улаанбаатар , Монгол.
33. Т. Мягмарсүрэн, Т. Амармэнд. (2024). *Холимог сургалтын аргыг хэрэгжүүлэхэд багшийн хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа*. Улаанбаатар.

ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН ТЕХНОЛОГИ



Б.БАЛЖИН

Мөнх хааны гэрэлт хөшөө Уран бичлэгийн дурсгал
болох нь

МӨНХ ХААНЫ ГЭРЭЛТ ХӨШӨӨ УРАН БИЧЛЭГИЙН ДУРСГАЛ БОЛОХ НЬ

Магистр, Б.Балжин

(ОУУБИС. ИДТС)

baljin.b@ulaanbaatar.edu.mn

Title: The Inscribed Stele of The Munkh Khan As a Monument of Calligraphic Art

Author: B. Baljin, Lecturer, Department of Design, School of Engineering, Design, and Technology, International University of Ulaanbaatar

Abstract.

Numerous ancient inscriptions have been discovered throughout the Mongolian steppes. The steles, stones, and wall inscriptions created by ancient nomads are not only valuable linguistic, cultural, and artistic heritages of Mongolia but also of global historical significance. These inscriptions are distinguished by their unique styles, artistic brushstrokes, scripts, and compositions, reflecting a distinct aesthetic in the sociocultural and artistic realms. This distinctiveness is particularly evident in the traditional vertical writing style, from top to bottom. Royal decrees, steles, and various other inscriptions carved into stone and walls reflect the history, culture, and national identity of the Mongolian people.

The Inscribed Stele of the The Munkh Khan is one such representative artifact, found in Mongolia and dating back to the 13th century. It exemplifies the development of written language during that era. This stele not only expresses the power and authority of the Khan but also embodies the unique tradition of Mongolian calligraphy. Its composition features rhythmic and asymmetrical arrangements balanced through spatial design, making it a remarkable monument of artistic expression.

Keywords: Mongolian script, calligraphy, style, typeface, proportion, composition.

Хураангуй. Монгол нутгаас эртний бичээсүүд элбэг олдсон байдаг. Эртний нүүдэлчдийн бүтээсэн гэрэлт хөшөө, чулуу, хана туурган дээрх бичээсүүд нь монголчуудын төдийгүй дэлхийн түүхийг агуулсан хэл шинжлэл, соёл, урлагийн үнэт өв юм. Эдгээр нь нийгэм, соёл, урлагийн ертөнцөд өөрийн өвөрмөц хэв маяг бүхий төрх, уран сайхан зурлага, тиг, зохиомжоороо ялгардаг. Энэ ялгарч буй төрх байдал нь дээрээс доош босоо чиглэлд бичдэг уламжлалт хэв маягт оршиж байна.



Хаадын зарлиг, гэрэлт хөшөө болон бусад төрөл бүрийн бичээсийг чулуу, хана туурганд дээр сийлж үлдээсэн нь түүх, соёл, үндэсний хэв маяг, дүр төрхийг агуулж байдаг.

Мөнх хааны гэрэлт хөшөө бол монгол нутгаас олдсон, XIII зууны бичиг үсгийн хөгжлийг харуулсан, чулууны бичээсийг төлөөлөх бөгөөд хааны сүр хүчийг илэрхийлсэн, монгол бичгийн өвөрмөц уран бичлэгийн уламжлалыг агуулсан, бичээсүүдийг зохиомжилсон хэлбэр нь хэмнэлтэй, тэгш бус хэмийг орон зайгаараа тэнцвэржүүлсэн уран сайхны шийдлээрээ онцгой дурсгал юм.

Түлхүүр үг: Монгол бичиг, уран бичлэг, хэв маяг, тиг, харьцаа, зохиомж.

ОРШИЛ

Монголчууд 10 гаруй үсэг, бичгийг хэрэглэж, тэдгээр нь хад чулуу, хана туурга, зоос, пайз, тамга, зарлиг, захидал, судар, номонд хадгалагдан уламжилж ирсэн байна. Гадаадын болон монголын олон арван эрдэмтэд нүүдэлч өвөг дээдсийн хад чулуу, хана туурга, гэрэлт хөшөөний бичиг, үсгийн дурсгалыг түүх, археологи, соёл, хэл шинжлэлийн чиглэлээр судалж шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмрийг оруулсаар байна.

Гэрэлт хөшөө, чулууны бичээс нь түүхийн баримт, хэл шинжлэлийн эх сурвалж, соёлын дурсгал төдийгүй дүрслэх урлагийн бүтээл юм. Тухайн бичээс урлагийн түвшинд хамаарах эсэх нь түүний илэрхийлж буй агуулга, гоо зүй, дүрслэх урлаг, үсгийн урлагийн элементүүдээр илрэх бөгөөд үүнийг бичиг үсгийн урлаач, зураач, урлаг судлаачид шинжлэн судалгааны эргэлтэд оруулж, санал шүүмжийг хэлэлцэх хэрэгтэй юм. Монголчуудын бичиг, үсгийн дурсгалын зохиомж, уран сайхны шийдлийг судалсан дүрслэх урлагийн судалгаа нь тун хомс байна. Түүх, соёл, хэл шинжлэлийн эрдэмтэд монголчуудын гэрэлт хөшөө, чулууны бичээсүүдийн түүх, бичээсийн агуулга, үсэг зүй, бичгийн соёл зэргийг судлан, олон зуун эрдэм шинжилгээний бүтээл, өгүүллэг, ном товхимлууд гаргасан нь дүрслэх урлаг, график дизайны судлаачдад мэргэжлийн зүгээс шинжлэн судлах орон зай, боломжийг олгоод байна.

Мөнх хааны гэрэлт хөшөө нь үсгийн урлагийн бүтээл болохыг тодорхойлж, бичээсийг бүтээсэн зохиомжийн шийдлийг шинжлэх зорилгоор дараах зорилтуудыг тавин ажиллаа. Үүнд: Мөнх хааны гэрэлт хөшөөг судалсан эрдэмтдийн бүтээлүүдийг уншиж танилцах; судлаачдын уран бичлэгийг тодорхойлсон ажилтай танилцах, хөшөөний бичээсийн зохиомжид оролцож буй урлаг, гоо зүйн элементүүдийг тодорхойлох; бичээсийн зохиомжийн байгуулалт хийж дүн шинжилгээ хийсэн болно.

Бидний судлан буй Мөнх хааны гэрэлт хөшөөг анх 1953 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс томилон илгээсэн О.Намнандорж ахлагчтай хээрийн шинжилгээний баг Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэрхааны өвөр, Дэлгэр мөрний хойд хөвөө Алтан гадас уулын ар талд нэгэн балгасны тууринд байсныг илрүүлэн судлаж XIII зууны үед холбогдохыг нотолсон байна. Тахилгын сүм мэт зүйлийн дотор хадгалагдаж байсан нь малтлагын явцад ажиглагдсаныг тэмдэглэсэн байдаг (Намнандорж 1956, 28). Эртний энэ туурийг судлаачид хуучны монгол сурвалжид нэр дурдагддаг Юань улсын үеийн Эрчүүгийн балгас гэж үздэг байна. Монгол бичиг, хятад ханз үсэг бүхий уг хөшөөний монгол бичээст “... Мөнх хаан түмэн түмэн насалтугай...” хэмээсэн нь хааныг амьд ахуй цагт бүтээсэн, хятад бичээсийг тайлж уншсанаар Мөнх хааны долдугаар оны улаагчин могой жил буюу 1257 онд хааныг Сүн улсыг гурван замаар байлдаж явсан үед түүний өлмий бат оршихыг ерөөж, тавнан Бамту (Барс түгэ) гүнж Исижи (Исүгэй) нар босгосон болохыг (Цэвээндорж 2006, 209) тодорхойлсон байна. Энэ нь өнөөгийн байдлаар монгол бичгийн хамгийн эртний дурсгал болох ОХУ-ын Санктпетербургийн Эрмитажид хадгалагдан буй “Чингисийн чулууны бичиг”-ээс 30 гаруй жилийн дараа бүтээж босгожээ.

Монгол бичээсийн нэгдүгээр мөр нь “Уругун уругугар хэдэн хэдэн үест”, хоёрдугаар мөрөнд “Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж барс түгэ босгуулж” хэмээгээд гуравдугаар мөрөнд “хөндлөн энэ дабаригт (учралт) буян хүртүгэй” гэсэн болохыг О.Намнандорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин нар судлан тайлж уншин бүтээлдээ¹¹ **тайлбарласан байдаг**. Нэрт эрдэмтэн Николас Поппе уг хөшөөний монгол бичээсийн тайлсаныг шүүмжилж, дэлгэрэнгүй тайлбарласан нийтлэлдээ мөр тэтгэсэн хоёрдугаар мөрийг эхэлж уншаад нэг, гуравдугаар мөрийг уншвал өгүүлбэр утга төгөлдөр болох юм гэсэн санал дэвшүүлсэн (Рорре, 1961, 14–18) байна. Үүнд эрдэмтэд “босгуул...” гэсэн үгийн төгсгөл ямар байсан нь тодорхойгүй тул эргэлзээтэй гэж үзсэн байдаг.

Ханз үсгийн бичээст тавнан Барс түгэ тэнгэрийн өршөөлд нийцэхийг эрмэлзэж, гэр бүл, үр удмаа аз жаргалтай байлгахыг хүссэн залбирал, Мөнх хааны ач буянаар хангалуун амьдарч байгаадаа талархаж, түүнд урт насалж, гүрэн улсаа хөгжин бадруулахыг ерөөсөн агуулгатай байдаг. Хөшөөний магнайн бичээс

¹¹ Эхний судалгааг 1956 онд О.Намнандорж, 1957 онд Ц.Дамдинсүрэн нар хийж, гэрэлт хөшөөний бичээсийн орчуулга болон тайлбаруудыг нийтэлсэн. “Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай” болон «Монголын XIII–XVII зууны уран зохиолын түүх» зэрэг бүтээлүүд хэвлэгдсэн. Тус хөшөөний хятад үсэг нь нийт 263, үүний дотор 207 үсэг нь бүтэн, 5 үсэг нь хагас эвдэрхий, 51 үсэг нь бүрмөсөн эвдэрсэн гэж О.Намнандорж бүртгэлдээ тэмдэглэсэн байна. 1959 онд Б.Ринчен монгол бичээсийн орчуулга болон гэрэлт хөшөөг тайлбарласан нийтлэл гаргаж, түүний байрлаж байсан газрын барилга байгууламж, туурийн бүдүүвч зургуудыг оруулсан байдаг.(Ренчин, 1959, х.135).



болон үндсэн дэлгэрэнгүй бичвэрийг хятад хэл, ханз үсгээр бичсэнийг судлаач А.Г.Люлина, К.В.Батыгин нар өгүүлэлдээ тайлбарлахдаа “Тухайн цаг үеийн ойрадын түшмэдүүд, тэр дундаа Мөнх хаан хятад хэлтэй байсан байж магадгүй. Бичээст хятадын даос, конфуцианизмын бүтээлүүдээс иш татсан үгс байгаа нь тухайн үеийн шашин, философийн синкретизм¹²-ийг харуулж байна” гэж өгүүлсэн байна. Мөн хятад хэлийг ашиглах бас нэг чухал шалтгаан нь ханз үсгээр хязгаарлагдмал талбайд мэдээллийг багтааж илэрхийлэх боломж нь илүү байсан” (Люлина А.Г. Батыгин К.В. 2023) гэжээ. Харин хятадын судлаач Ху Байгийн үзэж буйгаар тэр үед буддизм хятад хэлний Чань хувилбараар Монголд нэвтэрсэнтэй холбоотой. Бичээсийн эхийг боловсруулахад хятад лам нар оролцсон бөгөөд тэд хятад судар, шашны номлолд тулгуурласан (Ху, Бай, х. 258) гэсэн нь байж болох тайлбар бөгөөд үүнтэй санал нийлж байна.

УРАН БИЧЛЭГ

Уран бичлэг нь тухайн үсгийн бүтэц, хэлбэрийг тусгах шаардлагатай боловч үндсэн зураас, түүний хэлбэр, мөн тэдгээрийн хоорондын зай, үсэг тэмдэгтүүдийн холболт, төгсгөл, үзэг, бийрийн даралт, өргөлтийн хослолын аргыг ашиглан, бичих талбайн хэмжээ харьцаанаас хамаарна. Мөн бичвэрийн бүтэц, мөр, эгнээ (багана) хоорондын зай нь ялгаатай байж өөр өөрийн гоо зүйн шинж чанарыг харуулдаг. Гоо зүй нь мэдрэмжийн туршлагад үндэслэж, байгаль, амьдрал эсвэл урлагийг үнэлэхэд хүн ямар мэдрэмж болон сэтгэл хөдлөлд орж, таашаал авдагийг судалдаг. Иймээс гоо зүйд гоо зүйн туршлага, мэдрэмж, сэтгэл хөдлөл, таашаал, гоо зүйн мэдрэмж гэх мэт ойлголтууд хамгийн түгээмэл хэрэглэгддэг.

Бичиг үсэгтэй улс орон бүрт уран бичлэг хөгжсөн байна. Азийн орнуудаас Хятад, Япон, Солонгос, өрнө дахинаас Араб, Европын орнуудад хөгжсөн урлаг юм. Европ, Арабд ихэвчлэн хулсан болон төмөр үзгээр бичдэг. Тухайн улс үндэстний бичгийн онцлог Харин Азийн орнуудад бийрээр бичдэг бол монголчууд орон үзэг болон бийрэн бичлэг хоёуланг нь ашиглаж ирснийг хаадын захидал, судрын хуудаснаас бид хардаг.

“Үзэг ашиглан урлагийн түвшинд бичсэн, олон төрлийн хэлбэртэй, өөрийн гэсэн онцлогтой уран бичвэрийг хэлдэг” (Саскиа, 2020). “Уран бичлэг хэмээх нэр томъёо нь ерөнхий ойлголт бөгөөд зөвхөн араб хэл төдийгүй хятад, латин,

¹² Синкретизм гэдэг нь өөр өөр шашин, соёл, философийн үзэл санаа, зан үйл, уламжлалуудыг нэгтгэж, шинэ нэгдмэл тогтолцоо бий болгох үйл явцыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн янз бүрийн соёл, шашны уламжлал харилцан үйлчилж, нэгдэж, шинэ хэлбэрийг үүсгэх үед тохиолддог. Синкретизм нь соёл, шашин, хэлний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж, шинэ үзэл санаа, уламжлал, хэлбэрүүдийг бий болгоход нөлөөлдөг.

еврей зэрэг олон хэлний бичлэгийн урлагт хэрэглэгддэг. Араб хэлэнд “Хатт” гэж нэрлэдэг ба энэ нь араб уран бичлэгийн урлагийг илэрхийлдэг” (Sirojuddin, AR, 2015). Маъруф Зурэйкийн тайлбарласнаар каллиграфи гэдэг нь “үг, хэллэгийг үсгийн дүрслэлээр урлан гаргасан урлагийн бүтээл” юм. Энэ нь бичгийн эхнээс төгсгөл хүртэл үсгүүдийн байрлалыг ойлгож, хэрхэн байрлуулж байгааг мэдэх боломжийг олгодог (Сухарно ба Мухтаром, 2021). Уран бичлэг гэдэг нь зүгээр л сайхан бичиг бус, өөрийн гэсэн ухаан, дэг журамтай урлаг юм. Исламын урлагт уран бичлэг нь бичлэгийн дүрэм болон урлагийн дүрмийг хослуулсан, утга санааг гажуудуулахгүйгээр, гоо сайхнаар илэрхийлсэн бичвэрийг хэлдэг (Dea Adinda, 2024, 16).

Судлаач Поужа Верма “Уран бичлэг нь гар бичмэлээр тэмдэгтүүдийг бүтээлчээр уран бичиж, тэдгээрийг уран зохицолтой байрлуулах урлаг юм. Энэ нь үгсийг сэтгэл татам, уламжлалт мэдрэмж төрүүлэхүйц, хэмнэлтэй зохиомжлох, бүтээлч эрч хүчийг шингээсэн байдлаар бичих ур чадвар, арга техникүүдийн цогц юм”(Pooja Verma. 2019. 204) хэмээн тодорхойлсон байдаг.

Хятадын судлаач Шиги Гао судалгааны өгүүлэлдээ “... Уран бичлэг нь зураасны өвөрмөц хэрэглээ, бичих хэмнэлээр дамжуулан гоо зүйн шинжүүд илэрдэг. Бичгийн бүтээлийн гоо зүй нь үсэг бүрийн тэгш хэм, тэнцвэрт байдлаар хязгаарлагдахгүй, мөн янз бүрийн зурлагын хэлбэр, үсгийн хэлбэржилт, зохиомжийн тулгуур дүрсийн байрлал, зохиомжийн бүтэц, тэдгээрийн зохицлоор тодорхойлогддог байна. Тухайлбал, бичээсийн эхлэл, үргэлжлэл, төгсгөл хэсгийг хэрхэн гүйцэтгэж байгаагаас тухайн бүтээлийн харагдах байдал шууд нөлөөлдөг. Бичээчээс бийр, бэхний хэрэглээний нарийн хянуур чадвар шаардахын зэрэгцээ бүтээлийн ерөнхий зохиомжид өндөр мэдрэмжтэй хандахыг шаарддаг. Ингэснээр нүдэнд таатай, зохицсон уран дүрслэл бий болно. Бичээчид үсгийн бүтцийг гүнзгий ойлгож, зурлагын зузаан, урт, муруйд өөрчлөлт оруулан, уран сайхны үнэ цэнэтэй бүтээл туурвидаг” (Shiqi Gao, 2024) гэж тайлбар хийсэн байна.

Судлаач Лижуан Пү “Уран бичлэг нь бийрээр бичиж буй зураасны хэлбэрт тулгуурлан оршин тогтнодог. Зураас нь үсгийг бүрдүүлэх хамгийн чухал хэсэг бөгөөд уран бичлэгийн бүтээлийн түвшин зураасны чанараас шалтгаална. Уран бичээч нар хүчирхэг, эрч хүчтэй зураасанд ач холбогдол өгдөг. Хятадын эртний судлаачид уран бичлэгт зураасыг тодорхойлох олон нэр томъёог хэрэглэж ирсэн бөгөөд үүнд товч тодорхой, дотоод хүчтэй, жад, сүх мэт хурц, нэвт сүлбэсэн гэх мэт үгс багтдаг. Эдгээр нь зураасыг хүчний талаас нь дүрсэлсэн үгс юм. Хүчирхэг, эрч хүчтэй зураас нь хамгийн сайн гэж үзэхийн шалтгаан нь бийрийн даралт, өргөлт, хурд, цаас, бэх, бийрийн харилцан үйлчлэл амьдлаг харагдуулдагт оршино (Lijuan Pu, 2016, 380).



Судлаач Лю Ванг “Уран бичлэг нь бийрийн татлага, бэхний илэрхийллийн гоо сайханд анхаарч, бэх ашиглалт, бийрийн хөдөлгөөн, бүтэц, зохиомж, уран сайхны төсөөлөл зэрэг илэрхийллийн аргуудыг чухалчилдаг. Харин чулуун бичээсийн хувьд, үсэг сийлэх хутганы техник, уран бичлэгийн бийрийн татлага, хөдөлгөөнийг хадгалах, бүтэц болон хэлбэрийн уран сайхны илэрхийллүүдэд илүү их ач холбогдол өгдөг (2023, 44)” болохыг тэмдэглэсэн байна.

Дээрх судлаачдын уран бичлэгийн тухай өгүүлсэн тодорхойлолтуудыг дүгнэж үзвэл;

- Улс үндэстэн өөрийн хэлийг тэмдэглэдэг бичиг үсгээр утга санаа, түүхийг тодорхой талбайд уран сайхнаар зохиомжилж илэрхийлсэн, хүний сэтгэл хөдөлгөсөн гоо зүйтэй, цаас болон бусад материал дээр бийр болон үзгээр гараар бичсэн бичиг юм.
- Тэрхүү бичиг нь өөрийн үсгийн онцлогийг зохиомжийн элементүүдээр дэмжигдэн утга санаагаа хүний сэтгэлийг хөдөлгөх уран сайхнаар илэрхийлэгдсэн байна.
- Үсэг бичгээр тухайн үндэс утгаатны бусдаас ялгарах онцлог илэрдэг. Үндэсний хээ угалз, чимэглэлтэй нийцдэг. Мөн тухайн үндэс утгаатны нийтлэг шашин, философи, түүх, хэл соёлтой холбоотой байна.

“... Зохиомжийн уран сайхны илэрхийлэл гэдэг нь уран бүтээлийн санаа, зорилгыг тод, нарийн, гоо зүйн дээд хэлбэрээр гүн гүнзгий илэрхийлэх чадвар бүтээлд илэрч байгаа шинж чанар юм. Уран сайхны илэрхийлэл бол зохиомжийн эцсийн үр дүн, зорилго, оргил цэг нь билээ” хэмээн судлаач Р.В.Паранюшкин (2005, 52) бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.

Урлагийн аливаа хэлбэр нь гоо зүйд тэмүүлэхгүйгээр оршин тогтнох боломжгүй. Ихэвчлэн сүр жавхлан, баяр баясал, харуусал гунигт байдлын мэдрэмжээр илэрдэг. Дүрслэх урлагийн үндсэн бүрдүүлбэр (element)-ийн хувьд зураас, хэлбэр дүрс, сул орон зай, эзэлхүүн, ялгарал, өнгө ба бүтцийг бүтээлийн гоо зүйн үндэс суурийг бүрдүүлэгч гэж үздэг. Үсгийн урлагт ч мөн гоо зүйн мөн чанар олон талаараа илэрдэг. Үүнд үсгийн зурлага тиг, бичгийн хэлбэр, харьцаа, хэв маяг, мөр, эгнээ хоорондын зай, түүгээр илэрхийлэгдэх хэмнэл давтамж, зохиомж түүний бүтэц зэргийг авч үздэг байна. Хаадын зарлиг, захидал, гэрэлт хөшөөний бичээс дэх монгол бичгийн тиг нь хичээнгүй бичгээр хааны сүр хүчийг харуулсан эгц нуруутай, эрчтэй сүүл, орхицтой илэрхийлсэн байдаг нь уг хөшөөний бичээст мөн тусгагдсан байна.

МӨНХ ХААНЫ ГЭРЭЛТ ХӨШӨӨ БА УРАН БИЧЛЭГ

Мөнх хааны гэрэлт хөшөөний өндөр нь 144 см, өргөн 78 см, зузаан 20 см хэмжээтэй, оройн хэсгийг дугуйруулж зассан хавтгай хөх занар чулуун¹³ дээр магнай хэсэгт “Шагжа сүмийн хөшөөний тэмдэглэл” гэсэн хятад ханз таван үсэг (Б.Сайшаал. 2004, 276), түүний доор зүүн гар талд монгол бичгээр гурван мөр, 18 үгтэй, хоёрдугаар мөр болох Мөнх хааны нэрийг мөр тэтгэн бичсэн. Баруун хэсэгт нь 12 мөр, 268 хятад ханз бичээстэй. Нийт бичээсийн хоёр хажуугийн хүрээ нь 3,5 см өргөн эвэр угалзаар чимэглэсэн, магнай 5 хятад ханз бичээс ба үндсэн бичвэрийн дунд хөндлөн урт зураасыг ухаж сийлсэн байна (Зураг 1). Хөшөө хүрэн боржин суурьтай байсан бөгөөд урт нь 100 см, өргөн 68 см, өндөр 40 см, түүнд 46 см урт, 20 см гүн, 20 см өргөн углуурга гарган хөшөөг бат бөх тогтоож суулгасан байжээ.

Хөшөөний чулууг бэлтгэн боловсруулж, нүүрийн бичих талбайг тооцон урьдчилан эхийг бэлтгэж, зохиомжийн тойм зураг гаргаад, түүнийгээ чулуун дээрээ буулган бийрээр бичиж тэмдэглээд сийлсэн нь үсгийн хэлбэрээс харагдаж байна.

Хөшөөнийн бичээсийг магнай ханз бичиг, монгол болон хятад бичиг гэсэн гурван хэсэг бүлэглэсэн байна. Хөшөөнд байгуулалт хийж, хэмжилт хийхэд нийт бичээсийн талбайн өргөн (нэг талын хээнээс нөгөө талын хээ хүртэл)- ий зайг 5 хуваасны 2-ыг монгол бичээс, 3-ыг хятад бичээс эзэлж байна. Мөн 10 хуваасантай ижил зай нь монгол бичээсийн мөр хоорондын зайг тодорхойлж байна. Хятад бичээсийн мөр хоорондын зай монгол бичээсийнхээс 2 дахин бага байна. *Зураг 2.*

Хөшөөний бичээсийг бүрдүүлж буй үндсэн элемент нь үсэг бөгөөд монгол бичгийн үсгүүдийн нурууны дагуух босоо үндсэн шугам чухал үүрэгтэй нь зохиомжид харагдаж байна. Монгол бичиг нь дээрээс доош босоо чиглэлд авиан дуудлагаар үсгийг залгаж, зүүнээс баруун мөрлөж бичдэг. Бичигдэж буй үгийн уртаас хамаарч янз бүр байх ба хоёр тал руу үсгийн зурлагууд бичигдэх тул мөр хооронд орон зай их шаардлагатай байдаг. Харин хятад ханз нь дүрс үсгийн хэлбэртэй, тухайн үеийн хятад бичээс баруун мөрөөс зүүн тийш, дээрээс доош чиглэлтэй уншигдана. Өөрөөр хэлбэл, бичээсийн эхний үсэг нь хөшөөний баруун дээд буланд байрлаж доош чиглэлтэй бичиж, дараагийн мөрүүд нь зүүн тийш байрласан байна. Нэг тэмдэгт нь үг эсвэл үгийн хэсгийг илэрхийлдэг тул ам

¹³ Хөх занар чулуу (Slate) нь хувирмал чулуулагт хамаарах, нарийн ширхэгтэй, үечилсэн давхаргатай, тунамал шаварлаг чулуулаг (argillite) ба гнейсийн завсрын хувирлын үр дүнд үүсдэг. Органик бодис, төмрийн нэгдлүүдээс хамаарч хар саарал, хөх саарал, ногоон, улаавтар, хар гэх мэт янз бүр өнгөтэй байна. Хатуулаг нь 2.5 – 4 (Моосын шаталбараар). 2.7 – 2.9 г/см³ нягт. Ус бага шингээдэг, цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй, гэрэлд гялайх нь бага, нимгэн хавтангуудаар ховхорч хагарах шинж чанартай.



дөрвөлжин хэлбэрт багтаан бичдэг (Zhao Chao.1997).

Бичээсийн зохиомжид бичгийн хэсгүүдийн ач холбогдол болон унших дарааллыг бий болгохын тулд хэмжээ харьцаа, харааны дараалал, ялгарлын зарчмыг ашигладаг. Хэмжээний зарчмыг зөв ашиглах үед хамгийн чухал хэсэг нь бусад бага ач холбогдолтой хэсгээсээ илүү том харагдуулахаар зохион байгуулдаг. Энэ зарчмын үндэс нь зохиомжид оролцож байгаа том хэсэг байвал тэр нь илүү анхаарал татдаг. Хэмжээний ялгаатай хэсгүүд байх нь олон хэлбэр үүсгэн зохиомжийг харагдах байдлыг сайжруулах төдийгүй уншигч үзэгчийг удирдан чиглүүлж, бичээсийг ач холбогдлын дарааллаар харуулна. Харахад таатай байдал нь гурваас ихгүй төрлийн хэмжээ ашигласнаар бүрддэг. Харааны дарааллыг бий болгохдоо хэмжээг өөрчлөх, үсгийн ялгарал, орон зай, байрлал, мөн бусад өөр олон төрлийн зарчмыг ашиглан хэрэгжүүлдэг. Гэрэлт хөшөөний бичээсийг зохиомжлохдоо хэмжээний зарчмыг зөв ашигласнаар харааны дараалал, ялгарлыг бий болгож уншигчид харах, унших, ойлгоход амархан, хялбар болгосон байна.

Хөшөөний зохиомжид зэрэгцүүлэлтийн зарчим (alignment)-ыг ашиглахдаа монгол бичгийн дунд мөр болон хятад дэлгэрэнгүй бичээсийн мөрүүдийг эхлэл болох дээд талдаа зэрэгцүүлсэн нь хөндлөн зураасанд захирагдаж нэгдмэл байдлыг хангахад нөлөөж байна. Энэхүү зэрэгцүүлэлтээр уншигч мөр хооронд шилжиж уншихад амар хялбар болдог. Зэрэгцээгүй тохиолдолд бүрдэл хэсгүүд болон дараагийн мөр лүү шилжиж уншихад төвөгтэй, харахад эвгүй санагддаг.

Хөшөөний зохиомжийг цэгцтэй харагдуулж байгаа гол хүчин зүйл нь зүүн талын хээнээс ханз хүртэлх монгол бичгийн мөр хоорондын ижил зай болон ханз үсэг болон мөрний ижил зай, байршилаар илэрч буй хэмнэл байна. Хэмнэл нь энгийн ба нарийн төвөгтэй эсэхээс үл хамааран ижил төстэй, эсвэл олон янзын элементүүдийн хоорондын харилцааг цэгцлэх, тэнцвэржүүлэх, тэдгээрийн хоорондын нэгдмэл байдлыг бий болгох үндэс суурь болдог (Victor Baumgartner, 1983, 77)-ийг уг хөшөө дээрх бичээсийн мөр болон үсэг хоорондын зай, байршлаар үүсч буй хэмнэл нь харуулж байна. Нэгдмэл байдал гэдэг нь тухайн нүүр хуудасыг бүх бүрдүүлэгч хэсгүүдийн хооронд зохицол, уялдаа холбоо бий болгохтой холбоотой. Бүрдүүлэгч хэсгүүдийн харагдах байдал болон утга агуулгын хувьд уялдуулан байрлуулсан нь ихэвчлэн нэгдмэл байдлыг мэдрүүлдэг. Нэгдмэл байдал хангагдаагүй бол эмх замбараагүй, тав тухгүй байдлын сөрөг сэтгэгдэл төрүүлдэг. Харааны мэдрэмж нь оюун дүгнэлт хийхэд чухал нөлөөтэй оролцдог байна. Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээсийн зохиомж тэгш бус хэмтэй байтлаа тэнцвэртэй, бичвэрүүдийн мөр болон ханз үсэг хоорондын зай нь хэмнэлтэй, хоосон зай нь тэнцвэрийг хадгалах үүрэг гүйцэтгэж байна. Зохиомжид ажиглагдаж буй тэгш хэмт зүйл нь хөшөөний хоёр хажуугийн хээ чимэглэл, магнайн бичээсийн доорх хөндлөн зураас байна. Бичээсүүдийг зохиомжлохдоо ямар нэгэн тэнхлэг, тэгш

хэмийн төвгүй, тэнцвэр болон нэгдмэл байдлыг зөн совин, харааны мэдрэмжээр бүрдүүлсэн бололтой.

Хөшөөний монгол бичээсийн нэг болон хоёрдугаар мөрөнд буй сүүлүүдийг урт ташуу бага зэрэг доош дугуйрсан, төгсгөл рүүгээ өргөн хийсэн байхад, дунд мөрний “Мөнх хаан түмэн түмэн” гэснийг доош өргөсөж буусан (сэлмэн) сүүлээр, Барс Түгэ-гийн цацлага урагш хөндлөн мөн бийрийн даралтаар өргөсгөж бичсэн мэт байна.

Судлаач Ц.Шагдарсүрэн “Монголчуудын үсэг бичгийн товчоон” бүтээлдээ “... монгол бичгийн хүмүүсийн аман уламжлал хийгээд хэрэглээний талаас үзвэл тухайн нэг үсгийн махбодыг ч хэлбэрээр нь ялган нэрлэдэг ёсон элбэг байжээ. Зөвхөн сүүл гэхэд л бичмэл, дармал буюу хичээнгүй, бийрийн, барын, хулсан үзгийн гэх буюу тэдгээр дотор зуураа өргөх бичгийн сүүл, шодон сүүл, жад сүүл, мухар сүүл, соёо сүүл, шаантаг сүүл, өвсөн сүүл гэх зэрэг 20 орчим ялгаатай, тэр ялгаа нь яв явсаар бичих зорилготой холбоотой, тодорхой зорилгод хэрэглэгдэх болсон ажээ.(2001, 33)” хэмээн өгүүлсэн байдаг. Монгол бичээсийн хааны сүр хүчний илэрхийлэл болж харагдахад бичээсийн эгц нуруу, орхиц, сүүл чухал нөлөө үзүүлж байна. Энэ нь нурууны эгц шулуун зураас болон сүүл, орхицын ташуу зураасны нөлөөлөл юм.

Судлаач Д.Жамсранжав “Чулуун ном” бүтээлдээ энэхүү хөшөөний “... хүрээлсэн эвэр угалзан хүрээ нь хятадад буй Өгөдэй хааны (хатан Дөрэгэнэгийн) зарлигийн хөшөөнийхтэй адил, бичээсийн зохиомжийн ерөнхий хэлбэр, үсэг зүй нь бага зэрэг ялгаатай боловч ойролцоо гэж хэлж болохоор, Мөнх хааны хөшөөний бичээсийн үсэг зүйн хэлбэр нь тэр үеийн бусад хөшөөний бичгийн үсэг зүйгээс нэлээд өвөрмөц байна...” гээд, “... голын мөрийн “сүүл”-ийн хэлбэр нь Чингисийн чулууны бичгийнхтэй адил, эхний болон эцсийн мөрөнд байгаа “сүүл” хэлбэрүүдийг одоохи үеийн хөндлөн сүүлт монгол бичгийн гэдрэг хэлбэртэй

байгаа нь уйгуржин монгол бичгийн хэлбэр өөрчлөгдөж шинэчлэгдэх үе¹⁴-ийн бичлэгийн шинжийг харуулж (2003,)” байгааг тэмдэглэжээ. Өгөөдэй хааны (хатан Дөрэгэнэгийн) зарлигийн бичээстэй харьцуулсан хоёр хөшөөний монгол бичээс ойролцоо гэсэн нь нарийн ажиглахад бичлэгийн хэв маяг өөр харагдана. Үгийн дунд Д, Т үсгийн хэлбэр нь Мөнх хааны хөшөөнд хажуу тийш чиглэлтэй дээш дугуйрсан бол Өгөөдэй хааны зарлигийн бичээст дугуйрсан хэлбэр нь бага, чиглэл нь арай доош байх ба орхиц, сүүлний дугуйрсан хэлбэр нь эсрэгээрээ Өгөөдэй хааны зарлигийн бичээст их харагдана. Хүрээлсэн эвэр угалз хээ нь ойролцоо хэдий ч сийлсэн аргын хувьд ялгаатай. Мөнх хааны хөшөөнд бичээсийн зурлагын

¹⁴ Хятад бичээст буйгаа 1257 оны зуны дунд сарын хорьдын үед бичигдсэн. Энэ үе бол Сажу бандид Гунгаажалцан монголд 1247 буюу 1251 онд залагдаж байсан үе юм.



өргөнтэй ижил хоёр шулуун зураасны голд хээг горив татаж ухсан байхад нөгөөд эвэр хээ угалзыг өргөн нарийн хувиралтай зураасаар үлдээж бусад талбайг тууз хэлбэрээр ухаж сийлсэн байна. Эвэр угалз хээгээр олз омог, амьдралын холбоо, хүсэл тэмүүллийг бэлгэдэн илэрхийлсэн бололтой.

Хөшөөний монгол бичээсийн хоёрдугаар мөрийг тэтгэхдээ Мөнх хааны нэрийг нэг ба гуравдугаар мөрнөөс эрс дээш өргөсөн нь тэгш хэмт байдлыг бий болгосон байна (Зураг 3). Энэ шийдэл уг мөр унших дараалалд нөлөөлж хааны нэрийг эхэнд уншуулах, мөн тэгш хэмт хэлбэр нь монгол бичээсийг төв тогтуун харагдуулж тогтвортой сэтгэгдэл төрүүлж буй нь бичээсийн утгыг дэмжсэн уран сайхны шийдэл юм. Үсэг болон мөр хоорондын зай нь хэмнэл давтамжийг үүсгэж байна (Зураг 4). Харин хоёрдугаар мөрний дунд хэсэгт “насалтугай” гэсэн үгийг хоёр талдаа бусдаас их зай авсан байгаа нь орон зайн тоглолт төдийгүй үгийн утгыг илэрхийлсэн байж болох юм. Эсвэл хоёрдугаар мөрийг бичихдээ дээд болон доод талаас ээлжилж хөөж бичихдээ хамгийн сүүлд бичигдсэн нь “насалтугай” хэмээх үг бөгөөд түүнийг үлдсэн зайд бичихэд бусдаас их зай үлдсэн байж болох юм.

Гурван хэсэг бүлэглэсэн бичээсүүдийн үсгийн хэмжээ, мөр хоорондын зайн харьцаа, орон зай, хэмнэлээрээ өөр хоорондоо ялгаа (contrast)-тай байна. Ялгарлын зарчим нь бүрдэл хэсгүүдийг зэрэгцүүлэн байрлуулах замаар ялгаатай шинж чанарыг илэрхийлж, өөр өөр ангилалд хамааран, өөр үүрэгтэй оролцдог. Өөрөөр хэлбэл, ялгарал нь хоёр объектуудын хооронд хэмжээ, харьцаа, өнгө тоны мэдэгдэхүйц ялгааг бий болгож, тэдгээрийн тусгаар байдал, ялгааг онцлон харуулах явдал юм.

Гэрэлт хөшөөг үзэгчид эхлээд магнайн том ханз бичээс унших тулгуур болж, дараа нь Монгол бичгийн 3 мөр, төгсгөлд хятад 12 мөр бичээст шилжих бөгөөд, монгол бичиг нь орон зайн хувьд тусгаар харагдаж буй нь монгол бичгийн мөр хоорондын зай их байж уншигдах чадвартай байдгийг харгалзсан, зохиомжлохдоо ач холбогдол өгснийг илэрхийлж байна. Энэ нь зохиомжийн байгуулалт хийж шинжлэх явцад ажиглагдаж байна. Магнайн ханз бичээсийн доор буй хэвтээ нарийн зураас нь шинж чанараар тайван тогтуун байдлыг илтгэж, гарчиг ба бичвэрийг тусгаарлах үүрэгтэй, түүнд захируулж бусад бичээсийг дээд талдаа тэнцүүлсэн нь зохиомжийг нэгдмэл байдалд чухал нөлөө үзүүлж байна.

Олж нээгээд нийслэлд авч ирэхэд бүрэн байсан уг хөшөөний магнайн бичээсний таван ханзнаас хагас дугуу гурав нь үлдсэн байна. Улсын төв номын сангийн зүүн талд, дараа нь баруун талд, сүүлд Түүхийн музейд байрлуулж байсан бөгөөд одоо Чингисийн музейд заларч буй энэ хөшөө суурин дээрээ зургаан зууныг элээхдээ бүрэн бүтэн байсан бичээс сүүлийн жилүүдэд холцорч муудсан нь цаг агаар, чийгшил болон хүний нөлөө байж болох юм. Уран бичлэгийн хосгүй энэ дурсгалыг үр хойчдоо өвлүүлэн үлдээхийн

тулд тухайн хөх занар чулууны шинж чанар, хадгалалтын горимыг судлан хуурайшилтаас хамгаалж, уур амьсгалыг тохируулах шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

Мөнх хааны гэрэлт хөшөө нь монгол бичгийн үсгийн залгаа, эхлэл төгсгөл болон чулуун дээр сийлсэн хэв маяг нь сонгодог монгол бичгийн өмнөх үеийн үсгийн тигээр бичсэн, XIII зууны дунд үеийн бичлэгийн хэв шинжийг тодорхойлж, монгол бичгээр бичигдсэн төрийн зарлиг, гэрэлт хөшөөний уламжлалыг хадгалсан байна.

Хөшөөний монгол бичээс нь XIII зууны эзэнт гүрний сүр хүчийг харуулсан эрхэмсэг, хурц, тод зурлагатай, үгийн төгсгөлийн сүүл орхицыг шулуун эрчтэй зураасаар илэрхийлсэн, уг гурван мөрийг тэгш хэмээр зохиомжилсон нь төв тогтуун харагдуулж тогтвортой сэтгэгдэл төрүүлж бичээсийн утгыг дэмжсэн уран сайхны шийдэлтэй байна.

Бичээсүүдийг зохиомжилходоо гурван хэсэгт бүлэглэж, тэгш хэмгүй тэнцвэрт бус байдлыг хоосон орон зайгаар тэнцвэрийг хангасан, мөр болон үсэг хоорондын зайгаар хэмнэлтэй, хэмжээний болон зэрэгцүүлэлтийн зарчмыг ашиглаж харааны дараалал болон ялгарлыг бий болгож, бэхээр бийрийн даралт өргөлтөөр уран сайхан бичиж, түүнийгээ хөх занар чулуунаа сийлж гүйцэтгэсэн уран бичлэг, үсгийн урлагийн бүтээл юм.

Цаашид монголчуудын бүтээсэн бичиг үсгийн дурсгалуудын урлагийн шүүмж судлалыг хөгжүүлэхийн тулд уран бичээч, зураач, урлаг судлаачдын анхаарлыг татсан үйл ажиллагаа зохион байгуулж, чиглүүлэн ажиллах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Жамсранжав Д. (2003). “Чулуун ном” Улаанбаатар.
2. МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. (2022). Монгол хэл судлал VII боть, Үсэг зүй, Улаанбаатар.
3. Намнандорж О. (1956). “Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай”. Улаанбаатар.
4. Сайшаал. Б (2004). “Чингис хааны товчоон” тэргүүн дэвтэр, УБ. Хаан принтинг
5. Цэвээндорж Д. Баяр Д. (2006). Монгол нутаг дахь соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт, Улаанбаатар.
6. Шагдарсүрэн Ц. (2001). “Монголчуудын үсэг бичгийн товчоон” Улаанбаатар




Гадаад хэлээр:

1. Паранюшкин Рудольф Васильевич, (2005). Композиция: Теория и практика изобразительного искусства, ISBN 5-222-07410-2 Ростов-на-Дону, Издательство «Феникс»
2. Victor Baumgartner, (1983). Graphic games : from pattern to composition, USA., p77
3. Zhao Chao. (1997). Introduction to Ancient Chinese Stone Carvings [M]. Cultural Relics

Цахим эх сурвалжууд:



1. Dea Adinda. (2024), The Role and Contribution of Calligraphy in Islamic Education, Eduslamic: Jurnal Pendidikan Islam dan Keagamaan, Vol. 2, No.1, Agustus 2024. E-ISSN: 2988-6686, DOI: <https://doi.org/10.59548/jed.v2i1>.
2. Люлина А.Г. Батыгин К.В. (2023). “Надпись на Стеле Мункэ-хана 1257 г. в Монголии: интерпретация и анализ китайского текста” <https://doi.org/10.31696/2618-7043-2023-6-3-4-568-584>
3. Luya Wang, Nor Azlin Hamidon. (2023). Aesthetic and Value Study of Inscriptions from the Perspective of Calligraphy, Art and Performance Letters Clausius Scientific ISSN 2523-5877 Vol. 4 Num. 11 Press, Canada DOI: 10.23977/artpl.2023.041107
4. Lijuan Pu, (2016), Initial Exploration of Aesthetic Value of Calligraphic Art, International Conference on Education, Sports, Arts and Management Engineering (ICESAME 2016), DOI: [10.2991/icesame-16.2016.80](https://doi.org/10.2991/icesame-16.2016.80)
5. Pooja Verma, (2019), Calligraphy: An Art of Self Expression, Journal of Emerging Technologies and Innovative Research JETIR Volume 6, www.jetir.org.
6. Saskia, S. (2020). Nilai dan Makna Kaligrafi Arab Pada Masjid Al-'Atiq. 21(1), 1–9. <http://journal.um-surabaya.ac.id/index.php/JKM/article/view/2203>
7. Suharno, S., & Mukhtarom, A. (2021). Nilai-Nilai Pendidikan Islam Dalam Seni Kaligrafi Al-Qur'an. Jurnal Kajian Islam Dan Pendidikan Tadarus Tarbawy, 3(1), 296–299. <https://doi.org/10.31000/jkip.v3i1.4255>
8. Poppe N. (1961). Notes on the monument in honor of Monke Khan (The Mongolian inscription). Central Asiatic Journal. No. 6(1), https://www.jstor.org/stable/41926488?read-now=1&seq=1#page_scan_tab_contents
9. Өсөхөө Б. Хээний бэлгэдлүүд, <https://www.academia.edu/19635565/>
10. Shiqi Gao, (2024). Research on the Aesthetic Experience of Calligraphy Art and the Enhancement of Undergraduate Students' Artistic Literacy <https://doi.org/10.70767/jacps.v1i2.210>
<https://www.atlantic-press-journals.com/index.php/JACPS/article/view/210/341>

ХАВСРАЛТ



Зураг 1. Мөнх хааны гэрэлт хөшөөний гэрэл зураг (Улаанбаатар хотод авч ирж, төв номын гадна байрлуулсан үеийн зураг)

Зураг 2. Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээсийн байгуулалт



Зураг 3. Гэрэлт хөшөөний монгол бичгийн мөрийн шугам, хятад ханзны үсэг болон мөр хооронд зайг шугамаар тодорхойлсон байгуулалт

Зураг 4. Гэрэлт хөшөөний магнайн бичээс, монгол бичгийн болон хятад ханз бичвэр, хүрээ хээг толбоор харуулсан байдал

БИЗНЕСИЙН УДИРДЛАГА



Б.БҮЖИДМАА

Компанийн ашигт ажиллагаанд ажлын капиталын
агрессив бодлогын үзүүлэх нөлөө

КОМПАНИЙН АШИГТ АЖИЛЛАГААНД АЖЛЫН КАПИТАЛЫН АГГРЕССИВ БОДЛОГЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Магистр, Б.Бүжидмаа

(ОУУБИС. ЭЗБС)

bujidmaa.b@ulaanbaatar.edu.mn

Abstract

This study examines the impact of working capital policy on corporate profitability. Using financial statement data and GDP growth of listed food industry joint stock companies between 2019 and 2023, the impact of working capital policy was assessed using return on total assets. The study found that there is a negative relationship between return on assets and the level of investment and financing policies for working capital. This has a positive effect on profitability when the company's current assets and short-term liabilities are low. The results of the analysis show that sales growth (GROWTH) is the variable with the greatest negative impact on return on assets (ROA), which means that when the growth rate of sales revenue is less than the growth rate of additional costs required to generate it, the return on total assets is lower than the return on total assets before the increase in revenue. The results of the study conclude that implementing an aggressive policy in working capital management is effective.

Түлхүүр үгс: ROA, AIP, AFP, SIZE, GROWTH, LVGR, регрессийн шинжилгээ

ОРШИЛ

Ажлын капитал буюу эргэлтийн хөрөнгөө зөв зохистой удирдах нь компанийн хувьд зайлшгүй чухал асуудлуудын нэг байдаг. Ажлын капиталын удирдлагын гол зорилго нь тэдгээрийн ашигт байдал ба эрсдлийн оновчтой харьцааг тогтоох явдал юм. Эргэлтийн хөрөнгөө оновчтой удирдах нь компанийн санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой цогц ойлголт юм. Ажлын капиталын бодлого нь ажлын капиталын болон ажлын капиталын санхүүжилтийн түвшинг тодорхойлоход чиглэгдэнэ. Компаниуд ажлын капиталыг хангалттай түвшинд байлгах шаардлагатай боловч түүнийг хэт их эсвэл бага байлгах нь компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй тул зохистой хэмжээнд байлгах



шаардлагатай. Ажлын капитал бага байх нь богино хугацаат өр төлбөрийг хугацаанд нь төлөх чадварыг бууруулдаг сөрөг талтай бол хэт их байх нь эдгээр хөрөнгөтэй холбоотой зардлыг нэмэгдүүлдэг дутагдалтай. Энэ нөхцөл байдлуудаас авч үзвэл хөрөнгийн удирдлага нь компанийн хувьд маш чухал юм. Гэсэн хэдий ч практик дээр компаниудын гүйцэтгэх удирдлага өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааг хөтлөн явуулахдаа ажлын капиталын удирдлагад төдийлөн анхаарлаа хандуулдаггүй.

СУДАЛГААНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Эргэлтийн хөрөнгийг анх тоон үзүүлэлт талаас нь Адам Смит 1776 онд “Үндэстний баялаг” номондоо “Худалдаачид мөнгөөрөө бараа авч бага зэрэг ашигтай тохиолдолд бараагаа зарж мөнгө болгодог. Худалдаачны капиталын тасралтгүй хэлбэрээ солих энэ цикл нь түүнд ашиг авчирдаг. Иймээс энэхүү циклд орж байгаа капитал нь эргэлтийн хөрөнгө юм” гэж тодорхойлсон. Ихэнх судалгааны бүтээлүүдэд ажлын капиталын удирдлагын нэг хэсэг болсон санхүүгийн харьцаануудыг авч үзсэн байдаг ба цөөн тооны судалгаанууд ажлын капиталын бодлогыг тусгайлан судалсан байдаг. Gupta (1969) болон Gupta and Huefner (1972) нар аж үйлдвэрийн салбарын компаниудын санхүүгийн харьцааны дунджийг тооцон хэр зэрэг ялгаатай байдлыг шинжилсэн. Дээрх 2 судалгааны ажлаар аж үйлдвэрлэлийн салбарын компаниуд ашигт ажиллагаа, үйл ажиллагаа, хөшүүрэг, хөрвөх чадварын харьцаа зэргээрээ ялгаатай байгааг гаргаж ирсэн. Weinraub, Visscher (1998) нар АНУ-ын компаниудын 1984-1993 оны улирлын мэдээллийг ашиглан ажлын капиталын удирдлагын аггрессив болон консерватив бодлогын асуудлыг шинжилсэн. Судалгаандаа өөр өөр салбарын компаниудын 10 жилийн хугацаан дахь мэдээллийг ашиглан ажлын капиталын аггрессив болон консерватив бодлогын хоорондын хамаарлыг судалсан ба энэхүү хугацаанд салбар бүрийн ажлын капиталын бодлого өөр хоорондоо ялгаатай байгааг илрүүлсэн. Ажлын капиталын удирдлагын талаарх анхдагч судалгаа болох Саганы “Towards a Theory of Working Capital Management” өгүүлэлд авлага, бараа материал болон мөнгөн хөрөнгийн удирдлага нь компанийн үйл ажиллагааны функцүүдэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тогтоожээ. Түүний энэхүү өгүүллийг ажлын капиталын удирдлагын судалгаа хийх үндэс суурийг тавьж өгсөн гэж үздэг. Назир ба Афза¹⁵ Мервилль Тавис нар ажлын капиталын аггрессив, консерватив бодлогын нөлөөг судалсан.

¹⁵ Nazir.M.S., Afza.T., “Impact of Aggressive Working Capital Management policy on Firm’s Profitability”, 2009

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгааны ажлаар ажлын капиталын агрессив хөрөнгө оруулалтын (AIP) болон санхүүжилтийн бодлогын (AFP) компанийн ашигт үзүүлэх нөлөөллийг хөрөнгийн биржид бүртгэлтэй хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 9 хувьцаат компанийн 2019 – 2023 оны хоорондох 5 жилийн санхүүгийн тайланг ашиглан судаллаа. Нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувийн жин бага өөрөөр хэлбэл эргэлтийн хөрөнгөнд хийгдэх хөрөнгө оруулалтын түвшин бага байгаа бол энэ нь агрессив хөрөнгө оруулалтын бодлого байна. Үүнийг дараах байдлаар тодорхойлно.

$$AIP = \frac{\text{Total Current Assets (TCA)}}{\text{Total Assets (TA)}}$$

IP – Aggressive Investment Policy (Агрессив Хөрөнгө оруулалтын бодлого)

TCA – Нийт эргэлтийн хөрөнгө

TA - Нийт хөрөнгө

Энэ харьцаа бага байвал өөрөөр хэлбэл нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувийн жин бага байвал агрессив бодлого болно. Нөгөө талаар компани үйл ажиллагаандаа богино хугацаат өр төлбөрийг их хэмжээгээр ашиглаж урт хугацаат өрийг бага түвшинд ашиглаж байвал энэ нь агрессив санхүүжилтийн бодлого болно. Үүнийг дараах байдлаар тодорхойлно.

$$AFP = \frac{\text{Total Current Liabilities (TCL)}}{\text{Total Assets (TA)}}$$

AIP – Aggressive Financing Policy (Агрессив Санхүүжилтийн бодлого)

TCL – Нийт богино хугацаат өр төлбөр

TA - Нийт хөрөнгө

Ажлын капиталын бодлогын ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөг хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтийг ашиглан тооцсон.

$$ROA = \frac{\text{Net Earnings After Taxes (NEAT)}}{\text{Book Value of Assets (BVA)}}$$

ROA – Хөрөнгийн өгөөж

NEAT – Татварын дараах цэвэр ашиг

BVA - Хөрөнгийн дансны үнэ

Энэ үзүүлэлт нь компани нийт хөрөнгөө хэр зэрэг ашиглаж буйг харуулдаг.

Хяналтын хувьсагчид. Ажлын капиталын талаарх судалгааны бүтээлүүдэд компанийн ашигт ажиллагаанд ажлын капиталын удирдлагын үзүүлэх нөлөөг шинжлэхийн тулд үндсэн хувьсагчдын хамт хяналтын хувьсагчдыг ашигласан байдаг (Ламберсон, 1995; Смит, Бегеманн, 1997; Deelof, 2003; Элжелли, 2004; Теруэл, Солано, 2005, Лазаридис ба Трифонидис, 2006). Энэхүү судалгаанд ажлын капиталын хувьсагчийн зэрэгцээ компанийн хөрөнгийн хэмжээ, борлуулалтын өсөлт, санхүүгийн хөшүүрэг зэрэг зарим хяналтын хувьсагчдыг авч үзсэн болно. Компанийн нийт хөрөнгийн дансны үнэ өндөр учраас энэ нь шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх магадлалтай хэмээн үзэж нийт хөрөнгийн дүнг (SIZE) натурал логарифм аван тооцсон. Компанийн өсөлтийг (GROWTH) тухайн жилийн борлуулалтын өсөлтийн хувиар тооцоолж гаргасан. Түүнчлэн санхүүгийн хөшүүргийг (LVRG) бүх түүврийн хугацаанд компани тус бүрийн өр болон өөрийн хөрөнгийн харьцаа болгон авч үзсэн. Делооф (2003) Эцэст нь, эдийн засгийн сайн нөхцөл байдал нь пүүсийн ашигт ажиллагаанд тусгагдах хандлагатай байдаг тул (Ламберсон, 1995) энэ үзэгдлийг 2019-2023 он хүртэлх Монгол улсын ДНБ-ий жилийн бодит өсөлтийг (GDP) мөн авч үзсэн байгаа.

Статистикийн шинжилгээ. Ажлын капиталын бодлого компанийн ашигт байдалд үзүүлэх нөлөөг гүйцэтгэлийн хувьсагч (ROA), түүнчлэн TCA/TA болон TCL/TA-г хянагдах хувьсагчдын хамт Eviews программ дээр регрессийн шинжилгээг ашиглан үнэлэв. Үүнд дараах тэгшитгэлийг ашиглан тооцоолол хийлээ. Үүнд:

$$ROA_i = \alpha + \beta_1 \left(\frac{TCA}{TA_i} \right) + \beta_2 (SIZE_i) + \beta_3 (GROWTH_i) + \beta_4 (LVRG_i) + \beta_5 (GDP_i) + \varepsilon$$

Мөн

$$ROA_i = \alpha + \beta_1 \left(\frac{TCL}{TA_i} \right) + \beta_2 (SIZE_i) + \beta_3 (GROWTH_i) + \beta_4 (LVRG_i) + \beta_5 (GDP_i) + \varepsilon$$

$$\frac{TCA}{TA}$$

-Эргэлтийн хөрөнгийн нийт дүнг нийт хөрөнгөнд харьцуулсан харьцаа

$$\frac{TCL}{TA}$$

-Богино хугацаат өрийн нийт дүнг нийт хөрөнгөнд харьцуулсан харьцаа

ROA_i - Нийт хөрөнгийн өгөөж

$SIZE_i$ - Нийт хөрөнгийн хэмжээ /натурал логарифм авсан дүн

$GROWTH_i$ - Тухайн жилийн борлуулалтын өсөлтийн хувь

$LVRG_i$ - Компанийн санхүүгийн хөшүүргийн харьцаа

GDP_i - Монгол улсын ДНБ-ний бодит өсөлтийн хувь

α -

ε - загварын алдаа

Сонгож авсан компаниудын хувьд эргэлтийн хөрөнгө ба түүний эх үүсвэр хоёрын хоорондын харьцаа болон тэдгээрийн нийт хөрөнгөнд эзлэх бүтцийг авч үзлээ. Үүнийг дараах хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 1. Компаниудын нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувийн жин

Компани	2019	2020	2021	2022	2023
АПУ ХК	34.39%	36.82%	40.84%	41.81%	24.75%
Сүү ХК	39.76%	43.53%	48.31%	35.86%	51.48%
Талх чихэр ХК	24.87%	26.02%	30.89%	23.32%	30.96%
Атар өргөө ХК	46.57%	40.10%	39.99%	44.81%	46.22%
Хөвсгөл хүнс ХК	69.14%	73.39%	64.92%	78.32%	73.09%
Эрдэнэт хүнс ХК	28.18%	35.57%	39.15%	40.17%	44.17%
Увс чацаргана ХК	8.07%	0.09%	0.08%	0.01%	2.50%
Дархан хүнс ХК	35.46%	28.20%	28.83%	37.77%	36.14%
Увс хүнс ХК	49.06%	60.15%	68.84%	61.28%	57.37%

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Шинжилгээнээс харахад дийлэнх компаниудын хувьд эргэлтийн хөрөнгийн хувийн жин бага буюу агрессив бодлого баримталж байна гэж үзэх үндэстэй байна. Харин Хөвсгөл хүнс ХК, Увс хүнс ХК – уудын хувьд эргэлтийн хөрөнгийг их хэмжээгээр ашигладаг нь харагдаж байна. Мөн компаниудын эх үүсвэрийн бүтцэд шинжилгээ хийлээ.

Компани	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
АПУ ХК	БХӨТ	5.15%	1.18%	10.05%	15.54%	11.41%
	УХӨТ	50.08%	30.17%	44.87%	37.70%	35.34%
	Эзний өмч	44.77%	68.65%	45.08%	47.39%	53.25%



Сүү ХК	БХӨТ	11.83%	11.13%	18.83%	35.76%	32.98%
	УХӨТ	80.33%	79.50%	69.13%	37.88%	45.24%
	Эзний өмч	7.84%	9.37%	12.04%	26.36%	21.78%
Талх чихэр ХК	БХӨТ	14.73%	18.99%	17.76%	15.58%	16.45%
	УХӨТ	50.32%	34.25%	27.80%	19.89%	11.63%
	Эзний өмч	34.95%	46.76%	54.44%	64.53%	71.92%
Атар Өргөө ХК	БХӨТ	6.68%	10.31%	11.24%	16.76%	13.93%
	УХӨТ	0.47%	0.27%	9.42%	0.00%	3.00%
	Эзний өмч	92.85%	89.42%	79.34%	83.24%	83.07%
Хөвсгөл хүнс ХК	БХӨТ	50.36%	54.26%	76.70%	78.32%	65.89%
	УХӨТ	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
	Эзний өмч	49.64%	45.74%	23.30%	21.68%	34.11%
Эрдэнэт хүнс ХК	БХӨТ	6.77%	7.62%	8.43%	8.41%	8.84%
	УХӨТ	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
	Эзний өмч	93.23%	92.38%	91.57%	91.59%	91.16%
Увс чацаргана ХК	БХӨТ	69.48%	0.16%	0.00%	0.00%	0.01%
	УХӨТ	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
	Эзний өмч	30.52%	99.84%	100.00%	100.00%	99.99%
Дархан хүнс ХК	БХӨТ	36.35%	42.54%	42.42%	43.62%	37.93%
	УХӨТ	0.00%	0.00%	0.00%	0.00%	12.94%
	Эзний өмч	63.65%	57.46%	57.58%	56.38%	49.13%
Увс хүнс ХК	БХӨТ	45.76%	47.76%	34.31%	14.55%	6.67%
	УХӨТ	0.00%	0.00%	35.41%	64.32%	74.00%
	Эзний өмч	54.24%	52.24%	30.28%	21.13%	19.33%

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Сонгон авсан компаниудын хувьд дийлэнх нь урт хугацаат санхүүжилтийг бараг ашигладаггүй байдал харагдаж байна. Иймээс мөн л агрессив санхүүжилтийн бодлого баримталж байна гэж үзэх үндэстэй. Харин АПУ ХК, Сүү ХК, Талх чихэр ХК-уудын хувьд урт хугацаат санхүүжилтийг ашигладаг байна.

Сүүлийн 5 жилийн нийт хөрөнгийн өгөөжийг тооцож үзлээ. (ROA)

Компани	2019	2020	2021	2022	2023	Дундаж өгөөж	Стандарт хазайлт
АПУ ХК	13.86%	16.00%	6.62%	14.80%	19.75%	14.21%	4.80%
Сүү ХК	8.92%	8.97%	11.12%	7.61%	11.73%	9.67%	1.71%

Талх чихэр ХК	3.49%	4.11%	6.72%	8.05%	9.10%	6.29%	2.44%
Атар өргөө ХК	2.32%	1.41%	1.48%	3.46%	1.47%	2.03%	0.88%
Хөвсгөл хүнс ХК	0.80%	0.17%	0.10%	2.54%	4.34%	1.59%	1.83%
Эрдэнэт хүнс ХК	11.53%	4.84%	0.06%	-3.08%	1.07%	2.88%	5.60%
Увс чацаргана ХК	0.21%	0.47%	-2.57%	-2.31%	0.99%	-0.64%	1.67%
Дархан хүнс ХК	-3.22%	-5.50%	0.73%	2.28%	-2.82%	-1.71%	3.15%
Увс хүнс ХК	0.44%	4.37%	4.01%	9.59%	11.02%	5.89%	4.35%

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Тооцооллоос харахад хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин зарим онуудад сөрөг утгатай гарсан хэдий ч нийт хөрөнгөөс олох өгөөжийн түвшин боломжийн хэмжээнд байна. Ажлын капиталын үзүүлэлтүүд болох AIP, AFP, өрийн харьцаа мөн тухайн улс орны эдийн засгийн чадавхийг харуулдаг ДНБ – ний бодит өсөлтийн түвшин байгууллагын ашигт хэрхэн нөлөөлж буйг олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийж судалсан.

Шинжилгээний үр дүн

<u>Variables</u>	<u>ROA</u>	
		<u>t-value</u>
constant	-0.194401	-3.132966
AIP	-0.002923	-0.051289
SIZE	0.015356	4.128278
GROWTH	-5.72E-05	1.416696
GDP	-0.041183	-0.840998
LVRG	0.004327	-0.676811
F-value	3.906539	
R ²	0.881900	
DW	1.812320	

Эх сурвалж: E-views- програмын үр дүн /*-0.01-ээс бага магадлалтай, **-0.05-аас

бага магадлалтай, ***-0.9-өөс бага магадлалтай гэсэн тэмдэглэгээ болно./

$$ROA = -0.19 - 0.003 \cdot AIP + 0.015 \cdot SIZE + 0.004 \cdot LVRG - 5.72 \cdot 10^{-5} \cdot GROWTH - 0.041 \cdot GDP$$

Детерминацийн коэффициент 0.88 гарсан нь загварын тайлбарлагч хувьсагчид ROA үзүүлэлтийн 88 хувийг тайлбарлаж байгааг харуулах бөгөөд энэ нь дээрх тэгшитгэлийн үр дүнг цаашид ашиглах боломжтой гэдгийг харуулж байна. F-шинжүүрийн магадлалын утга 3.90 буюу итгэх түвшин $\alpha=0.05$ -аас их гарсан нь тайлбарлагч хувьсагчид нэгэн зэрэг хамаарагч хувьсагчид нөлөөлөхгүй (H_0 : $\beta_1=\beta_2=\beta_3=\beta_4=\beta_5=0$; H_1 : дээрх нөхцлүүдийн ядаж нэг нь биелэхгүй) гэсэн “тэг” таамаглалыг 95 хувийн магадлалтайгаар няцаах үндэслэл болж байна. Мөн DW үнэлсэн утга 2 орчим хэлбэлзэж байгаа нь тухайн тэгшитгэлд байгаа хувьсагчид хоорондоо автокорреляци алдаагүй, хувьсагчид хооронд хүчтэй хамаарал байхгүй байгааг харуулж байна. Шинжилгээний үр дүнгээс харахад хөрөнгийн өгөөжид (ROA) хамгийн их нөлөөлөлтэй хувьсагчаар борлуулалтын өсөлт (GROWTH) үнэлэгдсэн бөгөөд, борлуулалт нэг хувиар өсөхөд, хөрөнгийн өгөөж 5.72 пунктээр буурах хандлагатай байна гэсэн үр дүн гарчээ. Энэ нь борлуулалтын орлогын өсөлтийн хувь хэмжээ нь түүнийг бий болгоход шаардагдсан нэмэлт зардлын өсөлтийн хувь хэмжээнээс бага байсан тохиолдолд нийт хөрөнгийн өгөөж нь орлого нэмэгдэхээс өмнөх үеийн нийт хөрөнгийн өгөөжөөс бага байна. Үүнээс гадна эдийн засгийн бодит өсөлтийн хувь хэмжээ (GDP), нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ (AIP) зэрэг хүчин зүйлүүд сөрөг хамааралтайгаар үнэлэгджээ. Тухайлбал: хөрөнгийн өгөөж нэг хувиар өсөхөд GDP 0.04 пунктээр, AIP 0.003 пунктээр тус тус буурах хандлагатай байна. Харин хөрөнгийн өгөөжийн нэг хувийн өсөлтөнд компанийн хөрөнгийн хэмжээ (SIZE) 0.02 пунктээр өснө гэсэн үр дүн гарчээ.

Шинжилгээний үр дүн

<u>Variables</u>	<u>ROA</u>	
		<u>t-value</u>
constant	-0.156284	-2.533842
AFP	-0.144591	-1.757908
SIZE	0.013862	3.939316
GROWTH	-4.72E-05	-1.524057
GDP	-0.045398	-0.994976
LVRG	0.035167	1.695055
F-value	5.098286	

R ²	0.848304
DW	1.593681

$$\text{ROA} = -0.16 - 0.145 \cdot \text{AFP} + 0.014 \cdot \text{SIZE} + 0.035 \cdot \text{LVRG} - 4.72 \cdot \text{GROWTH} - 0.045 \cdot \text{GDP}$$

Детерминацийн коэффициент 0.85 гарсан нь загварын тайлбарлагч хувьсагчид ROA үзүүлэлтийн 88 хувийг тайлбарлаж байгааг харуулах бөгөөд энэ нь дээрх тэгшитгэлийн үр дүнг цаашид ашиглах боломжтой гэдгийг харуулж байна. F-шинжүүрийн магадлалын утга 5.09 буюу итгэх түвшин $\alpha=0.05$ -аас их гарсан нь тайлбарлагч хувьсагчид нэгэн зэрэг хамаарагч хувьсагчид нөлөөлөхгүй ($H_0: \beta_1=\beta_2=\beta_3=\beta_4=\beta_5=0$; H_1 : дээрх нөхцлүүдийн ядаж нэг нь биелэхгүй) гэсэн “тэг” таамаглалыг 95 хувийн магадлалтайгаар няцаах үндэслэл болж байна. Мөн DW үнэлсэн утга 2 орчим хэлбэлзэж байгаа нь тухайн тэгшитгэлд байгаа хувьсагчид хоорондоо автокорреляци алдаагүй, хувьсагчид хооронд хүчтэй хамаарал байхгүй байгааг харуулж байна. Шинжилгээний үр дүнгээс харахад хөрөнгийн өгөөжид (ROA) хамгийн их нөлөөлөлтэй хувьсагчаар борлуулалтын өсөлт (GROWTH) үнэлэгдсэн бөгөөд, борлуулалт нэг хувиар өсөхөд, хөрөнгийн өгөөж 4.72 пунктээр буурах хандлагатай байна гэсэн үр дүн гарчээ. Энэ нь борлуулалтын орлогын өсөлтийн хувь хэмжээ нь түүнийг бий болгоход шаардагдсан нэмэлт зардлын өсөлтийн хувь хэмжээнээс бага байсан тохиолдолд нийт хөрөнгийн өгөөж нь орлого нэмэгдэхээс өмнөх үеийн нийт хөрөнгийн өгөөжөөс бага байна. Үүнээс гадна эдийн засгийн бодит өсөлтийн хувь хэмжээ (GDP), богино хугацат өр төлбөрийн хувь хэмжээ (AFP) зэрэг хүчин зүйлүүд сөрөг хамааралтайгаар үнэлэгджээ. Тухайлбал: хөрөнгийн өгөөж нэг хувиар өсөхөд GDP 0.05 пунктээр, AFP 0.145 пунктээр тус тус буурах хандлагатай байна. Харин хөрөнгийн өгөөжийн нэг хувийн өсөлтөнд компанийн хөрөнгийн хэмжээ (SIZE) 0.013 пунктээр өснө гэсэн үр дүн гарчээ.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь ажлын капиталын бодлогын агрессив болон консерватив бодлогын хоорондын хамаарал, түүний ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хүнсний үйлдвэрлэлийн 9 компанийн 2019-2023 оны хоорондох санхүүгийн тайлангийн мэдээллийг ашиглан Eviews программыг ашиглан шинжилгээ хийлээ. Судалгаагаар хөрөнгийн өгөөж болон ажлын капиталын хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн бодлогын түвшингийн хооронд сөрөг хамаарал байгаа нь харагдсан. Энэ нь компанийн

эргэлтийн хөрөнгийн болон богино хугацаат өр төлбөрийн хувийн жин бага байхад ашигт эерэг нөлөөтэй байна. Судалгаанаас үзэхэд ихэнх компаниудын эргэлтийн хөрөнгийн хэмжээ хэт их биш, хэт бага биш байгаа нь ажлын капиталын агрессив бодлогыг баримталж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Ажлын капиталын агрессив бодлого нь эргэлтийн хөрөнгийн мөнгөн дүнг аль болох бага байлгах зорилгоор хэрэгжүүлдэг бодлого юм. Харин Хөвсгөл хүнс ХК, Увс хүнс ХК-уудын хувьд эргэлтийн хөрөнгийн төвлөрөл үүсэх хандлагатай байна. Ажлын капиталын консерватив бодлого нь эргэлтийн хөрөнгийг харьцангуй их байхыг зөвшөөрдөг бодлого байдаг. Дээрх 2 компанийн хувьд консерватив бодлогыг баримталж байна үзэж байна. Эргэлтийн хөрөнгийн хэт их төвлөрөл үүсэх нь компанийн мөнгөний урсгалд саад учруулж улмаар ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Шинжилгээгээр хөрөнгийн өгөөжид хамгийн их сөрөг нөлөөлөлтэй хувьсагчаар борлуулалтын өсөлтийн хувь хэмжээ үнэлэгдсэн. Энэ нь борлуулалтын орлогын өсөлтийн хувь хэмжээ нь түүнийг бий болгоход шаардагдсан нэмэлт зардлын өсөлтийн хувь хэмжээнээс бага байсан тохиолдолд нийт хөрөнгийн өгөөж нь орлого нэмэгдэхээс өмнөх үеийн нийт хөрөнгийн өгөөжөөс бага байна. Харин дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хувь хөрөнгийн өгөөжтэй маш бага сөрөг хамааралтай, харин компаниудын нийт хөрөнгийн хэмжээ эерэг хамааралтай байхаар үнэлэгджээ. Судалгааны үр дүнгээр агрессив бодлогыг ажлын капиталын удирдлагад хэрэгжүүлэх нь үр ашигтай гэж дүгнэсэн.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр:

1. Ц.Аюурзана “Компаний санхүү” УБ хот 2010 он
2. С.Жамъянсүрэн “Бизнесийн шинжилгээ” УБ хот 2012 он
3. Л.Эрдэнэсүвд “Бизнесийн статистик” УБ хот 2008 он
4. Б.Бүжинлхам “Санхүүгийн удирдлага” УБ хот 2015 он

Гадаад хэл дээр:

1. Lawrence J.Gitman, Chad J.Zutter “Principles of Managerial Finance” 13th edition
2. Eugene F.Brigham “Fundamentals of Financial Management”

Докторын судалгааны ажил:

1. Нямсүрэн.О., “Аж үйлдвэрийн газруудын эргэлтийн хөрөнгө”, 1964
2. Эрдэнэбат. М., “Эргэлтийн хөрөнгийн оновчтой удирдлагын зарим асуудал”,

УБ., 2018

Англи хэл дээрх эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Asad Uzzamen, Tabassum Chowdhury, “Effect of Working Capital Management on Firm’s
2. Profitability: Empirical Evidence from textiles industry of Bangladesh”, 2014
3. John Kwaku Mensah Mawutor, “Working Capital Management and Profitability of Firms: A Study of Listed Manufacturing Firms in Ghana” 2014
4. Iman Soukhakian, Mehdi Khodakarami, “Working capital management, firm performance and macroeconomic factors: Evidence from Iran”, 2019
5. Rahimah.M.Y., Farha.A.G., Syahrul.A.A., Noralsah.S., “Working capital management and its effect on profitability Empirical evidence from Malaysian caoital market” 2018
6. Hwang Lan Lu, Kieu Trang Vu, Thi Bieh Ngoc Le, Manh Dung Tran, “Impact of Working Capital Management on financial performance: The case of Vietnam” 2018
7. Vianny Jenistan Delima, “Impact of Working Capital Management on Firm’s Profitability: A Study on Listed Companies in Sri Lanka” 2020
8. Nazir.M.S., Afza.T., “Impact of Aggressive Working Capital Management policy on Firm’s Profitability”, 2009
9. Deloof. M., “Does Working Capital Management affect profitability of Belgian firms?”, Journal of Business Finance and Accounting, 2003
10. Dong.H.P., Su.J.T., “The Relationship between Working Capital Management and Profitability: A Vietnam Case”, 2010

Цахим эх сурвалж

1. <http://mse.mn/mn>
2. <https://www.1212.mn/>

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ



Ц.ОЮУНАА

Орон сууц худалдах – худалдан авах гэрээнд заасан орон сууцны талбайн хэмжээнээс үүссэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн шинжилгээ

**ОРОН СУУЦ ХУДАЛДАХ – ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНД ЗААСАН
ОРОН СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭНЭЭС ҮҮССЭН
МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ
ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ^{16, 17}**

**ANALYSIS OF THE RESULTS OF COURT DECISIONS RESOLVING
THE DISPUTE ARISING FROM THE MEASUREMENT OF THE
APARTMENT SIZE SPECIFIED IN THE PURCHASE AGREEMENT
FOR THE SALE OF APARTMENT^{18, 19}**

Доктор, дэд профессор Ц.Оюунаа

(ОУУБИС. ХЗС)

oyunaa.ts@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Монгол Улсад барилгын салбар хөгжихийн хэрээр олон тооны орон сууц баригдан ашиглалтанд орж байгаатай холбогдуулан тухайн барилгыг худалдан авч буй нэг талаас иргэн, хуулийн этгээд нөгөө талаас барилгын ажил гүйцэтгэгч хувь хүн, хуулийн этгээдүүдийн хооронд үүссэн маргаан нэмэгдэж, улмаар энэ төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлэсэн тоо жил ирэх тутам өсөж байгаа нь энэ сэдвийг судлах шаардлагыг бий болгож байна.

Summary: With the development of the construction industry in Mongolia, due to the fact that a large number of apartments are being built and put into use, the number of disputes arising between individuals and legal entities who are buying the apartment building on the one hand, and individuals and legal entities performing construction work on the other hand, is increasing the demand for research on this topic.

¹⁶ ОУУБИС-ийн багш, ажилтан, албан хаагчдад зориулан (шинэ) орон сууц худалдаж авахтай холбоотой гардаг нийтлэг маргааны нэг болох орон сууцны талбайн маргааны талаар хууль зүйн судалгаа хийсэн бөгөөд энэ талын мэдлэгтэй болгох үүднээс мөн өөр өөр салбарын уншигч байгааг ойлгон хүндэтгэж хууль зүйн хэллэг, нэр томъёоны дэлгэрэнгүй ишлэл тайлбар хийсэн тул унших явцдаа ишлэлээ хамт уншиж тодруулга авна уу (Ц.Оюунаа. Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн доктор, дэд профессор).

¹⁷ 2023 оны 4 сарын 13 –ны өдөр зохион байгуулагдсан ОУУБИС-ийн Профессор багш нарын эрдэм шинжилгээний хуралд III байрт орсон судалгааны өгүүлэл болно.

¹⁸ A legal study was conducted on one of the most common disputes related to purchasing (new) housing for the teachers, staff, and employees of INTERNATIONAL UNIVERSITY OF ULAANBAATAR SCHOOL OF LAW. The terms have been explained in detail, so please read the quotations together for clarification (Ts. Oyunaa, Law School teacher, Doctor of Law, Associate Professor).

¹⁹ It is a research article that won the third place at the scientific meeting of INTERNATIONAL UNIVERSITY OF ULAANBAATAR SCHOOL OF LAW professors held on April 13, 2023.



Keywords: Apartment, the size of the area and ownership rights, the right to claim, loss of rights, property failure, the law of duty, contract law, principle of contract, apartment construction contract, apartment sale - purchase agreement, loan sale - purchase agreement, transaction

Түлхүүр үг: Орон сууц²⁰, ²¹-ны талбайн хэмжээ, өмчлөх эрх²², шаардах эрх²³, эрхээ алдах²⁴, эд хөрөнгийн доголдол, үүргийн эрх зүй²⁵, гэрээний эрх зүй²⁶, гэрээний зарчим, орон сууц захиалан бариулах гэрээ, орон сууц худалдах – худалдах авах гэрээ, зээлээр худалдах – худалдан авах гэрээ, хэлцэл

Үндсэн агуулга: 1926 оны Иргэний хууль²⁷ (1952²⁸, 1963²⁹, 1994³⁰,

²⁰ Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Хоёр дахь хэвлэл. Уб., 2013. 586 дахь талд үзэх

²¹ Монголын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол хэл дээрх эх. <http://www.Legalinform.mn/law/>. Орон сууцны тухай Монгол Улсын хууль, 3 дугаар зүйл, нэг дэх хэсэг (2023.2.7 -ны өдөр нэвтэрсэн)

²² Өмчлэх эрх нь орчуулгын хувьд латинаар – Jus proprietatis, ангилаар – dominium, right of property, оросоор – право собственности гэж оноосон ойлголт ба тодорхой этгээдийн өөрт байгаа эд хөрөнгийг хуулийн хэм хэмжээ, хязгаарын хүрээнд өөрийн үзэмж, ашиг сонирхлоор болон бусад этгээдийн нөлөөллөөс үл шалтгаалан эзэмших, ашиглах, захиран зарцуулах хууль зүйн ойлголт болно. Академич Нарангэрэл С. Монголын Эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэл. Уб., 2015. 338 дахь талд үзэх

²³ Шаардах эрх нь – англ. right of demand/claim, орос. право требования гэж орчуулагддаг, үүрэгчлэлийн харилцааны тал болох үүрэг гүйцэтгүүлэгчийн субъектив эрх юм. Оюунаа Ц. Олон улсын хувийн эрх зүй. Сурах бичиг. Уб., 2017. 189 дэх талд үзэх.

²⁴ Эрхээ алдах – loss of a right –утрата право (ссылаться на...) гэж оноосон. English- Korean-Mongolian-Russian-German – LEGAL DICTIONARY. Академич Жүгнээ Амарсанаа. Уб., 2011, 648 дахь талд үзэх

²⁵ Үүргийн харилцаа үүсгэх зорилго бүхий гэрээг үүргийн эрх зүйн хэлцэл гэх ба гэрээ байгуулагч талууд тодорхой бөгөөд эсрэг тэсрэг ашиг сонирхлыг зохицуулахыг зорилго болгодог. Талууд нэгдмэл үзэл бодолд хүрснээр гэрээ байгуулах нь гэрээний эрх чөлөө, чөлөөт байдлын зарчимд үндэслэх бөгөөд өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн 16-ийн 3-т заасныг Иргэний хуулийн 1.2 зүйлээр баталгаажуулдаг өгдөг гэсэн үг.

²⁶ Иргэний эрх зүйн (Хувийн эрх зүйн) салбарт гэрээний эрх зүйн салбар онцгой байр суурь эзэлдэг бөгөөд гэрээний эрх зүйн салбар шиг байнгын, тогтмол, тогтвортой байдлаар харьцуулагдан судлагддаг судлагдахуун цөөн юм. Гэрээний эрх зүйн талаарх судалгааны бүтээлүүдээс Konrad Zweigert, Hein Kotz нарын сонгодог бүтээл сүүлийн 15 жилд Европын улс орнуудын гэрээний чиглэлд анализ хийх үндсэн гарын авлага болоод байгаа билээ. Konrad Zweigert and Hein Kotz, An introduction to Comparative Law, (trans Tony Weir, 3th edition 1980) Oxford University Press, 2006, P323.

²⁷ 1929 оны 5 сарын 17-ны өдрийн Засгийн газрын XVI хурал болон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 46 дугаар хурлын 2 дугаар зүйлд баталсан: БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. 1929 он. №48, 44-78 дахь талд үзэх

²⁸ БНМАУ-ын Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн 1952 оны 5 сарын 27-ны өдрийн 38 дугаар зарлигаар баталсан: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хууль тогтоомжийн лавлагааны сан, 1945 – 1948, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, VI хавсралт.

²⁹ 1963 оны 2 сарын 9-ны өдрийн БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоолоор батлагдсан: БНМАУ-ын хууль тогтоомжийн системчилсэн эмхэтгэл, 7 дахь боть, 7-105 дахь талаас үзэх

³⁰ Төрийн мэдээлэл. Сэтгүүл. 1995 он, №1 дугаарт үзэх

2002³¹⁾ батлагдсанаас хойш гэрээ хэлэлцээ, тохиролцооны агуулгыг илэрхийлсэн хууль зүйн нэр томьёотой болж улмаар хэвшин хэрэглэгдэж эхэлсэн түүхтэй. Иргэний хуулиудад гэрээ бичиг, гэрээ хэлэлцээ³², хэлцэл^{33, 34, 35}, гэрээ гэсэн нэр томьёог ашиглаж ирснээр орчин цагийн гэрээний эрх зүй судлал хөгжиж³⁶ ялангуяа эрх зүйн философийн онолууд, тухайлбал, шинэ позитив³⁷, эрх зүйн социологи, эрх зүйн реалист онол нь гэрээний онолын хөгжилд чухал нөлөө үзүүлсээр байна³⁸.

Эрх зүйн салбар бүр өөрийн бие даасан эрх зүйн зарчимтай ба зарчим бол эрх зүйн хэм хэмжээ тогтоох, хэрэглэх, эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйлийг зохицуулах, эрх үүргийг хэрэгжүүлэхэд баримтлах үзэл баримтлалын чиглэмж³⁹ болж байдгаараа суурь шалгуур нь болж өгдөг. Энэ утгаараа Иргэний хуулийн нэгдүгээр зүйлийг үндэслэн⁴⁰ эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлын болон бие даасан байдлын, гэрээний талуудын чөлөөт байдлын зэрэг зарчим нь иргэний эрх зүйн хэлцэл болон гэрээний хувьд чухалчлан авч үздэг суурь зарчим

³¹ УИХ-аас 1998 онд “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг батлан гаргасан ба 1995 оноос эхлэх ХЗЯ-Герман улсын ГТХАН-ийн тусламжтайгаар 2002 оны Иргэний хуулийн төслийг бэлтгэж, улмаар тус нийгэмлэгийн тусламжтайгаар Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарыг боловсруулсан.

³² Гэрээ хэмээх ухагдахуун анх 1952 оны Иргэний хуулийн 20 дугаар зүйлд “хэлэлцээ” хэмээн нэрлэгдэж хэрэглэгдэх болсон байна. Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл: 1206-2012 он. Уб., 2012. 84 дэх талд үзэх

³³ Харин Иргэний хуулийг 1963 онд шинээр найруулж дагаж мөрдөх болсноор 1952 онд гэрээг томьёолж байсан “хэлэлцээ” хэмээх ухагдахууныг “хэлцэл” хэмээн нэрлэж хэвших болсон байна. Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл: 1206-2012 он. Уб., 2012. 84 дэх талд үзэх

³⁴ Эх газрын эрх зүйн бүлийн улс оронд хэлцлийн тухай ухагдахуун (герм. rechtsgeschaef, англ. Legal transaction /act, латин.negotium juridicum) XVIII зуунаас эрх зүйн судалгааны болон хуулийн хэрэглэнд орж эхэлснээр “хэлцлийн онол сургаал” хөгжиж ирсэн байна. “Хэлцэл” (лат. negotium juridicum) хэмээх нэр томьёо анх 1748 онд германы хуулийн чиглэлийн ном, сурах бичигт бичигдэж эхэлсэн бол, Германы эрдэмтэн Фридрих Карл фон Савини 1840 онд хэлцлийн тухай ойлголтыг хууль зүйн судлалын эргэлтэнд оруулсан.[http3 //de.Wiki/ Rechtsgeschaef](http3://de.Wiki/Rechtsgeschaef), Мэндсайхан Т. Гэрээний эрх зүй. Уб., 2021. 68 дахь тал

³⁵ Эрх зүйн тодорхой үр дагаварт чиглэсэн нэг эсвэл хэд хэдэн хүсэл зоригийн илэрхийлэлийг хэлцэл гэнэ (Rechtsgeschaef), хэлцлийн үндсэн ойлголтонд хүсэл зориг, түүний илэрхийлэл байна (ОХУ-ын Иргэний хууль), харин Англи Саксоны эрх зүйд хэлцэлтэй дүйх ухагдахууныг хэрэглэхгүй байна, харин promise, legal transaction, legal act, contract, agreement зэрэг нэр томьёог хэрэглэж байна

³⁶ Улсын нэр томьёоны комиссын мэдээ. №107-108. Хууль зүйн нэр томьёо. Тэргүүн дэвтэр. Уб., 1978. 216, 227 дахь талд үзэх

³⁷ Эрх зүй нарийн логик бүхий ухаалаг тогтолцоо байх ёстойг номлодог шинэ позитив онол нь иргэнлэг тогтолцоо бүхий улс орнуудад, Монгол Улсад хөгжих боломжтой. (Судлаачийн үзэл – Ц.Оюунаа)

³⁸ Лүндэндорж Н. Jurisprudence – Эрх зүй судлал: философи онол. Уб., 2011. 72, 85 дахь талд үзэх

³⁹ Мөнхжаргал Т. Иргэний эрх зүй. Ерөнхий анги. Уб., 2001. 16 дахь талд үзэх

⁴⁰ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 5-8 дахь талд үзэх



юм⁴¹.

Орон сууц баригдан ашиглалтанд орохтой холбоотойгоор орон сууцны талбайн хэмжээ орон сууц захиалан бариулах гэрээнд (Түлхүүр гардуулах нөхцөлтэй барилгын ажил гүйцэтгэх гэрээ, Баригдаж байгаа орон сууцыг худалдах худалдан авах гэрээ, Орон сууц зээлээр худалдах худалдан авах гэрээ, Ашиглалтанд орсон орон сууцыг худалдах худалдан авах гэрээ, Орон сууц захиалгаар бариулах гэрээ, Орон сууц худалдах худалдан авах гэрээ⁴²) зааснаас бага байгаа нь гэрээний суурь зарчим алдагдаж маргаан гарах үндэслэл болж байна. Энэ төрлийн маргааныг шүүх хэрхэн шийдвэрлэж байгааг 2017-2022 оны хооронд Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд харьяалуулан шийдвэрлэсэн таван хэрэг, маргааныг герменевтик⁴³ арга зүй ашиглан харьцуулан дүн шинжилгээ хийсэн болно. Энэ судалгааны ажлын шинжилгээг хийхдээ Иргэний хуулийн 243 зүйлийн 1 дэх хэсэгт заасан худалдах – худалдан авах гэрээнээс үүссэн доголдол, түүнтэй холбоотой шаардах эрхээ алдаж байгааг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаарх хэрэг маргааныг түүвэрлэн авч судалгаанд ашигласанаа дурьдах нь зүйтэй ба өөрөөр хэлбэл **“Орон сууц худалдах худалдан авах гэрээ”-ний гол зүйл нь тухайн орон сууцны талбайн хэмжээ байдаг ба талбайн хэмжээг буруу тогтоосон, стандартын дагуу хэмжээгүй, гэрээндээ талбайн хэмжээг буруу тусгасан** иргэний хэргийн шүүхээр хэрхэн шийдвэрлэгдэж байгааг судлах нь практикт үүсээд байгаа тулгамдсан асуудал болж байна. Энэ төрлийн маргаан нь:

1. Ямар төрлийн гэрээнээс үүссэн эсэх
2. Эд хөрөнгийн доголдлын асуудал үүссэн эсэх
3. Ямар тохиолдолд уг хэргийн оролцогч Иргэний хуулийн 255.1 дэх хэсэгт зааснаар⁴⁴ шаардах эрхээ алдсан гэж үзэж байгаа юм бэ гэсэн асуулт тавьж, энэ талаар шүүхээр хэрхэн шийдвэрлэгдсэн байдлыг судлах юм.

Дээрх асуултанд хариулахын тулд:

- Худалдах-худалдан авах гэрээний ойлголт, онцлог,
- Зээлээр худалдах худалдах авах гэрээний ойлголт, онцлог – худалдах худалдан авах гэрээнээс ялгагдах үндэслэл,
- Ажил гүйцэтгэх гэрээний ойлголт, онцлог – худалдах худалдан авах гэрээнээс

⁴¹ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 6-7 дахь талд үзэх

⁴² Шүүхээр шийдвэрлэгдсэн орон сууцны талбайн хэмжээг тооцох тухай маргааныг судлах явцад тухайн маргаанд оролцогч талуудын байгуулсан гэрээний нэр нь өөр өөр нэрээр байгуулагдсан байна. Ийм маргааныг шийдвэрлэхдээ Дээд Шүүхээс 2016 оны есдүгээр сард гаргасан зөвлөмжийг үндэслэж шийдэж байна. Эх сурвалж: Улсын Дээд Шүүхийн 2016 оны 9 сарын 5-ны өдрийн Зөвлөмж.

⁴³ Герменевтик арга зүй нь -

⁴⁴ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 515-518 дахь талд үзэх

ялгагдах үндэслэл зэргийг эхний ээлжинд авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

1)Худалдах-худалдан авах гэрээ – нь үүргийн эрх зүйн гэрээний нэг төрөл ба хүчин төгөлдөр байгуулагдсан худалдах – худалдан авах гэрээ нь гэрээний талуудад шаардлага гаргах эрх ба үүргийг үүсгэдэг Иргэний хуулийн 225 зүйлд заасан хоёр талын гэрээ юм. Худалдагч нь худалдсан эд хөрөнгийн өмчлөлийг худалдан авагчид шилжүүлэх, худалдан авагч эд хөрөнгийн үнийг төлөх үүрэг тус тус хүлээнэ, өөрөөр хэлбэл энэхүү гэрээг байгуулсан хоёр тал хоёулаа үүрэг хүлээн гэсэн үг.

Шүүхээр шийдвэрлэгдсэн орон сууцны талбайн хэмжээг тооцох тухай маргаануудыг судлаад авч үзэхэд тухайн маргаанд оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээ нь нэг талаас орон сууц барьж өгөх, нөгөө талаас орон сууц бариулахаар захиалга өгч, мөнгийг төлөх үүрэг хүлээсэн гэрээ байх ба “Орон сууц захиалгаар бариулах гэрээ”, “Түлхүүр гардуулах нөхцөлтэй барилгын ажил гүйцэтгэх гэрээ”, “Орон сууц захиалан бариулах гэрээ”, “Орон сууц худалдах худалдан авах гэрээ”, “Ашиглалтанд орсон орон сууц худалдах авах гэрээ”, “Баригдаж байгаа барилгад орон сууц захиалах гэрээ” зэрэг өөр өөр нэртэй байгаа ч Иргэний хуулийн 243.1-д заасан зүйлийн дагуу шийдэж байгаа нь талууд гэрээгээ өөр өөрөөр нэрлэсэн нь тухайн гэрээний агуулгыг өөрчлөх, гэрээний шинжийг үгүйсгэх үндэслэл болохгүй бөгөөд эцсийн дүндээ яах аргагүй 243.1 дэх хэсэгт заасан⁴⁵ “Худалдах худалдан авах гэрээ” гэж тодорхойлолтод нийцэж байгаа тул Дээд Шүүхээс 2016 оны есдүгээр сард гаргасан зөвлөмж^{46, 47}-ийг үндэслэж энэ төрлийн маргааныг шийдэж байна.

Зээлээр худалдах худалдах авах гэрээнээс ялгагдах үндэслэл: Зээлээр худалдах худалдан авах гэрээ нь ердийн худалдах худалдан авах гэрээнээс худалдсан зүйлийн үнийг уг зүйлийг хүлээн авсан даруйдаа биш, харин гэрээнд заасны дагуу тодорхой хугацааны дараа хэсэгчлэн буюу бүрэн эсвэл тодорхой хугацааны туршид хэсэгчлэн төлөх үүргийг хүлээдгээрээ ялгаатай байна. Тиймээс Иргэний хуулийн 262.1-д худалдагч нь худалдсан зүйлийг худалдан авагчид үнийг нь бүрэн төлөхөөс өмнө шилжүүлэх үүрэгтэйг заасан бөгөөд ердийн тохиолдолд 243.1-д заасны дагуу өмчлөх эрхийг шууд шилжүүлдэг⁴⁸ бол Зээлээр худалдах худалдан авах гэрээний хувьд шууд шилжүүлэх үүрэг хүлээдэггүй⁴⁹ онцлогтой өөрөөр хэлбэл, ердийн үед үүргийг нэн даруй гүйцэтгэх ёстой. Харин Зээлээр худалдах худалдан авах гэрээний хувьд худалдан авагч нь үнийг хожим нь мөн хэсэгчлэн

⁴⁵ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 485 -489 дахь талд үзэх

⁴⁶ Эх сурвалж: Улсын Дээд Шүүхийн 2016 оны 9 сарын 5-ны өдрийн Зөвлөмж

⁴⁷ Эх сурвалж: Улсын Дээд Шүүхийн 2017 оны 12 сарын 5-ны өдрийн Зөвлөмж

⁴⁸ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 485 дахь талд үзэх

⁴⁹ Монгол Улсын Иргэний хууль. Шинжлэх ухааны тайлбар. Уб., 2018. 530 дахь талаас үзэх



төлөх боломжтой, худалдагч нь эд хөрөнгийг өмчлөх эрхийг шууд шилжүүлэхгүй ба зөвхөн эзэмшлийг шилжүүлэх боломжтой байдаг. Өмч шилжихгүй байх болон гэрээний үнийг хэсэгчлэн төлөхтэй холбоотойгоор үүсэх эрх зүйн үр дагавар, эрсдэл шилжих зохицуулалт нь ердийн худалдах худалдан авах гэрээнээс ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, ердийн худалдах худалдан авах гэрээгээр талуудын хүлээдэг бусад үүргийг Иргэний хуулийн 262 болон 264 дүгээр зүйлд өөрчлөхгүй хэвээр нь үлдээсэн нь Зээлээр худалдах худалдан авах гэрээ нь Худалдах худалдан авах гэрээ мөн бөгөөд худалдах худалдан авах гэрээний бүх зохицуулалт нэгэн адил үйлчилж байна. Үүнээс үзэхэд орон сууцны талбайн хэмжээг тооцохтой холбоотой маргааны хувьд тухайн гэрээ нь ердийн худалдах худалдан авах гэрээ юмуу, зээлээр худалдах худалдан авах гэрээ юм уу гэдгээс үл хамаарч эд хөрөнгийн доголдолтой холбоотой зохицуулалт нь адил байна.

Ажил гүйцэтгэх гэрээнээс ялгагдах үндэслэл: Иргэний хуулийн 343 дугаар зүйлээр зохицуулагдах ажил гүйцэтгэх гэрээ нь хариу төлбөртэй хоёр талын гэрээ бөгөөд ажил гүйцэтгэгч нь амалсан тодорхой нэг ажлыг гүйцэтгэх, нийлүүлэх нь энэ гэрээний үндсэн агуулга юм. Өөрөөр хэлбэл ажил гүйцэтгэгч нь өөрийнхөө эсвэл захиалагчийн материалаар хэлэлцэн тохирсон ажлыг гүйцэтгэх, захиалагч нь ажлыг хүлээн авч хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээх талаарх харилцааг зохицуулсан. Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шууд үүссэн үр дүн гэсэн үг. Ажил гүйцэтгэх гэрээ мөн эсэхийг тогтоохын тулд тухайн тохиолдолд талууд гэрээг ямар нэрээр нэрлэсэн нь гол биш, харин өөрсдийн хүлээх эрх, үүргийг хэрхэн тохиролцсон нь буюу тодорхой тохиолдолд бүх нөхцөл байдлыг ялангуяа үүргийн агуулгыг харгалзан үзэж тогтоох нь тухайн маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Худалдах худалдан авах гэрээнээс ялгагдах онцлог нь Иргэний хуулийн 243 дугаар зүйл нь бэлэн эд юмсын өмчлөх эрхийг шилжүүлэх агуулгатай бол ажил гүйцэтгэх гэрээний агуулга нь нэгэн үр дүнг буюу эд юмсыг шинээр бий болгох явдал юм.

Монгол Улсын Дээд Шүүхийн Зөвлөмжид “нэг тал нь тодорхой давхарт, өрөөний тоо, талбайн хэмжээ, загварыг тогтоон, орон сууц захиалж, үүнийхээ төлөө хөлс төлөх, нөгөө тал нь уг ажлын үр дүнг хүлээлгэж өгөхөөр тохирсон агуулга тогтоогдвол энэ нь ажил гүйцэтгэх гэрээний үндсэн шинж болох ба харин нэгэнт бий болсон орон сууцыг санал болгох, нөгөө тал нь тохирсон үнийг төлөх тохиролцоо нь худалдах худалдан гэрээ байна” гэж тайлбарласан⁵⁰ байна. Харин Иргэний хуульд заасны дагуу төрлийн шинжээр тодорхойлогдох эд юмс бүтээж захиалагчийн өмчлөлд шилжүүлсэн тохиолдолд худалдах худалдах авах гэрээний

⁵⁰ 2016 оны 9 сарын 5 –ны өдрийн Улсын Дээд Шүүхийн Зөвлөмж

эрх зүйн зохицуулалт шууд хэрэгждэг үндэслэлтэй юм.

Орон сууц захиалгаар бариулах, захиалан бариулж байгаа тохиолдолд энэ нь тухайн гэрээнд заагдсан газар, давхарт, тогтоосон хэмжээний дагуу, тохиролцсон загвар, өрөөний зохион байгуулалтын дагуу баригдах тул энэ нь төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө гэж үзэж, шүүхээс тухайн төрлийн хэрэг маргаанд талуудын хооронд байгуулсан гэрээг худалдах худалдан авах гэрээ гэж тогтоож байгаа нь маргалдагч талуудын хооронд байгуулсан гэрээний оноосон нэр ямар байхаас хамаарахгүйгээр гэрээний дагуу талуудын хооронд үүссэн эрх үүрэг, мөн эд хөрөнгийн шинж чанараас хамааран худалдах худалдан авах гэрээ гэж үзэж шүүхээс тухайн маргааныг шийдвэрлэж байгаа нь үндэслэлтэй байна⁵¹.

Худалдах худалдан авах гэрээг дээрх 2 гэрээнээс ялгагдах онцлогийг тодруулан авч үзсэн учраас одоо эд хөрөнгийн доголдлыг хэрхэн тооцох талаар болон шаардах эрхээ алдах, мөн үгүйсгэх нөхцөл байдлыг судлан авч үзье. Үүнд:

1. Эд хөрөнгийн доголдлыг хэрхэн тооцдог юм бэ – Доголдлыг тогтоох субъектив онол⁵²-ын үүднээс доголдлыг тогтооход гэрээнд юу гэж тохиролцсон бэ түүнийг л маргааны эхэнд авч үзэх ёстой байдаг.

Худалдах худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээх тухай Иргэний хуулийн худалдах худалдан авах гэрээний зохицуулалтанд томъёолсон байдаг нь худалдагдсан хөрөнгө доголдолгүй байх үүргийг илэрхийлж байна.

Худалдагдсан эд хөрөнгийг доголдолгүйд тооцогдохын тулд гэрээнд заасан тоо, хэмжээ, чанарыг агуулсан байхыг ойлгоно. Доголдолгүй байх ёстой эд хөрөнгө, барааг хүлээлгэн өгөх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 251 дүгээр зүйлийн нэгд зааснаар “гэрээгээр тогтоосон тоо, хэмжээ, чанар бүхий эд хөрөнгийг биет байдлын хувьд доголдолгүй гэж үзнэ” гэсэн зүйлчлэлийг өөрөөр хэлбэл, гэрээнд эд хөрөнгийн тоо, хэмжээ, ба чанарын үзүүлэлтийн тухай тусгайлан тохирсон нөхцөлд хэрэглэнэ гэсэн үг. Энэ тохиолдолд л дээр дурьдсан “субъектив онол” хэрэглэгдэнэ.

Харин гэрээний талууд гэрээнд тохирсноос өөр байгаа тохиолдолд “эд хөрөнгө доголдолтой” хэмээн үзэж Иргэний хуулийн 253 дугаар зүйлийн 1-д зааснаар **“худалдагдсан эд хөрөнгө доголдолтой байвал худалдан авагч тал нь**

⁵¹ Сонгомол шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. 2021 оны Дээд шүүхийн шийдвэрийн 43 дэх талд үзэх

⁵² Буянхишиг Б. Иргэний эрх зүй. Тусгай анги. III хэвлэл. УБ., 59 дэх талаас үзэх



уг доголдлыг арилгуулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг цуцлах шаардлага гаргах эрхтэй, худалдагч тал дээр дурьдсан байдлаар доголдлыг арилгах үүрэгтэй” болно.

Ингээд хууль болон гэрээнд заасан “эд хөрөнгийн доголдол” гэдэгт юу хамаарахыг тогтоох шаардлага үүсэж байна гэсэн үг. Үүнийг тогтоохын тулд Монгол Улсад баримталдаг “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал буюу MNS 6058:2009 стандарт⁵³ шаардлагыг судлах хэрэгтэй болно.

Орон сууцны талбайг хэрхэн тооцох вэ, өөрөөр хэлбэл, үүнтэй холбоотой маргаан ихсэх болсон нь хууль зүйн үндэслэл бүхий нэгдмэл аргачлалтай байхыг шаардаж байна гэсэн үг. Стандарчлал, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөс “Орон сууцны барилга доторх сууцны талбай тооцох аргачлал”-ыг 2009 онд баталсан нь энэ төрлийн маргааны эх сурвалж болон ашиглагдаж байна. Орон сууцны талбайн хэмжилт хийхэд “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал буюу MNS 6058:2009 стандартыг баримтлан хэмжилтийг хийж, баталгаажуулахдаа тухайн төрлийн маргааны нэхэмжлэгчид уг стандартын дагуу орон сууцны талбайг тусгай эрх бүхий хэмжилтийн хуулийн этгээдээр хийлгүүлж, гэрээнд заасан талбайн хэмжээнд хүрэхгүй байгаа үйлдлийг тогтоолгож байгаа нь нийтлэг байна. Орон сууц барих ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан тохиолдолд орон сууцны талбайн хэмжээ дутуу байгаа нь захиалсан зүйлийг зохих ёсоор хийгээгүй, ажлын үр дүн нь “доголдолтой⁵⁴” гэж дүгнэхэд хүргэж байна.

Орон сууц захиалан бариулах, худалдах – худалдан авах гэрээ байгуулж байгаа талууд гэрээндээ тусгасан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартыг баримтална гэж заасан нь **“Стандарчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 27.3 болон 31 дүгээр зүйлийг зөрчиж өөр хэмжээ бичсэн зэрэг асуудал нь шүүхээс тухайн тохиолдол үйл баримтад үндэслэж тогтоож байна. Орон сууцны талбайн хэмжээ дутуу байгаа нь захиалсан зүйлийг зохих ёсоор хийгээгүй, ажлын үр дүн “доголдол”-той болохыг харуулж байгааг шүүхээс 251.1 дэх хэсэгт заасны дагуу “биет байдлын доголдол” бүхий эд хөрөнгөд**

⁵³ “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал буюу MNS 6058:2009 стандарт нь 2010 оны 2 дугаар сарын 1-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн ба 2010 оноос хойш баригдсан болон баригдаж байгаа үл хөдлөх хөрөнгөд хамаарахаар зохицуулагдсан болно (Ц.Оюунаа – тодруулга).

⁵⁴ 2017 оны 12 сарын 21-ны өдөр баталсан 2018 оны 7 сарын 1-ны өдрөөс дагаж мөрдөж байгаа “Стандарчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 4.2.1-д “стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 4-т үндэсний стандартыг заавал дагаж мөрдөнө гэсэн нь дээрх стандартыг заавал дагаж мөрдөхыг өөрөөр хэлбэл хариуцагч тал үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэйг хуульчилсан байна (Ц.Оюунаа – тодруулга).

хамаарна гэж үзэж шийдвэрлэж байна⁵⁵. Хариуцагч тал нь гэрээнд заасан талбайн хэмжээ бүхий орон сууцыг нэхэмжлэгчид хүлээлгэн өгөх үүргээ зохих журмын дагуу биелүүлээгүй гэж үзсэнийг Иргэний хуулийн 255.1-д заасан “эд хөрөнгийн

доголдол” мөн гэж шүүх үндэслэл бүхий тайлбар⁵⁶ өгч байгааг анхаарах хэрэгтэй юм.

2. Шаардах эрхээ алдах буюу Иргэний хуулийн 255 зүйлийн 1 дэх хэсгийг хэрхэн ойлгох юм бэ –

Шүүхээс орон сууцны талбайн хэмжээнээс үүдэн гарч байгаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгт авагдсан баримт, зохиогчдын тайлбараас судлаад үзэхэд орон сууцны талбайн хэмжээг тодорхой тусгасан байхад нэхэмжлэгч нь гэрээний зүйлийг хүлээж авахаас өмнө, эсвэл хүлээж авах үедээ хэмжилт хийлгэх замаар тухайн орон сууцны талбайн хэмжээг мэдэх боломжтой байсан гэж дүгнээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж Иргэний хуулийн 255 зүйлийн 1.1-д заасны дагуу нэхэмжлэгчийн доголдолтой холбоотой шаардах эрхээ алдсан гэж үзэж байгаа шүүхийн практик түгээмэл ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл талууд Орон сууц барих ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан тохиолдолд ажлын үр дүнг хүлээж авах үед түүний доголдлыг захиалагч мэдэж байсан боловч ямар нэгэн гомдол гаргаагүй бол тэрээр Иргэний хуулийн 352.2-т заасан шаардах эрхээ алдахыг тус хуулийн 352.4-т заасан. Эдгээр зохицуулалтаас үзэхэд ажил гүйцэтгэх гэрээний захиалагч ажлын үр дүнг хүлээн авах үедээ доголдлын талаар мэдсэн боловч гомдол гаргаагүй бол шаардах эрх нь алдагдах, харин худалдах худалдан авах гэрээнээс ялгаатай нь доголдлыг мэдэх боломжтой байсан гэх нөхцлийг ажил гүйцэтгэх гэрээнд хуульчилж өгөөгүй байна.

Орон сууцны талбайн хэмжээ дутуу гэх доголдол нь хүлээж авах үед мэдэх боломжтой эд хөрөнгийн доголдолд хамаарахгүй гэж онолын үүднээс зарим судлаачид үздэг боловч орон сууц түүний үнэ зөвхөн талбайн хэмжээгээр бус тохижилт, байрлал загвар, өрөөний тоо зэрэг шинжүүдээрээ тодорхойлогддог, орон сууцны талбайн баримжаагаар бус хэмжих бололцоотой тул орон сууцны талбайн хэмжээг эд хөрөнгө хүлээж авах үед мэдэх боломжтой гэж үзсэн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн орон сууц худалдан авах гэрээнд заасан талбайн хэмжээнд хүрээгүй байгаа доголдолтой холбоотой маргаануудаас худалдан авагчийн доголдолтой холбоотой шаардах эрхийг Иргэний хуулийн 255 зүйлд

⁵⁵ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал (2017 оны 2 сарын 20-ны өдөр, №536)

⁵⁶ Баян-Зүрх, Сухбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. (2015 оны 12 сарын 2-ны өдрийн №8348 болон Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн тогтоол 2016 оны 4 сарын 26-ны өдрийн №415)



заасныг баримтлан шалгавал уг шаардах эрхээ алдсан гэж шийдвэрлэсэн нь их байна.

Үгүйсгэх нөхцөл буюу Иргэний хуулийн 255 зүйлийн 2 дахь хэсгийг хэрхэн ойлгох юм бэ – Худалдах худалдан авах гэрээг байгуулсан талуудын эд хөрөнгийн доголдолтой холбоотой шаардах эрхээ алдсан эсэхийг тогтоохдоо Иргэний хуулийн 255 –ийн 2 дахь хэсэгт заасныг шалгах шаардлагатай юм. Иргэний хуулийн 255.2-т “Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үед түүний доголдлыг мэдсээр байж нуун дарагдуулсан бол энэ хуулийн 255.1-д хамаарахгүй” гэж заасан. Энэ заалтын дагуу худалдагч нь эд хөрөнгийг шилжүүлж байхдаа доголдолтой болохыг мэдэж байсан бөгөөд худалдан авагчид хэлээгүй тохиолдолд 255 зүйлд тусгагдсан бүх тохиолдол буюу худалдан авагчийн гомдлын шаардлага гаргах эрх нь хаалттай байдаг зохицуулалт хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд худалдагчийг хамгаалах ёсгүй байдаг. Худалдагч санаатайгаар эд хөрөнгийн доголдлыг нуусан бол түүнд худалдан авагч эд хөрөнгийг нэн даруй шалгах үүргээ биелүүлээгүй гэх үндэслэл⁵⁷, ⁵⁸ байхгүй гэж шийдсэн шүүхийн шийдвэр 2016 оны “Шүүхийн сонгомол шийдвэр”-ийн эмхэтгэл⁵⁹-д орсон байна.

Дүгнэлт хэсэг: Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн 10 тогтоолд “нэхэмжлэгч орон сууцанд орохдоо тухайн орон сууцны талбайн хэмжээг гэрээнд зааснаас өөр байгааг мэдэх боломжтой бөгөөд орон сууцанд нүүж орсон нь тухайн доголдлыг мэдсээр байж хүлээн зөвшөөрсөнд тооцох үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн нь дийлэнх нь байна.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 255-ийн1 дэх хэсэгт заасныг баримтлан орон сууц худалдан авч буй этгээд нь орон сууцны талбайн хэмжээг дутуу байгаа, гэрээнд тохирсноос ялгаатай байгааг орон сууц хүлээн авахаас өмнө мэдэх боломжтой байсан гэсэн үндэслэлээр хэргийг шийдсэн байна. Үүнээс аваад үзэхэд анхаарах хэд хэдэн асуудал байна. Үүнд:

1. Орон сууцыг худалдах худалдан авах гэрээнд заасан талбайн хэмжээг талууд орон сууц хүлээн авахаас өмнө тогтоолгох, байгуулж буй гэрээндээ талбайн хэмжээг нэг бүрчлэн тооцох, хэмжилтыг зардлыг хэрхэн хэн хариуцах ... зэрэг заалтыг худалдан авагч тал мэдэж байх, шалгах үүрэгтэй гэж үзэж байгаа практик тогтсон ба энэ төрлийн гэрээг байгуулахад анхаарах шаардлагатай байна. Орон сууцны талбайн хэмжээнээс үүдэлтэй маргаанд хохиролын хэмжээ нь:

- Зөвхөн аваагүй талбайд төлсөн төлбөрөөр хязгаарлагдахгүй

⁵⁷ Улсын Дээд Шүүхийн 2016 оны 9 сарын 5-ны өдрийн Зөвлөмж

⁵⁸ Улсын Дээд Шүүхийн 2017 оны 12 сарын 25-ны өдрийн Зөвлөмж

⁵⁹ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн сонгомол түүвэр. 1959-2021. У6 хот 85-93 дахь тал үзэх

- Энэ байрыг авахад урт хугацаанд төлж буй банкны зээлийн хүү
- Мөн орон сууц ашиглах явцад сууц ашиглалтын зардал ... мөн адил хамаарч байгааг анхаарах ёстой.

2. Иргэний хуулийн 255-ийн 1-ийг баримтлан уг маргааныг шийдвэрлэхдээ 255.2 заасан нөхцөл байдлыг харгалзан үзэх – судалгаанд ашиглагдсан 10 маргааны тогтоолд 255.2-ийг шалган үзсэн тохиолдол байгаагүй бөгөөд үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг шалгах хэрэгтэй юм.

3. Орон сууцны талбайн хэмжээ нь гэрээний гол нөхцөл гэж үзэхэд эргэлзээтэй зүйл бол худалдан авагч гол нөхцлийг шалгаж хүлээж авах үүрэгтэй байгаа нь онолын хувьд ойлгомжгүй байгаа. Өөрөөр хэлбэл шудрага ёсны зарчим, шүүхээр хамгаалуулах зарчим, мөн хууль ёсны ашиг сонирхлыг шүүхийн журмаар хамгаалахдаа Үндсэн хуулийн 14.1 буюу хуулийн өмнө эрх тэгш байна гэсэн хэм хэмжээ зөрчигдөхөд хүрч байна. Хүлээн авч байгаа орон сууцны талбай 3-8 метр кв-ийн хэмжээг мэргэжлийн байгууллага бус энгийн иргэн шууд мэдэх боломжтой байсан гэж шүүхээс дүгнэж байгаа нь эрх зүйн шудрага ёсны, болон шүүхийн хамгаалалтын зарчмын мөн чанарт нийцэхгүй байна гэж үзэх үндэслэл байна. Үүнээс үүдээс иргэд худалдаж авсан орон сууцны хэмжээ дутуу болохыг мэдсэн ч, хохирч байгаагаа мэдсэн ч шүүхэд хандаж эрх ашигаа хамгаалуулах байдал багасах хандлага байгааг судлах хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Үндсэн хууль, (2019 оны нэмэлт өөрчлөлт)
2. Барилгын тухай хууль
3. БНМАУ-ын Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн 1952 оны 5 сарын 27-ны өдрийн 38 дугаар зарлигаар баталсан: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хууль тогтоомжийн лавлагааны сан, 1945 – 1948, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, VI хавсралт.
4. БНМАУ-ын хууль тогтоомжийн системчилсэн эмхэтгэл, 7 дахь боть,
5. Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл: 1206-2012 он. УБ., 2012.
6. Монгол Улсын Барилгын норм ба дүрэм. УБ., 2022
7. Орон сууцны барилгын зураг төсөл, төлөвлөлт. УБ., 2022
8. Иргэний хууль, УБ., 2002



9. *Орон сууцны тухай хууль*
10. *Орон сууц хувьчлах тухай хууль*
11. Стандартлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хууль

Ном, сурах бичиг: (Монгол хэл дээрх)

12. Академич Жүгнээ Амарсанаа. English- Korean-Mongolian-Russian-German – LEGAL DICTIONARY. УБ., 2011,
13. Академич Нарангэрэл С. Монголын Эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэл. УБ., 2018
14. Буянхишиг Б. Иргэний эрх зүй. Тусгай анги. III хэвлэл. УБ
15. Мэндсайхан Т. Гэрээний эрх зүй. УБ., 2021
16. Лүндэндорж Н. Jurisprudence – Эрх зүй судлал: философи онол. УБ., 2011.
18. Оюунаа Ц. Олон улсын хувийн эрх зүй. Сурах бичиг. УБ., 2017.
19. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Хоёр дахь хэвлэл. УБ., 2013.
20. Сонгомол шүүхийн шийдвэрийн боть. I, II, III, IV, V, VI. УБ. 2021.

Ном, сурах бичиг: (Гадаад хэл дээрх)

21. Konrad Zweigert and Hein Kotz, *An introduction to Comparative Law*, (trans Tony Weir, 3th edition 1980) Oxford University Press, 2006
22. Penner J.E. *The idea of Property in law*. Oxford University Press. 1997
23. Chang, Yun chien and Smith, Henry E. *An Economic Analysis of Common versus Civil Law Property*, Notre Dame Law Review. 2012

Сэтгүүл

24. БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. 1929 он. №48,
25. Улсын нэр томёоны комиссын мэдээ. №107-108. Хууль зүйн нэр томьёо. Тэргүүн дэвтэр. УБ., 1978.
26. Төрийн мэдээлэл. Сэтгүүл. 1995 он, №1 дугаарт үзэх
27. Эрх зүй судлал, Сэтгүүл. УБ., 2011.

Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол:

28. Нийслэлийн Иргэний хэргийн дагвж заалдах шатны шүүхийн магадлал (2017 оны 2 сарын 20-ны өдөр, №536)
29. Баян-Зүрх, Сухбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр
30. Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн тогтоол

Зөвлөмж:

31. Улсын Дээд Шүүхийн 2016 оны 9 сарын 5-ны өдрийн Зөвлөмж.
32. Улсын Дээд Шүүхийн 2017 оны 12 сарын 5-ны өдрийн Зөвлөмж
33. *Улсын Дээд Шүүхийн 2017 оны 12 сарын 25-ны өдрийн Зөвлөмж*

Аргачлал:

34. Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал буюу MNS 6058:2009 стандарт нь 2010 оны 2 дугаар сарын 1-ны өдрөөс мөрдөгдсөн

Цахим эх сурвалж:

35. Монголын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол хэл дээрх эх. [http // www. Legalinfo.mn/law/](http://www.Legalinfo.mn/law/).
36. Монгол Улсын Стандарт хэмжил зүйн газар. www.MASM.GOV.MN

**ОЛОН УЛСЫН
УЛААНБААТАРЫН ИХ
СУРГУУЛИЙН 30 ЖИЛИЙН
ОЙД ЗОРИУЛСАН ТУСГАЙ
ДУГААРЫН ИЛТГЭЛ**

АГУУЛГА

ХҮМҮҮНЛЭГ, НИЙГМИЙН УХААНЫ СУРГУУЛЬ

СОЛОНГОС СУДЛАЛЫН ТӨВ

КАН СОНЬ ХУА

Монгол дахь солонгос судлалын судалгаа, амжилт ба
сорилт iuu солонгос судлалын төвийн жишээн дээр..... 128

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТЭНХИМ

LEE, SEUNG HOON

국제울란바타르대학교의 연구중심대학으로의 전환을
위한 가능성과 방안, 그리고 한계 - 한국대학의 발전과정 사례를
중심으로..... 144

Б.АРИУНТУЛГА

Түүх соёлын биет өвийг дижитал аргаар сэргээх нь..... 157

ГЭР БҮЛ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ТЭНХИМ

Б.АНУЖИН, П.СҮНЖИДМАА

Нэр дэвшигчдийг үнэлэх шалгуурт нөлөөлөх зарим хүчин зүйлсийг
судалсан нь /хөвсгөл аймгийн жишээн дээр/..... 168

А.МӨНХЖИН, Ө. БАЙГАЛЬ

Өсвөр насны хүүхдийн үе тэнгийн дээрэлхэлтийг сэтгэл
хөдлөл, зан үйлийн бэрхшээлтэй харьцуулан судалсан нь..... 180



НИЙГМИЙН АЖЛЫН ТЭНХИМ

Э.САРАНЦАЦРАЛ

Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт,
түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх нь..... 196

СОЛОНГОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ТЭНХИМ

С.ЭНХЗУЛ

Солонгос, монгол хэлний холбох үгийн хэрэглээнд Анализ хийх нь..... 203

ИНЖЕНЕР, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

ДИЗАЙНЫ ТЭНХИМ

Н.ЭНХТАЙВАН

Тогтвортой хөгжил, монголчуудын сав, эдлэлийн, эко уламжлал..... 214

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

А.ХАНДМАА

“Үнэнч ажилтан”-ыг тодорхойлох онолын судалгаа..... 222

Т.БУЛГАН

Бизнесийн байгууллагын хөдөлмөрийн нөөц ашиглалтыг
нэмэгдүүлэх боломжийн судалгаа..... 232

БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ

С.ДЭЛГЭРМАА, М.ДОВУУЧ

Монгол улсын экспортыг нэмэгдүүлэхэд дээд
Боловсролын салбарын гүйцэтгэх үүрэг..... 242



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТЭНХИМ

JISEON KIM

The social and economic dimensions of tipping practices..... 250

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

П.АНХМАА

Амиа хорлох гэмт явдал, үүнээс урьдчилан сэргийлэх зарим асуудал.... 262

НОМЫН САН

Ю.БАДАМХАНД

Номын сангийн хөгжил, чиг хандлага..... 278

СОЛОНГОС СУДЛАЛЫН ТӨВ



КАН СОНЬ ХУА

Монгол дахь солонгос судлалын судалгаа, амжилт ба
сорилт иш солонгос судлалын төвийн жишээн дээр

МОНГОЛ ДАХЬ СОЛОНГОС СУДЛАЛЫН СУДАЛГАА, АМЖИЛТ БА СОРИЛТ IUU СОЛОНГОС СУДЛАЛЫН ТӨВИЙН ЖИШЭЭН ДЭЭР¹

Доктор, Кан Сонь Хуа

(ОУУБИС, Солонгос судлалын төвийн захирал)

sunhwa.k@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн харьяа Солонгос судлалын төв нь 2003 онд БНСУ-ын Санмён их сургуулийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан. Өнгөрсөн хорь гаруй жилийн хугацаанд Монголд солонгос судлалын үндэс суурийг тавьж, солонгос судлал, солонгос хэлний боловсрол зэрэг салбарт өөрийн хөгжилд хувь нэмрээ оруулж, Солонгос, Монголын салбар хоорондын солилцооны цар хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ, хоёр орны соёл урлаг, эрдэм шинжилгээний салбарын тасралтгүй судалгаа, төслүүдийг дэмжин ажиллаж байна. Энэхүү илтгэл нь Олон Улсын Улаанбаатарын их сургууль байгуулагдсны 30 жилийн ойг тохиолдуулан Монгол дахь солонгос судлалын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж буй манай төвийн ололт амжилтыг эргэн харж, цаашид хөгжүүлэх арга замыг эрэлхийлсэн болно.

ОРШИЛ

Солонгос орон судлал нь хэл, түүх, соёл, улс төр, эдийн засаг, нийгэм, газарзүй, шинжлэх ухаан гэх мэт солонгос судлалтай холбоотой мэдлэгийг бүхэлд нь хамарсан цогц шинжлэх ухаан(Doosan Encyclopedia) бөгөөд Солонгос орны эртнээс нааш уламжлагдан ирсэн өвөрмөц мөн чанарыг бусад улс оронд зөв таниулах академик үйл ажиллагаа билээ.

Солонгос улс, хилийн чанадад буюу гадаад орнуудад Солонгос судлалыг дэмжих ажлыг 1970-аад оноос эхлүүлсэн.(И Гиль Сан, 2006) (이길상, 2006) 1973 онд тухайн үеийн Соёл, боловсролын яамнаас хилийн чанадад Солонгосыг таниулах шаардлагатай байгааг олж харсан ба 240,000 ам.долларын санхүүжилтийг олгосон нь эхлэл болсон. 1979 онд Солонгосын Оюуны Соёлын Хүрээлэн (өнөөгийн

¹ This work was supported by the Core University Program for Korean Studies of Ministry of Education of Republic of Korea and the Korean Studies Promotion Service at the Academy of Korean Studies (AKS-2022-OLU-2250006)



Солонгос Судлалын Хүрээлэн, The Academy of Korean Studies) байгуулагдаж, гадаадын эрдэмтдийг урьж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлсэн. 1981 онд Солонгосын Шинжлэх Ухааны Хөгжлийн Сан² байгуулагдсанаар хилийн чанад дахь Солонгос судлалд бодитой дэмжлэг үзүүлдэг болсон. 1991 онд Гадаад хэргийн яамны харьяа Солонгос Судлалын Сан(Korea Foundation) байгуулагдсанаар олон улсын хэмжээнд Солонгос судлалын дэмжлэгийг өргөн хүрээнд үзүүлдэг болсон.(Ким Мира, 2007) (김미라, 2007)

Солонгос Судлалын Сангийн (한국국제교류재단, 2025.05.10)³ мэдээллээс авч үзэхэд, 2025 оны байдлаар Солонгос судлалын хичээл ордог гадаадын их, дээд сургууль 106 улсад нийт 1,404 болж, 1993 оны 32 улс, 151 сургууль байсантай харьцуулахад 9 дахин өссөн байна. Үүнээс Солонгос судлалын төв бүхий сургууль 144 байгаа нь нийт сургуулийн 10 хувийг эзэлж байна. Монгол Улсад 21 их дээд сургуульд Солонгос хэл, судлалын сургалт явагдаж байгаагаас, 4 сургуульд нь харьяа Солонгос судлалын төв үйл ажиллагаа явуулж байна.⁴

Энэхүү судалгаа нь ОУУБИС-ийн харьяа Солонгос судлалын төвийн 20 гаруй жилийн үйл ажиллагааг товчлон, Монгол дахь Солонгос судлалын ололт амжилт хийгээд сорилтыг таниулах зорилготой билээ.

1. Солонгос судлалын төвийн байгуулагдсан үндэслэл ба зорилго

Солонгос судлалын төв нь 2003 онд Санмён их сургуулийн дэмжлэгтэйгээр байгуулсан. Үүсгэн байгуулагдсан гол зорилго нь Монголд Солонгос судлалын судалгааны суурийг тавих, солонгос хэлний боловсрол, солонгос судлалыг хөгжүүлэхэд байсан. Мөн Монгол судлалын төвтэй хамтран, Солонгос, Монголын хамтын ажиллагааг өргөжүүлж, хоёр орны соёл, шинжлэх ухааны тогтвортой судалгаа, үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

1990 оны 5-р сард Монголын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн харьяа Солонгос судлалын төвийн судлаачдад зориулсан богино хугацааны Солонгос хэлний сургалт эхэлсэн бөгөөд 1991 оноос их, дээд сургуульд Солонгос хэлний тэнхим байгуулагдсан. 1993 онд 23-р сургууль Солонгос хэлийг хоёр дахь гадаад хэл болгон зааж эхэлснээр Солонгос хэлний боловсрол жинхэнэ утгаар нь эхэлсэн гэж үзэж болно. Түүний дараа буюу 10 жилийн дараа Солонгос судлалын төв байгуулагдсан нь Монгол дахь Солонгос судлалыг хөгжүүлэхэд чухал алхам болсон.

² 2009년 한국과학재단, 한국학술진흥재단, 국제과학기술협력재단이 통합하여 한국연구재단이 설립되었다.

³ <https://www.kf.or.kr/koreanstudies/koreaStudiesMap.do>

⁴ Мэдээллээс үзвэл МУБИС, МУИС, ХААИС, МУИС-ийн харьяа Улаанбаатар их сургууль гэсэн дөрвөн сургуульд бүртгэлтэй байна. Харин ОУУБИС-д Солонгос судлалын төв байдаг хэрнэ бүртгэлгүй байна.

2. Төвийн үйл ажиллагаа ба ололт амжилт

Манай төв анх байгуулагдах үедээ Солонгос судлалын үндэс суурийг тавих үүднээс бүх чиглэлээр идэвхтэй ажилласан. Эдгээр ажлуудыг сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээ судалгаа, ном сурах боловсруулах ажлыг дэмжих, эрдэм шинжилгээний эрхлэн гарах, ном толь бичиг эрхлэн гаргах, соёлын хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх гэсэн 7 хэсэгт хувааж авч үзвэл,

1) Сургалтын хөтөлбөр

2003 Солонгос судлалын тэнхимийн сургалтын хөтөлбөр, 2002 онд хэл шинжлэлийн (Солонгос хэл) магистрын хөтөлбөрийг боловсруулж, төгсөх хүртэлх сургалтын үйл ажиллагааг явуулсан.

2) Эрдэм шинжилгээ, судалгаа

Солонгос, Монголын шинжлэх ухааны солилцоог өргөжүүлэхийн тулд тогтмол эрдэм шинжилгээний семинар зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд мэргэжилтнүүдийг урьж тусгай лекц зохион байгуулсан

- Зүүн Хойд Азийн олон улсын эрдэм шинжилгээний хурал (2004, 2006)
- Олон улсын эссэчдийн холбооны симпозиум (2004)
- 21-р зууны Нэвтрүүлгийн Судалгааны Төв зохион байгуулсан симпозиум <Халуун орны ирээдүй ба Халлю соёл>, 2006.07.01
- Солонгосын макро эдийн засгийн тусгай лекц (лекц уншсан: Пэк Унги - Санмён их сургууль), 2006.11.25
- ФТА ба Солонгосын эдийн засгийн хөгжил (лекц уншсан: Хван Гилшин - элчин сайд асан), 2007.05
- Солонгос хэлний боловсролын онол (лекц уншсан: Хван Жонгсук), 2007.07
- Солонгосын уран зохиолын тусгай лекц (лекц уншсан: Хён Гильон), 2010.09.10
- Солонгосын уран зохиолын тусгай лекц (лекц уншсан: Сон Пильён, Ким Ханчан), 2011.02–07
- Солонгос хэлний багш нарын тусгай лекц (лекц уншсан: Вьетнамын Ханой их сургуулийн профессор), 2015.03
- Зүүн хойд Азийн түүхийн сан - Монголын түүх, нийгмийн багш нарын семинар 9 удаа (2015–2024)
- 2023.08.23-нд Чунан ИС-ийн Түүхийн хүрээлэнтэй хамтрсан ЭШ-ний бага хурал, Сэдэв: “13-14-р зууны Монголын эзэнт гүрний гадаад харилцаа ба Зүүн ази”



- 2024.08.26-нд Хангүг Гадаад судлалын ИС-ийн Хятад судлалын хүрээлэнтэй хамтрсан ЭШ-ний бага хурал, Сэдэв: “Зүүн азийн соёл иргэншлийн солилцооны босоо тэнхлэгийн судалгаа-Монгол дахь Монгол, Хятад, Вьетнамын соёлын иргэншлийн солилцооны судалгааны чиг хандлага”

3) Ном сурах бичиг эрхлэн гаргах

Монгол дахь солонгос судлалын судалгааны баазыг бий болгож, солонгос хэлний боловсролыг хөгжүүлэх ном зохиол бичих, Монгол судлалын хүрээлэнтэй хамтран судалгаа хийж монгол судлалтай холбоотой зохиол бичдэг байсан. Түүнчлэн солонгос судлалын томоохон бүтээлүүдийг Монголд нэвтрүүлснээр материалыг Солонгост нэвтрүүлж, монгол судлалын судалгааны бааз суурийг өргөжүүлэх зорилгоор томоохон бүтээлүүдийг монгол, солонгос хэлээр орчуулан хэвлүүлсэн.

- И. Анна, «Монгол үндэстний гарал үүслийн домог», 2001
- И. Анна, «Монголчуудын амьдрал ба зан заншил», 2005
- Т. Намжил, «Монгол гэр бүлийн уламжлал ба ёс зүй», 2005
- Т. Намжил, «Монголын эрдмийн уламжлал», 2006
- И. Анна, «Солонгосын шилдэг 50 шүлэг»
- Амартаван, орчуулга, хэлмэрчлэлийн онол (Чой Жонхва), 2004
- И. Анна, «Солонгосын шилдэг 50 шүлэг», 2005
- 1994 онд Солонгос-Монгол толь бичиг
- 1997 онд Солонгос-Монгол толь бичиг 2 дахь хэвлэл
- 2004 онд Монгол-Солонгос толь бичиг (14,000 үгтэй)
- 2009 онд Монгол-Солонгос толь бичиг (35,000 үг, хэлц үгтэй)
- Солонгосын Шинжлэх Ухааны Хөгжлийн Сангийн дэмжлэгтэй
- Мөн анагаахын, архитектурын, эдийн засгийн толь бичгүүд
- 2015 онд Солонгос-Монгол мэргэжлийн үг хэллэгийн толь бичиг
- 2016-одоо “Монгол-Солонгос толь бичиг” нэйвор хайлтын системд бүртгүүлсэн

4) Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах

- “Улаанбаатарын эрдэм шинжилгээний сэтгүүл” (2004–2010) 1-10 дахь дугаар
- “УВ Солонгос судлал” (одоогийн IUU Солонгос судлал) сэтгүүлийн 1–6 дугаар
- Тусгай лекц, воркшоп, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл зэрэг үйл ажиллагааны материалыг хэвлэх

5) Номын фонд

Жил бүр Үндэсний Ассамблейн номын сангаас 2 сая воны номын хандив авч, одоогоор 8,700 гаруй номтой номын санг бүрдүүлсэн.

6) Соёлын үйл ажиллагаа

Солонгосын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2003 оноос эхлэн Хангиль үсгийн баярт зориулсан Хангиль их наадмыг зохион байгуулсан. Тус наадмаар сайхан бичих, үсэг бичих, зохион бичлэг, яриа, дууны уралдаануудыг явуулж, Солонгос хоол, Ханбок, уламжлалт тоглоом зэргийг танилцуулсан.⁵ Солонгос хэл сурч буй оюутнуудад «Оэсол» тэтгэлэг олгож, багш нараас шилдгийг сонгон 16 жилийн турш «Оэсол» Солонгос хэлний багшийн шагналыг олгож ирсэн.⁶ Дараах нь шагнал авсан хүмүүсийн жагсаалт юм.

Мөн Солонгос-Монголын соёлыг танилцуулах, соёлын харилцааг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Солонгосын соёлоор сонирхдог монголчуудад зориулан Солонгосын соёлыг таниулах видео материал, лекц, Солонгос судлалын холбогдолтой эх сурвалжийг хүргэх замаар таниулах төв байгууллагын үүргийг гүйцэтгэж ирсэн.

- Ердийн иргэд болон оюутнуудад Солонгосын соёлыг танилцуулах материалуудыг нийлүүлдэг.
- Солонгосоос Монголд ирж буй багуудад зориулан Монголын соёлын лекц уншуулсан.
- 2010.09. Солонгосын Утга зохиол орчуулгын хүрээлэн – Солонгос, Монголын дипломат харилцааны 20 жилийн ойн семинар
- 2010.07. Солонгосын Соёл, Урлагийн Зөвлөлтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, зохиолч илгээх, харилцан соёлын солилцоо явуулсан: уригдсан яруу найрагчийн Солонгосын уран зохиолын лекц сар бүр (10 сараас 3 сар хүртэл)

7) Төслүүд

- Чингис хааны түүхэн дурсгалт газруудаар танин мэдэх аялал (Зүүн Хойд Азийн

⁵ 2007онд Улаанбаатар 1 Сэжун Институт байгуулагдснаар Хангиль наадмыг Солонгос судлалын төв, Солонгос хэлний тэнхимтэй хамтран зохион байгуулдаг болсон.

⁶ Дараах нь шагнал авсан хүмүүсийн жагсаалт юм.

2008	Квон Сон Хүн (МУИС)	2014	Кан Сонь Хуа (ОУУБИС)	2020	Ё Бён Мү (ОУУБИС)
2009	Чой Сон Сү (ХИС)	2015	М.Амартайван (ОУУБИС)	2021	Д.Болормаа (ОУУБИС)
2010	И Анна (ОУУБИС)	2016	Квон У Сог (23-р сургууль)	2022	Пэ Юн Жү (Дархан Оюуны-Ирээдүй ЕБС)
2011	Б.Сумъяабаатар (ОУУБИС)	2017	Д.Сайнбилэгт (МУИС)	2023	Б.Туяа (ОУУБИС)
2012	Сун Ы Мин (МУБИС)	2018	Д.Эрдэнэсүрэн (ХИС)		
2013	Д.Эрдэнэчимэг (МУИС)	2019	Нямхишиг (МУБИС)		

нийгэмлэгтэй хамтран, 2006.07.31–08.04)

- Санмөн их сургуулийн дэмжлэгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (Солонгос-Монгол толь бичиг, Хангиль наадам)
- Солонгосын Шинжлэх Ухаан, Судалгааны Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Мон-Сол толь бичиг” төсөл (2004–2006)
- Солонгос судлалын төв (АКС)-ийн гадаад Солонгос судлалын үр хөтөлбөр: “Хан-Мон мэргэжлийн орчуулгын толь бичиг” (2011–2013)
- Зүүн хойд Азийн түүхийн сангийн дэмжлэгтэй төсөл: Монголын түүх, нийгмийн багш нарын семинар (2015–2024)
- Солонгос судлалын төвийн (АКС) гадаад Солонгос судлалын гол сургууль хөгжүүлэх төсөл (2022–2027)

3. Гадаад Солонгос судлалын гол их сургууль хөгжүүлэх төслийн амжилт

Энэхүү төсөл нь Солонгос судлалын төвөөс хэрэгжүүлж буй Солонгос судлалын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн нэг хэсэг юм. Уг төсөл нь хүмүүнлэг, нийгэм, байгалийн шинжлэх ухаан, урлагийг хамарсан “Шинэ Солонгос судлал”-ын хэтийн төлөвийг нээж, Солонгос судлалыг дэлхийд түгээх зорилгоор дотоод болон гадаадын судалгааг дэмжих, шинжлэх ухааны дэд бүтцийг хөгжүүлэх, Солонгос судлалыг олон нийтэд ойртуулах, судалгааны үр дүнг түгээх зэрэг олон чиглэлээр Солонгос судлалыг дэмжин ажилладаг.

Солонгос судлалын хөгжлийн хөтөлбөр нь дараах хоёр үндсэн чиглэлтэй: гадаад дахь Солонгос судлалын дэмжлэг, дотоодын Солонгос судлалын хөгжүүлэлт (АКС – Солонгос судлалын төв).

Солонгос судлалын дэлхий даяар тархалт

Хилийн чанад дахь солонгос судлалын төслүүд

- Солонгос судлалыг хилийн чанадад тарих төсөл
- Их сургуулийг түшиглэн солонгос судлалыг хилийн чанадад хөгжүүлэх төсөл
- Солонгос судлалын даяарчлалын лаборатори төсөл
- Солонгос судлалын стратеги хүрээлэнг хөгжүүлэх төсөл
- Солонгос судлалын ном зохиол орчуулах төсөл

Солонгос судлалын баазыг бэхжүүлэх

Солонгосын дотоод дахь солонгос судлалын төслүүд

- К эрдэм шинжилгээ судалгааг өргөжүүлэх хүрээлэнгийн төсөл
- Солонгос судлалын солонгос, англи хэлний толь бичиг зохиох төсөл
- Солонгос судлалын мега төлөвлөгөөг боловсруулах төсөл
- Солонгос судлалын суурь материаллаг баазыг бий болгох төсөл

Гадаад дахь Солонгос судлалын гол их сургууль хөгжүүлэх төсөлд хамрагдахын тулд өмнө нь «үрийн хэлбэрийн төсөл»-ийг амжилттай хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Манай төв 2011–2013 онд гадаад Солонгос судлалын үрийн хэлбэрийн төслөөр “Солонгос-Монгол мэргэжлийн үг хэллэгийн толь” төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

2022 онд их сургуулийг түшиглэн солонгос судлалыг хилийн чанадад хөгжүүлэх төсөлд АНУ-ын Индиана их сургууль, Австралийн Күртин их сургууль, Монголын Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль сонгогдож, 2022 оноос 2027 он хүртэл 5 жилийн хугацаанд (3+2 жилийн бүтэцтэй) төслийг хэрэгжүүлэхээр болсон.

Уг төслийн нарийвчилсан сэдэв нь “Монгол дахь шинэ үеийн Солонгос судлалын сургалт, судалгаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх” бөгөөд санхүүжилт нь жилд 165,000,000 вон (ойролцоогоор 422,400,000 төгрөг — ханш: 1 вон = 2.56 төгрөг), 5 жилийн нийт санхүүжилт нь 825,000,000 вон (ойролцоогоор 2,112,000,000 төгрөг) байна.

Төслийн зорилго нь Монгол дахь Солонгос судлалын төвийг бэхжүүлж, боловсрол, судалгаа, сүлжээ, сурах бичиг боловсруулах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зэргээр үр дүн гаргах ба энэ бүхнийг бусад их сургууль, байгууллага, Монгол үндэстэн ястанд түгээн дэлгэрүүлэх, цаашид тогтвортой, тэнцвэртэй шинэ үеийн Солонгос судлалыг хөгжүүлэхэд оршино.

Төслийн 5 жилийн төлөвлөгөө:

- Эхний жилд: Монгол дахь Солонгос судлалын өнөөгийн байдлыг дүгнэж, уялдаа холбоотой төслийн бүтэц бий болгох
- 2 дахь жилд: Солонгосын эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжил сэдвээр судалгааны бүтцийг бүрэн боловсруулж, эдийн засгийн салбарын гүнзгийрүүлсэн судалгаа хийх
- 3 дахь жилд: Монгол-Солонгосын ардчиллын хөгжлийг сэдэв болгон боловсролын тогтолцоог бүрдүүлж, олон улсын харилцааны гүнзгийрүүлсэн судалгаа явуулах
- 4 дэх жилд: Солонгосын соёл сэдвээр сурах бичгийн иж бүрдлийг бүрдүүлж, соёлын гүнзгийрүүлсэн судалгаа хийх
- 5 дахь жилд: Солонгосын түүх ба Монголын түүхийг сэдэв болгон түүхийн гүнзгийрүүлсэн судалгаа хийж, өмнөх амжилтыг түгээнэ.

Энэхүү төслийг боловсрол, судалгаа, хамтын ажиллагаа гэсэн гурван чиглэлд



хувааж хэрэгжүүлж байна.

Боловсрол	Судалгаа	Хамтын ажиллагаа
•Сургалтын тэтгэлэг •Солонгос судлалын семинар •Ахисан түвшний сургалтын шинэ хичээл боловсруулах, багш ажилд авах •Ном сурах бичиг авах	•ЭШ-ий сэтгүүл эрхлэн гаргах •ЭШ-ий шилдэг өгүүлэл, бүтээлийг дэмжих •Сурах бичиг боловсруулах	•ЭШХ зохион байгуулах(дотоод vs олон улс)

Хүлээгдэж буй үр нөлөө нь дараах байдалтай байна.

- Хүмүүнлэг, нийгмийн ухааны үүднээс Солонгос судлалыг заах арга зүйг боловсруулж, Монголын нөхцөл байдалд нийцсэн Солонгос судлалын боловсролын хөтөлбөр боловсруулах
- Солонгос судлалын дараагийн үеийн судлаач, мэргэжилтнүүдийг эртнээс дэмжиж, Монголын онцлогт тохирсон мэргэжилтэн бэлтгэх
- Тэтгэлэг олгох, төрөл бүрийн магистр, докторын сургалтын хөтөлбөр болон семинар зохион байгуулж, Солонгос судлалын дээд боловсролыг идэвхжүүлэх
- Монголын салбар бүрт(засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа, их сургууль, багш, бизнес, судалгааны байгууллага, аялал жуулчлал, худалдаа) Солонгос судлалын мэргэжилтэн бэлтгэн гаргах
- Монголын их сургуулиуд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж, дотоодын Солонгос судлалын сүлжээг өргөжүүлэх
- Улаанбаатар хотод Солонгос судлалын төв байгуулах ба монгол үндэстэн ястнууд бүхий бүс нутагт (Тувагийн БНУ, Буриадын БНУ, Өвөр Монгол) Солонгос судлалын хөгжилд дэмжлэг үзүүлэх
- Өмнө нь бага судлагдсан Солонгос судлалын сэдвүүдийг олон талаас нь судалж, нийтлэх замаар судалгааны гүн гүнзгий байдал, хүрээг тэлэх
- Монгол хэлний цаг үеийн өөрчлөлтийг ойлгож ухварлан, цаашид орчуулах шаардлагатай Солонгосын бичгийн эх сурвалжуудыг тодорхойлох
- Солонгос судлалын цогц систем бүхий сурах бичиг, бичгийн эх сурвалжийн орчуулгын чиглэлийг тодорхой болгох
- Солонгос судлалын сургалтын агуулга болон арга зүйг илүү үр ашигтай болгох

Салбар бүрээр хэрэгжүүлсэн гол үр дүн дараах байдалтай байна.

1) Боловсрол

(1) Тэтгэлгийн хөтөлбөр (нэгж: MNT)

	22-23-2	23-24-1	23-24-2	24-25-1	24-25-2	хүлээн
Баклавр	8	12	7	6	6	39
Магистр	12	15	6	9	10	52
магистр (туслах судлаач)	1	1	2	2	1	7
нийт	21	28	15	17	17	98
	78,500,000		77,753,714		44,276,945	200,530,659

(2) Солонгос судлалын семинар

	Огноо	Сэдэв	Лектор
1	2023.02.08	Монгол дахь солонгос хэлний боловсролын өнөөгийн байдал, чиг хандлага	Д.Эрдэнэсүрэн Б.Алтай
2	2023.03.15	Солонгос хэлний галигийн зарим асуудал	Г.Эрдэнэчимэг Д.Уртнасан
3	2023.04.12.	Солонгос хэлний заах арга зүй ба сурах бичиг	Н.Мэнд Б.Ариунбаатар
4	2023.10.04	Монгол дахь Солонгос судлалын бүтээлийн тойм	Д.Сайнбилэгт М.Амартайван
5	2023.11.29 Солонгос, Монголын гадаад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа		Ким Йён Рэ Х.Сэлэнгэ, Ц.Энхцэцэг
6	2024.02.28	Өнөөгийн Солонгосын эдийн засаг болон Солонгос, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа	Юн Жи Хён И Жон Хунь
7	2024.03.27	Монгол, Солонгосын Эдийн Засгийн Түншлэлийн Хэлэлцээр, хөрөнгийн зах зээлийн төлөв байдал	Н.Отгонсайхан Б.Мөнх-Өлзий
8	2024.10.16	Монгол, Солонгосын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үр нөлөө, хэтийн төлөв	Ц.Цэцэгмаа Шинь Минь Сонь
9	2024.11.14	Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Стратегийн түншлэлд	Д.Оюунцэцэг И.Энхболд
10	2025.02.13	БНСУ-ын Үндэсний ассамблей, сонгууль, иргэний нийгэм	Ж.Төртогтох И Дэхэг
11	2025.04.15	Солонгосын дайн ба олон улсын харилцаа	Ц.Батбаяр Д.Нарантуяа

Ерөнхийдөө Солонгос хэлний багш нарын холбоо, Солонгос судлалыг хөгжүүлэх холбоо (профессоруудын холбоо)-оос гадна Монгол дахь их дээд сургуулиуд, ерөнхий боловсролын сургууль, ахлах сургуулийн багш нар болон

Солонгост Монгол судлалаар мэргэшсэн эрдэмтэд онлайн болон танхимын хэлбэрээр өргөнөөр оролцож байна. Хоёр, гурав дахь жилийн сэдэв нь эдийн засаг, улс төрөөр хязгаарлагдсан тул Солонгос хэл эсвэл хэлний боловсролын салбарын хүмүүсээс илүү эдгээр сэдэвтэй холбоотой тэнхимийн профессор, оюутан, холбогдох ажилтнууд түлхүү оролцож байна.

(3) Солонгос судлалын магистрын сургалтын хөтөлбөр нээх ба профессор томилох

2022 оны 4 дүгээр сард магистрын хөтөлбөр нээх батламж, магадлан итгэмжлэлийн шалгалтыг амжилттай өгч, 2022 оны 9 дүгээр сараас эхлэн Солонгос судлалын магистрын сургалт эхэлсэн. 2025 оны 5-р сарын байдлаар нийт 29 хүн элссэнээс 5 нь төгсөж, 3 нь удахгүй төгсөхөөр байна. Оюутнуудын дунд Солонгос иргэн 11, Монгол иргэн 18 байгаа бөгөөд тэднээс 7 нь тус сургуулийн төгсөгчид юм.

2024 оны 9-р сарын 1-ний өдрөөс Ж. Баттөр(МУИС, улс төр олон улсын харилцааны мэргэжлийн профессор) манай төвийн гэрээт профессорын албан тушаалд томилогдож, Солонгос хэл, соёл судлалын бакалаврын хичээл болон Солонгос судлалын магистрын сургалтыг хариуцан зааж байна.

Доорх нь магистрын сургалтанд шинээр нээгдсэн хичээлүүдийн жагсаалт болно.

Хичээлийн жил	Улирал	Шинээр хэрэгжсэн хичээл			
2022-2023	Намар	Солонгосын түүх Пак ЖанБэ			
	Хавар	Орчин үеийн Солонгосын соёл Наранбаатар	Зүүн Азийн харьцуулсан соёл судлал Жан Сог Ху	Солонгосын угсаатны зүй судлал Жан Жан Шиг	
2023-2024	Намар	Солонгосын нийгэм судлал Жон Жэ Хун	Солонгосын түүх И Сын Хүн	Монгол Солонгосын харилцааны түүх И Пён Лай	Солонгосын шашин, сэтгэлгээ Наранбаатар
	Хавар	Орчин үеийн Солонгосын соёл Жан Ён Сок	Зүүн Азийн харьцуулсан соёл судлал Пак Жан Бэ		
2024-2025	Намар	Солонгосын нийгэм судлал Жон Жэ Хун	Солонгосын түүх И Сын Хүн	Солонгосын орчин үеийн түүх Ж.Баттөр	Солонгосын эдийн засаг судлал Жу Жэ Хо
	Хавар	Орчин үеийн Солонгосын соёл Жан Ён Сок	Солонгосын улс төр судлал Ж.Баттөр		

Солонгос судлалын боловсролын хөтөлбөр нь 2025–2026 оны хичээлийн жилд зайлшгүй болон сонгон судлах бүх хичээлийг дор хаяж нэг удаа хичээл хэлбэрээр явуулсан. Одоо Монголын нөхцөлд илүү тохирсон Солонгос судлалын хичээлийг тодорхойлж, сайжруулах ажлыг төлөвлөж байна.

Одоогоор Солонгос судлалын докторын хөтөлбөр хараахан нээгээгүй байна. Төгсөгчдийн дунд докторын хөтөлбөр нээж өгөх хүсэлт удаа дараа гарч байсан. Докторын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эхлээд Солонгос судлалын бакалаврын хөтөлбөрийг идэвхжүүлэх, төгсөгчдийн дунд Монголд магистрын сургалтад хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх, Солонгос судлалын мэргэжилтэй төгсөгчдөд ажлын байр бий болгох шаардлагатай юм.

Энэ бүхэн Солонгос судлалын хүний нөөцийг бэлтгэх, төлөвшүүлэхтэй шууд холбоотой. Манай сургуулийн төгсөгчдөөс гадна олонх бакалаврын төгсөгчид Солонгост сурах, амьдрах хүслийг илэрхийлдэг. Солонгос руу сургуульд явах явдлыг өргөн утгаар нь харвал хүний нөөц бэлтгэх, гаргах үйл явцын нэг хэсэг гэж үзэж болох ч, нарийн утгаар нь авч үзвэл Монголын дотоодод судлаач бэлтгэх тал дээр тодорхой хязгаар байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

(4) Ном, эх сурвалж худалдан авалт

Одоогоор манай төв нийт 24 чиглэлээр 8,700 гаруй номын сантай. Төслийн хүрээнд нийт 838 ном шинээр худалдан авсан бөгөөд Солонгос судлалын судалгаанд шаардлагатай ном, эх сурвалжуудыг Солонгос болон Монголын зах зээлээс худалдан авч бүрдүүлсэн.

Төслийн дараах номын худалдан авалтын статистик:

	Эхний жил	2 дахь жил	Нийт
Монгол ном	260	157	417
Солонгос ном	281	140	421
нийт	541	297	838

2) Судалгаа

(1) Эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлэн нийтлэх

Өмнө нь гардаг байсан «UB Солонгос судлал» эрдэм шинжилгээний сэтгүүлийг сургуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан «IUU Солонгос судлалын судалгаа» болгон нэрийг шинэчилж, ISSN код авч, олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлийн шаардлагыг хангасан. Уг сэтгүүлийг жил бүр нэг удаа тогтмол хэвлэн гаргаж байна. Өмнө нь хэл шинжлэл, боловсрол, уран зохиолын чиглэл давамгайлж байсан бол сүүлийн жилүүдэд улс төр, эдийн засаг, философи,

түүхийн чиглэл рүү өргөжин тэлж байна. Сэтгүүлд ирүүлсэн өгүүллүүдийг мэргэжлийн шүүмжлэгчдийн шүүлтүүрээр оруулж, шилдэг өгүүллийг шалгаруулан шагнал олгож байна.

(2) Шилдэг өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэлийн дэмжлэг

	Эхний жил	2 дахь жил
Тэргүүн байр	Д. Уламбаяр(ХИС): “Монгол улс, БНСУ-ын стратегийн түншлэлийг газрын ховор элементийн салбарын хамтын ажиллагаагаар өргөжүүлэх нь”	Ж. Баттөр(МУИС): “20-р зууны Монголчуудын дурсамж дахь Солонгосчууд ”
Дэд байр	.Ц.Булган, Л.Одончимэг(ОТИС): “Солонгос, англи хэлийг зэрэг сурч буй монгол суралцагчдад тулгарч буй бэрхшээл ба сайжруулах арга зам-Агаарын тээврийн үйлчилгээний ангийн оюутнуудын жишээн дээр”	Д.Мягмар(ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн): “Эдийн засгийн хөгжлийн дүнд өөрчлөгдсөн БНСУ-ын олон улсын тавцан дахь байр суурь”
	Г.Мөнхнасан(Хангүг ИС), Н.Отгонсайхан(МУИС): БНСУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээрийн талаарх судалгаа	И Сын Хүн(ОУУБИС): “Эмэгтэй хүнтэй холбоотой солонгос, монгол зүйр цэцэн үгийн хэл, соёлын онцлогийг харьцуулах нь”
Тусгай байр	Б.Пүрэвсэн(ОУУБИС): Солонгосын яруу найраг дахь авиа дуурайх, дүрслэх үгийн хэрэглээ-Yun Dong ju зохиолчийн жишээгээр	

Эрдэм шинжилгээний өгүүллийг жил бүрийн эхэнд зарлан хүлээн авч, чанартай сэтгүүл хэвлэхийн тулд шилдэг өгүүллийг шалгаруулан шагнал олгох зэрэг арга хэмжээг авч байгаа боловч тодорхой хязгаарлалт байсаар байна. Манай их сургуулийн багш нарын судалгааны оноог зөвхөн Монголын Шинжлэх Ухааны Академиас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл дээр үндэслэн тооцдог. Тиймээс манай төв нь тус академийн шалгуурыг хангасан сэтгүүл болохын төлөө чармайн ажиллаж байна. Гэсэн хэдий ч үнэхээр чанартай эрдэм шинжилгээний сэтгүүл болохын тулд өгүүллийн тоо, өгүүллийн түвшин, мэргэжлийн шүүгчдийн хяналт зэрэг үндсэн шаардлагуудыг хангах ёстой. Харин судалгааны оноонд тооцогддоггүй учраас манай сэтгүүлд өгүүлэл ирүүлэх тоо хязгаарлагдмал хэвээр байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд эхний ээлжид холбогдох тэнхим, сэдэвтэй өгүүлэлд дотоод судалгааны оноо олгох боломжийг бүрдүүлж, дараагийн шатанд сэтгүүлийг Монголын ШУА-гаас албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай байна.

(3) Нэг сэдэвт судалгаа

Эхний жил	О.Амарсанаа(ОУУБИС), Чонь Кён Гын(Ажү ИС): “МУ-ын хууль заасан нийтлэг болон хууль ёсны гэрлэлтийн эд хөрөнгийн эрхийн асуудлыг шийдвэрлэх арга зам-МУ-ын гэр бүлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн жишээн дээр
-----------	--

2 дахь жил	Г.Мөнхнасан(Хангүг ИС), Шинь Минь Сонь(Хангүг ИС), МУИС-ийн БС-ийн профессор, доктор Н.Отгонсайхан(МУИС): “БНСУ-ын гадаадаас авах ажиллах хүчний бодлогын хэрэгжилтийн тухай судалгаа: Монгол ажилчдын жишээн дээр
3 дахь жил	И Дэхаг, И ЖүХэ(БНСУ Хангүг ИС), С.Туяа(ШҮТИС) БНСУ-ын ардчилалын үйл явц Монгол улсад үзүүлэх нөлөө

(4) Ном сурах бичиг боловсруулах, орчуулах

Эхний жил	<Солонгосын эдийн засгийн хөгжил, энтрепренер сэтгэлгээ>	<Солонгосын түүхийн электрон толь бичиг> <БНСУ-ын ерөнхийлөгч нар>
2 дахь жил	<Солонгос орон судлал>	
3 дахь жил	<Олон улсын харилцаа ба Солонгосын гадаад бодлого> сурах бичиг (2025.9 сард хэвлэгдэнэ)	<БНСУ-ын улс төр> ном (2025.9 сард хэвлэгдэнэ)

Сурах бичиг боловсруулах нь багш, суралцагчдын аль алинд нь зайлшгүй шаардлагатай үйл явц боловч цаг хугацаа, санхүүгийн зардал их шаарддаг тул амархан эхлүүлж чаддаггүй тохиолдол олон байдаг. Өнгөрсөн хугацаанд голчлон Солонгос хэлтэй холбоотой ном, сурах бичиг зонхилж байв. Харин Солонгос судлалын чиглэлээр түүх, нийгэм, эдийн засгийн хичээлүүдийн сурах бичгүүд хэвлэгдсэн ч ихэвчлэн тухайн сургуулиудын хэрэгцээнд нийцүүлэн хэвлэж ашигласан. Мөн «Солонгос орон судлал» хэмээх сурах бичиг нь Солонгос судлалыг цогцоор нь авч үзсэн, монгол хэл дээр бичигдсэн анхны бүтээл болсон гэж үзэж болно.

Бичиж хэвлүүлсэн номыг сурталчилж, борлуулах ажил мөн адил чухал байна. Манай сургуульд хэвлэлийн алба бий боловч мэргэжлийн сурах бичиг болон сургуулийн нэр дээр хэвлэгдсэн номыг зохион байгуулалттайгаар сурталчлан таниулах, борлуулах тал дээр сул тал ажиглагддаг.

Сүүлийн жилүүдэд хүмүүс цаасан ном худалдаж авахаас илүүтэйгээр цахим ном хэрэглэж, бүр цаашлаад номноос илүү медиа контент сонирхох хандлага нэмэгдэж байгаа тул цаасан ном хэвлүүлсэн ч борлогдох эсэх нь таамаглахад бэрх болсон. Үнийн хөөрөгдөл өндөр байгаатай холбоотой номын үнэ ч өсч, улмаар борлуулалт буурч, ихэнх ном агуулахад дарагдаж үлдэх нь элбэг байна. Манай төслөөс ном сурах бичиг гаргахдаа хэвлэлийн зардлыг гаргадаг тул одоогоор хамгийн бага өртгөөр борлуулж байгаа ч, сурталчилгаа дутагдалтай, борлуулах суваг хомс, хэрэглэгч хязгаарлагдмал(тодорхой бүлэг л сонирхдог гэх мэт) байгаа зэргээс хамаарч цаашид хэрэглээний сонирхолд нийцэх борлуулалтын стратеги шаардлагатай цаг үед ирээд байна.

(3) Хамтын ажиллагаа

(1) Эрдэм шинжилгээний хурал (орон нутгийн ба олон улсын)



Эхний жил	2023.05	“Монгол дахь солонгос судлалын ололт амжилт ба хэтийн төлөв” ЭШХ
2 дахь жил	2024.04	“Солонгос- Монголын эдийн засаг ба аж үйлдвэрлэлийн хөгжил” ОУЭШХ
3 дахь жил	2025.03	“Солонгосын гадаад бодлого ба олон улсын харилцаа” ОУЭШХ

Солонгос судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын хүрээнд Солонгос, Монгол, Япон, Хятад, Орос, Казахстан, Энэтхэг зэрэг олон улсын судлаачид оролцсоноор эрдэм шинжилгээ судалгааны нэтворк улам өргөжин тэлж байна. Ялангуяа Монгол дахь их, дээд сургуулиуд болон судалгааны хүрээлэнгүүдийн оролцоо идэвхжиж байгаа нь онцлох үр дүн юм.

ДҮГНЭЛТ

Ийнхүү ОУУБИС-ийн Солонгос судлалын төвийн сүүлийн 20 гаруй жилийн үйл ажиллагааг тоймлон авч үзлээ. Монголд Солонгос хэлний сургалттай хамт Солонгосын соёлыг танилцуулах, Солонгос судлалыг гүнзгийрүүлэх зорилгоор судалгаа, хэвлэл, төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн.

Одоогоор хэрэгжиж буй “Гадаад дахь Солонгос судлалын гол их сургууль хөгжүүлэх төсөл” нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын оргил үр дүн гэж хэлж болно.

Төслийн эхний жилд Монгол дахь Солонгос судлалын өнгөрсөн түүхийг эмхлэн дүгнэж, 2 дахь жилд эдийн засгийн асуудлыг, энэ жил буюу 3 дахь жилд улс төр ба олон улсын харилцаа гол сэдвээрээ сонгон ажиллаж байна. Ялангуяа энэ жил нь Монгол, Солонгос хоёр улсын дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ой тохиож байгаа тул олон улсын харилцаа, гадаад бодлогын сэдэвт илүү анхаарч байна. Хэрэв 3-р жилийн зорилтыг амжилттай биелүүлж чадвал дараагийн 2 жилд соёл, түүхийн чиглэлийн төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломж нээгдэнэ. Төслийн дараа тогтвортой хөгжлийг хангахын тулд дараах хэд хэдэн саналыг дэвшүүлж байна.

1-рт, Монгол орны нөхцөл байдлыг сайн мэддэг Солонгос судлалын мэргэжилтэнг урьж, төслийн баг болон судалгааны төвийг удирдуулах боломжийг бүрдүүлэх.

2-рт, Солонгос судлалын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд анхаарлаа хандуулах шаардлагатай. Тус төв байгуулагдсан эхний жилүүдэд солонгос судлал, солонгос хэлийг таниулахад илүү анхаарсан бол харин одоо төвийн үндсэн үйл ажиллагаа болох Монгол дахь солонгос судлалын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд илүү үр бүтээлтэй хандах шаардлагатай юм.

3-рт, Монгол, Солонгос болон эргэн тойрны хөрш орнуудыг холбох эрдэм шинжилгээний сүлжээ болон тогтолцооны дэмжлэг шаардлагатай.

Төв Азийн бүс нутагт жил бүр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг өөр өөр улсад ээлжлэн зохион байгуулдаг уламжлалтай. Өмнө нь Монголыг Төв Азийн бүсэд хамруулж үздэг байсан бол өнөө үед Дорнод Азийн бүсэд багтаах болсон ба, Төв болон Зүүн Азийн зааг дээр оршиж байгаагаараа онцлог.

Энэхүү өөрчлөлт нь Монголд тулгуурласан бүс нутгийн сүлжээг бий болгоход тодорхой бэрхшээл учруулж байгаа ч, үүнийг Монголын өвөрмөц Солонгос судлалаар хөгжүүлэх боломж гэж үзэж болно.

Юуны өмнө ойрын хөршүүд болох Өвөр Монгол, Буриад, Эрхүү, Тува зэрэг бүс нутгийн эрдэмтэн, судлаачидтай эрдэм шинжилгээний солилцоог эхлүүлж, хамрах хүрээг үе шаттайгаар өргөжүүлэх шаардлагатай. Үүний тулд сургуулийн зүгээс болон холбогдох тэнхимүүдийн бүрэн дэмжлэг, хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

1. 국제울란바타르대학교 한국학연구소. (2023), 한국학진흥사업(해외한국학중핵대학육성사업) 1차년도 연차보고서
2. 국제울란바타르대학교 한국학연구소. (2024), 한국학진흥사업(해외한국학중핵대학육성사업) 2차년도 연차보고서
3. 김미라. (2007). 해외 한국학 현황 및 발전 저해요인 분석. (p. 3). 한국외국어대학교 석사학위논문.
4. 두산백과. (n.d.). Retrieved from <https://terms.naver.com/entry.naver?docId=1161153&cid=40942&categoryId=32856>
5. 이길상. (2006). 70년대 이후 한국학 연구지원의 양적 성장과 한계, 21세기 한국학의 진로 모색. 서울대학교 개교 60주년 및 규장각 창립 230주년 기념 한국학 국제학술회의, (p. 152).
6. 한국국제교류재단. (2025.05.10). <https://www.kf.or.kr/koreanstudies/koreaStudiesMap.do>.

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТЭНХИМ



LEE, SEUNG HOON

국제울란바타르대학교의 연구중심대학으로의 전환을 위한 가능성과 방안, 그리고 한계 - 한국대학의 발전과정 사례를 중심으로



Б.АРИУНТУЛГА

Түүх соёлын биет өвийг дижитал аргаар сэргээх нь

7. 한국학중앙연구원. (n.d.). Retrieved from <https://www.aks.ac.kr/com/cmm/Egov-ContentView.do?menuNo=1010170500&lang=kor>

국제울란바타르대학교의 연구중심대학으로의 전환을 위한 가능성과 방안, 그리고 한계 - 한국대학의 발전과정 사례를 중심으로

Доктор, И Сын ХҮН

(ОУУБИС. Суурь боловсролын тэнхим)

seunghoon.l@ulaanbaatar.edu.mn

Abstract

This study aims to analyze the possibilities and limitations of the International University of Ulaanbaatar (IUU) transitioning into a research university on the occasion of its 30th anniversary, and to propose strategies for its implementation. To this end, it examines international standards by focusing on South Korea's case of fostering research universities and derives development strategies that consider the realities of Mongolia's higher education environment and IUU's specific conditions. A research university leads education and academia through advanced research and innovation, and is characterized by a graduate school-centered research system. South Korea has promoted research capacity through initiatives such as the BK21 project, based on the principle of selection and concentration, which provides implications for Mongolia's university development strategy. This study comprehensively analyzes IUU's research foundation, human resources, finances, and policy environment, emphasizing the need for a gradual structural transition and government policy support.

1. 서론

1) 연구목적

본 연구는 몽골의 사립대학인 국제울란바타르대학교(IUU)가 개교 30주년을 맞이하여 앞으로 연구중심대학으로 전환하기 위한 가능성과 실행방안, 그리고 그 한계를 고찰하는데 목적이 있다. 이를 위해 연구중심대학으로의 전환을 위한 한국대학의 사례를 고찰하고 몽골의 고등교육 환경과 IUU의 현 상황을 반영한 실행 가능한 발전 방안, 그리고 그 한계를 제시하고자 한다.

2) 연구중심대학의 개념

연구중심대학(Research University)이란 말은 학문적 연구와 혁신을 중시하는



대학을 의미한다. 연구중심대학은 교수와 연구진들이 고도의 연구를 수행하고, 그 연구 성과를 학문적, 산업적, 사회적 가치로 전환하며, 대학의 교육과 학문적 발전을 이끄는 중심 역할을 수행하는 대학이다. 이 대학들은 단순히 교육을 제공하는 곳을 넘어 고급 연구 및 혁신이 대학의 핵심 활동 중 하나로 자리잡고 있으며 교수들이 진행하는 연구는 국제적으로 인정받고, 주요 학술지에 다수 게재되는 것을 목표로 하며 그 연구 성과는 종종 산업, 기술 발전, 사회적 문제 해결에 기여한다. 또 사회의 각 분야에서 필요로 하는 고급의 전문지식을 연구를 통하여 창출하고, 전문지식을 실용적으로 활용할 능력을 보유한 고등인력을 교육시켜 배출하는데 기여하는 대학이다.

빌헬름 폰 훔볼트(Wilhelm von Humboldt, 1767-1835)는 19세기 초 독일 베를린대학(현 훔볼트대학)을 설립하며 기존의 강의, 교육중심대학에서 교육과 연구의 통합'을 강조하며 연구중심대학의 기초를 놓았다. 그는 교수와 학생이 공동의 연구자로서 진리를 탐구하는 것을 대학의 본질로 보았다. 그의 영향을 받은 독일대학들은 연구소, 실험실, 세미나 등을 갖추고 국가 재정 지원 아래 연구 중심의 교육 환경을 조성하며 최고의 대학으로 발전했다.

미국의 존스 홉킨스 대학(The Johns Hopkins University, 1876년 설립)은 학부와 대학원을 함께 운영하며 미국형 연구중심대학의 출발점이 되었다. 미국의 대학은 대학원과 학부를 같이 운영하는 학과(department) 제도와, 다양한 분야의 연구 및 교육이 이루어질 수 있도록 하는 발판인 종합대학(university)를 만들어 다양한 분야의 연구와 교육이 가능하도록 했고, 대학원 중심의 연구중심대학을 활성화했다. 정부는 연구 역량이 뛰어난 대학들에 집중 지원하며 대학원 중심의 고급인력 양성에 주력했고 그 결과, 1950년대 이후 미국의 연구중심대학은 세계적 수준의 대학으로 성장했다.

II. 본론

1. 선진국과 몽골 주변국 연구중심대학의 발전과정

몽골과기대(ШУТИС) 국제고등교육연구소의 2017년 보고서에 의하면 미국은 내부적으로 명확한 분류에 따라 대학을 구분하여 발전시키는 전략을 시행해왔다. 그 대표적인 예로 캘리포니아 주에는 고등교육 체계의 최상위에는 10개 캠퍼스를 둔 캘리포니아대학교(University of California)라는 연구중심대학이 있으며, 그 다음 단계에는 23개 캠퍼스와 433,000명의 학생을 보유한 캘리포니아 주립대학교(California State University)가, 세 번째 단계에는 300만 명의 학생을 가진 커뮤니티 칼리지들이 포함된다(Д.Бадарч, 2017:2). 이 분류에 따라 미국은 연구중심대학에 대한 별도의 지원 전략을 세워 육성해왔다.⁷ 몽골 주변국들인

⁷ UC대학은 석,박사과정을 운영하는 연구중심대학이며, CSU주립대학은 학사, 석사과정까지만 있다. 그리고 커뮤니티칼리지(CC)는 대개 전문학사를 제공하는 2년제 칼리지이다. 몽골정부는 이 보고서가 주는 조언에 따라 2023년 교육법 개정 시에 대학을 연구, 교육, 직업중심으로 나

중국, 러시아, 일본 등도 연구중심대학을 육성하고자 다양한 정책을 시행했는데 그 상세한 내용은 아래의 표와 같다.

표1. 몽골 주변국들의 연구중심대학으로의 발전 정책

국가	정책명 및 시기	주요 내용	선정 대학 수 /	주요 성과
중국	- 9 8 5 프 로젝트 (1998) - 쌍일류 정책 (2015)	- 985 프로젝트: 세계적 선도대학 육성 - 쌍일류 정책: 일류 대학 + 일류 학과 동시 육성	- 985: 9개(1차), 39개 - 쌍일류: 42개 대학, 465개 학과 - 3억~18억 위안 지원	- 칭화대, 베이징대 등 세계대학순위 50위권 진입
러시아	5:100 프로젝트 (2012)	- 세계대학 랭킹 100위 내 5개 대학 진입 목표 - 연구역량 및 국제화 강화	- 참여 대학: 21개 - 605억 루블(약 10억 USD) 지원 - 36만 명 재학생	- QS 세계대학 순위에 22개 러시아 대학 포함 - 모스크바 국립대학 108위
일본	- 국립대학 법인화 (2004)	- 자율성 및 경쟁체제 강화	- 글로벌30: 13개 대학	- 노벨상 수상자 배출 대학 증가
	- 글로벌30(2009) - 세계 일류	- 국제화 확대: 유학생 유치, 영어 강의, 외국인 교수 초빙	- 일류 연구대학: 10개 대학	- 연구역량 기반의 세계적 위상 확보
	연구대학 사업 (2014/2023)	- 세계적 연구성과 도출	- 수백억 엔 규모의 연간 지원	

2. 한국 연구중심대학의 발전과정

1) 연구중심대학으로의 발전과정과 정부지원사업

한국정부는 1970년대 후반에 대학의 연구를 지원하기 위한 산하 기관을 각각 설립하였는데 1977년에 과학기술처 산하에 한국과학재단을 설립했으며, 1979년에는 교육부 산하에 한국학술진흥재단을 설립해서 대학의 장기적 학술 활동을 지원하기 시작했다. 한국은 연구중심대학의 개념을 도입함에 있어 미국 대학의 사례를 벤치마킹 하여, 1990년대 후반부터 연구중심대학을 육성하기 위한 지원 사업을 실시했다. 연구재단의 초기 연구개발 투자의 목적은 세계적 수준의 연구중심대학을 육성하는 것이었다. 이를 위해 핵심분야 연구 역량을 높이고, 학문의 후속세대를 양성하며, 대학원 체제를 개편, 대학원 교육을 내실화하는 것을 목표로 정했다.⁸

눈 것으로 보여진다.

⁸ 이를 실현하기 위한 구체적인 방향으로 1) 연구경쟁력 강화, 2) 석/박사급 연구인력 양성, 3) 대학원 교육과 연구의 내실화, 4) 국가 사회적 필수연구인력을 집중 양성하는 데 두었다.

한국은 1990년대 중반 이후 연구중심대학으로의 전환을 위해 정부 주도 여러 프로젝트를 마련했는데 대표적으로 교육부가 시행한 대학원 중심대학 육성 지원사업과 두뇌한국 21(BK21) 사업을 들 수 있다. 두뇌한국21(Brain Korea 21, 일명 BK21) 사업은 한국의 연구중심대학 육성 정책들 가운데 가장 많은 예산을 투자한 사업으로, 우수인력 양성에 주안점을 둔, 가장 대표적인 연구중심 대학 육성사업이다. 당시 한국은 고등교육 분야의 연구 및 교육역량이 저조하여 대학의 국제 경쟁력을 획기적으로 개선하는 대책의 일환으로 대학원에 중점을 둔 연구중심대학 육성을 목표로 BK21 사업이 기획되었다. 특히 BK21 사업은 교육재정 한계상 모든 학문 분야를 한꺼번에 육성하기 보다는 선택과 집중의 원칙하에 국제적 비교우위를 확보할 수 있고 과학과 산업의 발전에 큰 영향을 미치는 소수의 이공분야를 중심으로 제한된 자원을 집중적으로 투자했다(김병주, 2007). 이 사업의 단계별 사업 성과와 한계를 살펴보면 아래 표와 같다.

표2. 한국 BK21 사업의 단계별 성과 및 한계

정책 단계	주요 성과	비판적 평가 및 한계
BK21 1단계 (1999–2005)	- 대학원 중심 연구 인프라 구축 - 연구경쟁력 기반 마련 - 대형 연구사업단 운영으로 집중적 지원	- 특정 이공계 분야에 편중 - 지방대 소외 현상 심화 - 연구성과보다 양적 실적 중심 평가 경향
BK21 2단계 (2006–2013)	- 참여 대학 수 확대 - 융복합 연구 시도 확대 - 국제 공동연구 증가	- 사업단 선정 기준의 불투명성 지적 - 학문 분야 간 균형 부족 - 일부 대학 중심 자원 집중 가속화
B K 2 1 플 러 스 (3단계, 2013–2020)	- 전국 단위 사업단 확대 (64개 대학) - 다양한 연구분야 포함 - 인재양성과 국제화 성과	- 사업 단위 분산으로 집중 효과 약화 - 실질적인 대학원 내실화는 부족 - 단기성과 위주의 평가 구조 지속
BK21 4단계 (2020–2027)	- 창의·도전형 연구인재 양성 목표 - 평가기준 고도화 - 연구중심 체제로의 정착 시도 - 사업단 215개 중 183개가 상위 10개 대학 소속 (85.1%)	- 상위 대학으로의 자원 쏠림 현상 심화 - 대학 간 양극화 확대 우려 - 지방 및 중소대학의 경쟁력 약화 가능성 - 제도개혁 조건 이행의 현실성 부족

이러한 원칙하에 BK21 사업의 중심은 과학기술분야에서 주로 대형 사업단을 선정하고 7년간 집중 투자했다. 과학기술분야 대형 1차 사업에 13개 대학이,

2차 사업에는 20개 선정되었다. 정부는 선정된 대학들에 대학원 위주 연구중심 대학으로의 전환을 위해 제도개혁을 부가적 조건으로 제시하였다. 제도개혁 요구 조건은 학사과정 입학전형제도 개선, 학사과정 학생정원 감축, 타 대학 학사과정 출신 50% 이상을 선발하도록 하는 대학원 문호 개방, 교수업적평가와 인사, 급여체계를 연계하고, 기타 대학이 연구중심 대학 체제를 갖추기 위해 필요한 경쟁적 연구풍토를 조성하도록 하는 등 창의적인 개혁을 포함했다(김병주, 2007). GK21 사업은 대학원 석·박사과정 학생에 대한 재정지원을 통해 구미 선진국들이 운영해온 연구중심대학 유형 체제가 우리나라 대학들에서도 운영되도록 하는 시발점을 만들었다는 평가가 지배적이다(김병주, 2006).

(한국대학신문, 2020.08.14일자, <https://news.unn.net/news/articleView.html?idxno=233427>).

2) 기업가형 대학으로의 전환과 정부사업

20세기 말에 들어서면서 미국을 중심으로 대학이 연구중심에만 머무르지 않고 연구 성과와 시장의 요구를 연계하는 것으로 나아가야 한다는 인식이 확산되기 시작했는데 이를 흔히 기업가형 대학(Entrepreneurial University) 이라고 일컫는다. 기업가형 대학이란 대학운영에 있어서 기업가적 마인드를 기반으로 연구 성과를 사업화 하는 대학으로 교수 및 학생의 기업가적 활동을 장려하는 대학을 말한다(임한려, 홍성표, 2020:28).⁹

한국대학은 2003년부터 산학협력단을 설립하기 시작하면서 이제 대학을 산업계나 사회 전반의 요구에 부응하여 기초과학, 응용과학 또는 공학 분야의 연구를 주된 목적으로 하는 고등교육기관으로 인식하게 되었다. 기업가형 대학은 기존의 교육과 연구를 기반으로 하되, 교육과 연구의 기반 위에서 국가와 사회가 요구하는 다양한 가치를 창출하는 대학을 지향한다. 이를 위해 기업가형 대학은 기술사업화 활동과 기업 창업 활동을 강화한다(임한려, 홍성표, 2020:28).¹⁰

한국정부는 대학을 기업가형 연구중심대학으로 전환하도록 BK21 사업 외에 아래의 표와 같이 세계수준의 연구중심대학(World Class University, 이하 WCU) 사업, 교육과학기술부 및 산업자원부의 산학협력 중심 대학 육성 사업과 Global Ph.D. Fellowship 사업들을 추진하고 있다.

⁹ 교육과 함께 연구업무를 중시하는 연구중심대학으로의 전환을 1차대학혁명이라고 한다면 기업가형 대학으로의 전환을 흔히 2차대학혁명이라 한다.

¹⁰ 대표적인 기업가형 대학인 미국의 스탠포드(Stanford) 대학의 경우, 스탠포드대 동문이 세운 기업의 수는 구글, 넷플릭스, 나이키, HP 등 4만여개에 달하고, 창출한 일자리와 연 매출액은 각각 540만 개와 2조 7000억 달러에 이른다. 스탠포드대 출신이 세운 비영리 단체도 3만 개에 달하는데, 이를 통해 스탠포드대는 강한 사회적 영향력을 미치고 있음을 알 수 있다.

표3. 기업가형 연구중심대학으로의 전환을 위한 정부사업

사업명	시작 년도	주 관 기 관	주요 목적	지원 내용	비고
WCU (World Class University)	2008	교육과학기술 부	세계 석학 초 빙을 통한 국 내 대학 연구 역량 강화	5년간 총 8,250억 원 지원, 해외 석학 초빙 및 공동연구 수행	BK21에 통합
Global Ph.D. Fel- lowship	2011	교육과학기술 부 / 연 구 재단	국가 핵심 과 학기술 인재 양성	박 사 과정 생 에게 학비 및 생활비 지원	개인 대 상 지원
LINC+ (산학협력 선도대학)	2016	교육부 / 통 일 산업 자 원 부	산학협력 중 심의 대학 중요	교육 연구 경 쟁력 강화 위한 지원 맞춤형	산 학 협 력, 창 의. 융합 형 인재 양성 중심

현재 한국의 연구개발(R&D) 투자는 정부와 기업을 합쳐 2021년 기준 102조 1352억원으로 사상 처음 100조원을 넘었다. 이는 미국과 중국·일본·독일에 이어 세계에서 다섯 번째 규모다. 국내총생산(GDP) 대비 R&D 투자는 세계 2위 수준이다. 이러한 사업들의 목적은 종합적으로 교수 연구업적 평가제도 마련 및 연구업적 향상의 성과를 달성하는 것이며, 둘째로는 대학원 중심대학체제로의 개편 실적이고, 셋째로는 교육연구 인프라를 구축해가는 것이다.

종합하여 보면, 한국의 대학원 중심대학의 모델을 구성 하는 데 토대를 마련한 것이 바로 대학원중점육성지원사업들에 있다. 한국연구재단은 2005년부터 전국 4년제 대학의 연구활동 실태조사를 매년 수행해오고 있는데 이 조사는 대학의 전임교원과 부설연구소의 전임연구원을 대상으로 연구비와 연구 실적(논문, 저술, 특허, 기술이전 등)을 분석하여 효율적인 연구개발(R&D) 정책 수립을 위한 정책 자료로 활용하고 있다. 대학평가의 각 지표와 결과는 국내 대학이 연구중심대학을 지향하는 방향에 큰 영향을 미쳤다. 대학 평가는 각 대학들의 경쟁을 부추겼고 이것은 대학 연구의 발전으로 이어졌다는 것이 한국대학들의 공식적인 평가다.

3) 연구중심대학의 특징

선진국과 몽골 주변국들의 연구중심대학들을 살펴보면 보편적으로 몇 가지 공통적인 특징을 갖는다.

먼저 미국과 일본, 한국의 소수 사립대학을 제외하고 대부분의 연구중심대

학은 정부의 재정지원으로 운영되는 국공립대학이다. 연구의 기능이 대학에서 가장 비용이 높은 부문이며, 공공지원을 필요로 하는 부문이기 때문에 대부분 국가에서 지원하는 구조를 가지고 있다.

둘째, 연구중심대학은 일반적으로 다양한 학과와 학부로 이루어진 종합대학이다. 따라서 대부분의 나라에서 연구중심대학은 대체로 규모가 큰 대학들이다. 특히 연구중심대학은 의학이나 경영학, 예술, 과학, 등 특정분야에서 전문대학원과 수준 높은 시설을 보유하고 있다.

셋째, 연구중심대학은 연구와 대학원 중심교육을 집중적으로 수행하는 경향을 가지고 있다. 대학의 사명은 대규모의 학부교육을 뛰어 넘어 지역사회와 국가에 영향력을 행사하며 학생에게는 광범위한 직업적, 전문적 신뢰를 제공한다.

넷째, 연구중심대학은 다른 대학보다 관리와 유지에 상당한 비용이 든다. 그 이유로 비싼 과학 장비의 증가 정보기술의 급속한 확대, 세계적 과학 지식에 대한 접근성, 교수들의 높은 봉급 부담 등이 있다. 마지막으로 연구중심대학은 국가 수준에서 또는 전 세계수준에서 훌륭하고 똑똑한 학생이 모여 실력 있고, 재능 있는 교수가 고용된다(박주호, 2012:327-328).

3. 몽골 교육부의 연구중심대학

1) 몽골 고등교육 환경 분석

몽골 고등교육 분야의 2024-2028년도 연구관련 발전 정책을 보면 몽골의 국립대학교를 교육중심대학에서 연구중심대학으로 발전시키고, 학문적 자유를 보장하며, 혁신적 생태계를 조성한다. 또 노동시장에서 인정받을 수 있는 지식과 기술을 갖춘 졸업생을 양성하고, 몽골의 대학들이 세계 유수 대학들과 공동 프로그램을 시행할 수 있도록 지원하고, 해외의 저명한 연구자와 학자를 초청하여 근무하게 하며, 학생들이 해외에서 여름학기 프로그램에 참여할 수 있도록 하는 정책을 시행한다고 되어 있다. 해외에서 시행하는 일부 연구중심대학의 활동을 몽골 대학에서도 수행하겠다는 목표를 정했다.

그러나 현재 몽골 대학교육과 연구의 현실은 녹록하지 못하다. 몽골 대학이 직면하는 문제는 졸업생들의 40%만이 전공과 관련된 직업을 가지고 있다. 졸업생들이 취업을 못하는 이유 중 하나는 '전공습득 수준과 기술이 노동시장 수요를 만족시키지 못한다'라는 것이다. 따라서 몽골대학은 시대 변화를 인지하고 미래사회가 필요로 하는 기술과 역량을 키우는 새로운 고등교육의 변화를 모색할 필요가 있다. 이를 위해 대학은 다른 국가의 교육 발전 경험을 연구, 적용하여 자국 조건에 맞게 토착화 시키는 과정을 통해 고등교육의 질과 효과를 향상시키는 과제를 안고 있다(안혜정, 2019:104).

둘째, 연구중심 대학의 구축이 필요하다. 산업, 대학, 연구기관, 정부와의 연



계를 통해 인력개발 및 기술개발을 실현하기 위한 연구중심 대학 구축은 현재 몽골 정부 및 국립대학의 핵심적 현안이다. 특별히 IT기반 새로운 전공의 개설, 교육과정의 개선, 대학 간 정보 공유 문제 개선이 필요하다.

셋째, 대학의 질 유지 및 관리를 위한 보다 체계적인 평가가 필요하다. 현재 대학을 대상으로 종합평가를 실시하고 있으나 이외에도 질 관리를 위한 일상적인 평가 실시가 필요하다. 전반적으로 교육과정에 관한 평가와 교수 질에 관한 평가 및 분석 기준 등을 마련할 필요가 있다(안혜정, 2019:105-106).

몽골정부의 연구중심 대학 구축과 관련해서는, 경제 발전에서의 대학교 역할 및 참여를 확대하고, 연구 역량과 효율성을 높이며, 연구결과를 시장 순환에 도입함으로써 새로운 제품과 서비스를 창출하는 목표를 시행하기 위해 '연구중심대학' 국가 프로그램을 개발하고 있다. 이를 위해서는 실제적인 계획 수행이 요구된다. 국가 차원의 연구개발 예산을 증대시켜 R&D 투자 확대를 실시하고 이를 통한 대학의 연구 역량을 강화할 필요가 있다. 두 번째로 국제 협력 강화하여 국제기구 및 외국 대학과의 협력을 통해 연구비를 확보하고 연구 역량을 향상시킬 수 있다. 세 번째로 성과 기반 보상 체계 도입하여 교수들의 연구 성과에 따라 보상하는 체계를 마련하여 연구 활동을 장려하는 것이다. 몽골의 국가 R&D 투자 규모는 GDP 대비 약 0.1~0.2%로, 이는 OECD 평균인 약 2.5%에 비해 현저히 낮은 수준이다. 대학의 연구 예산도 대부분 외부 프로젝트라 할 수 있는 국가과제나 아시아개발은행(ADB), 세계은행(World Bank), KOICA, JICA 등 국제협력기금 프로젝트가 주를 이룬다.¹¹

2) 연구중심대학으로의 전환

2025년 9월 새 학년도부터 대학은 이흐소르골, 칼리지로 나뉘게 되며 이흐소르골도 그 기준에 따라 연구, 교육, 전공(직업) 중심으로 분류된다. 앞으로 대학은 기술적, 특별 요건을 갖추어야 그 기준에 맞는 대학으로 남게 된다. 대학을 여러 기준으로 평가해서 연구중심대학으로 선정된 대학들을 국회에서 정해서 집중적으로 재정을 투자하겠다는 것이 몽골 정부의 방안이다.¹² 2024년 1월 22일자 교육부 회의자료에는 연구중심대학을 설립할 수 있는 가능성에 대한 예비 연구결과가 발표되었다. 해당 연구는 4개 분야, 27개 기준을 바탕으로

¹¹ KOICA 2022.04.21자 보도자료에 의하면 KOICA는 2019년부터 2025년까지 약 600만 달러(한화 약 74억 원)를 투입하여 몽골 국립과학기술대학교 정보통신대학의 역량 강화 사업을 진행하고 있고, 서울대학교와 함께 2022년부터 2027년까지 약 68억 원을 투입하여 몽골과학기술대학교에 도시계획공학과를 신설하고, 도시개발 전문인력 양성을 위한 교육과정 및 연구시설을 구축하고 있다(한국경제신문, 2022년9월 6일자). 또 독일과 합작대학인 GMIT에는 연간 22억 투그릭을 투자하고 있다.

¹² 몽골은 2023년에 개정된 고등교육법 7.4항에 이흐소르골을 업무활동의 크기, 교육, 연구분야, 교육 전공, 재학생 수, 졸업 수, 관련된 기타 지침에 근거해 연구중심, 교육중심, 직업중심으로 분류한다고 규정했다. 아울러 7.8항에 연구중심 이흐소르골을 정부가 제출한 자료를 바탕으로 국회에서 법으로 설립한다고 규정했다.

수행되었는데 이 조사에 따르면, 몽골 대학에 총 2,800명 이상의 연구자가 있으며, 이들이 국제 학술지에 1,637편의 논문을 발표하고 25개의 특허를 보유하고 있다고 한다. 이는 몽골 대학들이 상당한 연구 역량을 보유하고 있음을 보여주는 지표지만 국제적인 기준과 비교하면 여전히 미흡한 수준이다. 따라서 향후에는 재정적, 법적 환경 측면에서의 지원을 통해 연구중심대학의 기반을 강화할 필요성이 있다.¹³

2024년 6월 6일에 나온 국무회의 의결 253호를 보면 대학의 세 등급에 따라 각각 갖추어야 할 기술적 기준을 정하고 있다. 교육부는 4년마다 대학을 평가해서 그 등급을 정하겠다는 계획을 세웠으며 2025년 현재 첫 번째 조사가 이루어지고 있다. 대학 평가제도는 대학의 교육과 연구의 질 향상을 위해서 전통적으로 사용되어 온 방법으로 THE, QS 등 세계적으로 인정받는 평가기관들은 그 평가 항목이 조금씩 다르지만 교육환경, 연구, 논문피인용수, 연구수입, 국제화를 지표로 삼아서 대학을 평가해왔다. 몽골 교육부도 대학의 등급을 분류하는 지표로 교육환경과 관련해서는 석,박사생 비율, 박사학위자 전임교원 비율, 박사학위 취득자 수, 연구로는 국제적 수준의 학술지 논문 게재 수, 교수 1인당 지급 연구비, 논문피인용수는 H-Index에 논문 게재한 전임교원 비율, 연구수입은 교수 1인당 연구수입 정도, 전체수입 중 연구비가 차지하는 비율 등이 포함되어 있다. 몽골 정부는 앞으로 소정의 지표를 기준으로 대학의 랭킹과 등급을 정하고 지표에 따라 연구중심대학을 선정하여 지원하겠다고 발표했다. 앞으로 대학 간의 경쟁을 유도하여 대학의 질적 발전을 유도하겠다는 방침을 밝힌 것으로 해석할 수 있다.

4. 국제울란바타르대학교의 연구중심대학으로의 전환 가능성과 한계, 극복 방안

국제울란바타르대학교(이하 IUU)는 설립된 지 30년이 되었다. 그 동안 유치원부터 대학원 박사과정에 이르기까지 모든 수준의 교육을 수행하는 종합대학교로 괄목할만한 성장을 이루었다. 그러나 몽골 고등교육 발전계획에 따라 연구중심대학으로 발전해나가야 할 도전과 과제가 남아 있다.

1) IUU의 연구중심대학으로의 전환 가능성 - 내부역량 및 SWOT 분석

교육부가 2024년에 발표한 등급 결정에 따른 지표를 보면 IUU는 대부분의 연구중심대학의 지표에 미치지 못하고 있다.

¹³ 2023년에 개정된 고등교육법에 따르면 22.3항에 고등교육기관은 지적 재산 신청, 보호, 경제적 수요를 창출하는 과학기술을 통한 조직을 만들어 대학교와 회사와 합작으로 하는 활동을 지원하는 제도를 마련한다. 22.4항에 지적, 기술적 기반을 이용하고 학술연구, 조사업무의 성과를 산업체나 서비스 분야에 활동하는 이흐소르골은 대학의 기본 조직에 연구소, 교육, 연구, 경영연구소, 과학기술연계센터, 스타트업 회사, 과학공원, 과학기술 기술혁신연구소, 실험 실습과 이와 비슷한 부서를 독자적, 공동으로 설립할 수 있다고 정함으로써 연구중심대학이나 기업가형 대학의 법적 보호규정을 명시하고 있다.

표4. 연구중심대학 지표에 따른 IUU 현황

지표 항목	IUU 현황	연구중심대학 기준	충족 여부
석·박사과정 재학생 비율	17.3%	전체 학생의 $\geq 30\%$	미달
박사학위 소지 교원 비율	40%	$\geq 50\%$	미달
H-Index 보유 교원 수	3.3%	$\geq 20\%$	매우 미달
최근 3년간 박사학위 취득자수	1명	≥ 200	매우 미달
최근 3년간 국제학술지 논문 수	15편	≥ 200	매우 미달
교원 1인당 평균 연구비	5,625,840₩	최저임금의 8배 이상	미흡
교원 1인당 평균 연구수입	5,300,000₩	최저임금의 5배 이상	미흡

SWOT 분석을 통해 IUU의 연구중심대학으로의 전환 가능성을 평가해보면, 강점과 기회 요인은 존재하나 연구 기반의 약점과 외부 위협이 여전히 크다는 것을 알 수 있다.

- Strengths: 한국과의 연계, 20년 넘은 전통 있는 학과, 유연한 조직 구조, 젊은 교수진
- Weaknesses: 연구 인프라 부족, 국가재정지원 미비, 교수 연구역량 제한, 박사과정 운영 미흡
- Opportunities: 국제적 경쟁력 있는 인재 개발, 해외 프로젝트 협업, 연구성과 기반 지원
- Threats: 국제적 수준의 인재 부족, 재정적 원천의 한계, 국제학술지에 논문 게재 지원 부족, 영어 기반 학습의 미비

2) IUU의 현 상황 분석과 예상되는 한계

IUU는 외국인투자 사립대학이어서 몽골 정부의 지원을 받기가 어려우며, 학생 수도 2,000명정도의 소규모 대학이어서 10,000~25,000명에 달하는 몽골국립대학들보다 예산 규모나 투자 면에서 차이가 많다.

국제적 연구를 수행할 수 있는 영어 실력이나 국제적 학술연구 경험이 있는 교수들도 국립대학에 비해 그 비율이 현저히 적다. 2025년 현재 국제적 수준의 학술지에 논문을 게재한 IUU 교수는 2-3명에 불과하다. 1년에 1,000개 이상의 국제 학술지에 논문을 게재하는 몽골 주변국들의 연구중심대학들과는 비교조차 할 수 없고, 1년에 200개 가까운 논문을 게재하는 몽골국립대와 비교해도 매우 미흡한 수준이다.

학생들의 평균 수능성적도 500점 정도로 몽골 입학생의 평균에 해당하는 학생들이 우리 대학에 입학하는 것이 현실이다. 우수한 학생을 유치하는 과제

가 여전히 남아있다.

IUU는 몽골 사회가 요구하는 IT나 엔지니어 전공들이 거의 없으며, 대부분 인문, 사회전공이 많은 비중을 차지해서 국가적 규모의 사업을 지원받아 추진하기가 어렵다. 2023년 3월에 정부가 발표한 최우선적 수요가 있는 전공 83개 중에 우리 학교가 개설한 전공은 2개, 수요가 있는 전공 38개중에서는 5개에 불과하다. IUU와 경쟁관계에 있는 ЭТҮГЭН대학이 5개, 8개가 있는 것과 비교해도 수요가 있는 전공 개설 수가 적다. 따라서 IUU가 이와 같은 한계를 극복하고 연구 중심대학으로 발전하려면 혁신적 사고와 방향 전환이 필요하다.

3) 연구중심대학으로의 전환을 위한 극복 방안

연구중심대학으로 전환하는 방안을 크게 조직 재구성, 인적자원 개발, 재정 확보 방안, 연구문화 조성이라는 네 가지로 살펴보고자 한다.

IUU는 먼저 조직을 재구성해야 한다. 연구 담당 컨트롤타워(Control tower)를 세워서 연구지원업무를 확대하고, 체계적인 연구 발전 계획과 성과에 기반한 지원제도를 세워야 한다.

두 번째는 인적자원을 개발해야 한다. 박사급 국내외 연구 인재의 채용을 확대하고, 교수진의 해외 연수를 통해 연구역량을 키워야 한다.

세 번째는 재정 확보이다. 한국 정부 및 대학과의 협력 연구를 추진하고, 전공 특성화에 따른 산학협력을 통해 재원을 확보하는 방안을 마련해야 한다.

마지막으로 연구문화 조성이다. 연구중심대학은 단순히 조직과 인재만으로는 이뤄지지 않는다. 지속적인 세미나, 연구윤리교육, 학술지 발간 등 연구문화를 조성해야 한다.

이러한 전환을 위한 과정에는 여러 어려움도 있다. 교원들은 방대한 연구 업무 외에 입학 홍보와 신입생 모집, 전공 교수법 개발 등 여러 분야에 관심을 기울여야 하기에 심리적 압박감이 크기 마련이다. 따라서 대학에서는 강의나 봉사 시수에 대한 조정을 통해 부담을 줄이는 등의 방안을 마련해서 탄력적으로 교과운영을 할 필요가 있다. 또한 학부와 대학원을 연계하는 학문연구 풍조를 강화해서 학생인재들이 졸업 이후에도 계속 연구 업무에 매진할 수 있도록 지원해야 한다.

III. 결론

몽골 정부가 요구하는 연구중심대학은 앞으로 IUU가 나아가야 할 궁극적인 방향이다. IUU가 연구중심대학을 지향해야 하는 이유는 분명하다. 점점 치열해지는 고등교육 환경 속에서 대학의 지속가능성과 정체성 강화를 위해 반드시 연구중심대학을 지향해야 한다 이를 위해 몇 가지 제안을 하고자 한다. 먼저 대학



은 연구중심대학으로의 전환을 위한 발전 기획과 전략, 핵심성과지표(KPI)를 명확히 설정해야 한다. 둘째로 교수들이 연구할 수 있는 인프라 환경을 조성해야 한다. 연구중심대학의 핵심은 대학원이다. 양질의 지식 생산이 이루어지도록 외국 대학이나 연구소와의 공동연구, 해외 학술대회 발표, 저명한 외국인 교수 유치를 통해 국제적 감각과 수준을 높여야 한다. 셋째로 연구 재정 확보 및 유지이다. 한국 및 제 3국 대학과의 협력을 강화해서 공동연구 프로젝트 유지하고, 교수들이 국제 공동저자 논문을 다수 게재할 수 있도록 연구환경을 만들어야 한다. 넷째 인문, 사회과학이 중심인 IUU의 특성상 특성화 분야 전공을 선정하여 집중 투자할 필요가 있다. 특성화 전공에는 박사학위 소지자 비율을 높이고, 해외우수연구인력을 초청하여 협력 연구나 프로젝트에 참여하여 IUU 교원 연구자들의 경험과 질을 높이도록 해야 한다. 이를 바탕으로 정부의 연구중심대학 사업에 참여하는 길을 모색해야 한다. 다섯째로 교원의 성과에 기반한 인사 제도를 마련하고 연구 성과에 기반한 인사 평가와 승진, 보상에 직접적으로 반영되도록 제도를 정비해야 한다. 이러한 방향 전환은 학교와 교원들 모두에게 큰 과제요 도전임에 틀림없다. 결국 대학의 살 길은 대학이 연구중심대학으로 나아가기 위한 리더십을 보이고, 교수들이 연구중심 교원으로서의 삶을 택할 것인가의 우리의 선택과 태도에 달려 있다.

IV. 참고문헌

1. 김병주 (2006), BK21 사업 재정지원의 상대적 효율성 분석, 교육재정경제연구, 15(2), 221-245.
2. 김병주 (2007), BK21 사업 재정지원 정책의 정치학, 교육정치학연구, 14(1), 29-50.
3. 민철구 외(2008), 대학 연구기능 활성화를 위한 교육·연구 연계, 과학기술정책연구.
4. 안혜정(2019), 지속가능개발목표(SDGs) 달성을 위한 교육개발협력 연구(Ⅲ): 고등교육 실천 전략, 한국교육개발원.
5. 임한려, 홍성표(2020), 기업가형 대학(Entrepreneurial University)을 위한 대학의 창업 성과 영향요인 분석, 한국벤처창업학회, 벤처창업연구 15(2), 19-32.
6. 이춘근, 민철구 외(2001), "연구중심대학의 효과적 육성방안", 과학기술정책 제128권, 과학기술 정책관리연구소.
7. 전승준(2011), 연구중심대학의 발전 과정과 육성 방향. 과학기술정책, (183), 27-41.

8. 최정윤, 채재은 외(2011), 대학교육역량 강화를 위한 국제동향 분석 연구, 한국교육개발원.
9. Philip G.Altbach(2007), 세계수준의 연구중심대학을 향한 도전, 신정철 외 역, 서울: 교육과학사.
10. Clark, B. R.(1999), 연구중심대학의 형성과 발전, 고용 외 역. 문음사.
11. Д.Батцэцэг, Н.Оюунжаргал(2021), Их сургуулийн “энтрепренер” чиг баримжаатай хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа, Бизнес ба Инноваци Vol.7, No.1.
12. Д.Бадарч, Б.Очирбат, Т.Намнан, Б.Мөнххүж(2017), СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ, ШУТИС-ийн Олон улсын дээд боловсрол судлалын төв.
13. https://www.hankyung.com/article/202209064119i?utm_source=chatgpt.com (한국경제신문, 2022.09.06)
14. <https://news.unn.net/news/articleView.html?idxno=233427> (한국대학신문, 2020.08.14)

ТҮҮХ СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ДИЖИТАЛ АРГААР СЭРГЭЭХ НЬ

Докторант, археологич, Б.Ариунтулга
(ОУУБИС, Суурь боловсролын тэнхим)

ariuntulga.b@ulaanbaatar.edu.mn

Abstract: In Mongolia it has only been 100 years since archaeological science research. Compared to world archaeology, it is young but Mongolia is very rich in historic and cultural heritage that always captivates other countries' archaeologists and thieves.

3D modeling, graphic design, even computer technology is fast developing and preparing a very talented community every year in Mongolia. These two branches must work together to retain national history, lifestyle and oriental. First step to obtain this task is making a product or artistic creation based on archaeological research.

Монгол улсад археологын шинжлэх ухаан дэлгэрч, археологын судалгаа явуулж эхлээд 100 хүрэхгүй жил болж байна. Хэдий дэлхийн археологын салбарт бага залуу настайд тооцогддог боловч Монгол орон археологи түүх, соёлын арвин их дурсгалтай дэлхийн археологич, эрдэмтэд болоод ашиг хонжоо хайгчдын сонирхолыг байнга татаж иржээ.

Түлхүүр үг: Дижитал археологи, гурван хэмжээст скайнер, AI, digital art, археологи, богтаг малгай.

I. ОРШИЛ

Монгол улсад археологын шинжлэх ухаан дэлгэрч, археологын судалгаа явуулж эхлээд 100 хүрэхгүй жил болж байна. Хэдий дэлхийн археологын салбарт бага залуу настайд тооцогддог боловч Монгол орон археологи түүх, соёлын арвин их дурсгалтай дэлхийн археологич, эрдэмтэд болоод ашиг хонжоо хайгчдын сонирхолыг байнга татаж иржээ.

Х. Пэрлээ, Г. Сүхбаатар, Д. Наваан тэргүүтэн эхлүүлсэн монголын археологи Д. Цэвээндорж, З. Батсайхан, н. Эрдэнэбаатар, У. Эрдэнэбат нараар дамжин олон арван жилийн туршид дэлхийн археологын шинжлэх ухаантай хөл нийлүүлэн хөгжсөөр ирсэн. Гэвч өдгөө дэлхий нийт компьютер, техникийн үсрэнгүй дэвшлийн үрээр археологын шинжлэх ухаан ч дэлхий нийтэд хурдацтай хөгжсөөр байна. Археологын олдворыг авран хамгаалах, сэргээн засварлах зэрэг маш өндөр мэдрэмж, анхаарал болгоомж шаардсан чухал ажлын үед өдий төдий дурсгалууд

эвдэн сүйтгэгдэх явдал гарахыг үгүйсгэх аргаггүй юм. Энэ асуудлыг технологийн салбарт сүүлийн 20 жилийн туршид үр дүнтэй болохоо баталж байгаа 3D буюу гурван хэмжээст дүрслэлээр тухайн олдворыг ямар нэг эвдрэлгүйгээр сэргээн засварлах боломжтой болжээ.

Манай улсын хувьд түүхийн өдий төдий ил далд дурсгалтай, хүн төрлөхтөний соёл иргэншилийн түүхэнд эзлэх байр суурины хувьд аль ч улс, гүрнийг дагуулхааргүй арвин баялаг*. Гэвч энэхүү түүхийн арвин үнэт дурсгалыг малтан шинжлэх ажил хийгээд эд өлгийн дурсгалыг малтан шинжлэх үйл ажиллагаа орчин үеийн технологээр баяжин улам боловсронгуй болоод буй. Археологийн дурсгалуудыг малтан судлаж илрүүлсэний дараах шатны ажил нь зөвхөн түүхч археологичидоор зогсохгүй шинжлэх ухаан, технологийн бүх салбарын мэргэжилтнүүдтэй шууд болон шууд бусаар холбогддог. Манай улсын хувьд түүх соёлын биет дурсгалыг дижитал аргаар сэргээн засварлах, баримтжуулан хадгалах ажил сүүлийн 10 жилд эрчимтэй хөгжиж байна. Гэвч үүний дараагын шатны ажилууд болох арилжааны /commercial/ эрэглтэнд оруулах үйл явц тун удаан, бараг хийгдэхгүй байгаа нь энэхүү сэдэвтэй холбогдох бүх салбарын асуудал болоод байгаа юм.

II. СУДЛАГДСАН БАЙДАЛ

2000 он гарсаар монгол улсын археологын салбарт компьютер технологи ашиглаж хайгуул, малтлага судалгаа явуулсан олон шинжилгээний ангиуд байна. Герман, Монголын хамтарсан “Хар хорин” хотын малтлага, Япон, Монголын хамтарсан “Аврагын балгас”-ын малтлага гэх мэт ажлууд олон байна. Гэвч археологичидын тав зургаан жилээр тооцогдох энэ нүсэр их ажилын гол үр дүн нь малтлагаас илэрсэн эд өлгийн зүйлийг сэргээн засварлах, түүнийг судалж, он цаг, хамаарлыг тогтооход оршидог. Гэвч өдгөөг хүртэл монгол улсад археологын дурсгалыг сэргээн засварлах ажил гар аргаар хийгддэг учир дурсгалын хэмжээ, үнэ цэнээс хамаарч 3 сараас 5 хүртлэх жилийг зарцуулна. Мөн үүний зэрэгцээ зарим нэг хүнд элемент бүхий дурсгалыг гадаад улсад сэргээн засварлуулхаар өгч явуулдаг ба энэ асар их хэмжээний үнэ өртөгтэй болдог тул цөөхөн, чухал гэж үзсэн олдворуудыг явуулдаг. Гэтэл түүхийн үнэт олдвор, эд өлгийн зүйлд чухал чухал бус гэсэн ангилал байдаггүй. Нөгөөтэйгүүр монгол улсын хил гаалиар өдий төдий түүхийн үнэлж барашгүй олдвор, дурсгалууд хулгайгаар болоод хууль бусаар гадаад улсад гарч байгаа бөгөөд, хууль ёсоор гарсан нь хувилагдаж олшируулаад хуурамчыг нь өгч явуулж байгаа эсэхийг үнэхээр тааж мэдхээргүй юм. Монгол улсын түүхийн үнэт зүйлс гадаад улсад буюу хилийн дээсээр гарна гэдэг нь өөрөө үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц ноцтой асуудал юм. Энэ асуудлыг шийдвэрлэх арга зам нь монголын археологыг компьютер технологийн

салбартай нягт холбож, олдвор дурсгалуудыг дижитал болон гурван хэмжээстээр дүрслэлээр баримтжуулан авч үлдэх шаардлага нэн тэргүүнээ тавигдаад байна. 3 хэмжээст загварчлалыг археологын шинжлэх ухаанд ашиглах нь олон улсын хэмжээнд түгээмэл болоод байна. Үүнээс улбаалан түүхийн виртуал музей болон түүхийн олон үеийн дурсгалыг танин мэдэж болох баримтат болон уран сайхны кино, хувцас загвар зэрэг олон салбарт ашиглаж байна.

III. СУДАЛГААНЫ ТАЛБАРААС ДЭЛГЭЦРҮҮ: 3 ХЭМЖЭЭСТ ДИЖИТАЛ ДҮРСЛЭЛ БА АРХЕОЛОГЫН ӨВ СОЁЛ

3 Хэмжээст график дүрслэлийг ашиглах нь өөр хоорондоо харилцаа холбоотой хоёр идвэхтэй ба идвэхгүй гэсэн хоёр янзын мэдээллийг үүсгэж болно. Нэгдүгээрт археологын малтлага судалгаанаас илэрч буй соёлын өвийг дижитал хэлбэрт шилжүүлэх малтлага судалгааны үйл явц болоод олдворын муудах, задрах үйл явцыг хянах боломжыг олгоно. Энэ нь идвэхгүй мэдээлэл үүсгэж байна гэсэн үг. Хоёрт судалгааны талбайн 3 хэмжээст орчинг бий болгож интернэт, вэб хуудас болон виртуал музей зэрэг соёлын өвийг авран хамгаалах, илрүүлэх бүх шатны ажилыг ил тод болгох, цаашлаад дэлхийн өнцөг булан бүрт буй археологичидыг тухайн талбар дээр зэрэг зэрэг ажиллах боломжыг нээж өгч буй юм. Энэ нь зөвхөн археологын шинжлэх ухаанд төдийгүй соёлын өвийг хамгаалах зорилготой бусад шинжлэх ухаанд ч боломж олгож буй юм.

IV. 3 ХЭМЖЭЭСТ ДИЖИТАЛ БАРИМТЖУУЛАЛТЫН АШИГТАЙ ТАЛ.

Археологын дурсгалыг 3 хэмжээст модель болгох нь шинжлэн судлах, хамгаалах, сэргээн засварлах болон танин мэдүүлэхэд маш чухал ач холбогдолтой. Археологын өв соёл нь маш хэврэг, байнгын аюул заналхийлэл доор байдаг талаар дээр дурдсан. Зөвхөн олдвор төдийгүй архитектурын дурсгалууд нь аялал жуулчлал, тонуул дээрэм, дайн зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотойгоор сүйтгэгдэхээс гадна газар хөдлөлт, үер ус, хөрсний өөрчлөлт зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр ч устаж үгүй болох аюултай байдаг. 3 хэмжээст баримтжуулалт нь бидэнд археологын шинжлэх ухаан болоод соёлын өвийг хамгаалах байгуулгын эрдэмтэн судлаачдад түүхийн дурсгалыг таньж мэдэх болоод, түүхийн өнгөрсөн цаг үеэр аялаж, соёлын өвийн утга учирыг ойлгоход тус болох юм. Цаашилбал 3 хэмжээст баримтжуулалт нь дэлхийн соёлыг өвийг авран хамгаалах сэргээн засварлах үйлсэд нэн чухал болох нь батлагдаж байгаа юм. (зураг 1, 2.)

Археологи, түүх соёлын дурсгалыг 3 хэмжээст дижитал хэлбэрээр сэргээн засварлах нь зөвхөн хамгаалах хадгалахад чухал хэрэгтэйгээр тогтохгүй түүнийг

дараагын шатны судалгаа болоод арилжаа болоод медиа салбарт ч ашиглаж болох боломжтой болгож өгдөг. Энэхүү жишиг нь дэлхийн олон улсад аль хэдийн бүрэлдэн тогтсон бөгөөд зөвхөн музейн шилэн хоргоор тогтохгүй кино урлаг, компьютер болон уламжлалт тоглоом, зурагт хуудас, бодит хэмжээс бүхий дурсгалын зүйлс гэх мэтээр ашигласаар байгаа юм.

Манай орны хувьд өдий төдий археологи, түүх соёлын дурсгалыг нээн илрүүлсэн ч хүүхэд злуус хийгээд олон нийтэд хүртээл болсон нь тун ховор. 2019 онд “Чингис хаан” музей нээгдсэн нь манай улсын түүх соёлын хийгээд музейн салбарт нэгэн шинэ хуудас нээгдсэн. Гэтэл музейн ихэнх үзвэр нь хуучин “Монгол улсын үндэсний түүхийн музейн” хуучин үзвэрүүдээс бүрдэж, ганц нэг шинэ үзвэрүүдийг МУИС болон ШУА, УТМ-н архив, олдворын сангаас дэлгэсэн байв. Гэтэл эдгээр байгууллагууд дээр нэмэгдэн ШУТИС гэх мэт өдий төдий археологийн малтлага судалгаа явуулдаг байгууллагуудын олдворын санд олон нийтэд хүрээгүй өдий төдий соёлын биет өвүүд байсаар байна. Чухам эдгээр олдворуудыг дижитал аргаар хурдан шуурхай сэргээн засварлаж гэмээ нь дахиад арван “Чингисийн Музейтэй” болох боломжтой юм.

V. МОНГОЛ ДАХЬ СУДАЛГААНЫ АЖИЛ

ШУТИС-н багш, урлахуйн ухааны магистр А. Цэрэндуламын “13-р зууны Монгол хатны 3 хэмжээст загвар, модель бүтээх нь” судалгааны ажилдаа эртний монгол хатдын булш оршуулганаас олдсон монгол хатны богтаг малгай болоод түүний гоёл чимэглэлийг 3 хэмжээст загварчлалд оруулсан байна. Судалгааны ажилын гол цөм хэрэглэгдхүүн нь энэхүү монгол эхнэрийн богтаг малгайн 3 хэмжээст загварчлал болох юм. Богтаг малгайг судлаач 3D скайнер биш харин проекцын зураг ашиглаж сэргээсэн байна.(зураг3.4) Монгол улсын археологын салбарт 3 хэмжээст скайнерыг ашигласан судалгаа гарын таван хуруунд багтахаар цөөхөн. Хамгийн амжлалтай болсон нь Үндэсний түүхийн музей болоод Смитсоны музейн хамтарсан буган чулуун хөшөөний судалгаа юм. 2005 онд шинжилгээний баг Хөвсгөл аймгийн нутаг дахь Улаан Толгойн буган чулуун хөшөөг гар скайнерын тусламжтай 3 хэмжээст мэдээлэлийг үүсгэжээ.(зураг 5, 6, 7)

2020 онд МУ-н засгийн газрын дэмжлэгтэй ШУТсан, Рио Тинтогийн хөрөнгө оруулалтаар Digital Solution компани Их Монгол улсын нийслэл Хар Хорум хотыг бүрэн сэргээсэн виртуал музей нь манай улсад хийгдсэн хамгийн том судалгааны болоод гүйцэтгэлийн төсөл болоод байна.*

2023 онд дижитал, 3D загвар зохион бүтээгч Г. Шинэбаяр бие даан “Сарьдагийн хийдийн дижитал сэргээлт, виртуал музей” төслөө эхлүүлэн ажиллаж байгаа нь манай улсын шинэ залуу судлаач, дижитал артистууд энэ ажлын хамрах өргөн цар

хүрээг олж харсаныг илтгэж байна.

Одоогоор Монгол улсад археологын салбарт 3 хэмжээст скайнер ашиглаж байгаа байгуулга нь Соёлын өвийг хамгаалах төв, Түүх болон Археологийн хүрээлэнгүүд, Чингис хаан музей зэрэг байна. Хэдийгээр биет соёлын өвийг скайнердаж дижитал мэдээлэл үүсгэх, 3 хэмжээст хэвлэлээр зарим нэг дурсгалыг хэвлэж гарган музейн үзвэр зэргээр олон нийтэд хүргэж байгаа боловч түүний дараагийн шатны алхамуудыг авч хэрэгжүүлээгүй байгаа нь хөрш зэргэлдээ улстай харьцуулахад дэндүү хоцрогдолтой байгаа юм.

VI. ДҮГНЭЛТ

Монгол улс нь газрын хөрсөн дээр болоод хөрсөн доороо асар их баялаг бүхий улс хэмээн их номын хүн Х. Пэрлээ абугай нэгэн цагт бичиж байжээ. Тэрээр хөрсөн доорхи баялагын талаар дурдахдаа ашигт малтмалын талаар огт дурдаагүй бөгөөд түүх соёлын үнэлж бараагүй дурсгалыг хэлсэн нь маргаангүй юм. Сүүлийн хорь хүрэхтэй үгүйтэй жилийн хугацаанд дэлхий ертөнц асар хурдацтай хөгжин дэвшиж, техник технологийн үсрэнгүй хөгжилийн дүнд хүрэхгүй хийхгүй зүйл үгүй болжээ. Энэхүү техникийн хөгжил эртний эд хэрэглэл судалдаг археологын шинжлэх ухаанд ч мөн адил нэвтэрсэн байна. Гэвч манайх шиг түүх соёлын дурсгалаараа гадны орны судлаачид, эрдэмтэд төдийгүй тонуулчид, дээрэмчидийн сонирхолыг татаж байдаг улсын археологын салбар энэхүү техник технологи, мэдээллийн хурдтай хараахан хөл нийлүүлж чадахгүй байгаа нь гашуун боловч үнэн юм. Манай улсын хувьд Соёлын өвийг хамгаалах төв, Чингис хаан музей, Археологийн болон түүхийн хүрээлэнгүүд, ШУТИС тэргүүтэй зарим их дээд сургуулиуд энэхүү археологын олдворыг судлах, хадгалах, сэргээн засварлах шинэ арга технологийг нэвтрүүлээд байгаа юм.

3 хэмжээст дижитал баримтжуулалт Монгол улсад нэвтрээд буй тун авууштай. Харин түүний боловсруулалт болон, дараагын шатны үйл ажиллагаанд(жишээ нь виртуал музей болоод, 3 хэмжээст хэвлэл зэрэг) бэлдэхэд зөвхөн археологич, сэргээн засварлагч нарын ажил бус түүхч, антропологич, химич, физикч, физиологичид болоод хамгийн чухал нь компьютер график дизайнер, программ хангамж, код, AI бүтээгчидийн мэдлэг чадвар ус агаар мэт хэрэгцээтэй гэдэг нь тод харагдаж байна.

Монголын залуу үе өөрсдийн түүх соёлын давуу талыг олж харах болсон нь олзуурхууштай. Шинэ залуу төрөн гарч буй технологийн салбарын төлөөлөгчид маань үндэсний түүх соёлын дурсгалыг дижитал хэлбэрээр сэргээн босгох ажлыг хэн нэгэн хүний хүлээлэгсэн үүрэг, дарамт шахалтгүйгээр сайн дураар хийж гүйцэтгэж байгаа нь бидэнд тун их итгэл найдвар төрүүлж буй юм.

Монгол улсын түүх соёлын өв нь гагц түүхчид археологичидын өмч мэтээр


хандаж, зөвхөн өөрсдөө судлан шинжлэх гэсэн мөчид бодол одоо ч монголын археологи, түүхийн салбарт байсаар байна. Нөгөөтэйгүүр шинжлэх ухааны байгууллага гэдгээ умартан, өрсөлдөөн тэмцэлдээн, нэг нэгнийхээ дээр гарах гэсэн хийрхэл ч аль аль салбартаа байгаа нь нууц биш.

Монгол улсын үндэсний аюулгүй, соёлын элементийн дархлааг бий болгож, үндэсний ёс заншилыг авч үлдэх нь монгол улсын иргэн бүрийн хийх ёстой, үүрэх ёстой үүрэг юм. Чухам энэхүү үүрэг хариуцлагын гол ачааг нуруун дээрээ үүрч явах дааж гарах гарц нь компьютер технологи хийгээд түүх, археологын салбарууд нягт холбоотой уялдан ажиллах юм.


НОМ ЗҮЙ

- [1] “Монголын археологи”, Д Цэвээндорж -2000 он.
- [2] “Монгол эхнэрийн Богтаг малгай”, У. Эрдэнэбат -2006 он.
- [3] “Дугуй Цахирын хадны оршуулга”, У. Эрдэнэбат -2010 он.
- [4] “Digital imaging for Cultural heritage preservation” 2011
- [5] “Joint Mongolian-Smithsonian Deer stone project” 2005
- [6] <https://www.tuuhsoyol.com/Kharakhorum/index.html>
- [7] http://www.si.edu/mci/english/research/conservation/deer_stones.html
- [8] “13-р зууны Монгол хатны 3 хэмжээст загвар, модель бүтээх нь”, А. Цэрэндулам 2012 он
- [9] <https://chinggismuseum.com/history>

Зураг№1: Мексик дэх Маяагын “Алтан хотыг” сэргээн засварласан байдал.




Зураг №2: Эртний Грекийн ваарыг 3 хэмжээст загварчлалаар сэргээсэн байдал.



Зураг №3: монгол хатны богтаг малгайн олдвор.
(13-р зуун, Дугуй Цахирын хадны оршуулга)



Зураг №4: Археологын олдвор дээр үндэслэн монгол хатны богтаг малгайг 3 хэмжээст загварчлалаар сэргээсэн нь.



Зураг №5: Улаан Толгойн буган чулуун хөшөө.



Зураг №6: Улаан толгойн буган чулуун хөшөөний 3 хэмжээст модель



Зураг №7, 8 ХарХорум виртуал музей төсөл



Зураг № 9, 10 “Сарьдагийн хийд” төсөл



ГЭР БҮЛ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ТЭНХИМ



Б.АНУЖИН, П.СҮНЖИДМАА

Нэр дэвшигчдийг үнэлэх шалгуурт
нөлөөлөх зарим хүчин зүйлсийг
судалсан нь /хөвсгөл аймгийн
жишээн дээр/



А.МӨНХЖИН, Ө.БАЙГАЛЬ

Өсвөр насны хүүхдийн үе тэнгийн
дээрэлхэлтийг сэтгэл хөдлөл, зан
үйлийн бэрхшээлтэй харьцуулан
судалсан нь

НЭР ДЭВШИГЧДИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРТ НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН НЬ /ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Докторант, Б.Анужин (ОУУБИС. ХНУС)

anujin@ulaanbaatar.edu.mn

Магистр, П.Сүнжидмаа (ОУУБИС. ХНУС)

sunjidmaa.p@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Уг судалгаа нь сонгогчид нэр дэвшигчдийг үнэлэхдээ чухалчилдаг шалгуур болон эдгээр шалгуурт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилготой. Судалгаанд Хөвсгөл аймгийн 1688 иргэн хамрагдсан бөгөөд мэдээллийг анкет-сурвалжлагын аргаар цуглуулж боловсруулалт хийсэн. Судалгаанд улс төрчдийн хувийн шинж чанар, ёс суртахуун, иргэдтэй харилцах чадвар, улс төрийн туршлага, нийгэм-хүн ам зүйн онцлог зэрэг дөрвөн гол шалгуурт төвлөрсөн. Үр дүнгээс үзэхэд сонгогчид шударга байдал, нэр цэвэр байдал зэрэг ёс суртахууны шалгууруудыг хамгийн өндөрт үнэлж байв. Мөн иргэдийн дуу хоолойг сонсох, орон нутгийн нөхцөл байдлыг мэддэг байх зэрэг харилцааны чадамжийг дэмжсэн хандлага хүчтэй ажиглагдсан. Насны ангилал болон үнэлгээний шалгууруудын хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн ба залуу сонгогчид шинэ, залуу улс төрчдийг дэмжих хандлагатай байсан бол ахмад сонгогчид уламжлалт үнэт зүйлсийг илүү чухалчилж байв. Харин улс төрийн туршлага, эд хөрөнгө, удам судар зэрэг уламжлалт шалгуур харьцангуй бага үнэлгээтэй гарсан нь ёс суртахууны үнэт зүйлд чиглэсэн үнэлгээ давамгайлж байгааг харуулж байна. Судалгааны үр дүнд сонгогчдын санал өгөх шийдвэрт үнэт зүйлийн хүчин зүйлс гол үүрэгтэй байгаа нь ажиглагдлаа.

Түлхүүр үгс: нэр дэвшигчийг үнэлэх шалгуур, сонгогчийн зан үйл, ёс суртахуун, улс төрийн үнэлгээ



Abstract: This study aims to identify the key criteria voters consider when evaluating political candidates and the factors that influence these evaluations. The research involved 1,688 citizens of Khuvsgul province, using a structured survey and interview method. The collected data were processed using SPSS 25.0 statistical software. The study focused on four major evaluation categories: personal traits and morality, communication skills with citizens, political experience, and socio-demographic characteristics. The results indicate that voters place the highest value on ethical criteria such as honesty and integrity. In addition, candidates' ability to listen to citizens and their familiarity with local issues were strongly emphasized. A statistically significant difference was found between age groups and candidate evaluation criteria. Younger voters showed a stronger tendency to support new and younger political candidates, while older voters placed greater importance on traditional values such as integrity, moral character, and social responsibility. In contrast, traditional criteria such as political experience, wealth, and family background received relatively lower scores, suggesting a shift toward valuing ethical standards and a demand for renewal in political representation. These findings demonstrate that psychological and value-based factors play a central role in shaping voters' decision-making in elections.

Keywords: candidate evaluation, voter behavior, political trust, ethical standards,

ОРШИЛ

Аливаа улс орны ардчилсан нийгмийн тогтвортой байдал, засаглалын эрхийн үндэс нь иргэдийн идэвхтэй оролцоо бөгөөд үүний нэг чухал илрэл нь сонгуулийн санал хураалтад оролцох явдал юм. Гэвч сүүлийн жилүүдэд дэлхий даяар, тэр дундаа хөгжиж буй орнуудад сонгуулийн ирц буурах хандлага ажиглагдаж байгаа нь энэ үзэгдлийг олон талаас нь судлах шаардлагыг улам нэмэгдүүлж байна. (Blais, 2000; IDEA, 2023). Монгол улсад ч мөн сонгуулийн идэвх буурч, ялангуяа залуу сонгогчдын оролцоо сул байгаа нь чухал асуудал болоод байна. Өмнөх судалгаануудын үр дүнгээс харахад сонгогчдын зан үйлийг улс төрийн мэдлэг, эдийн засгийн нөхцөл байдал, намын үнэнч байдал гэх мэт хүчин зүйлсээр тайлбарлаж ирсэн ч сүүлийн үед нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлсийн үүргийг онцолж судлах хандлага нэмэгдэж байна (Fiske & Taylor, 2013). Тухайлбал, улс төрчдөд итгэх итгэл, улс төрийн оролцооны ач холбогдлыг хэрхэн ойлгож байгаа байдал, бүлгийн нөлөө, хамтын үнэт зүйлсийн мэдрэмж, оршин буй бүлэгтээ хүлээгдэж буй үүргийг биелүүлэх сэдэл зэрэг нь санал өгөх эсэхэд нөлөөлдөг байна. Энэхүү судалгаа нь иргэдийн санал өгөх зан үйлд /шийдвэр гаргалтад/ улс


төрчдийн хувь хүний нийгэм-сэтгэл зүйн онцлог хүчин зүйлс ямар нөлөө үзүүлж байгааг судалж, тэдгээрийн харилцан уялдаа, нөлөөллийн түвшнийг тодорхойлох зорилготой юм.

Тус судалгаанд Хөвсгөл аймгийн нийт 1688 иргэн хамрагдсан бөгөөд түүврийн хүрээ нь тухайн бүс нутгийн нас, хүйс, боловсролын түвшин зэргээр ялгаатай олон нийтээс бүрдсэн. Судалгааны хүрээнд улс төрчдийн талаарх иргэдийн үнэлэмжийг тодорхойлох зорилгоор тусгайлан боловсруулсан анкетыг ашигласан. Уг судалгааны зорилго нь сонгогчид улс төрчдөд тавьж буй шаардлага болон тэднийг үнэлэх хүчин зүйлүүдийн дотроос аль шалгуурыг илүү чухалчилж, санал өгөх шийдвэрт нь хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох явдал юм. Судалгааны таамаглалыг шалгах зорилгоор дараах бүлэг үзүүлэлтүүдийг боловсруулсан: i. Улс төрчийн хувийн зан чанар, ёс суртахуун, ii. Сонгогчидтой харилцах, нийгмийн харилцаа, iii. Улс төрийн чадвар, туршлага, iv. Нийгэм-хүн ам зүйн хүчин зүйл Судалгаанд түүврийн аргаар сонгогдсон оролцогчдоос анкет-сурвалжлагын хэлбэрээр авч, цуглуулсан мэдээлэлд SPSS 25.0 программ хангамж ашиглан статистик шинжилгээ хийсэн.

САНАЛ ӨГӨХ ШИЙДВЭР ГАРГАЛТАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Сонгогчдын санал өгөх шийдвэр нь улс төрийн үзэл баримтлал, эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон хүчин зүйлийг хамардаг (Lodge, Steenbergen, & Brau, 1995). Гэвч сүүлийн жилүүдэд судалгаанууд улс төрчдийн хувь хүний шинж чанар, зан төлөв, үнэт зүйлс нь сонгогчдын шийдвэр гаргалтад улам бүр чухал үүрэгтэй болж байгааг харуулж байна (Funk, 1999). Энэ чиг хандлага нь “candidate evaluation” буюу нэр дэвшигчийн талаарх үнэлгээ сонгогчийн санал өгөх хандлагад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах онолын чухал чиглэл болон хөгжиж байна.

Улс төрчийн хувь хүний шинж чанарыг санал өгөх зан төлөвтэй холбон тайлбарлахад сонгуулийн зан төлөвийн онолууд чухал суурь болдог. Тухайлбал, сэтгэл судлалын салбарт өргөн хэрэглэгддэг Азжений “Төлөвлөсөн зан төлөвийн онол” (Theory of Planned Behavior; TPB) нь хувь хүний хандлага, субъектив норм, зан төлөвийн хяналтыг санал өгөх шийдвэрт хэрхэн нөлөөлдгийг тайлбарлах онолын загвар болж өгдөг (Ajzen, 1991).



Зураг 1. Төлөвлөсөн зан үйлийн онолын загвар

Азжений онолоор нь хувь хүний зан төлөвийг урьдчилан таамаглахад хандлага, субъектив норм, зан төлөвийн хяналт гэсэн гурван үндсэн хүчин зүйлийг онцолдог ба улс төрчийн шинж чанар, тухайлбал боловсрол, мэргэжлийн туршлага зэрэг нь сонгогчийн хандлагад шууд нөлөөлж, тэдний итгэл үнэмшлийг бүрдүүлэн санал өгөх шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлдэг. Мөн улс төрчийн итгэл үнэмшилтэй байдал, ёс зүй, сэтгэл татам шинж чанар нь тэдний манлайллын чанарыг тодорхойлж, сонгогчдын дэмжлэгийг татахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа харизматай улс төрчид сонгогчдын сэтгэл хөдлөлд хүчтэй нөлөөлж, хандлагыг өөрчлөх замаар тэдний оролцоог нэмэгдүүлдэг болохыг судалгаанууд харуулж байна (Conger & Kanungo, 1987). Түүнчлэн харизма нь улс төрчийн ярианы хэв маяг, биеийн хэлэмж, олон нийтийн харилцаанд үзүүлэх нөлөөллөөр дамжин илэрдэг бөгөөд энэ нь санал өгөх зан төлөвийг бүрдүүлэх чухал хүчин зүйлсийн нэг юм.

“Attribution theory” буюу “Холбон тайлбарлах онол” нь хүмүүс бусдын зан үйлийг хэрхэн ойлгож, түүний шалтгааныг юу гэж үздэгийг тайлбарладаг танин мэдэхүйн онол юм (Heider, 1958; Kelley, 1967). Энэ онолын дагуу хувь хүн бусдын үйлдлийг тайлбарлахдаа дотоод (жишээлбэл, зан чанар, итгэл үнэмшил) болон гадаад (нөхцөл байдал, аз) хүчин зүйлсэд үндэслэдэг. Улс төрийн орчинд энэхүү онол нь сонгогчид улс төрчдийн үйлдэл, шийдвэрийг хэрхэн хүлээн авч, үнэлдэг зэргийг ойлгоход ашиглагддаг.

Иргэдийн улс төрчидтэй холбоотой үнэлгээ нь тухайн үйлдлийн шалтгааныг хэрхэн тайлбарласнаас ихээхэн хамаардаг. Тухайлбал, нэг улс төрч буяны ажилд оролцсон тохиолдолд зарим нь үүнийг түүний хүнлэг зан чанартай холбож эергээр хүлээн авах бол, нөгөө хэсэг нь сонгуулийн өмнөх сурталчилгаа хэмээн

гадаад шалтгаантай холбон сөргөөр үнэлж болно (McGraw, 1991). Иймээс холбон тайлбарлах онол нь улс төрчдийн үнэлэмж нь бодит үйлдлээс гадна сонгогчийн хандлага, ойлголт, орчны нөлөөнд хэрхэн тулгуурлаж байгааг тайлбарлахад чухал онолын үндэс болдог.

УЛС ТӨРЧИЙН ТАЛААРХ СУБЪЕКТИВ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрчдийг үнэлэх сонгогчдын үйл явцад субъектив хүчин зүйлс онцгой үүрэгтэй бөгөөд эдгээр нь сэтгэл зүйн болон нийгэм-хүн ам зүйн шинжүүдээс бүрддэг. Сэтгэл зүйн хүчин зүйлсэд хувь хүний болон бүлгийн сэдэл, хэрэгцээ, сэтгэл хөдлөл, мэдлэг, төсөөлөл зэрэг ордог бол нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлс нь хүйс, нас, боловсролын түвшин, мэргэжлийн харьяалал зэргийг хамарна (Пищева, 2006). Сүүлийн жилүүдэд нийгмийн бүтэц, соёлын хэв маягт гарч буй өөрчлөлт нь улс төрчдөд хандсан шинэ хүлээлт, үнэлгээний хэм хэмжээг бий болгож байна.

Сонгогчид улс төрийн сонголтоо зөвхөн намын харьяалал, бодлогын байр сууринд үндэслэхгүйгээр, нэр дэвшигчийн хувийн шинж чанар, түүх, гарал үүсэл зэрэг хувь хүний талаарх мэдээлэлд үндэслэн үнэлэлт дүгнэлт өгдөг. Үүний үр дүнд нэр дэвшигчийн хүйс, мэргэжил, боловсрол, орлого зэрэг шинжүүд нь тухайн хүнийг ойлгомжтой, ойр дотно, эсвэл чадварлаг хэмээн үнэлэхэд нөлөөлдөг бөгөөд эдгээр үнэлгээ нь сонгогчдын дэмжлэгийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг (Adams et al., 2011). Түүнчлэн, нэр дэвшигчийн эдгээр гадаад шинжүүд нь түүний бодлогын байр суурийг урьдчилан таамаглахад ч нөлөөлж болзошгүй бөгөөд ингэснээр сонгогчийн шийдвэрт шууд болон шууд бус байдлаар нөлөөлж байдаг.

Сонгогчид нэр дэвшигчийн мэргэжлийг түүний чадвар, хандлага, үнэт зүйлсийг илтгэх дохио хэмээн хүлээн авдаг бөгөөд энэ нь боловсрол, орлого зэрэг бусад шинжүүдийг урьдчилан таамаглах үндэс болдог. Carnes ба Lupu (2016)-ийн судалгаагаар их дээд сургуулийн боловсролтой нэр дэвшигчийг илүү чадвартай, харин боловсролын түвшин багатай нэр дэвшигчийг туршлага дутмаг гэж үнэлэх хандлага илэрдэг болохыг тогтоосон. Олон улсад нэр дэвшигчийн хүйс, орлого, боловсрол зэрэг хүчин зүйлийг судалсан олон тооны эмпирик судалгаанууд хийгдсэн байдаг бол гэр бүлийн гарал, удам угсаатай холбоотой судалгаа харьцангуй ховор байна. Жишээлбэл, Sadin (2015)-ийн судалгаанд нэр дэвшигчийн удам угсаа нь сонгогчдын түүний чадварын талаарх үнэлэмжид нөлөөлөхгүй болохыг харуулсан байдаг. Гэсэн хэдий ч Монголын нийгмийн соёлын онцлогийг харгалзан үзвэл удам угсаа, нутаг ус нь нэр дэвшигчийн мэргэжлийн гаралтай адил хэмжээнд үнэлэгдэх магадлалтай гэж таамагласан.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд Хөвсгөлаймгийн нийт 1688 иргэн хамрагдсан бөгөөд хүйсийн хувьд 872 нь эрэгтэй (51.7%), 816 нь эмэгтэй (48.3%) байв. Судалгаанд хамрагдагсдын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байсан нь түүврийн төлөөлөл, үр дүнгийн найдвартай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Судалгаанд оролцогчдыг насны хувьд ангилан авч үзэхэд, 18–28 насныхан 325 буюу (19.3%), 29–44 насныхан 618 буюу (36.6%), 45–60 насныхан 549 буюу (32.5%), 60 ба түүнээс дээш насныхан 196 буюу (11.6%)-г тус тус бүрдүүлж байна.




График 1. Сонгогчдын улс төрчдөд тавьж буй үнэлэмжүүдийн харьцуулалт

График 1-ээс харахад сонгогчид улс төрчдийг үнэлэхдээ хамгийн түрүүнд хувийн зан чанар, ёс суртахуун, шударга байдлыг (35.8%) онцгойлон чухалчилж байна. Дараа нь иргэдтэй харилцах чадвар, нийгмийн харилцаа (25.0%) болон улс төрийн туршлага, нөлөөлөл, бодлогын асуудлыг (22.9%) сонгосон бол харьцангуй бага хувийг тухайн улс төрчийн хөрөнгө мөнгө, гэр бүл, удам судар эзэлж байгаа нь харагдаж байна. Эдгээр үзүүлэлтийг задалж үзвэл:



График 2. Хувийн зан чанар, ёс суртахууныг үнэлэх шалгуурын эрэмбэ

Хувийн зан чанар, ёс суртахуун гэсэн өргөн хүрээтэй үнэлгээний дотроос сонгогчид шударга байдал (22.8%), нэр цэвэр байдал (22.4%) гэсэн хоёр шалгуурыг хамгийн өндөр үнэлсэн нь ажиглагдаж байна. Энэ нь иргэд улс төрчдийг авлигаас ангид, ёс зүйтэй, үнэнч шударга байхыг хамгийн түрүүнд шаарддагтай холбоотой. Дараа нь: Үзэл бодолдоо үнэнч, тууштай байх (16.4%), Хэлсэн амлалтдаа хүрдэг байдал (16.2%) гэсэн үнэлэмжүүд дунджаар ойролцоо үнэлэгдсэн байна. Харин хамгийн бага үнэлгээтэй шалгуурт: Бусдын нөлөөнд автахгүй, бие даасан байр суурьтай байх (11.2%), Эх оронч, үндэсний үзэлтэй байх (11.0%) гэсэн үнэлэмжүүд орж байна. Эдгээр үр дүнгээс харахад сонгогчид улс төрчдийн үндэсний үзэл, бие даасан байдал зэргийг бага зэрэг чухалчилж байгаа боловч нийт дүнгээрээ шударга байдал, нэр цэвэр байх нь улс төрчийн үнэлгээнд хамгийн шийдвэрлэх нөлөөтэй байна гэж дүгнэж болно. Энэ нь сонгогчдын дунд улс төрийн итгэл, ёс суртахууны үнэт зүйлд суурилсан хандлага давамгайлж байгааг харуулж байж болно.



График. 3 Сонгогчидтой харилцах, нийгмийн харилцааг үнэлэх шалгуурын эрэмбэ

Иргэдтэй харилцах чадварыг үнэлэхэд хамгийн өндөр хувьтай үнэлэгдсэн шалгуурууд нь: “Иргэдээ сонсдог, иргэдийн дуу хоолой болж чаддаг” үзүүлэлт (44.8%) болон “Аймаг, сумынхаа нөхцөл байдлыг, онцлогийг сайн мэддэг” (31.7%) байна. Энэ нь улс төрчид иргэдийн санаа бодлыг сонсох, төлөөлөх үүрэгтэй байх нь сонгогчдын хувьд хамгийн чухал хандлага гэдгийг харуулж байна. “Иргэдийн хар бор амьдралыг ойлгодог байдал” (18.7%) өндөр байгаа нь энгийн иргэдийн амьдралын онцлог, зовлон бэрхшээлийг мэдрэх чадвар нь дунджаас арай доогуур үнэлэгдсэн ч тодорхой хувь эзэлж байна. Харин “Гадна төрх, биеэ авч явах байдал” (4.7%) гэсэн үзүүлэлт хамгийн бага ач холбогдол өгсөн шалгуур байгаа

нь сонгогчид бодит харилцаа, иргэдийн төлөө ажиллах чадварыг чухалчилдаг болохыг илтгэж байна.





График. 4 Улс төрийн чадвар, туршлагыг үнэлэх шалгуурын эрэмбэ

Судалгаанд оролцогчдын талаас илүү нь улс төрд шинэ хүн, залуу төлөөлөл оролцохыг чухалчилж (48.1%) байна. Энэ нь шинэчлэл, өөрчлөлтийн хэрэгцээ, залуусын оролцоог дэмжих хандлага өндөр байгааг илтгэж байгаа боловч “улс төрийн туршлага” (25.5%) үзүүлэлт нь харьцангуй бага боловч сонгогчид туршлагатай улс төрчийг тодорхой хэмжээнд үнэлдэг нь харагдаж байна. Энэхүү үзүүлэлт нь улс төрийн туршлага, мэргэжлийн чадамжид хандах олон нийтийн хандлагыг дахин шинжлэх боломж олгож байна. Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн олонх шинэ залуу хүмүүсийн улс төрд оролцохыг илүүд үзэж байгаа нь улс төрийн шинэчлэл, итгэл сэргээх хэрэгцээ өндөр байгааг илтгэсэн.



Судалгаанд оролцогчдын 75.8% нь улс төрчдөөс хамгийн түрүүнд боловсролыг чухалчилж байна. Энэ нь мэдлэг, боловсролтой байх нь улс төрийн шийдвэр гаргах чадамж, олон нийтийн итгэлийг даах чухал шалгуур хэмээн үзэж буйг илтгэсэн. Удам судар сайтай байх (11.0%) үнэлгээ харьцангуй бага хувьтай байгаа нь уламжлалт үнэлгээ багасаж байгааг харуулж байна. Хөрөнгө мөнгө бэл, бэнчинтэй байдал үзүүлэлт нь (9.6%) үнэлгээ авсан ба сонгогчид мөнгө хөрөнгөнөөс илүү боловсрол, ёс суртахууныг чухалчилдаг чиг хандлага давамгайл байгааг илтгэнэ. Гэр бүлийн хувьд тогтвортой байдал (3.5%) буюу хувь хүний амьдралын тогтвортой байдал хамгийн бага хувьтай үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд сонгогчид хувь хүний хувийн амьдралд бус, олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, мэдлэг чадварт илүү ач холбогдол өгч байна.

Түүнчлэн бид судалгаанд оролцогчдын нийгэм эдийн засгийн үзүүлэлтээс хамааран сонгогчдыг үнэлэх үнэлэмж ялгаатай байж магадгүй хэмээн таамаглан Хи-квадрат шинжилгээг хийсэн.

	Chi-Square (χ^2)	df	Asymp. Sig. (p-value)
Улс төрд шинэ залуу хүн байх	34.215	4	0.00*
Шударга байдал	21.769	4	0.001*
Нэр цэвэр байх	27.302	4	0.00*
Иргэдийн дуу хоолой болж чаддаг	18.529	4	0.001*

График. 6 Хи-квадрат шинжилгээний үр дүн

Хи-квадрат шинжилгээгээр насны үечлэл ба улс төрчдийн үнэлгээний хүчин зүйлсийн хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн. Тухайлбал, “улс төрд шинэ, залуу хүн байх” ($\chi^2(4) = 34.215$, $p < .001$), “шударга байдал” ($\chi^2(4) = 21.769$, $p = .001$), “нэр цэвэр байдал” ($\chi^2(4) = 27.302$, $p < .001$), “иргэдийн дуу хоолой болж чаддаг” ($\chi^2(4) = 18.529$, $p = .001$) зэрэг үнэлгээний шалгууруудын хувьд насны бүлгүүдийн хооронд ач холбогдол бүхий ялгаа байгааг тогтоосон.

Энэхүү үр дүн нь сонгогчдын наснаас шалтгаалан улс төрчдөд тавих хүлээлт, үнэлэмжийн эрэмбэ, ач холбогдол өөрчлөгдөж байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, нас нэмэгдэхийн хэрээр улс төрчдөд тавих шаардлага, үнэлэмжийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж байгааг тогтоосон. Залуу насны бүлгийн сонгогчид улс төрийн шинэ, залуу төлөөллийг илүүд үзэх хандлагатай байгаа нь тэдний хувьд шинэчлэл, өөрчлөлтөд чиглэсэн хүлээлт, үнэт зүйл давамгайл байгааг илтгэсэн бол ахмад насны бүлгийн хувьд ёс суртахуун, шударга байдал, нэр хүнд, олон нийтийн дуу хоолойд анхаарал хандуулах байдал илүү давамгайлж, уламжлалт үнэт зүйлсийг чухалчилж буй хандлага ажиглагдсан.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь сонгогчдын санал өгөх шийдвэрт улс төрчдийн хувь хүний онцлог, ёс суртахуун, иргэдтэй харилцах чадвар, улс төрийн туршлага, нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зорилготой. Судалгааны үр дүнгээс харахад сонгогчид улс төрчдийг үнэлэхдээ хувь хүний ёс суртахуун, шударга байдал, нэр цэвэр байдал зэрэг ёс зүйн үнэт зүйлсийг хамгийн чухал шалгуур болгон онцолсон ба сонгуульд нэр дэвшигчид иргэдтэй харилцах чадвар нь сонгогчдын дэмжлэг авахад чухал нөлөө үзүүлэх талтай ажиглагдаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх нь иргэдийн дуу хоолойг сонсож, төлөөлж чаддаг байхыг хамгийн чухал шалгуур хэмээн үнэлсэн. Энэ нь төлөөллийн ардчиллын суурь агуулгатай нийцэж, улс төрч нь олон нийтийн санал бодлыг илэрхийлэх чадамжтай байх шаардлага сонгогчдын хүлээлтэд гол байр суурь эзэлж буйг илтгэнэ.

Мөн улс төрийн туршлага, чадварын шалгуурын хүрээнд “улс төрд шинэ, залуу хүн байх” гэсэн үнэлэмж хамгийн өндөр байсан нь сонгогчдын дунд улс төрийн шинэчлэл, өөрчлөлтийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулсан. Энэхүү хандлага нь уламжлалт албан тушаал, нөлөөллийн байр суурь, туршлагыг бус, шинэ үеийн төлөөллийг дэмжих чиг хандлага нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Нийгэм-хүн ам зүйн шалгуурын хувьд “өндөр боловсрол эзэмшсэн байдал” нь хамгийн өндөр үнэлгээ авсан нь улс төрчдийг үнэлэхэд мэдлэг, чадамжийг түлхүү чухалчилдаг шинэ хандлага төлөвшиж байгааг харуулж байна. Харин хөрөнгө чинээ, гэр бүлийн тогтвортой байдал зэрэг уламжлалт үзүүлэлтүүд харьцангуй бага ач холбогдолтойд тооцогдсон нь улс төрийн үнэлгээний шалгуурт тулгуурлах иргэдийн хандлага өөрчлөгдөж байгааг нотолж байна.

Судалгаанд ашигласан Хи квадрат шинжилгээний үр дүнгээс харахад насны ангилал болон улс төрчдийг үнэлж буй шалгууруудын хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн. Тодруулбал, сонгогчдын нас нэмэгдэхийн хэрээр улс төрчдөд тавих шаардлага, үнэлэмжийн чиг хандлага өөрчлөгдөж байгааг тогтоосон. Залуу сонгогчид шинэчлэл, өөрчлөлтийн бэлгэдэл болсон улс төрийн шинэ, залуу төлөөллийг илүүтэй дэмжих хандлагатай байсан бол ахмад насныхан ёс суртахуун, шударга байдал, нэр хүнд, олон нийтийн дуу хоолойд хандах хандлага зэрэг уламжлалт үнэт зүйлсийг илүү чухалчилж буй нь ажиглагдсан. Энэ нь сонгогчдын нас нь улс төрчдөд хандсан үнэлгээний онцлог, сэтгэл зүйн

хүлээлтийг тодорхойлоход нөлөөлөх чухал хүчин зүйл болж байгааг харуулж байна.

Эдгээрээс дүгнэн үзэхэд сонгогчдын улс төрийн сонголтод ёс зүй, иргэдтэй харилцах чадвар, боловсрол, шинэчлэлд чиглэсэн хандлага давамгайлж байгааг илэрхийлж байгаа нь “сонгогчдын зан үйлийг тайлбарлах төлөвлөсөн зан үйлийн онол” (Ajzen, 1991) болон улс төрийн лидерийн үнэлгээний тухай нийгэм-сэтгэл зүйн хандлагуудтай уялдаж буй юм. Тодруулбал, сонгогчдын үнэлгээ нь тухайн улс төрчийн мэдлэг, үнэт зүйл, зан үйлийн хүлээлт зэрэгт үндэслэгдэж байгаа нь үзэл бодлын суурьтай сонголт давамгайлж байгааг харуулж байна. Уг судалгаа нь тодорхой бүс нутаг, цаг хугацаанд хязгаарлагдан явагдсан тул үр дүнг нийт ард түмний төлөөлөл болгон шууд дүгнэхэд хязгаарлалттай. Мөн ирээдүйн судалгаанд явцын болон сонгуулийн дараах үнэлгээ (pre- болон post-election evaluation)-г харьцуулан, үнэлэмж хэрхэн өөрчлөгдөж буйг тодруулах боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Adams, J., Ezrow, L., & Somer-Topcu, Z. (2011). *Is anybody listening? Evidence that voters do not respond to European parties' policy statements during elections. American Journal of Political Science*, 55(2), 370–382. <https://doi.org/10.1111/j.1540-5907.2010.00490.x>
2. Ajzen, I. (1991). *The theory of planned behavior. Organizational Behavior and Human Decision Processes*, 50(2), 179–211. [https://doi.org/10.1016/0749-5978\(91\)90020-T](https://doi.org/10.1016/0749-5978(91)90020-T)
3. Blais, A. (2000). *To vote or not to vote: The merits and limits of rational choice theory*. University of Pittsburgh Press.
4. Carnes, N., & Lupu, N. (2016). *Do voters dislike working-class candidates? Voter biases and the descriptive underrepresentation of the working class. American Political Science Review*, 110(4), 832–844. <https://doi.org/10.1017/S0003055416000551>
5. Conger, J. A., & Kanungo, R. N. (1987). *Toward a behavioral theory of charismatic leadership in organizational settings. Academy of Management Review*, 12(4), 637–647. <https://doi.org/10.5465/amr.1987.4306715>
6. Fiske, S. T., & Taylor, S. E. (2013). *Social cognition: From brains to culture* (2nd ed.). SAGE Publications.
7. Heider, F. (1958). *The psychology of interpersonal relations*.
8. International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA). (2023). *Vot-*



er turnout database. <https://www.idea.int/data-tools/data/voter-turnout>

9. Kelley, H. H. (1967). Attribution theory in social psychology. In D. Levine (Ed.), *Nebraska Symposium on Motivation* (Vol. 15, pp. 192–238). University of Nebraska Press.
10. Lodge, M., Steenbergen, M. R., & Brau, S. (1995). *The responsive voter: Campaign information and the dynamics of candidate evaluation.* *American Political Science Review*, 89(2), 309–326.
11. McGraw, K. M. (1991). Managing blame: An experimental test of the effects of political accounts. *American Political Science Review*, 85(4), 1133–1157. <https://doi.org/10.2307/196>
12. Pishcheva, T. N. (2006). *Perception of presidential candidates: Communicative aspects of election campaigns* (Candidate of Political Science dissertation). Moscow.
13. Sadin, M. L. (2015). *Campaigning with class: The effect of candidate social class on voter evaluations.* [Doctoral dissertation].

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТИЙГ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ЗАН ҮЙЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

Магистр, А.Мөнхжин (ОУУБИС. ХНУС)

munkhjin.a@ulaanbaatar.edu.mn

Доктор, дэд профессор, Ө.Байгаль (ОУУБИС. ХНУС)

baigal.u@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үг: Сэтгэц, ассоциаци, нийлэмж, холбоос, зөвлөгөө

Хураангуй: Үе тэнгийн дээрэлхэл болон өсвөр үеийнхний сэтгэл зүй болон зан үйлийн бэрхшээл хоорондын хамаарлыг тодорхойлоход чиглэгдсэн юм. Судалгаанд 10-аас 12 дугаар ангийн сурагчид буюу 15-18 нас хүртэлх 100 өсвөр насны хүүхдүүд оролцсон. Тэднээс үе тэнгийн дээрэлхэл болон сэтгэл-зүйн ба зан үйлийн бэрхшээлийг үнэлэх зорилгоор асуумжын аргаар мэдээлэл цуглуулсан. Үр дүнд нь, үе тэнгийн дээрэлхэлд өртсөн хүүхдүүд сэтгэл түгших, сэтгэл гутрал, зан үйлийн доголдол, нийгмийн харилцааны бэрхшээл зэрэг олон талт хүндрэлүүдийг илүүтэйгээр үзүүлдэг болох нь тогтоогдсон. Түүнчлэн дээрэлхлийн хэлбэрүүд (бие махбодын, үгээр, цахим орчноор) нь сэтгэл-зүйн хариу үйлдэлд янз бүрээр нөлөөлдөг болохыг судалгаа харуулсан. Эцэст нь, дээрэлхэл нь өсвөр үеийнхний сөрөг сэтгэл хөдлөл, гутрал, хямрал, зан үйлийн доголдол үүсэх нэг хүчин зүйл болохыг баталсан бөгөөд энэ нь сургууль, эцэг эх, нийгмийн зүгээс анхаарч, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг илэрхийлж байна. Судалгааны үр дүн нь үе тэнгийн дээрэлхэлтэй тэмцэх, хүүхдийн сэтгэл зүйг дэмжих сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн тусламж үзүүлэх арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Abstract: This study aimed to determine the relationship between peer bullying and emotional and behavioral difficulties among adolescents. A total of 100 high school students aged 15 to 18, from grades 10 to 12, participated in the research. Data were collected through questionnaires assessing experiences of peer bullying and levels of emotional and behavioral difficulties. The results indicated that students who were subjected to bullying exhibited higher levels of anxiety, depression, behavioral

problems, and social interaction difficulties. Furthermore, the study revealed that different types of bullying—physical, verbal, and cyberbullying—had varying impacts on adolescents’ psychological responses. Ultimately, the research confirmed that peer bullying is a contributing factor to negative emotional states, depression, psychological crises, and behavioral disorders in adolescents. These findings emphasize the importance of proactive and preventive measures by schools, parents, and society. The results of this study are significant for developing anti-bullying strategies, creating educational programs that support students’ mental health, and planning professional interventions to support the well-being of adolescents.

Өнөөгийн нийгэмд өв тэгш төлөвшилтэй, хариуцлагатай ирээдүйн иргэнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх нь хүн бүрийн нийгмийн өмнө хүлээсэн чухал үүрэг болж байна. Тиймээс өсвөр үеийнхний хөгжлийг бүх талаас нь судалж, шинжлэх ухаанд суурилсан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай болжээ. Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхдүүдийн дунд сэтгэл зүйн эмгэг, харилцааны доголдол, сөрөг зан үйлийн илрэл нэмэгдэх болсон нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Өсвөр насныхны зан төлөв, харилцааны онцлог нь хувь хүний онцлог, гэр бүлийн орчин, нийгмийн оролцоо зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. НҮБ болон ДЭМБ-ын тодорхойлолтоор өсвөр нас гэдэг нь хүүхэд ахуй нас ба залуу насны хоорондох шилжилтийн үе шат бөгөөд 11–19 насны хүүхдүүдийг хамардаг. Харин БНСУ-ын Хүүхэд хамгааллын хуульд 9–24 насны хүмүүсийг өсвөр насны ангилалд багтаасан байдаг (Juveniles, 2017).

Хүний хөгжлийн сэтгэл зүйн талаас Horlock (12–21 нас), боловсролын талаас E.L.Thorndike (14–18 нас), анагаах ухааны талаас Kohl (15–24 нас) өсвөр насны үе шатыг өөр өөрөөр тодорхойлжээ (Kun he sun, 2013:17). Дэлхий даяар 10–24 насны 1.8 тэрбум хүн амьдарч байгаа бол манай улсад энэ насныхан 2016 оны байдлаар нийт хүн амын 22.9 хувийг эзэлж байна (WHO, 2009). Өсвөр нас бол өөрийн үзэл бодол тогтож, «би хэн бэ» гэдэг асуултад хариулт эрж, өөрийгөө таних, төлөвшүүлэх онцгой үе шат юм. Үе тэнгийн харилцаа, мэргэжил сонголт, нэр хүндтэй болох, ирээдүйн амьдралаа төлөвлөх зэрэг олон чухал нийгмийн үүрэг энэ үед ногддог.

Швейцарийн сэтгэл зүйч Жан Пиаже (1896–1980) хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онолоо үе тэнгийн харилцааг чухалчлан авч үзсэн. Үе тэнгийнхэнтэй харилцах нь хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлдэг гэж үзсэн бөгөөд тэдний

харилцан үйлчлэл нь эрх мэдлийн ялгаа багатай, харилцан ойлголцол, ойлголтыг хуваалцах замаар логик сэтгэлгээг хөгжүүлэхэд тусалдаг гэж тодорхойлсон.

Үе тэнгийнхэн гэдэг нь ижил насны болон сонирхол, үзэл бодлоороо ойролцоо хүмүүсийг хэлнэ. Өсвөр насныхны хувьд үе тэнгийнхэн нь:

- Нийгмийн харилцааны суурь – Найз нөхөдтэй харилцах нь бие даах, өөрийгөө нээх, нийгмийн ур чадвараа хөгжүүлэхэд тусалдаг.
- Идэвхтэй суралцах орчин – Тэд бие биенээсээ суралцаж, мэдээлэл, туршлага солилцдог.
- Сэтгэл санааны дэмжлэг – Гэр бүлээс гадна ойлголцож, сэтгэл санаагаа хуваалцдаг чухал хүмүүс нь үе тэнгийнхэн байдаг.

Өсвөр насныхан үе тэнгийнхэнтэйгээ илүү их цагийг өнгөрүүлж, насанд хүрэгчдийн хяналт харьцангуй багасдаг. Үе тэнгийнхний хүлээлт, үзэл бодлыг илүү чухалчлан үзэх хандлагатай болдог. Зарим нөхцөлд үе тэнгийнхэн өсвөр насныхны хандлага, үйл ажиллагаа, сэтгэл зүйн сайн сайхан байдалд насанд хүрэгчдийн адил, зарим тохиолдолд түүнээс ч илүү нөлөөлдөг.

Өсвөр насныхны үе тэнгийн харилцааны онцлог Өсвөр насны хүүхдүүдийн үе тэнгийнхэнтэйгээ харилцах байдал нь дараах онцлогтой:

- **Найз нөхөрлөл:** Найз нөхдийн хүрээ өргөжиж, найзын үнэнч байдал, хамтдаа байх нь чухал болдог. Нийтлэг сонирхол, ижил хүсэл мөрөөдөлтэй хүүхдүүдийн хамтын үйл ажиллагаа.
- **Бүлэглэл, нөлөөлөл:** Өсвөр насныхан заримдаа тодорхой бүлгүүдэд нэгдэж, тэдгээр бүлгийн соёл, үнэт зүйлсийг дагадаг. Үе тэнгийн дарамт ихэвчлэн энэ үед илэрдэг. Эерэг (спорт, сургалтын чиглэлд дэмжих) Сөрөг (муу зуршилд уруу татах) байдлаар нөлөөлж болно.
- **Харилцааны хэв маяг:** Харилцааны суваг улам бүр олон төрөл болж (сошиал медиа, чат, видео дуудлага гэх мэт), шууд бус харилцаа ихэсдэг. Өсвөр насныхан заримдаа сэтгэл хөдлөлөө хянахад хүндрэлтэй байдаг тул маргаан, үл ойлголцол гарах нь элбэг тохиолдог.

Эрик Эриксон (Erik Erikson) – Нийгмийн хөгжлийн онол: Үе тэнгийн харилцаа нь өсвөр насныханд өөрсдийгөө таньж мэдэх, бусадтай харьцаж, үнэт зүйлсээ тодорхойлох боломжийг олгодог. Энэ харилцаа нь хүүхдэд өөрийгөө таних, хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг бий болгох үндэс болдог.

- Хүүхэд насанд (6-12 нас) үе тэнгийнхэнтэйгээ харилцах нь өөртөө итгэх итгэл,

ажилч хичээнгүй байдал болон багийн ажиллагааг хөгжүүлэхэд тусалдаг.

- Өсвөр насанд (12-18 нас) үе тэнгийн бүлэг нь өөрийн “би”- гийн дүр төрхийг олоход голлох үүрэг гүйцэтгэдэг бөгөөд нийгмийн харилцааны ур чадвар, зан төлөв төлөвшдөг.

“Нийгмийн бүтцийн онол” нь өсвөр насныхан болон хүүхдүүдийн сэтгэл зүй, хэм хэмжээг үе тэнгийн харилцаагаар дамжуулан суралцахад онцгой ач холбогдолтойг онцолдог. Өсвөр насныхны хувьд үе тэнгийнхэн нь зөвхөн найз нөхдийн хүрээлэл төдийгүй нийгэмшлийн гол талбар болж өгдөг. Энэ үед тэд бие даах, өөрийгөө нээх, бусадтай харилцах, хүлээн зөвшөөрөгдөх зэрэг хөгжлийн чухал үе шатыг туулдаг. Үе тэнгийнхэн нь тэдний хувьд нийгмийн харилцааны суурь болохын зэрэгцээ сэтгэл санааны дэмжлэг, мэдлэг, туршлага солилцох идэвхтэй орчин болж өгдөг. Үе тэнгийн харилцаа нь хүүхэд, өсвөр насныхны хөгжлийн салшгүй хэсэг боловч энэхүү харилцааны дунд *дарамт*, *дээрэлхэлт* зэрэг сөрөг үйлдэл үүсэх нөхцөл бүрддэг.

Гэсэн хэдий ч үе тэнгийн харилцаа нь зөвхөн эерэг нөлөөтэй байгаад зогсохгүй зарим тохиолдолд сөрөг үр дагавар дагуулдаг. Үүн дотроос хамгийн түгээмэл бөгөөд ноцтой нөлөөтэй сөрөг тал нь **үе тэнгийн дарамт, дээрэлхэлт** юм. Энэ нь хүүхдүүд болон өсвөр насныхны харилцаанд хүч тэнцвэргүй байдал, сэтгэл санааны болон бие махбодийн хор хохирол авчрах түрэмгий үйлдлээр илэрдэг.

АНУ-ын Сэтгэл зүйн үндэсний ассоциацийн тодорхойлсноор дарамт, дээрэлхэлт гэдэг нь нэг хүн нөгөөдөө зориуд, давтамжтайгаар, сөрөг байдлаар нөлөөлөх үйлдэл бөгөөд энэ нь хэл ярианы, бие махбодийн, сэтгэл зүйн болон нийгмийн байдлаар илэрч болно. Монгол Улсын эрүүгийн хуулийн хүрээнд ч “танхайрах” гэдэг зүйл ангиар энэхүү сөрөг үйлдлийг хуульчлан тодорхойлсон байдаг.

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт нь өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл зүй, зан төлөв, нийгмийн харилцаанд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийллийн нэг хэлбэр юм. Энэхүү үзэгдлийг олон улсын судлаачид нийгэм, сэтгэл зүй, боловсролын шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судалсаар ирсэн бөгөөд дараах онолуудтай холбон тайлбарлаж байна:

Альберт Бандурагийн нийгмийн суралцах онолд хүмүүс орчны зан үйлийг ажиглан дуурайж, суралцдаг гэж үздэг. Үе тэнгийн бүлгийн дунд хүч хэрэглэж, түрэмгий байдал гаргаж буй сурагчид энэ төрлийн зан авирыг өмнө нь өөр бусдаас (гэр бүл, кино, найз нөхөд гэх мэт) ажиглан хүлээн авсан байдаг. Үүний үр дүнд

дээрэлхэх зан авир нь хэвийн үзэгдэл мэт ойлгогдож, давтамжтай, зорилготойгоор илэрч байна. **Нийгмийн бүтэц, эрх мэдлийн онолоор** хүмүүсийн хоорондын харилцаа нь хүчний тэнцвэргүй байдал дээр суурилдаг бөгөөд илүү давамгайл байр суурьтай этгээд өөрийгөө бусдаас дээгүүр байрлуулах зорилгоор түрэмгий үйлдэл гаргадаг гэж үздэг. Үе тэнгийн дарамт нь эрх мэдэл, нөлөөллийн хяналтыг тогтоох хэрэгсэл болж, сул дорой, итгэлгүй нэгнээ хүчирхийлдэг зан авирын хэлбэр юм.

Өсвөр насныхны сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сул байх нь сөрөг зан авир илрэх гол шалтгаануудын нэг болдог. Дээрэлхэгч хүүхдүүд ихэвчлэн уур бухимдлаа зохицуулж чаддаггүй, сэтгэл хөдлөлийн мэдрэмж багатай байдаг бол хохирогч хүүхдүүд өөрийгөө хамгаалж, эсэргүүцэх чадвар дутмаг байдаг. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт нь зөвхөн хувь хүний сэтгэл зүйн асуудал биш бөгөөд орчин, гэр бүл, нийгмийн бүтэц, соёл, суралцах орчин, сэтгэл хөдлөлийн боловсрол зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөн дор бүрэлдэн тогтдог нийгэм-сэтгэл зүйн цогц үзэгдэл юм.

Эрик Эриксоны нийгмийн хөгжлийн онолоор бол өсвөр үе бол өөрийн “би”-гийн дүр төрхийг бүрдүүлэх, үнэт зүйлсээ тодорхойлох чухал үе юм. Гэвч үе тэнгийнхний зүгээс ирэх дарамт нь өөрийгөө илэрхийлэх, хүлээн зөвшөөрөгдөх гэсэн суурь хэрэгцээг үгүйсгэж, сэтгэл зүйн гэмтэл, айдас, ганцаардал, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурахад хүргэдэг.

Дарамт, дээрэлхэлтийн онцлог шинжүүд нь:

- Давтамжтайгаар үйлдэгддэг;
- Түрэмгийлэгч ба хохирогчийн хооронд хүч тэнцвэргүй байдаг;
- Хохирогчийн хувьд өөрийгөө хамгаалах боломж хязгаарлагдмал байдаг;
- Зориудын, санаатай үйлдэл байдаг;
- Сэтгэл зүйн болон бие махбодийн хор хохирол учруулдаг.

Иймд үе тэнгийн харилцаа нь өсвөр үеийнхэнд хөгжил дэвшлийн түлхүүр байхаас гадна, зохицуулалт, хяналт, дэмжлэггүй нөхцөлд сэтгэл зүйн ноцтой хор хохирол учруулж болзошгүй эрсдэлтэй талбар болдог. Ийм нөхцөлд эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчид, сэтгэл зүйчдийн оролцоо чухал бөгөөд эерэг харилцаа, зөв дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх хэрэгтэй юм.

Дээрэлхэлт гэдэг нь мэдээж нь дарамт, дээрэлхэлтийг хийж байгаа гэмт буруутан хувь хүн, бүлэг этгээдийн зүгээс хэн нэгэнд хор учруулах үйлдэл юм. Энэ



үйлдэлд айлган сүрдүүлж байгаа дээрэлхэгч, хохирогч, хөндлөнгийн ажиглагч, асран хамгаалагч, эцэг эх, насанд хүрэгчид гээд олон хүмүүс оролцдог. Үе тэнгийхний хооронд дарамт дээрэлхэлт хэмээн үзхэд хэцүү ноцтой хүчирхийлэл их үүсдэг, хүчирхийлэлийн суурь дэвсгэр нь дарамт дээрэлхэлт байх нөхцөл олонтаа учраас эдгээрийг хооронд нь ялгахад амар биш байна. Барууны улс орнуудад эдгээр ойлголт нь харилцан адилгүй агуулгатай хэрэглэгддэг бөгөөд буу зэвсэг ашиглах, аллага гэх мэтийг ноцтой хохирол учруулсан, бие махбодид физик хүчээр үйлдсэн үйлдлийг хүчирхийлэлд (Bloomquist & Schnell, 2002; McCabe & Martin, 2005) багтаан үзэх нь нийтлэг байна.

Farrington (1993)-ийн үзсэнээр дарамт дээрэлхэлт нь далд байдлаар хүчирхийлдэг дээрэлхэгч ба далд байдлаар хүчирхийлэлд өртдөг хохирогчийн хооронд бий болдог, хоорондоо хүчтэй хамааралтай үйлдэл юм. Иймээс сургуулийн орчин дахь хүчирхийлэл нь дарамт дээрэлхэлтийг багтаасан илүү өргөн хүрээний ойлголт хэмээн үзэж болно. (Kim, 2013; Farrington, 1993; McCabe & Martin, 2005).

Хүчирхийлэлийг бий болгох гол суурь дарамт дээрэлхэлт юм. Дээр дурьдсанчлан өсвөр насныханы бие махбодь, сэтгэл санаанд нөлөөлж улмаар хувь хүний асуудалаасаа даван хальж нийгэмд хор уршигтай асуудал болон гүнзгийрнэ. Бусад хүүхдүүдэд муугаар нөлөөлөх, хүүхдийн зан төрх өөрчлөгдөх, түрэмгий болох эсвэл эсэргээрээ дуугай ноомой, бусдыг үл хүндэтгэсэн хүйтэн харилцаатай болон төлөвших нөхцлийг бүрдүүлнэ. Бусдыг дарамтлан дээрэлхэх, гадуурхах зан төрх нь сургуулийн өмнөх наснаас эхлэж, өсвөр насандаа лавширсаар бүрмөсөн арилдаггүй (Kim Storey, 2013).

Өсвөр насныхны дарамт бол сэтгэл санааны болоод бие махбодийн хүчирхийллийн нэг хэлбэр бөгөөд доорх гурван шинжтэй. Үүнд :

- Санаатай буюу хэн нэгнийг дээрэлхэж доромжлох сэдэлтэй.
- Давтамжтай буюу ихэвчлэн нэг хүүхдийг байнга дээрэлхэх
- Хүчний тэнцвэргүй буюу эмзэг дорой хүмүүсийг дээрэлхэх байдлаар илэрч байдаг.

10-аас 12 дугаар ангийн сурагчид буюу 15-18 нас хүртэлх 100 өсвөр насны хүүхдүүд оролцсон. Уг судалгааны түүвэрт өсвөр насны дунд үе буюу насанд хүрэх үерүү нилээн ойртсон учир сонгож авсан. Энэхүү нас нь өсвөр насны хөгжил идэвхтэй явагдсан байдаг. Судлагаандаа өсвөр насны дунд үеийнхэнийг сонгож авсан нь нийгэмд гарах өөрчлөлт илүү үр нөлөөтэй гэж үзсэн.

Судалгаа авах хугацаа 30-45 минут үргэлжилсэн бөгөөд Асуулга , Үе тэнгийхний дээрэлхэх хандлагыг тодорхойлох иллинойсын хэмжүүр , Сэтгэл хөдлөл зан үйлийн бэрхшээлийг судлах аргачлал (**strengths and difficulties questionnaire**) Өөрийн үнэлгээний түвшинг тодорхойлох сорил (С.В.КОВАЛЁВ) авч ашигласан болно .


Уг судалгааг авхад хүний нэр болон хувийн мэдээлэлд халдаагүй бөгөөд тус судалгаанд хамрагдагсад сайн дурын үндсэн дээр оролцсон болно.

/Зураг1. Судалганд оролцогчдын хүйс/



Уг судалгаанд эрэгтэй 50 эмэгтэй 50 хүн оролцсон.


/Зураг 2. / Судалгаанд оролцогчдын дээрэлхэх хандлагыг тодорхойлох ерөнхий үр дүн/



Нийт судалгаанд оролцогчдын бие махбодийн хохирол үзүүлэх байдал гэсэн асуултанд 3% нь ихэвчлэн гэж хариулсан бөгөөд заримдаа гэж хариулсан 36 % , огт байгаагүй гэж хариулсан 58 % байна. Харин дээрэлхэх байдал гэсэн асуултанд 6% ихэвчлэн , заримдаа 38% , огт байгаагүй 56 % байна. Дээрэлхүүлэх явдал 14 % нь ихэвчлэн , 60% заримдаа , 25% нь огт байгаагүй гэж хариулсан байна. Үүнээс харахад харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд өсвөр насны дунд үеийнхэнд


дээрэлхүүлэлт түгээмэл илэрч байгааг харуулж байна. Өсвөр насныхны дунд дээрэлхэхээс илүү дээрэлхүүлдэг хандлага түгээмэл боловч дээрэлхэх хандлага ч мөн анхаарах түвшинд байна.

/Зураг 3. / Судалгаанд оролцогчдын өөрийн үнэлэмж сорилын тодорхойлох ерөнхий үр дүн/



Үүнээс харахад нийт өөрийн үнэлэмж сорилд оролцогчдын 11% нь өөрийн үнэлэмж дээгүүр, өөрийн үнэлэмж дунд зэрэг нь 15%, өөрийн үнэлэмж доогуур 74 % байна. Нийт оролцогчдын өөрийн үнэлэмж доогуур байгаа нь өсвөр үеийнхний хувьд их байх харагдаж байна. Энэ нь өсвөр насныханы хувьд өөрийгөө батлаж харуулах хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээ хангалтгүй байгааг харуулж байна. Өөрийн үнэлэмж доогуур байх нь түрэмгий зан, сөрөг харилцааны үндэс болж байна.


/Зураг 4. / Судалгаанд оролцогчдын сэтгэл хөдлөл ба зан үйлийн бэхрхээлийг судлах сорилыг тодорхойлох ерөнхий үр дүн/



Үе тэнгийхний нийцэрхэг байдал 5 % өндөр, 21% дунд, 73% хэвийн гэж гарсан. Үе тэнгийн харилцааны илрэл дээр 41% өндөр, 54 % дунд, 5 % хэвийн байна. Хэт хөдөлгөөнтөх илрэл 27 % өндөр, 16 % дунд, 57 % хэвийн. Зан үйлийн

илрэл дээр 37% өндөр , 19% дунд, 44 % хэвийн байна. Сэтгэл хөдлөлийн илрэл 20% өндөр , 14 % дунд , 65 % хэвийн гарсан . Уг судалгаанд оролцогсдын зан үйлийн илрэл, үе тэнгийн харилцааны хүндрэл, хэт хөдөлгөөнтөх байдал зэрэг нь дунд болон өндөр түвшинд байна.Эдгээр үзүүлэлтүүд сөрөг зан үйлтэй уялдан илэрч, хүүхдийн сэтгэл зүйн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.

/Зураг 5. / Судалгаанд оролцогчдын үе тэнгийн харилцаа ба зан үйлийн бэрхшээлийг харьцуулсан судалгааны ерөнхий үр дүн/



Уг судалгаанд оролцогсдын үе тэнгийн харилцаа болон зан төлөвийн илрэл өндөр гарсан 14% байгаа бол үе тэнгийн харилцаа зан төлөвийн илрэл дунд 24% байна. Зан төлөв болон үе тэнгийн харилцаа хоорондын шууд хамаарал илэрч байна.Үе тэнгийн харилцаа нь өсвөр насныхны зан төлөвт хүчтэй нөлөө үзүүлдэг.

/Хүснэгт 1. Өөрийн үнэлэмжийг дээрэлхүүлэх хандлагатай харьцуулсан үр дүн/

Огт дээрэлхүүлж байгаагүй					Total
		Заримдаа дээрэлхүүлж байсан	Ихэвчлэн дээрэлхүүлж байсан		
Өөрийн үнэлэмж	дээгүүр	3	7	1	11
	Дунд	7	6	2	15
	доогуур	15	47	11	73
Total		25	60	14	99

Өөрийн үнэлэмжийг дээрэлхүүлэх хандлагатай харьцуулахад өөрийн үнэлэмж дээгүүр оролцогчдын дээрэлхүүлэх хандлага 1% тай байгаа бол өөрийн үнэлэмж доогуур байгаа оролцогчид 11% байна. Өөрийн үнэлэмж дээгүүр байгаа оролцогчидын 7% нь заримдаа дээрэлхүүлж байгаа бол. Өөрийн үнэлэмж доогуур байгаа оролцогчид заримдаа дээрэлхүүлэх хандлага 47% байна. Уг судалгааны үр дүнгээс хархад заримдаа дээрэлхүүлэх хандлага илүү их байгаа өөрийн үнэлэмжтэй хамааралтай байна.

/Хүснэгт 2. Өөрийн үнэлэмж дээрэлхэх явдалтай харьцуулсан судалгааны үр дүн/

Огт дээрэлхэж байгаагүй					Total
		Заримдаа дээрэлхэж байсан	Ихэвчлэн дээрэлхэж байдаг		
Өөрийн үнэлэмж	Дээгүүр	8	2	1	11
	Дунд	9	5	1	15
	доогуур	39	31	4	74
Total		56	38	6	100


Өөрийн үнэлэмж дээгүүр оролцогчид заримдаа дээрэлхэж байсан тохиолдол 2% байсан бол өөрийн доогуур байгаа оролцогчид 31% байна. Үүнээс хархад өөрийн үнэлэмж доогуур байгаа оролцогчид бусдыг дээрэлхэх хандлага ажиглагдаж байна. Үүнээс харахад өөрийн үнэлэмж доогуур байгаа оролцогчид бусдыг дээрэлхэх хандлага өндөр байгаа нь өөрсдийн хэрэгцээ шаардлага, үнэлэмж батлан харуулах хэрэгцээтэй байгаа нь ажиглагдаж байна.

/Хүснэгт 3. Өөрийн үнэлэмж бие махбодийн хохирол үзүүлэх байдалтай харьцуулсан судалгааны үр дүн/

Огт хохирол үзүүлж байгаагүй		Бие махбодын хохирол			Total
		Заримдаа хохирол үзүүлж байсан	Ихэвчлэн хохирол үзүүлдэг		
Өөрийн үнэлэмж	Дээгүүр	8	2	1	11
	Дунд	12	1	2	15
	доогуур	38	33	3	74
Total		58	36	6	100


Өөрийн үнэлэмж дээгүүр оролцогчид заримдаа хохирол үзүүлж байсан 2% бол өөрийн үнэлэмж доогуур байсан оролцогчид заримдаа бие махбодын хохирол үзүүлэх нь 33% байна. Өөрийн үнэлэмж доогуур байгаа сурагчид дээрэлхэх, дээрэлхүүлэх, бие махбодод хор учруулах хандлага өндөртэй байна. Өөрийгөө доогуур үнэлэх нь сөрөг харилцааны зан үйлийн суурь болдог.

/Зураг 6. / Судалгаанд оролцочдын хүйсийн ангилалаар дээрэлхүүлэх явдалд өртөж байгааг харьцуулсан судалгааны ерөнхий үр дүн/




Хүйсийн байдлаар дээрэлхүүлэх явдалд өртөж байгаа эсэх судалгааны үр дүнд заримдаа дээрэлхүүлэх явдалд 34% нь эмэгтэйчүүд байсан бол эрэгтэйчүүд 26 % байна. Харин дээрэлхүүлж байдаг гэсэн тохиолдолд эрэгтэйчүүд 9% , эмэгтэйчүүд 5 % байна. Огт дээрэлхүүлж байгаагүй 14% эрэгтэй байсан бол эмэгтэйчүүд 11% нь дээрэлхүүлэлтэнд өртөж байгаагүй байна. Уг судалгааны үр дүнгээс хархад эмэгтэйчүүд дээрэлхэлтэнд их өртдөг байна.

/Зураг 7. / Судалгаанд оролцочдын хүйсийн ангилалаар нь дээрэлхэх явдалыг харьцуулсан судалгааны ерөнхий үр дүн/



Хүйсийн байдлаар эрэгтэйчүүдийн ихэвчлэн дээрэлхэж байдаг гэсэн 4% гарсан бол эмэгтэйчүүд 2% байна. Харин заримдаа дээрэлхэж байсан 21% нь эмэгтэй байгаа бөгөөд эрэгтэй 17% байна . Огт дээрэлхэж байгаагүй 27% эмэгтэй бол эрэгтэй 17% байна

/Зураг 8. / Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилалаар нь бие махбодын хохирол амсах явдалыг харьцуулсан судалгааны ерөнхий үр дүн/



Бие махбодын хохирол огт амсаж байгаагүй 29% эрэгтэй мөн 29 % эмэгтэй байна . Хааяа бие махбодын хохирол өртөж байсан 15% эрэгтэй бол үүнээс илүү 21% нь эмэгтэй байна. Ихэнхдээ хохиролд өртдөг 2% эмэгтэй байдаг бол эрэгтэй 6% байна. Эмэгтэй хүүхдүүдийн дээрэлхэлтэд өртөх хувь харьцангуй өндөр байна. Эрэгтэй хүүхдүүдийн бие махбодын хүч хэрэглэдэг хувь өндөр гарсан. Хүйсийн ялгаатай байдлаар дээрэлхэлт болон хүч хэрэглэдэг хэлбэрүүдийн илрэл өөр байна.

/Хүснэгт 4. Өөрийн үнэлэмжийг бусдад хүч хэрэглэж байсан эсэх талаар харьцуулсан судалгааны үр дүн/

үгүй		Бусдад хүч хэрэглэж байсан уу?			Total
		тийм	заримдаа		
Өөрийн үнэлэмж	Дээгүүр	8	1	2	11
	Дунд	10	3	2	15
	Доогуур	45	15	14	74
Total		63	19	18	100

Өөрийн үнэлэмж дээгүүр оролцогчид бусдад хүч хэрэглэж байгаагүй 8% харин өөрийн үнэлэмж доогуур оролцогчид бусдад хүч хэрэглэж байсан тохиолдол 15% байсан бол өөрийн үнэлэмж дээгүүр байгаа оролцогчид 1% нь бусдад хүч хэрэглэсэн гэж гарсан байна. Өөрийн үнэлэмж доогуур сурагчид бусдад хүч хэрэглэх хандлагатай байна.Түрэмгий зан авирын суурь шалтгаанд өөрийгөө үнэлэх түвшин нөлөөлдөг.

/Хүснэгт 5. Өөрийн үнэлэмжийг болон үе тэнгийн харилцаа харьцуулсан судалгааны үр дүн/

		Хэвийн	дунд	өндөр	Total
Өөрийн үнэлэмж	Дээгүүр	1	6	4	11
	Дунд	3	8	4	15
	Доогуур	1	40	33	74
Total		5	54	41	100

Өөрийн үнэлэмж дээгүүр оролцогч 1% нь хэвийн байсан бол өөрийн үнэлэмж доогуур оролцогчдын үе тэнгийн харилцаа өндөр байсан нь 33% байна . Мөн өөрийн үнэлэмж доогуур оролцогчид үе тэнгийхний харилцаа дунд зэрэг байгаа 40% . Өөрийн үнэлэмж нь бусадтай харилцах харилцаанд нөлөөлдөг байна.

/Хүснэгт 6. Өөрийн үнэлэмжийг эцэг эхийн хоорондын харилцаатай харьцуулсан судалгааны үр дүн/

сайн		Эцэг эхийн хоорондын харилцаа			Total
		муу	заримдаа		
Өөрийн үнэлэмж	дээгүүр	4	0	7	11
	дунд	10	1	4	15
	доогуур	45	7	22	74
Total		59	8	33	100

Уг судалгааны үр дүнд өөрийн үнэлэмж доогуур байгаа оролцогчдын эцэг эхийн харилцаа сайн 45% байгаа бол өөрийн үнэлэмж дээгүүр байгаа оролцогчдын эцэг эхийн харилцаа сайн 4% байна. Эцэг эх хоорондын харилцаа сайн байгаа хэдий ч хүүхдийн өөрийн үнэлэмж доогуур байгаа нь эцэг эхийн харилцаанаас гадна бусад хүчин зүйлс нөлөөлдөг байна. Гэр бүлийн харилцаа нь өөрийн үнэлэмжид нөлөөлөх ч, цогц дэмжлэг (сэтгэл зүй, үе тэнгийн орчин г.м.) байхгүй бол хангалтгүй.

/Хүснэгт 7. Дээрэлхэх хандлагыг өсвөр насны хүүхдүүд эцэг эхтэйгээ ярилцдаг байдалыг харьцуулсан судалгааны үр дүн/

Дээрэлхэж байгаагүй					Total
		Дээрэлхэх явдал хааяа дээрэлхэж байсан	Дээрэлхэх хандлага өндөр		
Эцэг эхтэйгээ ярилцдаг уу	Үгүй	5	6	3	14
	Тийм	29	11	3	43
	заримдаа	22	21	0	43
Total		56	38	6	100

Судалгааны үр дүнгээс эцэг эхтэйгээ ярилцдаг хүүхдүүдийн дээрэлхэж байгаагүй нь 29% байна . Эцэг эхтэйгээ ярилцдаггүй гэж хариулсан 5% нь огт дээрэлхэж байгаагүй . Харин эцэг эхтэйгээ заримдаа ярилцдаг гэж хариулсан оролцогчид хааяа дээрэлхэх хандлага 21% байна. Үүнээс үзэхэд эцэг эхтэйгээ ярилцдаггүй хүүхдүүд бусдыг дээрэлхэж байсан хандлага өндөр ажиглагдаж байна. Эцэг эхтэй нээлттэй харилцдаг хүүхдүүд дээрэлхэх хандлага багатай. Гэр бүлийн дотоод харилцаа хүүхдийн харилцааны хэв маягт чухал нөлөөтэй.

ДҮГНЭЛТ

Эцэг эхийн харилцаа хүйтэн хөндий байх тусам хүүхдийг түрэмгий болгож улмаар эрсдэлт зан үйл үүсч нийгмийн харилцаанд оролцоход хүндрэлтэй болгож байна. Мөн эцэг эхтэйгээ таагүй байх харилцаа нь хүүхдийн өөрийн үнэлэмжид сөрөг байдлаар нөлөөлж энэ нь цаашлаад үе тэнгийхний хоорондын харилцаанд үл ойлголцол учруулж байна. Үе хоорондын харилцаанд өөрийн ойлгогдох хүсэл түүнийг эерэг байдлаар илэрхийлж чадахгүй байх нь үе тэнгийхний дарамт дээрэлхэлт болон эрсдэлт зан үйл үүсэх шалтгаан болж байна.

Энэхүү судалгаагаар өсвөр хүүхдүүдийн түрэмгийлэлийн онцлогыг эрсдэлт зан үйлтэй нь холбон судлахыг зорьсон.

1. Дээрх судалгааны үр дүнгээс хархад өсвөр насны хүүхдүүдийн дийлэнх хувь нь өөрийн үнэлэмж доогуур байна. Бусдыг дээрэлхэх болон дээрэлхүүлэх явдалд өртөх нь өөрийн үнэлэмжтэй хамааралтай гэж гарч байна.
2. Бусдыг дээрэлхэх болон дээрэлхүүлэх явдалд эмэгтэй хүүхдүүд их өртөж байгаа нь эцэг эхчүүдийн хүүхдээ сурган хүмүүжүүлэх байдалд эрэгтэй хүүхдүүдэд хүч хэрэглэж болохгүй гэж хэлдэг уламжлалт сэтгэлгээ нөлөөлж байгаа нь харагдаж байна. Харин эмэгтэй хүүхдүүдэд энэхүү талаар бага хэлдэг нь бусдыг түрэмгийлэх онцлогт хүргэж байх магадлалтай.
3. Эцэг эхчүүдийн хоорондын харилцаа сайн байгаа хэдий ч өсвөр насны хүүхдүүдийн өөрийн үнэлэмж доогуур байгаа нь үе тэнгийхний хоорондын харилцаа болон бусад хүчин зүйлс нөлөөлж байгаа нь үе тэнгийхний нийтлэг сөрөг байдлаар илэрч улмаар өөрийн хүсэл сонирхол , ойлгогдох хэрэгцээг буруугаар илэрхийлж байна.
4. Эцэг эхтэйгээ нээлттэй харилцаа нь үе тэнгийнхэнтэйгээ харилцахад

харилцаанд эерэг нөлөөлж байна. Харин эсрэгээрээ эцэг эхийн хүйтэн хөндий байдал нь үе тэнгийн дээрэлхэлтийн байдалд нөлөөлж . Өөрийн түрэмгий байдлаар илэрхийлэх нь үе тэнгийхний харилцааны сөрөг байдалд хүргэж байна.

Энэ бүхэнээс дүгнэж үзэхэд хүүхдийн түрэмгий байдалд эцэг эхийн харилцаа хандлага нөлөөлдөг ба өөрийн үнэлэмж доогуур байгаа нь өсвөр насны хэрэгцээ шаардлага өөрийгөө батлан харуулах хүсэл эрмэлзэл их байна гэсэн миний таамаглал ерөнхий байдлаар батлагдаж байна.

Иймээс эцэг эх өсвөр насны хүүхдүүдийн харилцаа цаашид судлах шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Жеймс Добсон. (2013). “Өсвөр насныхны мансууруулах бодисын хэрэглээ”
2. Maccoby, E. (1984) “Child Development”
3. Santrock, J.W. (1997). Psychology (5th Ed.)
4. David R.Shaffer. (2005). “Development psychology”
5. Allen, L., & Santrock, J.W. (1993). “Psychology”
6. Т.Энхбаяр (2013) “Өсвөр насны хүүхдийн девиант зан байдал ба эцэг эхийн харилцаа хандлага” (2015)
7. (Malchiodi, 2006)
8. Jess Feist. Gregory J.Feist., (2008)
9. Peter D, Spear. (1988). “Psychology perspectives on behavior”
10. Michael, L. Steven V,S. (2002) “Helping Children with Aggression and Conduct Problems”

НИЙГМИЙН АЖЛЫН ТЭНХИМ



Э.САРАНЦАЦРАЛ

Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын
тодорхойлолт, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх
нь

ХОРООНЫ НИЙГМИЙН АЖИЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Магистр, Э.Саранцацрал

(ОУУБИС. ХНУС)

sarantsatsral.e@ulaanbaatar.edu.mn

Abstract:

The purpose of this research is to analyze the implementation of the social worker position within the committee and to develop recommendations. Within the scope of this goal, we have studied the following objectives:

- To establish the theoretical and legal framework for social work
- To assess the implementation of the job description of social workers within the committee
- To map out the daily tasks of social workers in the committee

The research will be conducted using questionnaires, focus group interviews, sampling methods, document analysis, and quantitative and statistical processing of research results. The study focuses on managing social workers across nine district committees in the capital, encompassing a total of 54 committees. The research examines the regulation of social workers' workplaces in these districts. Issues related to work rights and violations of social workers in the committee have been addressed through legal proceedings. The findings of this research can be used to support policy improvements in this field. Social work within the executive supervision committee is a professional service and an additional function for the entire population served by the organizing committee. However, due to the multi-tasking nature of these responsibilities, there has been a decline in the social welfare system of the social security committee, as well as an increase in unemployment among working social workers. This study incorporates large-scale focus group interviews and monitoring of social workers in the committee. The aim is to improve the job description of social workers, enhance economic opportunities, and establish independent legal frameworks for social work.

Түлхүүр үг: Нийгмийн ажил, хороо, албан тушаал, чиг үүрэг

ҮНДЭСЛЭЛ

Монгол улс 2001 оноос Улаанбаатар хотын нийт хороодод хүүхэд, гэр бүлтэй ажиллах боловсон хүчнийг анхан шатанд бий болгох зорилгоор тухайн үеийн хорооны зохион байгуулагчийн орон тоог нийгмийн ажилтан гэж нэрлэж ажиллуулахаар болсон байдаг.¹⁴

2020 оноос хойш Монгол гэлтгүй дэлхий нийтээрээ сэтгэл зүйн болон эдийн засгийн хямралд өртөж байна. Үүнээс үүдэн нийгмийн асуудлууд, сөрөг үр дагаврууд гарч байна. Ажилгүйдэл, ядуурал, стресс уур бухимдал, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үе тэнгийнхний дээрэлхэлд гэх мэт бүх бүлгийн асуудал руу ханцуй шамлан ажилладаг хүн бол нийгмийн ажилтнууд билээ. Хорооны нийгмийн ажилтан тухайн хороонд оршин суудаг бүх насны хүмүүстэй болон зорилтот бүлгийнхэнтэй ажилладаг учраас бусад салбарын нийгмийн ажилтнуудаас илүү ачаалалтай байдаг.

Аливаа хууль тогтоомж, шийдвэрийг дээд шатны байгууллагууд гаргадаг ч хэрэгжилтийг хангадаг хүн бол хорооны нийгмийн ажилтнууд юм.

Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын зорилго нь: Нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд залуучууд, гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, холбогдох хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгаа хийх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хорооны Засаг даргад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хүлээнэ.¹⁵

Нийгмийн ажлын бусад салбаруудын хувьд өөрийн зорилтот бүлэгтэй ажиллах арга зүйтэй байдаг бол хорооны нийгмийн ажилтнууд нь бүх зорилтот бүлэг болон бүх насны хүмүүстэй ажилладаг гэдэг утгаараа нийгмийн ажилтнаас тэвчээр, ур чадварыг шаарддаг. Нийгмийн ажилтны үндсэн үүрэг нь хамтарсан багт ажиллах, үйлчлүүлэгчдэдээ мэргэжлийн үйлчилгээг хүргэх юм. Хорооны нийгмийн ажилтнууд албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй нэмэлт чиг үүргийн ажлыг давхар хийж гүйцэтгэж байна.

Ажлын ачаалал, стрессээс үүдэн хорооны нийгмийн ажилтнуудын дунд ажлаас халшрах хам шинж илэрч байна. Тиймээс хорооны нийгмийн ажилтны ажлын ачаалал албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтийг судлах хэрэгцээ шаардлага байна.

¹⁴ Нийгмийн ажил цуврал сэтгүүл

¹⁵ Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 5дугаар сарын 13-ны өдрийн 187 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

Судалгааны зорилго

Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх.

Судалгааны зорилт

- Нийгмийн ажлын талаарх онол, хууль эрх зүйн орчинг судлах
- Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийн хэрэгжилтийг судлах
- Хорооны нийгмийн ажилтны өдөр тутмын ажлыг ажиглан зураглал гаргах

Судалгааны таамаглал

Хорооны нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээний чанарт нэмэлт чиг үүргүүд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Судалгааны арга зүй

Хорооны нийгмийн ажилтнуудаас чанарын судалгаа авч судалгаанд үндэслэн баримт бичиг, эх сурвалжид анализ хийх, харьцуулах.

Судлагдсан байдал

- Нийслэлийн хорооны нийгмийн ажлын өнөөгийн байдал (Save the Children 2007он)

Хорооны халамжийн нийгмийн ажилтны үүргийг ажлын ачаалал ажиллаж буй нөхцөл байдлыг улсын хэмжээнд судалсан байна.

- Төсвийн зарим байгууллагын нийгмийн ажилтнуудын ажлын туршлага, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа (ГБХЗХГ- сургалт судалгааны мэдээллийн төв 2018 он)
- Хорооны нийгмийн ажилтнуудын хөдөлмөрийн сэтгэл ханамж (ШУТИС Бизнес Удирдлага Хүмүүнлэгийн Сургууль дипломын ажил Б. Мөнх-эрдэнэ 2016 он)

Энэхүү дипломын ажил нь хорооны нийгмийн ажилтны ажлын байрны нөхцөл, сэтгэл ханамжийн байдлыг судалсан. Нийт 4 дүүргийн 50 нийгмийн ажилтныг хамруулжээ.

- Ажлын ачаалал тодорхойлох судалгаа, Баянзүрх дүүргийн хорооны нийгмийн ажилтнуудын жишээ нь дээр (Д. Бурмаа 2022 он)

Баянзүрх дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д. Бурмаа (Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг Баянзүрх дүүргийн 43 хорооны нийгмийн ажилтнуудын жишээн дээр судалж гаргасан)

- Хорооны (Хөгжлийн) Нийгмийн ажилтан, Н. Нямдорж доктор 2022 он



Нийгмийн ажилтнуудын ажлын байрны өнөөгийн нөхцөл байдал, сэтгэл ханамж зэргийг судалжээ.

Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн тэгш байдал, үнэн шударгын зарчмууд нийгмийн ажлын үндэс суурь болж өгч байдаг. Нийгмийн ажлын янз бүрийн хэлбэрт хүмүүс орчинтойгоо харьцах олон талын цогц харилцаа, холбоо багтдаг. Нийгмийн ажлын үндсэн зорилго нь бүх хүмүүсийг хүчин чадавхаа бүрэн дайчлан өөрийгөө хөгжүүлэх, аж амьдралаа дээшлүүлэх, буруу үйлдлээс сэргийлэх чадварт сургахад оршино.

Монгол улсад сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хууль эрх зүйн шинэчлэлүүд хийгдэж байгаа билээ. Эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах нь нийгмийн ажилтны үндсэн үүрэг билээ. Нийгмийн ажилтан нь хүүхэд, гэр бүлийг хүчирхийлэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эрт шатанд илрүүлэн эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүй нийгмийн халамж, хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үүргүүдийг хүлээдэг байна.

Хорооны нийгмийн ажилтан нь хамтарсан багийн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ үзүүлэх хуулиар олгогдсон эрх бүхий цөөн мэргэжилтнүүдийн нэг юм.

Хорооны нийгмийн ажилтан нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүд, эмэгтэйчүүд, ажилгүйчүүд, өрх гэр бүл, тусламж дэмжлэг шаардлагатай хорооны бүх иргэдэд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 28.9.6-т ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах¹⁶ гэж заасан байгаа боловч бодит байдал дээр эдгээр эрхүүдийг нийгмийн ажилтнууд эдэлж чадахгүй байна. Хорооны нийгмийн ажилтнуудын ихэнх нь өөрийн гэсэн өрөөгүй бусад мэргэжилтнүүдтэй хамт нэг цонхонд суудаг.

Хорооны нийгмийн ажилтны үндсэн чиг үүрэг нь нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх. Нийслэлийн 9 дүүргийн 204 хорооны 30-40 хувьд нь нийгмийн ажилтангүй байна. Энэ нь хэд хэдэн шалтгаанаас болж байна. Нэгдүгээрт ажлын ачаалал их, үйлчлүүлэгчдийн харилцаа хандлага муу учраас нийгмийн ажилтнууд ажлаасаа халшран өөр хэлтэс албан тушаал руу хөрвөж байна. Хорооны нийгмийн ажилтан, зохион байгуулагч хэсгийн ахлагч нарын орон тоо ихэнхдээ сул байна. Үүнээс үүдэн 1 нийгмийн ажилтан 2 хороонд зэрэг ажиллахад хүргэж байна. Зарим үйлчлүүлэгч нар сэтгэл зүйн дарамт үзүүлж үг хэлээр доромжилдог.

Хорооны нийгмийн ажилтнууд нь олон нийтийн дунд нэр хүнд муутай, ажлын

¹⁶ Нийгмийн халамжийн тухай хууль

үр дүн гаргахад цаг хугацаа шаарддаг. Яагаад гэвэл ихэнх үйлчлүүлэгч нар нь архины хамааралтай байдаг. Кейсүүд нь хүнд байдаг, ихэнх 108 дуудлагууд нь түр оршин суугчид байдаг.

Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт: Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын зорилго: Нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд залуучууд, гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, холбогдох хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгаа хийх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хорооны Засаг даргад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.¹⁷

Энэхүү АТТ-ийг харахад нийгмийн ажилтан нь хорооны бүхий л үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах, иргэдийг идэвхжүүлэх гэх мэтээр тусгаж өгчээ. АТТ нь хэтэрхий өргөн хүрээнд хүрээнд, ерөнхий байгааг засаж сайжруулан дахин боловсруулах хэрэгцээ шаардлага байна. Хорооны нийгмийн ажилтан нь 12 төрлийн мэргэжлийн үйлчилгээг өдөр бүр үзүүлж байна. Хүүхдийн тусламжийн 108 дуудлага, цагдаагийн 102 дуудлага (Гэр бүл хүчирхийлэл), Иргэдтэй уулзах, уулзалт зөвлөгөө өгөх, мэргэжлийн ажил үйлчилгээ, Бусад албан хаагч, хэсгийн ахлагч нар арга зүйн зөвлөгөө өгөх, авах, мэдээ судалгаанд нэгтгэл, тодотгол хийх, хамтран ажиллах, Засаг даргын өгсөн үүрэг даалгавар, Нэг цэгийн төрийн үйлчилгээний чиглэлээр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, заавар зөвлөмж, ам бүлийн тодорхойлолт өгөх, Хүүхдийн тусламжийн утас 108, нийгмийн ажил үйлчилгээний программууд дээр ажиллах зөвхөн мэргэжлийн үйлчилгээгээ үзүүлбэл ажлын 5 өдөр дээрх үйлчилгээг иргэдэд өдөр бүр үзүүлж байна. Гэр эргэлт хийж айлуудаар явах болон кейс дээр ажиллах цагийг тооцож үзэхэд хүндрэлтэй. Кейсийн хүнд хөнгөнөөс шалтгаалж шийдвэрлэгдэх хугацаа өөр өөр байдаг. Жишээ нь зарим кейс 7-оос 14 хоноод хаагддаг бол хүнд кейсүүд 2-3 жил үргэлжлэх ч тохиолдол байдаг.

Нэмэлт чиг үүргийн ажил нь нийгмийн ажилтныг мэргэжлийн үйлчилгээг хүргэх цагийг багасгаж байна. ОУ-д нэг нийгмийн ажилтан стандартын дагуу 400-600 үйлчлүүлэгчтэй ажилладаг. Манай оронд стандарт байхгүй учир тус хороонд оршин суугаа хүн амд нэг нийгмийн ажилтан ажиллаж байгаа нь ачаалалыг нь 6-10 дахин нэмэгдүүлж байна. Хорооны нийгмийн ажилтнуудын ихэнх үйлчлүүлгээ авж буй иргэд нь 17 зорилтот бүлгийн иргэд байна. Зорилтот бүлгийн үйлчлүүлэгчид дандаа хавсарсан асуудалтай байдаг. (Ажиглалтын аргаар хорооны нийгмийн ажилтны ажлын үйл явцтай танилцаж тэмдэглэл хөтөлсөн үйл явц)

¹⁷ Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 5дугаар сарын 13-ны өдрийн 187 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

Судалгааны явцад анзаарагдсан нэг зүйл нь ажлын байрны тав тух муу нийгмийн ажилтан өөрийн гэсэн өрөөгүй байна. Нийгмийн ажилтныг хамгаалах хууль эрх зүйн орчингүй атлаа харьяалагдах хариуцлага тооцох хуулиуд их байна.

ДҮГНЭЛТ

Хорооны нийгмийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт хэт ерөнхий, гүйцэтгэх ажлын хүрээ өргөн байна. Практик дээр хорооны нийгмийн ажилтнууд нэмэлтээр нэмэлт чиг үүргийн ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тиймээс албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан боловсруулах хэрэгцээ шаардлага их байна.

Судалгааны дүнэлтэнд хорооны нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлыг сайжруулах ажлын ачааллыг бууруулах арга зам нь үйчлүүлэгчтэй ажиллах тусгай өрөө болон ажиллах таатай орчин нөхцөлөөр хангах, нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжлийн дагуу хэлтэст харьяалуулах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлснээр нийгмийн ажилтны ажлын ачаалал багасах боломжтой гэж үзэж байна. Мэргэжлийн бус байгаа хүмүүсийг мэргэшүүлэх, сургалтанд хамруулах хэрэгцээ шаардлага байна. Байгууллагаас төлбөртэйгөөр зохион байгуулах нь мэргэжлийн үйлчилгээг үйлчлүүлэгчид чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хорооны нийгмийн ажилтнууд нь АТТ заасан ажил үүргээс илүү нэмэлт чиг үүргийн ажлуудыг нэмэлтээр гүйцэтгэж байна. Хорооны нийгмийн ажилтнууд нь бусад салбарын нийгмийн ажилтнуудаас ялгагдах онцлог нь хүн амын бүх бүлэгтэй ажилладгаараа онцлогтой. Ажлын ачаалал их байдаг учраас хүнд зарим кейс шийдвэрлэгдэхгүй удах, санхүүжилтгүйн улмаас шийдвэрлэгдэхгүй байх гэх мэт асуудлууд байна. Ажлын ачаалалаас үүдэн нэг кейс дээр удаан ажиллаж чаддаггүй. Бүрэн шийдэгдээгүй кейсийг хурдан хугацаанд хаах зэрэг үр дүнгүй ажилууд хийгдэж байна.

Хорооны нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээний чанар, хүртээмжид нэмэлт чиг үүргүүд сөргөөр нөлөөлж байна. Судалгааны явцад ажиглалт, ярилцлага жлын ачааллаас шалтгаалан хорооны нийгмийн ажилтнуудын дунд ажлаас халширах хамж шинж ихээр илэрч байна.

Сайн дурын үйлчлүүлэгч бага байна. Сайн дурын бус үйлчлүүлэгч (нийгмийн ажилтнаар бүх асуудлаа шийдүүлнэ гэж ойлгодог) бол нийгмийн ажилтан хүний асуудлыг шийддэг хүн биш асуудлаа шийдвэрлэхэд нь тусладаг хүн. Энд

үйлчлүүлэгчийн харах өнцөг, хүлээлт хоёр зөрчилдөж байгаагаас үүдэн нийгмийн ажилтны үйлчилгээний чанарт нөлөөлж байна. Эцэст нь дүгнэхэд нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээний чанарт нэмэлт чиг үүргийн ажлууд сөргөөр нөлөөлж байна. Хорооны нийгмийн ажилтнууд нь цаг үеийн байдлаас хамаарч өдөрт 2 цаг 30 минутаас 4 цагийг мэргэжлийн бус үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулахад зарцуулж байгаа нь албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилт муу нэмэлт чиг үүргийн ажлыг давхар хийж гүйцэтгэж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Дээд шатны байгуулагуудын хамтын ажиллагааг сайжруулж хорооны нийгмийн ажилтнуудын хэрэгцээ шаардлаганд нийцүүлэн үе шаттай сургалтуудыг хийх нь үр дүнтэй гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

1. **www.1212.mn**
2. **www.ifsw.org,2014**
3. **www.legalinfo.mn**
4. **Нийгмийн халамжийн тухай хууль. УБ 2015 он**
5. **Нийгмийн ажил. Улаанбаатар хот. 2010 он**
6. **Нийгмийн ажил. Улаанбаатар. 2023он**
7. **Нямдорж.М.,(2013). Нийгмийн ажил. УБ**
8. **Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 5дугаар сарын 13-ны өдрийн 187 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт**
9. **Бүрэнжаргал, Т., (2017). Нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүй. УБ**
10. **Б. Сүхочир. Монголын Нийгмийн ажлын хөгжлийн өнөөгийн хэрэгцээ, шаардлага. ОУУБИС. Нийгмийн ажил – Гэр бүлийн хөгжил ОУЭШХ-ийн эмхэтгэл. УБ хот. 2023 он.**
11. **Нийгмийн ажил цуврал сэтгүүл. УБ хот. 2013 он.**
12. **Нийгмийн ажил цуврал сэтгүүл. УБ хот. 2018 он.**
13. **Нийгмийн ажил цуврал сэтгүүл. УБ хот. 2020 он**

СОЛОНГОС, МОНГОЛ ХЭЛНИЙ ХОЛБОХ ҮГИЙН ХЭРЭГЛЭЭНД АНАЛИЗ ХИЙХ НЬ

Магистр, С.Энхзул

(ОУУБИС. ХНУС)

enkhzul.s@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Холбох үг нь өгүүлбэр, цогцолбор, эхийн авцалдаат байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэлний механизм юм. Тус судалгаагаар солонгос хэл суралцагчдын солонгос хэлээр бичсэн цогцолборыг зөв хариулт байж болох жишиг эхтэй нь харьцуулан холбох үгийн хэрэглээнд анализ хийсэн бөгөөд энэхүү үр дүнд эх хэлний нөлөө хэрхэн нөлөөлж буйг солонгос хэл мэддэггүй суралцагчдын эх хэлээр бичсэн цогцолбороос гаргахыг зорилоо. Нийт солонгос хэлийг мэргэжлийн түвшинд суралцагч 15 оюутан, солонгос хэл мэддэггүй 15 оюутныг судалгаанд хамруулан үр дүнг гаргасан болно.

ОРШИЛ

Ертөнцийн юм үзэгдэл хязгааргүй, бүхэл уялдаат шинжтэй юм. Тэрхүү юм үзэгдэл байгальд зэрэгцэн оршдог бол хүний хэлэнд дохио болон илэрхийлэгдэхдээ цуварч хэлэгддэг байна. Цуварч хэлэгдсэн санаа буюу өгүүлбэр нь юм үзэгдэл, түүний хөдөлгөөн, чанар, харьцааг багтаасан өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн гэх төгс бус дохиог нийлүүлсэн төгс дохио юм. Төгс дохио-өгүүлбэр нь мөчлөгийг, мөчлөг нь цогцолборыг, цогцолбор нь хэлний олон янзын хэрэглүүр утга, хэлбэр, үүргийн давхарласан бүтэцтэй, харилцааны төгс дохио-эхийг бүтээнэ. Эх, өгүүлбэрийг төгс утгатай, зөв хэлбэржилттэй болгох нэгэн гол бүрдүүлбэр нь холбоосжилт(cohesion) юм.¹⁸

Хэл шинжлэлчид монгол хэлний холбоосыг *холбоос үг, сул үг, дайвар үг, үл хувилах үг, туслах үг, тодорхой бус үг, гол бус үндэст үг, нөхцөлгүй үг, эс хувилах үг* гэсэн дэд айд хамааруулан судлан тайлбарлаж иржээ. Орчин цагийн монгол хэл шинжлэлд холбох үгийг тусад нь үгсийн аймаг болгон авч үздэг эрдэмтэд

¹⁸ Cohesion гэдэг ойлголтыг цогц санааг холбох ерөнхий арга, холбох үйлийн үр дүнг заасан нэр учир холбоосжилт гэж нэрлэсэн байна.

байх бөгөөд харин солонгос хэлэнд холбох үгийг дайвар үгийн бүлэгт оруулан үзэж холбох дайвар үг (접속부사) гэж үздэг байна. Холбоос(Conjunction) гэдэг ойлголтын хэл шинжлэлийн тодорхойлолт олон ч хамгийн нийтлэг, ойлгомжтой тодорхойлолт нь “утга санааг илэрхийлэх хэсгүүдийг харилцан холбож өгдөг үгийг хэлнэ” гэсэн байдаг. Тиймээс энэхүү судалгаанд холбох үг¹⁹ гэдэг нэр томъёог ашиглах болно.

Эхийн хамгийн бага нэгж нь цогцолбор юм. Нэг санааг агуулсан хэд хэдэн өгүүлбэрийг цогцолбор гэнэ. Энэхүү цогцолбор нь хэд хэдээр нийлж бага мөчлөгийг бүтээж, тэдгээр нь нийлж, дэд сэдэв бүхий их мөчлөг болно. Их мөчлөг нь хэлэмж болж хэд хэдэн хэлэмж нийлж, эхийг бүтээнэ. Эхийн гол хэмжүүр бол Нэгт, түүний сэдэв, Хоёрт, эхийн доторх чухал санааг тэмдэглэсэн нэгж, элементүүд, Гуравт, эхийн цогцолбор, мөчлөгийг холбосон холбоо юм. (Базаррагчаа 2017: 346). Иймд эх бичихэд холбох үгийг зөв хэрэглэх явдал бол эх хэл төдийгүй гадаад хэлээр цогцолбор бичихэд ч чухал асуудал юм. Иймээс солонгос хэл суралцагч монгол хүн солонгос хэлээр холбох үгийг хэрхэн бичиж байгаа хэрэглээнд анализ хийж үүнд эх хэлний нөлөө байгаа эсэхийг тус судалгаагаар харуулахыг зорилоо.

2. Судалгааны агуулга ба хүрээ

Тус судалгаа нь солонгос хэлийг мэргэжлийн түвшин²⁰-д судалж буй 2-р курсийн суралцагчийн холбох үгийн утга, хэрэглээ ямар байгааг мэдэхийн тулд солонгос хэлний түвшин тогтоох шалгалт²¹-ын бичих хэсгийн 53-р даалгавар буюу цогцолбор бичих даалгаврыг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Судалгаанд хамрагдсан оюутнуудын мэдээллийг <Хүснэгт 1>-ээс харна уу.

< Хүснэгт 1> Судалгаанд хамрагдсан оюутнуудын ерөнхий мэдээлэл

Сургууль	Тэмдэглэгээ	Даалгавар	Анги	Оюутны тоо
1. ОУУБИС 2023-2024 хаврын улирал	Жишээ авахад оруулсан №1-15 дугаар нь нийт судалгаанд оролцогсдын нэрийг бичилгүйгээр дугаарласан тоо юм.	СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар(солонгос)	СХО, СХБ, СС2 ⁴ Хөтөлбөр 2-р курс	15

¹⁹ 2022 онд хэл шинжлэлийн эрдэмтдийн гаргасан монгол хэл судлал IX ботийн үг зүйн хэсэгт дээрх үгийг холбох үг гэж нэрлэсний дагуу тус судалгаандаа энэхүү нэр томъёог ашиглав. Ц. Өнөрбаян.,нар монгол хэл судлал боть үг зүй. 67-р тал.

²⁰ Солонгос хэлний орчуулга, солонгос хэлний багш, солонгос судлал мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчид.

²¹ Тус судалгаанд дээрх шалгалтын нэрийг СХТТШ гэж товчлон бичнэ.


2. ОУУБИС 2023-2024 хаврын улирал	Жишээ авахад оруулсан №1-15 дугаар нь нийт судалгаанд оролцогсдын нэрийг бичилгүйгээр дугаарласан тоо юм.	СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар(монгол) Өгсөн мэдээллийг 100-120 үг цогцолбор багтаан бичих	СС, ХНХ ²² Хөтөлбөр 2-р курс	15
---	---	--	--	----

Даалгавар 1-ийг ОУУБИС-ийн солонгос хэлний орчуулга, солонгос хэлний багш, солонгос судлалын хөтөлбөрөөр суралцаж буй нийт 15 оюутан хамрагдсан бөгөөд СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар буюу өгөгдсөн мэдээллийг ашиглан цогцолбор бичих даалгаврыг солонгос хэл дээр бичүүлсэн болно. Энэхүү даалгаврыг гүйцэтгэхийн тулд хамгийн багадаа 5 холбох үг бичих хэрэгтэй бөгөөд эдгээр холбох үгсээс **반면에**(эсрэгээр), **따라서**(тиймээс) холбох үгийг хэрхэн бичиж байгааг жишиг эхтэй харьцуулан гарсан үр дүнд анализ хийнэ. Даалгаврыг <Зураг 1>-ээс харна уу.

< Зураг 1 > СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар-1²³

■ 연습 문제

1 다음을 참고하여 '한복 구매율 변화'에 대한 글을 200~300자로 쓰시오. 단, 글의 제목을 쓰지 마시오. (30점)



Даалгавар 2-ыг ОУУБИС-ийн сэтгэл судлал, хүүхэд нийгмийн халамжийн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй солонгос хэл мэддэггүй нийт 15 оюутан хамрагдсан бөгөөд СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар буюу өгөгдсөн мэдээллийг ашиглан цогцолбор бичих даалгаврыг монгол хэлээр бичүүлсэн болно. <Зураг 2>-оос харна уу.

²² Сэтгэл судлал, хүүхэд нийгмийн халамж мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчид.

²³ СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгаврыг солонгос хэлээр бичүүлэх даалгавар юм.

< Зураг 2 > СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгавар-2²⁴

1 Өгөгдсөн мэдээллийг ашиглан “Ханбуут худалдан авалтын өөрчлөлт”-ийн талаар 100-120 үг бүхий цогцолбор бичнэ үү. (30 оноо)



<Хүснэгт 2> СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгаврыг үнэлэх хүснэгт²⁵

Сэдэв	Цогцолборт тавигдах шалгуур	Онооны ангилал		
		Дээд	Дунд	Доод
Агуулга болон даалгавар гүйцэтгэсэн байдал (7оноо)	1. Мэдээллийг бүрэн ашигласан эсэх 2. Сэдвийн дагуу нуршилгүй бичсэн эсэх 3. Өгөгдсөн мэдээллийг оновчтой олон янзаар илэрхийлсэн эсэх	7~6 оноо	5~3 оноо	2~0 оноо
Цогцолборыг өрнүүлж чадсан эсэх (7оноо)	1. Цогцолборын бүтэц(эхлэл, өрнөл, төгсгөл) тодорхой, учир шалтгааны хувьд зөв эсэх 2. Эхийн агуулга болон цогцолборын авцалдаа таарч байгаа эсэх 3. Логик дэс дараалалд тус болох илэрхийлэл, холбох үгийг зөв, зохистой ашигласан эсэх	7~6 оноо	5~3 оноо	2~0 оноо
Хэлний хэрэглээ (16 оноо)	1. Үг, дүрмийг давхцуулалгүй ашиглаж тохиромжтой үг, дүрэм сонгосон эсэх 2. Үг, дүрэм, хэлзүйн дүрмийг ашиглаж сайн найруулж, алдаагүй бичсэн эсэх 3. Эхийн зорилго ба найруулгын хэм хэмжээнд тааруулан бичсэн эсэх	16~14 оноо	12~8 оноо	60 оноо

Дээрх хүснэгт нь СХТТШ-ын цогцолборт үнэлгээ өгөх хэмжүүр үзүүлэлт юм. Агуулга болон даалгавар гүйцэтгэсэн байдалд гүйцэтгэлээсээ шалтгаалаад дээд(6-7), дунд(3-5), доод(0-2) гэж үнэлдэг байна. Цогцолборыг өрнүүлсэн эсэхт мөн дээд тал нь 7 оноо өгдөг бөгөөд түүнийг мөн адил дотор нь дээд(6-7) дунд(3-5) доод(0-2) гэж хуваан, логик дэс дарааллын дагуу өрнүүлэн бичихэд хэрэглэгддэг

²⁴ СХТТШ-ын бичих хэсгийн 53-р даалгаврыг монгол хэлээр орчуулан даалгавар 1-ээс ялгаатай нь хэл нь өөр болохоос яг адил даалгаврыг өгсөн бөгөөд үеийн тоог үгийн тоо руу шилжүүлсэн тооцсон болно.

²⁵ СХТТШ дээрх үнэлгээний хүснэгтийн дагуу бичих хэсгийн 53-р даалгаврыг шалгадаг бөгөөд үүнд учир шалтгааны хувьд зөв эсэх, авцалдаа таарч байгаа эсэх, холбох үгийг зөв, зохистой ашигласан эсэх нь холбох үгтэй холбоотой шалгуурууд юм.



илэрхийлэл, холбох үгийг хэрхэн ашигласныг үнэлнэ. Хэлний хэрэглээ ангилалд үг, хэлзүйн нөхцөлийг дунд, дээд түвшний үг хэллэг, хэлзүйн дүрэм ашигласан эсэх, найруулгын хэм, хэмжээнд тааруулан бичсэн эсэхийг шалгадаг байна. Энэхүү даалгаврыг 30 оноогоор үнэлдэг.

3. Судалгааны үр дүн

Монгол суралцагчдын солонгос хэлээр бичсэн цогцолборыг жишиг эхтэй харьцуулан үзэж тухайн холбох үгсийг утга, үүргийн хувьд хэрхэн хэрэглэж байгааг доорх зөв хариулт байж болох жишиг эхтэй харьцуулан хэрэглээний байдлыг тандав.

<Жишиг эх>

온라인 한복 판매 업체에서 한복 구매율 변화에 대한 조사를 실시했다. 조사 결과에 따르면 전체 구매율의 경우 2017년 26%에서 2018년 24%로 감소했다. **반면에** 20대의 경우 같은 기간 30%에서 34%로 증가한 것으로 나타났다. **이처럼** 20대의 한복 구입이 증가한 이유를 살펴보면 소재와 디자인이 달라졌을 뿐만 아니라 한복을 입고 사진을 찍는 문화가 확산되었기 때문이다. **따라서** 한복의 대중화를 위해 먼저 한복 체험 프로그램을 더욱 활성화하는 것이 좋다. **또한** 다양한 소재와 디자인의 한복을 개발할 필요가 있다. (292자)

Солонгос хэл суралцагчид дээрх жишиг эхийн хэмжээнд бичиж байж цогцолбор бичих даалгаварт өгөгдөх 30 оноог авах хэрэгтэй болно. Дээр тодруулсан үгнүүд бол холбох үг бөгөөд эдгээр үгсээс хэрэглээний давтамж болон олон янзаар сэлгэн хэрэглэгдэх байдлыг харгалзан **반면에**(эсрэгээр), **따라서**(тиймээс) холбох үгийг хэрхэн бичиж, хэрэглэж байгаад анализ хийсэн болно.

*<Хүснэгт 3> Монгол суралцагчдын солонгос хэлний холбох үгийг
солонгос, монгол хэл дээр хэрэглэсэн байдал²⁶*

Солонгос холбох үг	Хэрэглэсэн байдал(солонгос)	Хэмжих нэгж(%)	Хэрэглэсэн байдал (монгол хэл)	Хэмжих нэгж(%)
반면에 (эсрэг / эсрэгээр)	했으며 하고 이어서 그래서 반면에 이러한 огт холбох үг хэрэглээгүй	2(13.3%) ²⁷ 2(13.3%) 1(6.6%) 1(6.6%) 1(6.6%) 1(6.6%) 2(13.3%)	харин - сан бол - сан бөгөөд харин эсрэгээрээ - үүнээс хамааран - байгаа ч - сан боловч огт холбох үг хэрэглээгүй	4(26.6%) 3(20%) 2(13.3%) 1(6.6%) 1(6.6%) 1(6.6%) 1(6.6%) 2(13.3%)
Нийт хэрэглэсэн	8(53.3%)		13(86.6%)	
따라서 (тиймээс)	그래서 따라서 그러므로 огт холбох үг хэрэглээгүй	1(6.6%) 2(13.3%) 1(6.6%) 5(33.6%)	тэгвэл тиймд иймд тиймээс энэ нь огт холбох үг хэрэглээгүй	4(26.6%) 2(13.3%) 2(13.3%) 1(6.6%) 1(6.6%) 5(33.3%)
Нийт хэрэглэсэн	4(26.6%)		10(66.6%)	

Дээрх судалгааны үр дүнг харвал мэргэжлийн түвшинд солонгос хэл сурч буй оюутнуудын хувьд солонгос хэлээр тухайн даалгаврыг гүйцэтгэхэд반면에 (эсрэг /эсрэгээр) холбох үгийн хувьд нийт судалгаанд хамрагсдын 8(53.3%) ямар нэг байдлаар холбох үг болон холбох нөхцөлөөр илэрхийлсэн бөгөөд яг оновчтой хэрэглэсэн 1 оюутан байсан нь чамлалтай үр дүнг харуулж байна. Улмаар했으며 2(13.3%), 하고 2(13.3%), 이어서, 그래서, 반면에, 이러한 гэх мэт холбох үг болон холбох нөхцөлөөр тус бүр 1(6.6%) сэлгэж хэрэглэсэн байна.

따라서(тиймээс) учир шалтгаан заасан холбох үгийн хувьд нийт судалгаанд хамрагсдын ердөө 4(26.6%) бичсэн бөгөөд 그래서 1(6.6%), 그러므로 1(6.6%) сэлгэн бичсэн үр дүн гарсан нь энэхүү нөхцөл дээр онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

²⁶ Даалгавар 1-ээр солонгос хэл суралцагч монгол оюутнууд солонгос хэлээр цогцолбор бичихдээ холбох үгийг хэрхэн хэрэглэж байгааг харах болно. Даалгавар 2-оор солонгос хэл мэддэггүй оюутнууд эх хэлээрээ цогцолбор бичихэд холбох үгийг хэрхэн хэрэглэж байгааг харах болно.

²⁷ 2(13.3%) эхний 2 гэсэн тоо нь оюутны тоог илэрхийлж байгаа бөгөөд, хаалтан доторх тоо эзлэх хувийг илэрхийлж байгаа юм.

Нөгөө талаар солонгос хэл мэддэггүй оюутнуудын хувьд эх хэл(монгол) дээрээ бичсэн даалгаврыг ажиглахад **반면에**(эсрэг/эсрэгээр) холбох үгийг солонгос хэлээр бичсэн хүүхдүүдтэй нэлээн төстэй маш олон янзын холбох үг болон нөхцөлөөр илэрхийлж бичсэн байна. Нийт оюутнуудын 13(86.6%) энэхүү нөхцөлийг эх хэл дээрээ бичсэн бөгөөд солонгос хэлээр бичсэн хүүхдүүдээс 5(33.3%) илүү өндөр үр дүнг харуулжээ.

Мөн солонгос хэл мэддэггүй оюутнуудын хувьд эх хэл(монгол) дээрээ бичсэн даалгавраас **따라서**(тиймээс) учир шалтгаан заасан холбох үгийг бичсэн байдлыг ажиглавал 3/2 хувь буюу 10(66.6%) ямар нэг байдлаар маш олон янзын учир шалтгаан заасан холбох үгээр сэлгэн хэрэглэсэн байсан бөгөөд энэ үр дүн солонгос хэлээр бичсэн оюутнуудын 4(26.6%) үзүүлэлтээс харьцангуй өндөр үзүүлэлт байлаа.

Дээрх үр дүнд үндэслэн **따라서**(тиймээс) учир шалгаан заасан холбох үгийг солонгос хэлийг мэргэжлийн түвшинд суралцаж буй оюутнууд яагаад ингэж бичихэд хүндрэлтэй байгааг нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзэн толь бичгийн тайлбар болон жишээ өгүүлбэрээс тодруулах гэж үзлээ. Судалгааны үр дүнд **따라서**(тиймээс) гэсэн холбох үгийг **그래서**(тиймээс) 1(6.6%), **그러므로**(тийм учраас) 1(6.6%) сэлгэн бичсэн үр дүн гарсан нь энэхүү нөхцөл дээр онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

<Хүснэгт 4> (**그래서, 따라서, 그러므로**) холбох үгийн тайлбар ба жишээ

접속부사 (Холбох үг) ²⁸	Толь бичгийн Тайлбар ²⁹	Толь бичгийн тайлбар(орчуулга)	Жишээ:
그래서 (Тиймээс)	앞의 내용이 뒤의 내용의 원인이나 근거, 조건 따위가 될 때 쓰는 접속 부사.	Өмнөх агуулга дараах үйлдлийн шалтгаан буюу <u>үндэслэл, болзол</u> болох үед хэрэглэгддэг холбох дайвар үг.	어제는 많이 아팠어요. 그래서 결석했어요.
따라서 (1.Тиймээс, 2.Тийм учир)	앞에서 말한 일이 뒤에서 말할 일의 원인, 이유, 근거가 됨을 나타내는 접속 부사.	Өмнөх агуулга нь ард ирэх агуулгын <u>учир шалтгаан, үндэслэл</u> болох үед хэрэглэдэг холбох дайвар үг.	원값이 많이 올랐다. 따라서 국내 기름 값도 조만간 오를 것이다.

²⁸ Солонгос хэлэнд дайвар үг, монгол хэлэнд холбох үг гэж үздэг.(접속부사)

²⁹ Солонгосын үндэсний хэлний хүрээлэнгээс гаргасан стандарт эх хэлний толь бичиг(국립국어원 표준국어대사전)

그러므로 (1.Тийм болохоор, 2.Тийм учраас, тиймээс	앞의 내용이 뒤의 내용의 <u>이유나 원인. 근거가 될 때 쓰는 접속 부사.</u>	Өмнө нь ярьсан зүйл дараагийн ярих зүйлийн <u>учир шалтгаан буюу үндэслэл</u> болох үед хэрэглэдэг холбох дайвар үг.	인간은 말은 한다. <u>그러므로</u> 동물과 구별된다.
--	---	---	---

Дээрх толь бичгийн тайлбарыг харахад {그래서}-нь [шалтгаан/үндэслэл/нөхцөл байдал] зэргээр тайлбарлагдаж {따라서}-нь [учир шалтгаан/шалтгаан/үндэслэл/ нөхцөл байдал] гэж тайлбарлагдаж байна. Угтаа [원인-учир шалтгаан] болон[이유-шалтгаан]-ийг нарийн ялгахад амаргүй байтал 그래서, {따라서} хоёрын {따라서} дээр л энэ тайлбар нэмэгдэж байгааг харахад [원인-учир шалтгаан]а [이유-шалтгаан] хоёрын утгын ялгамжийг нарийн гаргахад хүндрэлтэй харагдаж байна. Энэ нь солонгос хэл суралцагч гадаад хүмүүст төдийгүй солонгос хүмүүс ч өөрсдөө өгүүлбэрийн урд, хойдох хам утгыг харж логик дарааллын дагуу [원인-учир шалтгаан]а [이유-шалтгаан]-ыг ялгах хүндрэлтэй байдаг бөгөөд энэ нь [근거-үндэслэл]а [조건-болзол]-ын хувьд ч адил хүндрэлтэй асуудал гэсэн үг юм.

ДҮГНЭЛТ

Солонгос хэл суралцагч монгол оюутнуудын хувьд бичих даалгаврыг гүйцэтгэхэд солонгос хэлний холбох үг чухал байдаг гэсэн ойлголттой байгаа нь ажиглагдлаа. 반면에(эсрэг/эсрэгээр) холбох үгийн хувьд нийт судалгаанд хамрагсдын 8(53.3%) ямар нэг байдлаар холбох үг болон холбох нөхцөлөөр илэрхийлсэн бөгөөд яг оновчтой хэрэглэсэн 1 оюутан байсан нь чамлалтай үр дүнг харуулж байна. Энэ үр дүн бол 반면에(эсрэг/эсрэгээр) гэдэг энэхүү холбоо үгийг монгол хэлэнд өргөн хэрэглэдэггүйтэй холбон тайлбарлаж болохоор байна. Солонгос хэл мэддэггүй эх хэлээрээ бичсэн оюутнуудын хувьд 반면에(эсрэг/эсрэгээр) холбох үгийг харин(그러나) гэдэг холбоо үгээр илэрхийлсэн 4(26.6%) үр дүн гарлаа. Мөн 반면에(эсрэг/эсрэгээр) холбох үгийг бусад холбох үг болон нөхцөлүүдээр сэлгэн хэрэглэсэн нь тохиромжгүй байсан бөгөөд үүнийг холбох үг, нөхцөл бүр дээр алийг нь сэлгэж хэрэглэж болох, алийг нь болохгүйг тодорхой тайлбарлаж нарийн судалгаа хийх хэрэгтэйг харуулж байна. Энэ нь энэ мэт ижил төстэй (그리고/그러나) гэх мэт холбох үгэн дээр ч мөн адил хамаатай юм.



따라서(тиймээс) учир шалтгаан заасан холбох үгийн хувьд нийт судалгаанд хамрагсдын ердөө 4(26.6%) хэрэглэсэн бөгөөд 그래서 1(6.6%), 그러므로 1(6.6%) сэлгэн бичсэн үр дүн гарсан нь энэхүү нөхцөл дээр онцгойлон анхаарах шаардлагатайг харууллаа. Үүнийг толь бичгийн тайлбар, жишээн дээр ажиглахад үнэхээр ялгахын аргагүй тайлбартайн дээр монгол хэлэнд 3-лаа тиймээс, тийм учраас гэж орчуулагдан бууж байгаа нь солонгос хэл суралцагчдыг хүндрэлтэй байдалд оруулж байгаа нь дээрх судалгаагаар батлагдлаа. Мөн энэхүү 3 холбох үгийг нарийн судлах хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

Солонгос хэл мэддэггүй, даалгавар 2-ыг гүйцэтгэсэн оюутнуудын хувьд эх хэл(монгол) дээрээ бичсэн байдлыг ажиглахад 반면에(эсрэг/эсрэгээр) холбох үгийг солонгос хэлээр бичсэн хүүхдүүдтэй төстэй маш олон янзын холбох үг болон нөхцөлөөр илэрхийлж бичсэн байна. Энэ нь нийт оюутнуудын 13(86.6%) энэхүү нөхцөлийг бичсэн нь солонгос хэлээр бичсэн хүүхдүүдээс 5(33.3%) илүү өндөр байгаа нь эх хэл дээрээ бичихэд амархан боловч гадаад хэл дээр яг тохирсон холбох үгээр бичихэд хэцүү байна гэсэн үр дүнг харуулж байна.

Энэхүү судалгааны ажил зөвхөн солонгос хэлний 5 холбох үгийн хувьд харьцангуй цөөн суралцагч дээр судалгааны цар хүрээг хязгаарлан тогтоосон боловч энэхүү цар хүрээг улам өргөн болгох, хүний тоог нэмэгдүүлэн илүү олон тооны холбох үг дээр, өргөн хүрээний ажиглалт, судалгааг хийвэл илүү нарийн бөгөөд олон мэдээллийг гаргаж болохоор харагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Амартайван.М, Энхзул.С *TOPIK-ийн тухай асуулт хариулт*. гарын авлага. УБ. 2024.
2. Базаррагчаа, М., нар *Өгүүлбэр зүй*. Монгол хэл судлал. XI боть. УБ. 2022.
3. Өнөрбаян.Ц, Жумдаан.Л, Саруул-Эрдэнэ.М, Ганбаатар.Ж. *Үгзүй*. Монгол хэл судлал. IX боть. УБ. 2022.
4. Цэрэнханд.Л, Энхчимэг.С. *Солонгос хэлний үнэлгээ, шалгалтын аргачлал (Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын жишээгээр)*. Гадаад Хэл Соёл Судлал. МУИС, 20(450), 2023.
5. Энхзул.С. *Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын цогцолбор бичих чадварыг хөгжүүлэх зарим асуудал (53-р даалгаврын жишээгээр.)* Ази судлал,

МУИС.2018.

6. Энхзул.С, Амартайван.М. *Монголд авч байгаа солонгос хэлний түвшин тогтоох шалгалтуудын онцлог ба сургалтад анхаарах хүчин зүйлс*. УБ.2024. 한국어능력시험연구회. 한국어능력시험 *TOPIK2* 한 번에 통과하기. 시대고시기획 시대교육.2022.

Цахим сайт:

1. <http://www.topik.mn> БНСУ-ын Олон Улсын Боловсролын Хүрээлэнгийн СХТТШ-ыг Монголд Зохион Байгуулах Хороо. Mongolian Topik Team. 2024.
2. <http://www.topik.go.kr> БНСУ-ын Олон Улсын Боловсролын Хүрээлэнгийн СХТТШ-ын албан ёсны сайт. 교육부 국립국제교육원. 한국어능력시험 TOPIK.

ДИЗАЙНЫ ТЭНХИМ



Н.ЭНХТАЙВАН

Тогтвортой хөгжил, монголчуудын сав, эдлэлийн эко
уламжлал

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, МОНГОЛЧУУДЫН САВ, ЭДЛЭЛИЙН ЭКО УЛАМЖЛАЛ

Доктор, Н.Энхтайван
(ОУУБИС. ИДТС)

enkhtaivan.n@ulaanbaatar.edu.mn

Товч агуулга: Монголчуудын уламжлалт сав, эдлэлүүд өнөө цагт ч хурааж хадгалах, зөөж тээвэрлэх, идээ, ундааг боловсруулах хэрэглээг маш сайн хангаж ирсэн. Нөгөөтэйгөөр эдгээр сав эдлэлийг хийхэд гаднын ямар нэг түүхий эд ордоггүй, идшинд хэрэглэсэн мал, амьтны арьс, эд, эрхтэнг ахуйн хүрээнд уламжлалт аргаар боловсруулан ашигласаар байгаа нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, эко хэрэглээнд нийцэхийн зэрэгцээ үндэстний хэрэглээний өвөрмөц өнгө төрөхийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм. Орчин цагийн хуванцар сав, эдлэл, байгаль орчин, эрүүл мэнд, эдийн засаг, тухайн үндэстний ондоошин хөгжихөд илүү хор хөнөөлтэйг сав, зарим эдлэлийн жишээн дээр харьцуулан үзэв.

Түлхүүр үг: тогтвортой хөгжил, уламжлалт хэрэглээний сав эдлэл.

Нэн эрт үеэс Монгол нутагт амьдарч ирсэн бидний өвөг дээдэс байгаль, цаг уур ахуйдаа зохицсон аж ахуйн соёлыг өвлүүлэн хөгжүүлж, хадгалсаар ирсэн.

Байгалийн элдэв үзэгдэл, уул овоо, ус мөрөн, од эрхсийг амьдчилан үзэж эзэн савдагтай³⁰ хэмээн онголон шүтэж, идээ ундныхаа дээжийг өргөн, байгаль цаг уурын аясыг даган нүүдэллэн амьдрах ахуйн хэвшил нь нүүдэлчдийн амьдрах гол арга болоод зогсохгүй шүтэн бишрэх, шүлэглэн дуулах, урлан бүтээх үйлийн нь эх ундарга болсоор ирэхдээ, эх дэлхийн өгөөж хишгийг хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэл тэмүүлэл нь өнөө цагийн дэлхий нийтийн амьдралын гол хандлага болох тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай олон талаар нийцэж буйг харж болно.

Тогтвортой буюу” Sustainable”³¹ үгийн утга нь хүрээлэн буй орчинд бага зэрэг буюу огт хохирол учруулахгүй, удаан хугацаанд үргэлжлэх тогтонги, тууштай гэсэн утга илэрхийлнэ. Тогтвортой хөгжлийн үзэл нь МЭӨ 400 онд Аристотелийн эш татаж байсан Грекийн “өөртөө тогтворшигч” айл өрхийн эдийн засаг, XIII-XIV зууны үед ойн аж ахуйд хэрэглэж байсан” нөөцийн хэрэглээ ба нөхөн

³⁰ Савдаг-газар орны эзэн -я

³¹ Sustainable Дэлхий дээрх шашин бүхэн байгалиа хайрлан хамгаалах үзлийг агуулж байдаг



үйлдвэрлэлийн тэнцвэр” зэрэг санаанаас эхэлсэн (Quiley,2008). Орчин үед 1972 оны Ромын клубийнхний “өсөлтийн хязгаарууд” илтгэлээс өдөөгдөн эрчимтэй ЦЯдэлгэрч байна. (Жадамбаа тогтворшилтой хөгжлийн боловсролын онол, арга зүйн зарим асуудал, 2015, х-8).

Өнөөг хүртэлх хөгжлийн загвар нь хүн төрөлхтөн тасралтгүй, тогтвортой хөгжих арга ухаан, аж төрөх ёсыг бүрэн тодорхойлж чадахгүй байгаа учраас энэ нь өнөөдрөө аргацаасан ирээдүйгүй “хөгжил” гэж үзэх болсон. Хүн төрөлхтөн хөгжлийн дээрх загвараа өөрчлөхгүйгээр үргэлжлүүлэх юм бол дэлхийд байгаль орчны сүйрэл, эдийн засгийн хямрал, нийгмийн шударга бус байдал улам нэмэгдэнэ гэдгийг мэдсэний үр дүнд, ирээдүйд чиглэсэн хувьсал өөрчлөлтөд нээлттэй тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын загварыг боловсруулсан (UNESCO, 2002).

Дэлхийн улс орнуудыг дөрвөн бүсэд хуваан үзэж тогтвортой хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйлийг дараах байдлаар дэвшүүлсэн байна. Монгол улс Ази, Номхон далайн орнуудын бүс нутагт хамрагдаж улмаар “Соёлын өв уламжлалд тулгуурлан хөгжих” гэсэн бодлого, боловсролын хандлагыг баримтлах болсон байна. Соёлын өв уламжлал – тогтвортой хөгжлийн үндэс гэж томъёолжээ (UNESCO, 2017).

Монголчуудын уламжлалт гэр сууц, чингэлэг тэрэг, модон сав эдлэлүүд өнөөдөр ч түгээмэл хэрэглэгдэж байгаагаас арьсан сав суулга, малын гүзээ, бүдүүн нарийн гэдэс³², хуухнаг³³, тулам³⁴ зэрэг нь хамгаалах чадвар, хэрэглээний үүргээ алдалгүй хэрэглэгдсээр байгаа бол, маш бага эсгүүр оёдол орсон, эртний хэлбэрээ хадгалан ашиглагдсаар байгаа сав болох борви,³⁵ хөхүүр, шарын уут³⁶, богц зэрэг нь ердийн хөсгөөр ачиж тээвэрлэх хэрэглээтэйгээ уялдсан шийдэл болохын зэрэгцээ хэрэглээгүй үед хуйлан эвхэж маш бага овор хэмжээтэй болгон хадгалах боломжтойн зэрэгцээ шингэн зүйл агуулах борви хөхүүрийг хэрэглэх үедээ усанд дэвтээж ашигладаг бол уламжлалт аргаар боловсруулсан богц³⁷, шарын уут нь

³² Бог, бодын нарийн бүдүүн гэдэс, гүзээг тос, мах хадгалхад ашиглана.

³³ Хуухнаг- эр малийн үр булчирхайн хүүдий,хуйх., хоол хүнсэнд хэргэлсэн болон, цаг бусаар үхсэн малын хуухнагийг туламлан өвчиж, идээлэн боловсруулснаар цай, давсны уут, тамихны хавтага болгон ашиглаж иржээ.

³⁴ Тулам- бог мал болон, зээр, тарвага, зэрэг амьтныг туламлан өвчиж арьсыг идээлэн боловсруулснаар гурил будаа агуулах, өрөм тос хураах зэрэгт ашиглана.

³⁵ Борив- бод мал болон том ангийн бүдүүн гуянаас шилбэний дээд хэсг хүртлэх нарийн хэсгийг туламлан өвчиж боловсруулан өргөн хэсгийг оёж битүүлэн нарийн хэсэгт ам гарган модоор бөглөж таглана, ус, унд хийж хэрэглэхэд ашиглана.

³⁶ шарын уут- бүтэн үхрийн ширээр хийсэн эд зүйл агуулан үхэр тэмээнд нуруу ачиж хэрэглэдэг уут сав.

³⁷ Богц- үхрийн ширээр хийсэн хос сав

хэрэгцээтэй үедээ шууд ашиглахаар хийгдсэн байдаг (зураг 1).

Дээрх арьсан сав эдлэл нь хадгалахад хялбар, овор бага, хөнгөн боловч, бөх бат, айраг цагаа агуулахад харьцангуй багтаамж сайтай шийдэгдсэн байна. Бүтэн үхрийн ширээр хийсэн айргийн хөхүүр тухайн арьсны том жижгээс хамааран шингэн зүйл агуулах үед 100 л-250 л багтаах боломжтой, эвхэж хадгалахад 20х20х50 см овор хэмжээтэй болдог. Хөхүүр хийсэн ширний зөөлөн эдлэгүүд тухайн агуулж байгаа бүтээгдэхүүний эсэж боловсрох, суурь хөрөнгө болох нөхцөлийг бүрдүүлдэг нь тухайн бүтээгдэхүүний өвөрмөц давтагдашгүй амт, үнэр, төлөвийг бүрдүүлэхэд онцгой үүрэгтэй нүүдэлчдийн уламжлалт хэрэглээ юм.



Зураг 1. Уламжлалт арьс, шир, эсгий, ноосон сүлжмэл, бургасан савнууд болон орчин цагийн хуванцар савнууд.

Дээрх сав эдлэл нь эко дизайнд тавигддаг үндсэн шаардлага болох бионик³⁸ формыг түлхүү ашиглахын зэрэгцээ тухайн арьс ширний биологийн үндсэн бүтцийг чухалчлан анхаарч сэргээгдэх байгалийн баялаг болох мал амьтны гаралтай түүхий эдийг маш бага зардлаар боловсруулснаар удаан хугацаанд олон дахин ашиглах, бүтээмж өндөртэй хэрэглэгдэхүүн хийж байсан бол, өнөө үед төрөл бүрийн хуванцар сав суулгад идээ, цагаа боловсруулах, хадгалах зэрэг ахуйн бүхий л орчинд хэрэглэх болсон нь эрүүл мэнд бүтээгдэхүүний онцлог байдалд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ тэдгээрийн хог, хаягдал байгаль орчинд асар их

³⁸ Бионик- Байгалын хэлбэр бүтэцийг техник технологийн шинэ шийдэлд ашиглах ухаан

хор хохирол дагуулж байгааг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч шинэ арга замыг хайх болжээ.

Зураг 2. Монгол хэт, хутга, савх, аяга, аяганы уут



Зураг 3. Орчин цагийн нэг удаагийн хоол, цайны бүрэн хэрэглээ



Өнөө цагийн бидний бүтээсэн ахуйн хэрэглээ байгаль, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйн зэрэгцээ маш олон химийн төрөл зүйлийг ашиглаж, тоо, гадаад хэлбэр чамирхлыг чухалчилж байгаа нь нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг замбараагүй ашиглаж, тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртож, сүйтгэл нь эрс ихсэж байгаагаар тайлбарлагдана (зураг 3).

1960-аад оныг хүртэл ихэнх Монгол эрчүүд хэт хутга,³⁹ аягаа биедээ авч явдаг

³⁹ Хэт хутга:-20-30см хуйтай ган хутга, хос савх, гал гаргахад хэрэглэгдэх уул, цахиур агуулах ширэн хэтэвч бүхий ган хэт зэргээс бүрдэх ба мөнгө, алт, гангаар хээлэн чимэглэж бүсэнд зүүж хэргэлхээр шийдсэн хэрэглээний эдлэл.

хэвшилтэй байсан нь эрүүл ахуй, гоо сайхан, эдийн засгийн хувьд маш зөв шийдэл байжээ (зураг 1).

Одоо цагт ресторанд хооллоход 4-5 таваг, 5-6 ширхэг халбага, сэрээ, хутга хэрэглэж байгаа нь түүхий эд болон, эрчим хүчний өндөр зардал шаардлагатайн зэрэгцээ “зуун ямаанд жаран ухна” гэгчийн үлгэрийг эрхгүй санагдуулах бол уламжлалт хэт хутга, савх, аягаа биедээ авч явдаг Монгол хүн хооллох хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй, байгаль дээр бэлэн байх дахин сэргээгдэх цахиур чулуу⁴⁰, уул⁴¹ хэтний⁴² ганг ашиглан хүссэн үедээ гал гаргах, хооллож, дулаацах, боломжоо бүрдүүлж байсан нь хэрэглээний болоод гоо сайхан, эрүүл мэндийн шаардлага хангасан шийдэл байв (зураг 2).

Торх, тоотон, араг, дөрвөлж, тэвш⁴³, үхэг, авдар зэрэг нүүдэлчин ахуйд нэн тохирсон сав эдлэлүүд, хэрэглээний бусад зүйлс нь орчин үеийн адил төстэй эдлэлүүдээс харьцангуй хямд өртгөөр хийгдэж, удаан хугацаанд, давхар үүрэгшилтэйгээр ашиглагдаж, нөхөн сэргээгдэх, байгальд хор хөнөөлгүй задрах материалаар хийж байсан нь жинхэнэ эко, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн шийдлүүд байжээ (зураг 1).

Араг, хунз⁴⁴ дөрвөлж нь нүүдэлчдийн түлш, аргал, хоргол түүж цуглуулах, төл малыг тусгаарлан хаших, өндөр настан, балчир хүүхдүүдийг нүүдлийн үед суулган тээх, өөд болоочийг оршуулан гээх, бүсгүй хүн төрөхөд түшүүлэн төрүүлэх зэрэг хэрэглээний болон бэлгэдэл, зан үйлийн чухал ач холбогдолтой эдлэлд тооцогдоно.

Эдгээр уламжлалт эдлэлүүд, хэрэглээний соёл нь бүх нийтээр ашиглах боломжгүй ч тодорхой хүрээнд сэргээн хэвшүүлбэл нүүдэлчин ахуйг тусгасан аялал жуулчлал хөгжүүлэх, эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд чухал ач холбогдолтой төдийгүй хүн төрөлхтний өмнө тулгамдаад буй ашигт малтмалын хомсдол, тогтвортой хөгжлийн асуудлуудад эерэг хандлага, зөв шийдэл гаргахад сэжиг болох нь дамжиггүй юм.

⁴⁰ Цахиур чулуу- Монгол нутагт элбэг тохиолдох гал гардаг нэгэн зүйл хатуу чулуу.

⁴¹ Уул – цагаан уул цэцгийн үр боловсрох үеийн хөвөнлөг төлөв, гал гаргахдаа цахиур чулууны хэсэг дээр бага хэмжээгээр тавиж хэтний ган хэсгээр хавиран гал гаргана.

⁴² Хэт-гал ноцоох хэрэглэл, болдыг давтаж сэнж сурвалж тогтоон шир булигаар мэтээр улавч тавьж хийнэ.хээрийн хүн хээгүй хэтийн гал утаагүй (уулыг цахиурт наалдуулан барьж хэтийг хавиран гал гарган ноцоох.

⁴³ Үхэг- бяцхан хүүхдийг агуулж тээх ба эд ям агуулж тээх авдар мэт дээд тал нь онгорхой сав.

⁴⁴ Хунз араг-бургасыг матаж хэлбэржүүлэн тэмээний үдээрээр үдэж бөхлөсөн 70x100x80 см том хэмжээний сүлжмэл сав.



ДҮГНЭЛТ

Олон мянган жилийн өмнөөс тээн хөгжүүлж ирсэн нүүдлийн соёл нь өнөөгийн соёлтой гэх үрэлгэн, чамин хэрэглээний дэргэд бүдүүлэг, соёлгүй, хэт минимал хэрэглээ мэт санагдаж болох боловч, нүүдэлч ахуйдаа зохицсон сонгодог хэв загвар, шийдэлтэй эд, эдлэлүүд нь яг энэ цаг үед дэлхий нийтийн чиг хандлага болоод байгаа амьдралын бүхий л орчин, хэрэглээг тогтвортой, эко орчинд ойртуулахаар зорьж буй хандлагатай нийцэж байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй биз ээ.

Мөн байгалийн шавхагдашгүй нөөцөд тулгуурласан уламжлалт сав, эдлэлүүдийг орчин цагийн хэрэглээний эд зүйлсийг орлох боломжийг судлан, түгээн дэлгэрүүлж, хэвшүүлж, (хамгийн наад зах нь хөдөө гадаа явахдаа өөрийн аяга, халбагатай явж сурах, айраг, цагаан идээгээ арьс, ширэн сав эдлэлдээ боловсруулах), жижиг үйлдвэрийн газруудыг нээснээр, малаас гарч байгаа түүхий эдийг бүрэн ашиглах, амьжиргаагаа дээшлүүлэх бүрэн боломжтойн зэрэгцээ нүүдэлчдийн хэрэглээний урлагийн өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, өөрийн гэсэн өнгө төрхтэй ахуйг бүрдүүлэх өргөн боломжтой юм.

НОМ ЗҮЙ:

1. Амгалан .М “Баруун Монголын эдийн соёлын дурсгал.” -УБ., 2005.
2. Бадрал.С. Чингис хаан Монголын түүх урлагийн өв соёл.,-УБ., 2011
3. Батчулуун.С Нүүдэлчдийн урлаг соёлын жимээр мөшгөхүй -УБ.,2011.
4. Жадамбаа,Б (2015). Тогтворшилтой хөгжлийн боловсролын онол арга зүйн зарим асуудал.Улаанбаатар EDU print.
5. Цанжид .А. Монгол соёл иргэншил -УБ., 2013.
6. Цэвэл.Я Монгол хэлний тайлбар толь УБ. 1966.
7. Чүлтэм .Н. Монголын гоёл чимэглэлийн урлаг, УБ 1998.
8. Энхтайван.Н. Сав суулгын дизайн шийдэлд хийсэн судалгаа -УБ.,2011.
9. UNESCO.(2017) Соёлын биет бус өв ба тогтвортой хөгжил.(U.Norov,Ed,. B.Tuul Trans)

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ



А.ХАНДМАА

“Үнэнч ажилтан”-ыг тодорхойлох онолын судалгаа



Т.БУЛГАН

Бизнесийн байгууллагын хөдөлмөрийн нөөц ашиглалтыг
нэмэгдүүлэх боломжийн судалгаа

“ҮНЭНЧ АЖИЛТАН”-ЫГ ТОДОРХОЙЛОХ ОНОЛЫН СУДАЛГАА

Доктор, профессор А.Хандмаа

(ОУУБИС. ЭЗБС)

khandmaa.a@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Ажилтнуудаа урт удаан хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах нь тухайн байгууллагын ашиг орлогыг нэмэгдүүлэх, өөрийн өрсөлдөх давуу талыг хадгалан үлдэх, өрсөлдөөнт зах зээл дээр оршин тогтнох байр сууриа бататгах үндэс болдог. Байгууллага зорилгоо биелүүлэхэд тухайн компанийн ажилчид чухал нөлөө үзүүлдэг. Ялангуяа үнэнч ажилчидтай компани зорилгоо богино хугацаанд биелүүлж амжилтад хүрсэн нь олон. Тийм ч учраас олон улсын бизнесийн томоохон байгууллагууд ажиллагчдын үнэнч байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж илрүүлэн түүнд зориулсан томоохон хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Монгол Улсын бизнесийн байгууллагууд ажиллагчдын үнэнч байдалд төдийлөн анхаарал хандуулахгүй байдал ажиглагддаг ч ажил олгогч байгууллагууд ажилтан авахдаа хүний зан төлөв, төлөвшил, үнэнч байдлыг харгалзан үзэх хандлагатай байна. Иймээс үнэнч байдлыг судалснаар тухайн байгууллага ажиллагчдын үнэнч байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж буй асуудлыг олж тогтоон түүнд тохирох бодлогыг хэрэгжүүлэх, сайжруулахад үр нөлөөтэй гэж үзэж байна.

Түлхүүр үг: Үнэнч ажилтан, үнэт баялаг, бизнес, байгууллага, эерэг хандлага,

Сэдвийн зорилго: Ажиллагчдын үнэнч байдлыг тодорхойлоход онол, арга зүйн үндсийг судлахад чиглэгдэнэ.

Зорилт: -Ажиллагчдын үнэнч байдлын онолын үндэс, шинж чанарыг судлах;

- Ажиллагчдын үнэнч байдлын талаар судлагдсан байдал, үзэл баримтлалыг судлах

Судалгааны арга, арга зүй: Үнэнч байдлыг тодорхойлох онол, арга зүйн загваруудыг судалгааны ажлуудаас баримт бичгийн аргаар судлах

Удиртгал: Байгууллагын хүний нөөцийн бодлогод ажилтнуудын ажлын ханамж, ёс суртахуун, хувийн хандлага зэргийг сүүлийн үед авч үзэх болсон бөгөөд байгууллагадаа үнэнч байх хандлага нь харьцангуй шинэлэг ойлголт мөн. Монголын бизнесийн байгууллагууд ялангуяа үйлчилгээний байгууллагын хувьд ажиллагчдын үнэнч байдлыг дээшлүүлэх аргыг зөв зүйтэй хэрэгжүүлэх боломжийг



таниулж, энэ нь байгууллагын гүйцэтгэлд чухал нөлөөтэйг харуулах боломжтой.

Үндсэн хэсэг: Бизнесийн байгууллагын хувьд ажиллагчдын үнэнч байдал нь амин чухал зүйл бөгөөд түүнд нөлөөлөх хүчин зүйл нь байгууллага бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй байдаг. Эрдэмтэд ажиллагчдын үнэнч байдал гэдгийг онолын хувьд судалсан ч тодорхой нэгдсэн тодорхойлолтод хүрээгүй байна. Зарим эрдэмтэд ажиллагчдын үнэнч байдлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Ажиллагчдын үнэнч зан байдлыг хүмүүсийн байгууллагадаа хандах сэтгэлзүйн холбоо буюу итгэл сэтгэлээр нь тодорхойлж болно. Ажиллагчдын сэтгэлийн ханамж өсөхийн хэрээр үнэнч зан байдал нь улам нэмэгддэг. Ханамж нь аажмаар бий болдог үйл явц бөгөөд ажилтны сэтгэлд нийцэж, түүний хүлээлтийн түвшнийг давсан бол сэтгэлийн ханамж нь улам бүр өсдөг. Ажиллагчдын үнэнч байдал нь байгууллагадаа хандах ерөнхий сэтгэлзүйн хандлагыг бий болгодог. Өөрөөр хэлбэл ажлынхаа орчин нөхцөлд илүү сэтгэл хангалуун байх тусмаа ажилтан байгууллагадаа илүү их сэтгэл зүтгэлтэй болдог. Ажиллагчдын энэ хандлага нь түүний үнэнч байдлыг нэмэгдүүлдэг. Байгууллагадаа буюу ажилдаа дуртай болсон ажилтан илүү их үнэнч байх хандлагатай, бүтээмжээ сайжруулах, үр ашгаа нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдэд өндөр чанарын үйлчилгээ үзүүлэх зэргээр байгууллагынхаа зорилгыг биелүүлэхийн төлөө хөдөлмөрлөдөг. *Ажиллагчдын үнэнч байдал* гэдгийг ажиллагчдын дунд бий болсон итгэл сэтгэл гэж томъёолжээ. Энэ нь ажилтан байгууллагад үнэнчээр зүтгэж, түүнд харьяалагддаг гэсэн мэдрэмжтэй, байгууллагынхаа тааламжтай уур амьсгалд ээнэгшиж дассан учраас ажил олгогчтой харилцаагаа үргэлжлүүлэх эрмэлзэлтэй байна гэсэн үг. Үнэнч ажилтан нь байгууллагадаа их ашиг орлогыг авчрахын төлөө зүтгэх чадвартай учир туйлын үнэ цэнтэй хөрөнгө юм. Үнэнч ажилчид нь үйлчлүүлэгчдэдээ анхаарал халамж тавьж, тэдний хүсэл хэрэгцээг ойлгож үйлчилгээ үзүүлдэг. Мөн үнэнч ажилчид нь байгууллагадаа тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой тул хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах боломжтой. Ажиллагчдын үнэнч байдал нь ажилтан байгууллагадаа хэр үнэнч итгэлтэй байгаагаас буюу тухайн байгууллагад хамааралтай, холбоотой гэсэн мэдрэмж, санаа тавих байдал, үүрэг хариуцлагын мэдрэмж, байгууллагынхаа төлөө зүтгэх чадвар хэр байгаагаас хамаарна. Мөн байгууллагынхаа сайн сайхны төлөө өөрийгөө зориулах чадвар буюу хөрөнгө оруулалт хийхэд тухайн ажилтнууд хэр зэрэг бэлэн байгаагаар нь тодорхойлох боломжтой.

Ажилчдын байгууллагатайгаа нэгдэх сэтгэл санааны холбоог хүчирхэгжүүлэх гурван үндсэн хүчин зүйл байдаг. Үүнд:

1. Бүх ажилчдыг үүрэг хариуцлагын мэдрэмжтэй болгох,
2. Тухайн байгууллагад ажиллах нь найдвартай, баталгаатай байдаг гэсэн мэдрэмж, сэтгэгдлийг бүх ажилчдад төрүүлэх,
3. Бүх ажилчдад тэгш шударга ханддаг гэсэн ойлголтыг бий болгох

Судлаач Meyer & Allen нар ажиллагчдын үнэнч байдлыг гурван томоохон хэсгээр буюу **сэтгэл хөдлөлийн үнэнч байдал, тасралтгүй үнэнч байдал, энгийн үнэнч байдал** гэж тодорхойлсон. Иймд байгууллагадаа үнэнч байх хандлага нь ажилтны байгууллагадаа гаргаж байгаа сэтгэл, байгууллагаас гарвал алдаж болох зүйлсээ олж мэдэх мэдрэмж, байгууллагадаа үлдэх гэсэн ёс зүйн үүрэг гэж харагдаж байна. *Ажиллагчдын үнэнч байдал* нь байгууллагадаа үлдэх бэлэн байдал, гадны хүмүүст байгууллагынхаа ашиг сонирхол, дүр төрхийг таниулахад үнэнчээр зүтгэдэг байгууллагын иргэншсэн зан төлөв юм.

Mowday, Steers, Porter нарын эрдэмтэд ажиллагчдын үнэнч байдлыг дараах гурван зүйлийг өөртөө багтаана гэж тодорхойлжээ. Эдгээр нь:

- а/ Байгууллагын зорилго, үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх, түүнд хүчтэй итгэх итгэл
- б/ Байгууллагаа төлөөлж их хэмжээний хичээл зүтгэл гаргах хүсэл зориг
- в/ Үргэлжлүүлэн байгууллагынхаа гишүүн байх хүчтэй хүсэл зориг гэжээ.

Үнэнч байдлын хоёр хэмжээс- Үнэнч байдал болон итгэл нь өсөн нэмэгдэж буй чанар юм. Энэ нь ажилтан компанид үнэнч эсэх эсвэл хэрэглэгч компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд үнэнч эсэхийг хайж олоход тусалдаг. Энэ нь хоёр хэмжээстэй:

а. Дотоод үнэнч байдал: Дотоод үнэнч байдал нь ажил руу чиглэх сэтгэл хөдлөлийн илэрхийлэл хэмээн тодорхойлогддог. Энэ нь санаа тавих, хайрлах болон зан чанар гэх мэтийг оролцуулдаг. Энэ нь мөн ажилдаа сэтгэл хөдлөлтэйгөөр харьцахыг хэлнэ. Энэ нь ажил дээр гаргах тухайн хүний дотоод сэтгэл хөдлөлийг гарган дүрсэлдэг.

б. Гадаад үнэнч байдал: Гадаад үнэнч байдал нь яг үнэнч байдал гэж юу байдгийг харуулдаг. Байгууллага нь үнэнч байдлын зан чанарыг ойлгохын тулд хэрэглэгчдээс тусламж авдаг. Ажилчдын оролцоо нь гадаад үнэнч байдалд шууд хамааралтай. Ажилтан хэрхэн хамгийн сайнаар ажиллахыг хичээж буйг менежментийн үүднээс судлах шаардлагатай.

Ажиллагчдын үнэн байдлыг тодотгох үзүүлэлтүүд:

Мэргэжил рүү чиглэх үнэнч байдал	
Хамтран ажиллагсаддаа үзүүлэх үнэнч байдал	
Байгууллагад үзүүлэх үнэнч байдал	
Компанийн нууцыг хадгалах	
Эхлүүлсэн зүйлээ дуустал нь найдвартай хийх	
Байгууллагын дүрэм журам, тушаалыг дагах	
Компанийн өмчийг зүй бусаар ашиглахгүй байх	
Хамтран ажиллагсад нь шаргуу ажиллаж байх үед нь туслах	

Зураг1.1. / Ажиллагчдын үнэнч байдлын тодотгол

Ажилтны үнэнч байдлын хандлага: Хэрэглэгчийн сэтгэл ханамж болон ажилтны үнэнч байдал нь байгууллагад маш том үр ашгийг авчирдаг. Үнэнч байдал, бүтээмж болон ашигтай байдлын дунд маш их холбоотой. Ашиг болон өсөлт хоорондын холбоо нь хэрэглэгчийн сэтгэл ханамж дээр суурилан хэрэглэгчийн үнэнч байдлыг тохируулснаар шийдэгддэг. Үйлчилгээний үнэ цэнэ нь ажилтны бүтээмжтэй холбоотой бол хэрэглэгчийн сэтгэл ханамж нь үйлчилгээний үнэ цэнтэй холбоотой. Ажилтны бүтээмж нь ажилтны үнэнч байдалтай, үнэнч байдал нь ажилтны сэтгэл ханамжтай холбоотой. Энэ нь дараах зүйлсээр хангагддаг.

- Бизнесийн үнэ цэнэ Компанид амжилт авчрахад туслах
- Мөнгө болон нөхөн төлбөрөөр хангах Компанийн талаарх эерэг төсөөллийг хэвээр үлдээх

Байгууллагын үнэнч ажилтны талаар эрдэмтэд судлагдсан байдал:

“Ажиллагчдын үнэнч байдал” сэдвээр олон орны эрдэмтэн судлаачид өргөн хүрээгээр судалжээ. Гадаадын эрдэмтдийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээс дурдвал:

(*Sajid & Mohammad, 2008*) Пакистаны мэдээллийн технологийн

мэргэжилтнүүдийн дунд байгууллагадаа үнэнч байх хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг хийхдээ карьер өсөлт, ажлын байрны нөхцөл, ажил амьдралын тэнцвэр зэрэг хүчин зүйлүүдийг судлан байгууллагадаа үнэнч байх хандлагад эерэг хамааралтай гэсэн таамаг дэвшүүлж судалсны үр дүнгээр ажлын нөхцөл байдал сул хамааралтай, карьер өсөлт, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хадгалах бодлого хүчтэй хамааралтай гэж үзжээ. Байгууллагууд гэр бүл рүү нь чиглэсэн бодлогод анхаарч, карьер хөгжлийн боломжоор хангаж өгөх нь тэднийг байгууллагадаа үнэнч байхад илүү түлхэц болно гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

(Debra & Valerie, 2012) Энэтхэг улсын технологийн салбарын 1229 ажилтнаас веб суурьт судалгаа авч ажлын байрны баталгаа, ажлын байрны стресс, ажил амьдралын тэнцвэр, өсөн дэвших боломж нь байгууллагадаа болон ажил мэргэжилдээ үнэнч байх хандлагатай хэрхэн хамааралтайг судалжээ. Ажил мэргэжилдээ үнэнч байх хандлагад эрэгтэй эмэгтэй ажилтнууд ялгаатай ханддаг. Өсөн дэвших сэтгэл ханамж, ажил амьдралын тэнцвэрийг эмэгтэйчүүд илүү чухалчилж, эрэгтэйчүүдийн хувьд ажлын байрны стресс нөлөөлдөг байна. Байгууллагадаа үнэнч байх хандлагын хувьд эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс илүү ажлын байрны баталгаа буюу найдвартай байдал нөлөөлдөг гэсэн дүгнэжээ. Эрэгтэй, эмэгтэй аль нь байгууллагадаа үнэнч үлдэх хандлагыг нэмэгдүүлье гэвэл карьер өсөх боломж, карьер хөгжилд анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай гэж зөвлөсөн байна.

(Ahmad Ismail Al-Ma'ani, 2013) “Иорданы арилжааны банкнуудын ажиллагчдын үнэнч байдалд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа” сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, байгууллагын үнэнч байдалд ажиллагчдын сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, эрх мэдэл, идэвхжүүлэлт шууд нөлөө үзүүлдэг, хувь хүний нас, хүйс, ажилласан жил, боловсролын түвшин зэрэг нь дам нөлөө үзүүлдэг гэж үзсэн байна.

(Wong & Tong, 2014) Байгууллагадаа үнэнч байх хандлагын загваруудын үнэлгээ ба түүний бүрэлдэхүүн хэсгүүд Азийн хотуудад хэрхэн хамаарч нөлөөлж буйг судлан шинээр 5 бүрэлдэхүүнт загварыг гаргажээ.⁴⁵

(Hoo Lai Wan, 2015) “Ажлын байран дахь ажилтны үнэнч байдал: Хүний нөөцийн менежментийн Японы загварын үр нөлөө”⁴⁶ сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, нийтлүүлжээ.

(Noraazian & Khalip, 2016) Ажиллагчдын үнэнч байдлын 3 бүрэлдэхүүнт загвар⁴⁷ -ын талаар онол арга зүйн үүднээс дэлгэрэнгүй судалсан нь “International

⁴⁵ “International Journal of Human Resource Studies”

⁴⁶ “International Management Journals”

⁴⁷ “International Journal of Academic Research in Business and Social Sciences”



Journal of Academic Research in Business and Social Sciences”-д нийтлэгдсэн байна.

Манай орны хувьд ажиллагчдын үнэнч байдлын талаар үүрэн холбооны салбар, банкны салбарт магистрын түвшинд судлагдсан ч докторын түвшинд нэг сэдэвт зохиолын хэмжээнд нарийн судалгаа хомс байна. Судалгааны ажлуудыг дурдвал:

Доктор Дэд профессор З.Алтанчимэг, С.Буянхишиг /МУИС, Бизнесийн сургууль/ нар “Банкны ажиллагчдын үнэнч байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд манлайлал нь ажилтны ёс суртахууны үнэнч байдал болон тууштай үнэнч байдалд хамгийн ихээр нөлөөлдөг, ажлын таатай орчин, аюулгүй байдал, байгууллагын халуун дулаан уур амьсгал нь ажилтны үнэнч, тогтвортой ажиллахад эерэг нөлөөтэй бөгөөд ажилтны сэтгэл зүйн үнэнч байдалд хамгийн ихээр нөлөөлдөг болох нь батлагдлаа. Карьер өсөх боломж нь ажилтны сэтгэл зүйн үнэнч байдал болон тууштай үнэнч байдалд эерэг нөлөө үзүүлэх бөгөөд цалин урамшуулал нь ажилтны сэтгэл зүйн, тогтвортой болон ёс суртахууны үнэнч байдалд аль алинд нь эерэг сул нөлөө үзүүлсэн⁴⁸ гэж бичжээ.


Судлаачдын үзэж байгаагаар ажилтны үнэнч байдлын хандлага:

Хэрэглэгчийн сэтгэл ханамж болон ажилтны үнэнч байдал нь байгууллагад маш том үр ашгийг авчирдаг. Үнэнч байдал, бүтээмж болон ашигтай байдлын дунд маш том холбоо байдаг. Ашиг болон өсөлт хоорондын холбоо нь хэрэглэгчийн сэтгэл ханамж дээр суурилдаг хэрэглэгчийн үнэнч байдлыг тохируулснаар шийдэгддэг. Өнөө үед үйлчилгээний үнэ цэнэ нь ажилтны бүтээмжтэй салшгүй холбоотой байхад хэрэглэгчийн сэтгэл ханамж нь үйлчилгээний үнэ цэнтэй холбоотой. Ажилтны бүтээмж нь ажилтны үнэнч байдалтай чухал холбоотой. Мөн ажилтны үнэнч байдал нь ажилтны сэтгэл ханамжтай холбоотойгоор дараах зүйлсээр хангагддаг.

- Бизнесийн үнэ цэнэ Компанид амжилт авчрахад туслах
- Мөнгө болон нөхөн төлбөрөөр хангах Компанийн талаарх эерэг төсөөллийг хэвээр үлдээх

Stevens хэмээх эрдэмтэн ажиллагчдын үнэнч байх хандлагыг ердөө хоёр категорид ангилж болно гэж үзээд харилцааны хандлага болон сэтгэл зүйн хандлагууд юм. (Зураг 1.1.2)

⁴⁸ “Банкны ажиллагчдын үнэнч байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа” Эрдэм шинжилгээний өгүүлэл З.Алтанчимэг, С.Буянхишиг



Зураг1.1. 2 Ажиллагчдын үнэнч байх хандлагууд

Харилцааны хандлага: Харилцааны хандлага нь байгууллагаас үзүүлж буй урамшуулал, тусламж дэмжлэг, нөхөн олговор, хандив туслалцааны үр дүнд ажилтны зүгээс бий болж буй үнэнч байдал юм. Иймд байгууллага ажилтны давуу, сул талыг тодорхой болгон түүнд таарах тусламж дэмжлэгийн арга хэрэгслийг ашиглана. Сэтгэл зүйн хандлагыг нь анх Porter болон Smith нар томьёолж байгууллагад илүү идэвхтэй, чин сэтгэлээсээ эерэг байдлаар хандах гэжээ. Харилцааны хандлага нь зан төлөвийн болон хамаарлын хандлагад хуваагддаг.

Зан төлөвийн хандлага: Зан төлөвийн хандлага нь анх Бекерийн бүтээлээс анх гарсан гэж үздэг. Энэ нь солилцоонд суурилсан буюу “бүлэглэн мөрий тавих” онол гэдгээрээ танигдсан бөгөөд ажилтнууд ажлын байраа хадгалж, ашиг орлого нэмэгдэж л байвал байгууллагадаа үнэнч байна гэж үзжээ. Ажлаасаа гарсан тохиолдолд их хэмжээний зүйл алдана гэдгээ мэдсэн тохиолдолд зан төлөвийн хандлага илэрдэг. Энэ нь ажилтнуудыг өөр ажил хайхад саад болох нь бий. Ажилдаа үлдэх нь өөр ажилд орохоос илүү үр ашигтай, зардал багатай бол ажилтнууд ажилдаа үнэнч, сэтгэлтэй байна гээд үнэнч байх нь урамшууллын үр дүн, ажилтнууд ба байгууллагын хооронд хийгдсэн ашигтай солилцоо гэсэн санаа гарчээ.

Хамаарлын хандлага: *Эрдэмтэн* Johnston, Snizek нарын үзлээр эдгээр хандлага анх бий болсон шалтгаануудын нэг нь ажилтны зан төлөв болон төрх байдлыг нэгэн хэвийн байлгах зорилго байв. Ажилтан өөрийгөө байгууллага болон түүний зорилтын нэг хэсэг хэмээн үзэж байгууллагаа зорилгодоо хүрэхийн тулд нэг хэсэг нь байхыг хүсдэг сэтгэл зүйн байдлыг энэхүү хамаарлын хандлага тайлбарладаг. Хувь хүн хүсэл тэмүүлэлтэй, ил тод, үл буцах шинжтэй зан төлөвүүдтэй болсны дараа байгууллагадаа үнэнч хандлагатай болох үед тохиодог зан төлөвийн журмын холбоо гэж тодорхойлсон байдаг.

Сэтгэл зүйн хандлага: Сэтгэл зүйн хандлага нь байгууллагын зорилгыг хувь хүн өөртэйгөө хамт тодорхойлж, түүнд хүч чадлаа зориулах процесстой холбогдоно. Аливаа байгууллага ажилтнуудынхаа ажлын орчиндоо, байгууллагадаа, үнэт зүйл, зорилгодоо, хүний өөрийн ажил мэргэжлийн карьертаа, ажлын ёс зүйд бат үнэнч



байгаа мэдрэмжийг нь хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Энэ бүгд л сэтгэл зүйн хандлага мөн бөгөөд ажилтны байгууллагадаа хандах хандлага буюу түүндээ төвлөрөн оролцож буй өөрийн оролцоо юм. Байгууллагадаа хэрхэн төвлөрч байгаа нь 3 үндсэн зүйлсээс бүрддэг. Эдгээр нь:

- Байгууллагын зорилгын нэг хэсэг болох
- Үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох
- Байгууллагын ажилтан байх хүчтэй хүсэл зоригтой байх юм.

Ажиллагчдын үнэнч байдлын шинж тэмдэг: Ажиллагчдын үнэнч байдлыг илтгэх, түүнийг танин мэдэх хэд хэдэн шинж бий. Үүнийг дараах байдлаар ялгаж болдог:

1. Удирдлагатайгаа хялбархан ойлголцдог: Үнэнч ажилчид цалин сайн авахын тулд шаргуу хөдөлмөрлөж компанид амжилт авчрахад анхаардаг. Тэд нэг л өдөр компанийг орхиж болох боловч тэр өдөр хүртлээ байгууллагад амжилт авчрахын төлөө шаргуу хөдөлмөрлөдөг. Ажилчдын цөөн хэсэг нь даргаа дайсан мэтээр хардаг. Үнэнч ажилчид ба дарга хоорондын харилцааг бий болгож чаддаг.
2. Тэд даргадаа санал дэвшүүлэхдээ чөлөөтэй байдаг: Бүх ажилчид даргадаа тайлангаа шууд хүргэдэг ч тун удалгүй саарч эхэлдэг. Үнэнч ажилчид бол биелүүлэлтдээ анхаарч тогтмол тайлагнахыг хичээдэг.
3. Тэд хэзээ ч цуу яриа гаргадаггүй: *Зарим* ажилчид муу харилцааг бий болгодог ч үнэнч ажилчид цуу яриа, шүүмжлэл зэргийг үл тоог бусад ажилчдын хөдөлмөрийг үнэлж хүндэлдэг.
4. Тэд өөрсдийн бодлоо нууцаар дэлгэдэг: Мэтгэлцээн, санал зөрөлт нь асуудалд эерэг зүйл. Дээд түвшний шийдвэрийг бусад ажилчид дагах хэрэгтэй ч санал нэгдсэн үнэнч ажилтан нь санаа тавин яагаад гэдгийг түүнд тайлбарладаг.
5. Үнэнч ажилчид=шинэ санаачилга илүү сайн: Шинийг санаачлах урам зориг нэмэх гол шалтгаан нь эрсдэлийг хүлээж авах чадвартай холбоотой. “Бид бүхнийг ингэж л хийдэг” гэсэн хэвшсэн үзэлтэй хүн сөрөг байдаг. Бүх шинэ сэдэл санаачлага үр өгөөжтэй байдаггүй ч ажилчдын санаа оноог уриалгахан хүлээн авч багахан эрсдэлийг байж болох зүйлгээ үздэг бол шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ санаачлахдаа илүү идэвхтэй байх хандлагатай. Үйлчлүүлэгчдээ баярлуулах нь хүн бүрийн зорилго гэдгийг ажилчид мэддэг учраас шинэлэг зүйл сэдэж гаргахаас эмээдэггүй, үргэлжлүүлэн сайжруулахыг эрмэлзэх хандлагатай байдаг. Ажилтнуудын оролцоо, идэвх сонирхолд хяналт тавьснаар ажилчдын сэтгэл санаанд ямар нэгэн байдлаар нөлөөлж болзошгүй

үйл явдлуудаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Үнэнч ажилчдын байгууллагад авчрах давуу болон сул талууд:

Үнэнч ажилчид нь компанийн хөрөнгө гэж үзэгддэг. Байгууллагад үнэнч ажилчид байж болох ч тэд байгууллагад давуу болон сул талуудыг үүсгэдэг. (Зураг 1.1.3)

Үнэнч ажилчдын давуу талууд	Үнэнч ажилчдын сул тал
• Хувийн асуудал бага байх тусам ажил улам чанартай хийгдэнэ. • Тогтвортой байдлын эсрэг алдагдал • Ажил дээрх илүү их оролцоо • Бага хэмжээний ажил таслах зуршил • Бизнес илүү их амжилттай болно.	• Зардал болон төсөв нь үнэнч хөтөлбөрт зориулагддаг. • Туршлага их байх тусам ажилчдын идэвх буурдаг. • Бүтээмж багатай ажилчид ямар ч шинэ санаагүй байдаг.

Зураг 1.1. 3. Үнэнч ажилчдын байгууллагад авчрах давуу болон сул талууд

Онолын судалгаанаас үзэхэд ямар ч үйл ажиллагаа явуулдаг, бүх төрлийн байгууллага ажиллагчдынхаа үнэнч байдалд судалгаа хийвэл тогтвортой ажиллуулах боломжтой бөгөөд цаашид байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд үнэ цэнтэй байх юм.

ДҮГНЭЛТ

Дээрх онолын судалгаанаас үзэхэд: Байгууллага нь ажиллагчдынхаа үнэнч байдлыг судлан тодорхойлсноор ажлын гүйцэтгэл болон бүтээмжийг үнэлэх, хөгжүүлэх, хэрхэн урамшуулах, хэнд, ямар хэмжээний хөрөнгө оруулалт хийх, тогтвортой үнэнчээр ажиллахад менежментийн шилдэг аргуудыг ашиглан удирдах шаардлага тулгамдсан асуудал болжээ. Үнэнч ажилчдыг олноор бий болгоосноор эдийн засгийн үр өгөөж дээшлэн, өрсөлдөх чадварт нөлөөлөх үндсэн хүчин зүйл гэдгийг онолоор тодорхойлсон байна.

Дэвшүүлсэн санал: Үнэнч байдлыг судлах арга, аргазүйн талаас илүү дэлгэрэнгүй судлан хүргэх шаардлагатай байна. Байгууллагын үнэнч ажилтанд оруулах хамгийн том хөрөнгө оруулалт тул хүний нөөцийн менежментийн чадварт нөлөөлөх болно.

Судлаачид Үнэнч ажилтныг судлан салбар бүрийн онцлогт тохирох арга замыг гарган нэвтрүүлэх шаардлагатай байна.



НОМ ЗҮЙ:

1. Хандмаа А “Үнэнч ажилтан бол үнэт баялаг” илтгэл 2024 он
2. Хандмаа А “Байгууллагын харилцааны уур амьсгал ба ажлын үр дүн” илтгэл 2022 он
3. Хандмаа А. “Шинэ зууны менежментийн чиг хандлага” илтгэл 2023 он
4. <http://orel.rsl.ru/diss/>
5. <http://www.harvarduniversity.org>

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Доктор, Т.Булган

(ОУУБИС. ЭЗБС)

bulgan.t@ulaanbaatar.edu.mn

Abstract: In developing countries, there is a high need to implement labor-based policies as one of the key steps for national development and economic growth. In addition to the transition to market growth, it is important to ensure competitiveness based on indicators such as the use of labor resources, the skills and utilization of the workforce, and the flexibility of industrial activities and service market changes. To address this issue, a methodology for calculating labor resource utilization was analyzed at a practical level based on the theory of economic and business analysis and empirical quantitative data from the factory.

Түлхүүр үг: Хөдөлмөрийн нөөц, бүтээмж, ашиглалт, норм, норматив, бодит цалин ажлын фонд, өгөөмж

I. УДИРТГАЛ

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөрийн нөөцийг өндөр бүтээмжтэй ашиглах асуудлууд голлох байр суурийг эзэлж байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд хөдөлмөрийн нөөц нь мэдлэг, ур чадвар сайн байгаад зогсохгүй, байгууллага нь хөдөлмөрийн нөөц ашиглалтын үзүүлэлтүүдийг байнга тооцож, хэмждэг үр дүнд нь тулгуурласан бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой арга хэмжээ авч байх нь чухал байдаг. Байгууллагын эдийн засгийн бүх төрлийн нөөцүүдээс, хамгийн өргөжүүлэх боломжтой, богино хугацаанд үр ашигтай байдлаар ашиглан бизнесийн байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломжтой нөөц бол хөдөлмөрийн нөөц юм. Тиймээс манай орны хувьд үйлдвэрлэлийн салбар бусад оронтой харьцуулахад хэдий сайн хөгжөөгүй ч одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэлийн газрууд хөдөлмөрийн нөөц хангамж түүний ашиглалтыг салбар бүртээ онолын үндэслэлтэй арга зүйгээр тооцож, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг энэхүү судалгаагаар тодорхойлохыг зорив.

Судалгааны зорилго: Бизнесийн байгууллагын хөдөлмөрийн нөөц ашиглалтын арга зүйг онолын үндэслэлтэй боловсруулж, түүгээрээ дамжуулан

байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх арга, замыг эрэлхийлэх.

Судалгааны дэд зорилтууд:


Зорилт-1 Хөдөлмөрийн нөөц ашиглалтыг хэмжих үзүүлэлтүүдийн талаарх онол, арга зүйн асуудлыг судлах

Зорилт-2 Бизнесийн байгууллагын хөдөлмөрийн нөөц ашиглалтыг хэмжих үзүүлэлтийг практик түвшинд тооцож, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох

II. Хөдөлмөрийн нөөц ашиглалтын онол, арга зүйн судалгаа

Нэрт эрдэмтэн К.Маркс, Ф.Энгельс нар хөдөлмөр нь нийгмийн үзэгдэлд шилжихэд хөдөлмөрлөж байгаа хүн зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилготойгоор давхар нийгмийн хэрэгцээг хангаж байдаг учир хөдөлмөр нийгмийн үзэгдэл болдог хэмээн тайлбарлаж, хөдөлмөрийн эх үүсвэр нь хүний хүчин чармайлтыг үйлдвэрлэлийн процесст нийлүүлэх явдал чухал болохыг анх судалж байжээ. Өөрөөр хэлбэл түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээ болгоход шаардагдах мэдлэг чадвар, боловсон хүчин мөн тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх бүхий л үйл явцыг хөдөлмөр хэмжээн тодорхойлж болох юм.

Схем 1. Хөдөлмөрийн үйл ажиллагаа⁴⁹




Хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах ажил 19-р зууны сүүл үед анх Америкийн нэгдсэн улсад эхэлж үүссэн түүхтэй байдаг. Эрдэмтэн Ф.Тейлор 1886 онд *“Гүйцэтгэлээрх цалингийн систем”, “Үйлдвэрийн шинжлэх ухааны зохион байгуулах зарчмууд”* гэсэн бүтээл нь хөдөлмөрийг шинжлэх ухаанч зохион байгуулах капиталист болох үндэс болж байв. Үүнтэй холбоотойгоор хөдөлмөрийн нөөц гэсэн ойлголтыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед /1918 онд/ академич Струмилин хөдөлмөрийн нөөц нь хөдөлмөрийн хүчин буюу ажиллах хүчнээс илүү өргөн хүрээтэй хөдөлмөр эрхлэх хүн амын хамгийн боломжит дээд хэмжээг багтаасан ойлголт хэмээн олон улсын нэр томъёололд анх оруулсан байдаг.

Аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйлчилгээ явуулахад тодорхой хэмжээний хүчин зүйлсийг зайлшгүй ашигладаг. Үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэдэг нь үйлдвэрлэлд хэрэглэгдэх төрөл бүрийн нөөцүүдийг хэлнэ. Эдийн засгийн онолд

⁴⁹ Н.Содномдорж *“Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг”* 2000 он

үйлдвэрлэлийн хүчин зүйл болох хөдөлмөр нь тодорхой чиглэсэн зорилготой хүний үйл ажиллагааг хөдөлмөр хэмээн хэлнэ.

Схем 2. Үйлдвэрийн хүчин зүйл⁵⁰



Хөдөлмөр бол нийгмийн баялгийг бүтээж арвижуулах үйл ажиллагаа мөн. Хүний хөдөлмөрийн тодорхой хэсгийг чиглүүлэгч гол зүйл бол оюуны хөдөлмөр болон биеийн хүчний чадвараас хамаарна гэж үзээд судалгааны 3 түвшинд хөдөлмөрийн хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг.

- Макро түвшинд эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлж байгаа нөлөөллөөр нь буюу нийт салбарын гарцын өсөлт, улс орны нийт үйлдвэрлэл, нийгмийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн чанаржилт зэргээр хэмжигдэнэ хэмээн тодорхойлжээ.
- Мезо түвшинд тухайн хөдөлмөр эрхэлж буй хүний гэр бүлийн амьжргааны түвшинд гарч буй өөрчлөлт болох хэрэгцээ, хуримтлал, боловсрол зэрэг үзүүлэлтээр тодорхойлогдсон байдаг.
- Микро түвшинд цалин, орлого түүнээс бий болох үр өгөөжтэй холбон тайлбарласан байдаг.

Нийгмийн хөгжилд нөлөөлөхдөө:

- Материаллаг болон оюун санааны баялгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэлийн багаж хэрэгслийг боловсронгуй болгох
- Шинжлэх ухааны технологийн дэвшлийг хурдасгах
- Хөдөлмөрийн ачаар бүтээмжийг бий болгох

Хувь хүний хөгжилд нөлөөлөхдөө :

- Хүний биеийн болоод оюуны хөдөлмөрийн чадварын хөгжил
- Мэргэжил, мэргэшлийн боловсронгуй бодолтыг бий болгох
- Нийгэм, хүмүүсийн материалын ба оюуны хэрэгцээг хангах

⁵⁰ Д. Занданишарав, “Үйлдвэрийн газарт хөдөлмөрийг нормчлох тухай” 1977 он

- Хүн амын оновчтой нөхөн үйлвэрлэлийг бий болгох
- Хөдөлмөрийн нөөц нь тухайн улс орон хөдөлмөр эрхлэлт хамгийн дээд боломжийнхоо хэдэн хувийг ашиглаж байгааг мөн цаашид нэмэгдүүлэх боломжийг тодорхойлоход голлон хэрэглээд

Схем 3. Хөдөлмөрийн нөөц ашиглалтыг хэмжих үзүүлэлтүүд⁵¹



Хөдөлмөрийн нөөц ашиглалтын үндсэн үзүүлэлт болох нормын биелэлтийг хөдөлмөр зарцуулалтаар тооцохдоо жинхэнэ хийж бүтээсэн зүйлийг түүний нэгжийн хугацааны нормоор үржүүлж, нормоор зарцуулах цагийг гаргаад жинхэнэ ажилласан цагт хувааж 100-р үржүүлнэ. Дараах томъёогоор илэрхийлнэ.⁵²

$$\text{Нормын биелэлт} = \frac{П * Х_n}{Х_ж} * 100\% \quad (1)$$

П –хийж бүтээсэн зүйлийн хэмжээ /биет бүтээгдэхүүнээр/

Х_н –нэгжийн хугацааны норм

Х_ж –жинхэнэ зарцуулсан хугацаа

Хөдөлмөрийн нормын биелэлтийг цалингаар тодорхойлохдоо жинхэнэ гүйцэтгэсэн ажлыг тухайн нэгжийн үнэлгээгээр үржүүлээд гарсан цалингийн дүнг тухайн сард жинхэнэ ажилласан цагт нь ноогдох хийснээрх тарифт цалингийн дүнд хувааж 100-аар үржүүлэн тооцно.

$$\text{Нормын биелэлт} = \frac{Ц_a}{Ц_t} * 100\% \quad (2)$$

Энд: Ц_а –гүйцэтгэсэн ажлыг нь нэгжийн үнэлгээгээр үржүүлээд гарсан цалин

Ц_т –тухайн сард жинхэнэ ажилласан цагийг мэргэжлийн зэргийн хийснээрх тарифт цалингаар үржүүлээд гарсан цалин

Үйлдвэрлэлийн газар, цех, тасгийн нормын дундаж биелэлтийг тодорхойлохдоо:

- Зөвхөн нэг нэр төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр, бригад, цех, тасагт бүх ажилчдын хийсэн бүтээгдэхүүнийг хийвэл зохих бүх бүтээгдэхүүнд

⁵¹ С.Жамъянсүрэн “Бизнесийн шинжилгээний аргачлал” УБ хот, 2015 он

⁵² С.Чимэд-Ойдов, “Аж үйлдвэрийн газарын хөдөлмөрийн нормчлолын арга зүй” 1971 он

хувааж 100-аар үржүүлнэ.

- Олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг үйлдвэр, бригад, цех, тасгийн хийснээр хөлс авдаг ажилчдын нормын дундаж биелэлтийг гаргахдаа бригад, цех, тасгийн хэмжээгээр нормоор зарцуулах цагийн нийлбэрийг нийт ажилчдын жинхэнэ ажилласан цагийн нийлбэрт хуваан 100-аар үржүүлнэ.

III .Хөдөлмөрийн нөөц ашиглалтын шинжилгээ

Талх Чихрийн компани нь 1984 оны 07-р сарын 05-ны өдөр ЗХУ-н техник, эдийн засгийн туслалцаатайгаар Улаанбаатар хотод Талх, Чихрийн комбинат нэртэйгээр байгуулж ашиглалтад орж байсан манай улсын ууган үйлдвэрүүдийн нэг юм. Тус комбинат хоногт 90тн талх, жилд 5000тн төрөл бүрийн чихэр, 6550 тн жигнэмэг, өрмөнцөр, бялуу, 800 тн жимсний чанамал үйлдвэрлэх хүчин чадалтай байгуулагдаж байсан бол өдгөө 800 гаруй ажилтантай, хүнсний үйлдвэрлэлийн топ аж ахуй нэгжүүдийн нэг болтлоо өргөжсөн байна.. Олон жилийн туршлагатай үйл ажиллагаа явуулж эдийн засгийн ашигтай ажиллаж байгаа хэдий ч тус компанид хөдөлмөрийн нөөц ашиглалтын үзүүлэлтүүдийг системтэйгээр тооцдоггүй нь эдийн засгийн ашгийг бууруулах томоохон шалтгаан болж байгаа юм. Тиймээс энэхүү судалгаагаар тус компанийн хөдөлмөрийн нөөц ашиглалтын үзүүлэлтүүдийг онолын үндэслэлтэйгээр арга зүй боловсруулан тооцсон болно.

А. Норм, норматив

Хүснэгт 1. Талх Чихэр ХХК-ний хөдөлмөрийн нөөцийн хангамж /2024он/

№	Ажиллагсдын бүрэлдэхүүн	Тоо		Ханамжийн хувь
		Төл	Гүйцэтгэл	
1	Үйлдвэрийн ажиллагсдын дундаж тоо	800	800	100
2	Үүнээс ажилчид	760	764	100,5
	Туслах ажилчид	350	352	100,6
3	Инженер техникийн ажилтан, албан хаагчид	160	164	102,5
4	Бэлтгэгч	250	248	99,2

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ болон түүний зардал, ашиг зэрэг эдийн засгийн бусад үзүүлэлтүүд нь машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын хэмжээ, нийт ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын биелэлт тэдгээрийн ашиглалтын үр дүн, хөдөлмөрийн нөөцийн хангамжаас ихээхэн шалтгаална. Үйлдвэрийн хөдөлмөрийн нөөцийн хангамжийг гүйцэтгэлээр ажилчдын тоог мэргэжлийн хэрэгцээтэй зэрэгцүүлэх замаар тодорхойлох тус компанийн хөдөлмөрийн нөөцийн үзүүлэлтийг ашиглан тооцоход хөдөлмөрийн нөөцийн хангамж төлөвлөснөөс 0.5-2% илүү ашиглалттай байгаа нь үйлдвэрлэлийн өсөлтийг даган

үндсэн ажилтны хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Эдгээр ажилчдын цалингийн бүтцийг шинжлэхэд:

Хүснэгт 2. Цалин хөлсний сангийн бүтэц

№	Үзүүлэлт	Дүн /мян/			Бүтэц ФЗП	
		T0	T1	Δ	T0	T1
1	Цалин хөлсний нийт дүн	18000	20600	+2600	100	100
	Үүннэ: аж үйлдвэрлэлийн ажилтан	17500	20000	+2500	97,2	97,0
	Үүнээс: - ажилчид	13500	15800	+2300	75,0	76,7
	- албан хаагчид	4000	4200	+200	22,2	20,4
2	Үндсэн бус үйл ажиллагааны ажилтан	500	600	+100	2,8	2,9
3	А. Ажилласан цаг ба гүйцэтгэсэн ажилд тооцсон цалин хөлс	10175	11500	+1325	56,5	55,8
	- Шагнал оруулан тарифт цалин	4070	4830	+760	40,0	42
	- Хийснээр олгох цалин	6105	6670	+565	60,0	58
4	Б. Шагнал урамшууллын чанартай цалин	5400	6280	+880	30,0	30,5
	Ажилласан жил, мастер зэрэгт олгосон цалин	1835	2072	+237	34,0	33,0
6	- Шагнал, урамшуулал	3500	4145	+645	64,8	66,0
7	- Материалын тусламж	65	63	-2	1,2	1,0
	В. Нөхөн олгох шинж чанартай хөлс	1080	1195	+115	6,0	5,8
	Г. Ажиллагаагүй цагт нөхөн олгосон	1225	1442	+217	6,8	7,0
	Д. Цалин хөлсний сангийн бүрэлдэхүүнд оруулсан төлөх хөлс	120	183	+63	0,7	0,9

Талх Чихэр компанийн цалин хөлсний бүтцийг судлахад үйлдвэрийн үндсэн ажилчдаас илүү удирдах ажилтны цалин хөлс 1.7%-иар илүү нэмэгдсэн, ажилчдын хийснээр олгох урамшуулалт цалин 2%-иар буурсан, материалын тусламж 0.2%-иар буурсан, нөхөн олгох цалингийн хэмжээ буурсан зэрэг нь ажилчдын цалин хөлсний системийг сайжруулахад эдгээр хүчин зүйлсийг өөрчлөх, сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Бүтээгдэхүүн гаргалтын индекс нь 1,254 болж байна. Цалин хөлсний үнэмлэхүй болон харьцангуй зөрүүгээр тооцоход:

$$\Delta\text{ФЗПабс} = \text{ФЗП1} - \text{ФЗП0} = 2000 - 17500 = 2500$$

$$\Delta\text{ФЗПотп} = \text{ФЗП1} - \text{ФКПск} = \text{ФЗП1} - (\text{ФЗПперо} * 1\text{вп} + \text{ФЗПпосто}) =$$

$$2000 - (10500 * 1.254 + 7000) = 20000 - 20167 = -167$$

Цалин хөлсний сангийн харьцангуй зөрүүнээс үзэхэд дээрх компанийн

цалингийн сангийн ашиглалтын хэмжээ 167 мян.төгрөгний хэмнэлт гарсан нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлс болж байна.

Хүснэгт 3. Цалин хөлсний сан

№	Үзүүлэлт	T0	T1
1	Цалин хөлсний сан /мян.төг/	17500	20000
2	Үүнээс: хувьсах хэсэг	10500	12800
3	тогтмол хэсэг	7000	7200
4	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ /мян/	80000	100320

Судалж буй үеийн нэг ажилчны ажилласан цаг болон өдрийн тоогоор ажилчдын ашиглалтын байдлыг үнэлж ажлын цагийн фонд ашиглалтыг ажлын өдрийн үргэлжлэх хугацаа нэг ажилчны жилд ажилласан өдрийн тоо, ажиллагсдын тооноос хамааруулан судлахад:

$$- \Delta GB_{xi} = \Delta CP * DI * PI$$

Хүснэгт 4. Ажлын цагийн фонд ашиглалтын шинжилгээ

№	Үзүүлэлт	Нэг ажилчид ноогдох		Өөрчлөлт	
		T0	T1	1 ажилчинд ноогдох	Бүгд ажилчинд
1	Календарийн өдрийн тоо	365	365	-	-
2	Баярын ба амралтын өдөр	101	101	-	-
3	Ажлын цагийн ердийн фонд	264	264	-	-
4	Ил бус ажлын өдөр	39	49	+10	1640
5	Жил бүрийн амралт	21	24	+3	+492
6	Амралтын сургалт	1	2	+1	+804
7	Төрөх ба жирэмсний амралт, нэмэгдэл амралт	3	2	-1	-804
8	Захиргааны зөвшөөрөлтэй	5	8	+3	+492
9	Өвчтэй	9	11,8	+2,8	+459
10	Зугаалсан	-	1,2	+1,2	+197
11	Ердийн	-	4	+4	+656

Ажлын цагийн дотоод ээлжийн алдагдал нь нэг өдөрт 0,3 цаг, нийт ажиллагсдын гүйцэтгэсэн бүх өдөрт -51858 (804*215*0.3) цаг болж ажлын цагийн алдагдал гарчээ. Ажлын цагийн нийт алдагдал -64650 буюу 1,8% байна. Ажлын цагийн алдагдал бүрийг төрлөөр нь нарийвчлан судалбал энэ нь үйлдвэрийн газрын нөлөөллөөс буюу захиргааны зөвшөөрөлтэй арга хэмжээ, зугаалга зэрэг дотоод үйл ажиллагаанаас шалтгаалсан ээлжийн алдагдал ихээр үүссэн байна.

$$\Delta \text{ЧВстр} = \frac{\text{ВПо} + \Delta \text{ВПстр}}{\text{ФРВо} + \Delta \text{ФРВстр}} - \text{ЧВо}$$

Түүнчлэн шинжилгээний явцад хөдөлмөрийн бүтээмж ба дундаж цалин хөлсний өсөлтийн хоорондын хурдыг зохицуулж тогтоох хэрэгтэй. Үүний тулд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн хурд цалин хөлсний өсөлтийн хурдаас түрүүлж байх ёстой. Аль нэг хугацаанд ажилчдын дундаж цалингийн өөрчлөлт /цаг, өдөр, сар, жил /-ээр түүний индексийг тодорхойлж болно.⁵³

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{\text{Нэмэгдсэн өртгийн хэмжээ/ДНБ/}}{\text{Ажиллагчдын жилийн дундаж тоо}}$$

Хүснэгт 5. Хөдөлмөрийн бүтээмжийн хүчин зүйлийн шинжилгээ

№	Үзүүлэлт	Үзүүлэлтийн ач холбогдол		Өөрчлөлт /+, -/
		T0	T1	
1	Жилийн дундаж ажиллагсдын тоо	800	800	-
2	Үүнээс: ажилчид	800	804	+4
3	Нийт ажиллагсдын дунд ажилчдын эзлэх хувь	0,8	0,82	+0,02
4	Жилд нэг ажилчны ажилласан өдөр	225	215	-10
5	Нийт ажиллагсдын ажилласан цаг	1,404,000	1,296,450	-107,550
6	Ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа	7,8	7,5	-0,3
7	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, суурь оны үнээр	80000	83600	+3600
8	Нэг ажилчны жилд дунджаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	400	418	+18,0
9	Ажиллагсдын үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн	-	-	-
10	Жилд дунджаар	500	509,8	+9,8
11	Өдөрт дунджаар	2222,2	2371	+148,8
12	Цагт дунджаар	284,9	316,13	+31,23

Дээрх хүснэгтээс хөдөлмөрийн бүтээмжийн ерөнхий үзүүлэлтийг тооцоход ажилчдын тоо 2%-иар өссөн ч, жилд ажилласан өдрийн тоо 10-р буурсантай холбоотойгоор ажиллагсдын ажилласан цаг 107,550-р буурч, ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа мөн 0.3-р буурсан үзүүлэлтэй гарчээ. Гэхдээ нэг ажилчны жилд дунджаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ 18-р өссөн нь хөдөлмөрийн нөөц ашиглалтын эрчимжилт сайн байсныг үр дүнд нийт үйлдвэрлэл тайлант онд 3600-р нэмэгдэх үндэслэл болж өгсөн байна.

⁵³ Л. Оюунцэцэг, “Бүтээмжийн менежментийн онол арга зүйн асуудал” УБ хот, 2004 он

ДҮГНЭЛТ

Манай улсын хувьд үйлдвэрийн газруудын нөөц ашиглалтад хөдөлмөрийн нөөцийн зөв зохистой хуваарилалт, тэдгээрийг ашиглан бүтээмжийг нэмэгдүүлж байгаа үйл явц хараахан сайн хөгжөөгүй байгаатай холбоотой хөдөлмөрийн нөөц ашиглалтын хэмжих үзүүлэлтүүд, арга аргачлалыг судалж үйлдвэрийн газруудад авч хэрэгжүүлэх боломжтой аргачлалаар судалгаа хийсний үр дүнд дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

- Хөдөлмөрийн нөөц ашиглалтыг онолын хүрээнд судлахад хөдөлмөр нь үйлдвэрлэл үйлчилгээний явцад хүмүүсийн хооронд нэгэн зэрэг үүсэж байдаг харилцаа бөгөөд хөдөлмөрийн нөөц ашиглалтыг хөдөлмөрийн норм, цалин хөлс, ажлын цагийн фонд, хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлтүүдээр зохих аргачлалын дагуу тооцож байна

- “Талх Чихэр” ХК-ний хөдөлмөрийн нөөц ашиглалтын үзүүлэлтүүдийг тооцоход хөдөлмөрийн бүтээмж буурахад ажилчдын цалин хөлсний нормын үзүүлэлтүүд буурсан, нэгж ажилчинд ноогдох хөдөлмөрийн эрчимжилт нэмэгдсэнээс болж ажилтны ажлын ачаалал нэмэгдэж, энэ нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлс болсон байна. Үүнээс гадна ажлын цагийн дотоод алдагдал их байгаа нь байгууллага хөдөлмөрийн нөөцийн менежментийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардагдах ажиллагч хүчний зайлшгүй зарцуулбал зохих хөдөлмөрийн хэм хэмжээг зөв тодорхойлох, хүний нөөцийн менежментийн бодлогыг хөдөлмөрийн нормтой, цалин хөлстэй уялдуулан тогтоох нь эргээд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх гол шалтгаан болохоор байна.

НОМ ЗҮЙ

1. Б.Баярдаваа, Д.Гансүлд “Эдийн засгийн онол” 2007 он
2. Н.Содномдорж “Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг” 2000 он
3. Д. Занданшарав, “Үйлдвэрийн газарт хөдөлмөрийг нормчлох тухай” 1977 он
4. С.Чимэд-Ойдов, “Аж үйлдвэрийн газрын хөдөлмөрийн нормчлолын арга зүй” 1971 он
5. Ё.Дамбадаржаа “Аж үйлдвэрийн газрын хөдөлмөрийн нормчлал цалин хөлсний тухай” УБ хот, 2000 он,
6. С.Жамъянсүрэн “Бизнесийн шинжилгээний аргачлал” УБ хот, 2015 он
7. Л.Лхамням, Л.Саран “Хөдөлмөрийн эдийн засаг” УБ хот, 2004 он
8. Л. Оюунцэцэг, “Бүтээмжийн менежментийн онол арга зүйн асуудал” УБ хот, 2004 он

БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ



С.ДЭЛГЭРМАА, М.ДОВУУЧ

Монгол улсын экспортыг
нэмэгдүүлэхэд дээд Боловсролын
салбарын гүйцэтгэх үүрэг

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Докторант, С.Дэлгэрмаа (ОУУБИС. ЭЗБС)

delgermaa.s@ulaanbaatar.edu.mn

Доктор, дэд профессор М.Довууч (ОУУБИС. ЭЗБС)

dovuuch.m@ulaanbaatar.edu.mn

ABSTRACT: Our country's export product range is limited and it is mostly based on few number mining products, so we cannot increase exports volume of our country. Therefore, increasing the export of the non-mining sector has become an important issue.

One of the ways to increase non-mining exports is the higher education sector, and if the number of foreign students can be significantly increased, it can play an important role in ensuring the future development of the sector. When increasing foreign exchange reserves, increasing the income of other sectors, and improving the competitiveness of the country at all levels.

In order to develop domestic universities to be competitive and capable at the global level, government policies, cooperation between universities, management and organization of university, teacher development, training grants, salary systems, management and financing of programs and legal environment are very important.

First of all, there is necessary to improve internal rules and regulations of institution in line with the market principles. The state development policy, reform of the legal environment on the teacher issues play important role in the implementation of higher education reform.

Keywords: Higher education, export of higher education, teaching staff, international education.

ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл ихэвчлэн алдагдалтай гарсаар байгаа бөгөөд экспорт уул уурхайн цөөн тооны бүтээгдэхүүн дээр тулгуурлаж байна. Иймд экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, экспортын баримжаатай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа



уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх нь маш чухал асуудал болсон. Уул уурхайн бус экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжит нэг салбар бол дээд боловсролын салбар бөгөөд түүний хөгжлийг дэмжсэнээр экспорт нэмэгдэх төдийгүй бусад салбарын хөгжилд түлхэц болох юм.

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй дотоодын их, дээд сургуулиуд зөвхөн дотоод элсэгчдийн тоог нэмэгдүүлэх асуудал дээр анхаарал хандуулж, оюутны тоо, түүний өсөлтөд ач холбогдол өгдөг хандлага түгээмэл байна. Тодруулж хэлбэл олон оюутантай л бол сайн сургууль гэж дүгнэх хандлага нийгэмд оршсоор байгаа.⁵⁴

Дээд боловсролын салбарын даяаршил нь олон улсын байгууллагуудын түншлэл, эрдэмтэн судлаачдын шилжилт хөдөлгөөн, хил дамнасан дээд боловсрол буюу үндэстэн дамнасан боловсрол, цахим сургалт, сургалтын хөтөлбөрийн интернациональчлал зэрэг асуудлыг хамардаг. БМИҮЗ (2022)

Өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд дээд боловсролын салбар нь үйлчилгээний салбарын хувьд томоохон экспортлогч салбар болтлоо хөгжиж чадсан. Боловсролын салбарын экспорт нь зөвхөн их, дээд сургуулиудын хөгжил, үйл ажиллагаанд дэмжлэг болоод зогсохгүй бусад салбарын үйл ажиллагааг дэмжиж, үндэсний хэмжээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй юм. Тухайлбал худалдаа, үйлчилгээ, орон сууцны түрээс, нийтийн хоол, тээвэр, харилцаа холбоо, бэлэн хувцас болон бусад салбарын орлогыг нэмэгдүүлдэг.⁵⁵

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улс орны хөгжлийн тухай ярихад тэргүүлэх чиглэл, тэр дундаа боловсролын салбарын хөгжлийг авч үздэг. Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо боловсролын салбарын хөгжлийн стратеги, тэр дундаа дээд боловсролын салбарын хөгжилд гол анхаарал хандуулах учиртай.

Дээд боловсролын байгууллагын тоо 2005 онд 184 байсан бол 2024 оны байдлаар 65 болтлоо 2,8 дахин буурсан байгаа бөгөөд цаашдаа ч буурах хандлагатай. Их, дээд сургууль, коллежуудын хооронд өрсөлдөөн эрс нэмэгдэж, тооноос чанарт шилжих гэсэн зарчим хүчтэй үйлчилж байна. Өрсөлдөөн нь зөвхөн

⁵⁴ Сургуулийн үйл ажиллагааг үнэлэхдээ зөвхөн суралцагчдын тоогоор үнэлэх нь учир дутагдалтай юм. Харин сургалтын орчин, багшлах бүрэлдэхүүн, сайн хөтөлбөр байж шилдаг мэргэжилтэн бэлтгэж чадвал суралцагчдын тоо аажимдаа өсөх, тогтвортой хадгалагдах боломжтой юм.

⁵⁵ АНУ-ын боловсролын салбарын экспорт 2020 оны байдлаар 39 тэрбум америк долларт хүрч, тус улсын үйлчилгээний салбарын экспортын 6-рт жагсаж байсан. Мөн гадаад оюутнууд 416000 ажлын байрыг бий болгоход тусалсан гэсэн статистик судалгаа байна.


дотоодын боловсролын байгууллага хооронд өрнөх бус, гадаадын боловсролын байгууллага үүнд татагдах оролцох болсон.

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Үндсэн ажиллагчид	3352	6109	5907	5982	6134
Шинжлэх ухааны доктор	136	153	133	139	161
Боловсролын доктор	657	1697	2000	1611	1908
Академич	38	64	57	63	60
Профессор	136	369	436	326	342
Дэд профессор	166	564	666	593	623
Дээд боловсролын байгууллагын тоо	94	95	88	69	64

Хүснэгт 1. Үндсэн болон эрдмийн зэрэг, цолтой ажиллагчид

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээд боловсролын сургалтын байгууллагын хамгийн чухал нөөц бол эрдмийн зэрэг цолтой багш нар юм. Боловсролын салбарын экспортыг нэмэгдүүлэх буюу гадаад орнуудаас оюутан элсүүлэхэд юуны өмнө багшийн нарын мэдлэг чадвар өндөр, оюутны байр, сургуулийн орчин нэн тааламжтай байх ёстой. Ялангуяа гадаад хэлний мэдлэг өндөр, эрдмийн зэрэг, цолтой багш нар чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймд багш нар эрдмийн зэрэг хамгаалах болон цолоо ахиулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэргэжлийн зэрэг авах шаардлага үүсэж байгаа юм. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо буурах хандлагатай



Зураг 1. Монгол Улсын экспортын хэмжээ, тэрбум америк доллар

Монгол Улсын экспортын хэмжээ сүүлийн 10 жилээр авч үзэхэд 2020 оныг эс тооцвол тодорхой хэмжээгээр өсөж ирсэн нь сайшаалтай боловч түүний нэр төрөл хязгаарлагдмал, цөөн тооны бүтээгдэхүүний үнээс ихээхэн хамааралтай хэвээр байгаа юм.



Хичээлийн жил	Бакалавр	Магистр	Доктор	Нийт тоо
2020-2021	644	544	255	1443
2021-2022	478	683	385	1547
2022-2023	657	1935	1001	3593
2023-2024	681	1762	1227	3670
2024-2025	1058	2200	1459	4717

Хүснэгт 2. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутны судалгаа


2024-2025 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургуулиудад гадаадын 4717 оюутан суралцаж байна. ШУТИС-ийн бакалаврын сургалтын кредитийн дундаж төлбөр 142,000 төгрөг, ШУТИС-ийн магистрын сургалтын нэг кредитийн дундаж төлбөр 198800 төгрөг, докторынх 269800 төгрөг байна.⁵⁶ Үүнийг гадаад оюутнуудын тоо болон нэг жилд судлах дундаж кредитийн тоогоор тус тус үржүүлэн тооцвол 19 тэрбум, 776 сая, 4 мянган төгрөгийн орлого олж байна гэсэн үг. Гадаад оюутнуудын сургалтын төлбөрөөс олж буй орлогыг америк долларт шилжүүлэх юм бол 1\$=3530 гэж үзвэл 5.6 сая америк доллар байна. Тодруулж хэлбэл манай улсын дээд боловсролын салбарын экспорт 5,6 сая америк доллар байна.

Улсын тоо	2020-2021		2021-2022		2022-2023		2023-2024		2024-2025	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хятад	1003	69.5%	1182	76.4%	3150	87.7%	3174	86,5	4053	85,8%
ОХУ	214	14.8%	182	11.8%	278	7.7%	280	7,6	473	10%
Бусад	226	15.7%	183	11.%	165	4.6%	216	5,9	196	4,2%
Нийт	1443	100%	1547	10%	3593	100%	3670	100	4722	100
Улсын тоо	32		27		24		31		31	
Өсөлт	-		7.21%		132,25%		2,14%		28.7%	

Хүснэгт 3. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутны судалгаа, улсаар


2024-2025 оны хичээлийн жилд Монгол Улсад суралцаж буй 4722 гадаадын оюутан суралцаж байгаа бөгөөд өмнөх жилээс 28.7%-аар өссөн байна. Үүний 85.8% нь Хятад, 10% нь ОХУ, бусад 4.2% эзэлж байна. Харин бусад орноос суралцаж буй оюутны тоо буурах хандлагатай байгаа боловч 2 хөршөөс суралцаж буй оюутны тоо өсөх хандлагатай байна. Нийтдээ 30 гаруй улсын оюутан Монгол Улсад суралцаж байгаа нь цаашид өсөх ирээдүй харагдаж байна.

⁵⁶ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ (must.edu.mn)



Зураг 2. Монгол суралцаж буй гадаад оюутнуудын бүтэц, сургалтын шатлалаар

Монгол Улсын их, дээд сургуулиудад суралцаж буй гадаад оюутнуудын бүтцийг сургалтын шатлалаар авч үзвэл бакалавр 23,5%, магистрантууд 47,6%, докторантурт 28,9% нь ногдож байна.



Зураг 3. МУИС-д суралцагчдын бүтэц

Эх сурвалж: www.num.edu.mn

2024-2025 оны хичээлийн жилд МУИС-д нийтдээ 20431 оюутан суралцаж байгаагийн 19921 буюу 97.5% нь Монгол оюутан, 510 буюу 2.5% нь гадаадын оюутан суралцаж байна. Цаашид гадаад оюутнуудын тоог нэмэгдүүлэх боломжтой юм. АНУ-ын сургуулиудад гадаад оюутнууд 20 гаруй хувийг нь бүрдүүлдэг. Манай үндэсний хэмжээний томоохон их сургууль болох МУИС-ийн хувьд гадаад орноос элсэн суралцагч 2,5% байгаа нь харьцангуй бага ч гэлээ цаашид нэмэгдүүлэх нөөц боломж их байна. Сүүлийн жилүүдэд дотоодын бусад их, дээд сургуульд суралцагч гадаадын оюутнуудын тоо өсөх хандлагатай байгаа нь сайшаалтай юм.

ДҮГНЭЛТ

Манай улсын их, дээд сургуулиуд хоорондоо өрсөлдөх гэхээсээ илүүтэй харилцан ашигтай хамтын ажиллагааны хөтөлбөр хөгжүүлэх, хүчээ нэгтгэх, багш нараа дэмжих, урамшуулах замаар гадаад элсэгчдийн тоогоо нэмэгдүүлэх өргөн боломж байна. Их, дээд сургуулиудын идэвхтэй хамтын ажиллагаа нь бие биенээсээ харилцан суралцах, туршлага солилцох, багшийн хөгжлийг дэмжих, сургалт, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Багшийн хөгжилд тусгайлан анхаарч, багш нараа сайн бэлтгэж, дадлагажуулж, мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэхэд ажлын таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Үүний тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанартай боловсролыг суралцагчдаар дамжуулан импортолж, дараа нь боловсролын салбарын экспортлогч орон болох бүрэн боломжтой.

Дээд боловсролын салбарын экспортыг нэмэгдүүлэх нь гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болоод зогсохгүй, боловсролын болон бусад салбарын хөгжилд томоохон өөрчлөлт ахиц дэвшил гаргах төдийгүй манай улсын өрсөлдөх чадварт сайнаар нөлөөлөх нь дамжиггүй.

Уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэхэд дээд боловсролын салбарын экспорт чухал нөлөө үзүүлж, манай эдийн засгийн өрсөлдөх чадвар эрс дээшлэх юм. Одоогоор манай улсын уул уурхайн бус салбарын экспорт дөнгөж 7% байна. Харин дээд боловсролын салбар нь олон улсын боловсролыг олгох хэмжээнд хөгжиж, олон улсад өрсөлдөх чадвартай болбол экспортын хэмжээг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой салбар гэж үзэж байна.

Эцэст нь хэлэхэд юуны түрүүн гадаадын өндөр хөгжилтэй орны шилдэг их, дээд сургуулиудад боловсон хүчний бэлтгэж, ялангуяа багш нарыг бэлтгэх нь маш чухал бөгөөд төгсөгчид нь сургуулиа, эдийн засгаа, бизнесээ, нийгмээ, цаашлаад улсаа хөгжүүлж, импортлогч орноос экспортлогч орон болох бүрэн боломжтой юм.

ДЭВШҮҮЛЖ БУЙ САНАЛ

Нэг. Дээд боловсролын салбарын экспортыг нэмэгдүүлэхэд юуны түрүүнд гадаад оюутуудыг хүлээн авах тохилог, стандартад нийцсэн оюутны байруудыг барих шаардлагатай байна.

Хоёр. Их, дээд сургуулиуд гадаад оюутнуудад зориулсан хамтарсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэснээр өндөр түвшинд бэлтгэгдсэн багш нараар хичээл заалгах боломжтой болно.

Гурав. Дээд боловсролын экспортын хэмжээг дэмжих хүрээнд гадаадаас ирж суралцаж байгаа оюутнууд, дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Дөрөв. Гадаад оюутнуудад оршин суух визний хөнгөлөлт үзүүлэх, тааламжтай нөхцөл санал болгох

Тав. Хууль эрх зүйн орчин, сургалтын дүрэм журам, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох

НОМЗҮЙ

- Дээд боловсролын тухай хууль 2023
- www.boundless.com
- https://moe.gov.mn/posts?category_id=11403
- www.1212.mn
- www.must.edu.mn
- www.num.edu.mn

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТЭНХИМ



JISEON KIM

The social and economic dimensions of tipping practices

THE SOCIAL AND ECONOMIC DIMENSIONS OF TIPPING PRACTICES

Магистр, Jiseon Kim

(ОУУБИС, ЭЗБС)

jiseon.k@ulaanbaatar.edu.mn

Abstract: This study focuses on finding a more concrete approach to tipping in restaurants with a focus on hospitality through the analysis of various studies concerning it.

Although many studies have already dealt with this topic from different perspectives, this study aims to focus on the flow of theories on tipping, specify the different theories, and outline the factors to consider when executives and managers in the hospitality industry decide on a tipping policy. Various perspectives were analyzed in connection, and the relationship between tips and service provision and tips and service quality was investigated. Finally, this study also presents aspects to consider when applying the tipping culture in South Korea.

INTRODUCTION

Consumers who purchase services often voluntarily leave tips for various reasons. Consumers who purchase services often voluntarily leave tips for various reasons. Service workers, such as casino dealers, concierges, delivery workers, doormen, golf caddies, limousine drivers, caretakers, massage therapists, valets, porters, restaurant musicians, restroom attendants, shoe shiners, taxi drivers, and tour guides, frequently receive tips (Star, 1988)

Although tipping is not as widespread globally as it is in the United States, it still occurs in many countries around the world (Star, 1988). The term “TIPS” is often interpreted as “To Insure Prompt Service” (Star, 1988). Tips were initially established to enhance service quality, but as time passed were gradually transformed into an act driven by the desire to conform to social norms. This encourages customers to pay tips in order to maintain a good face in society and avoid the judgment of others in appearing to be ungrateful.

Some individuals tip with their future benefits in mind, including the desire for improved service or social approval. Thus, consumers are motivated by psychological and social factors rather than purely economic considerations when leaving tips.



In another instance, they often wish to satisfy a need for fairness and to reward the efforts of service providers (Bodvarsson & Gibson, 1997). And although tipping may act as partial compensation for excellent service, it may not function entirely effectively as an incentive mechanism (Lynn & Graves, 1996).

Interestingly, people do not always leave large tips for good service, nor do they consistently leave small tips for poor service. Thus, expectations for future service are unlikely to be the sole reason for tipping; rather, psychological and social motivations play a more significant role. Azar (2007) mentions that early motivations behind the tipping culture included reasons such as showing gratitude and a social desire to impress. However, as tipping became more institutionalized in American society, people's motivations shifted towards attempting to avoid feelings of embarrassment, guilt or unfairness that were often linked with not tipping. Azar (2004) reveals how social norms create a sense of "cost of guilt" for those who do not comply, leading to diners fearing the penalties that come with noncompliance with social expectations. In the US, the main question that customers have changed from whether to tip but rather to "how much to tip" (Mason, 2006).

Europe, on the other hand, replaced tipping customs with mandatory service charges during the twentieth century; it, however, remained deeply rooted across various industries in the United States. As tipping culture evolved, so did the tipping percentages, highlighting the dynamic nature of societal perceptions surrounding tipping practices (Azar, 2003).

The ability to actively manage customer tipping behavior raises important managerial questions:

- How should businesses determine tipping policies?
- What is the business function of tipping?
- When should tipping be considered appropriate?
- Should service charges or inclusive pricing replace tipping?

Unfortunately, there is a lack of available guidance for service industry managers as to how to address these questions.

Despite its importance, tipping has received relatively limited attention in the service marketing literature (Koku, 2005).

While previous studies, such as Mansfield (2016), have hinted at the diffusion of tipping norms across borders through international travel, a comprehensive understanding of tipping remains limited. Similarly, although organizational tipping practices likely play a significant role in shaping tipping behavior, the ways organizations adopt, adapt, and abandon tipping practices are not yet fully understood (Azar, 2011).

Although previous studies have documented the pros and cons of various tipping

systems (Azar, 2011; Lynn & Withiam, 2008), insights into how organizations make decisions regarding tipping policies remain scarce. Understanding these questions will contribute to breaking down the concept of the rapid evolution of tipping behaviors and ongoing debates surrounding tipping practices. Tipping has become an important center of topic in various disciplines - psychology, sociology, behavioral economics, and service management—because it is not perceived more so as a social norm rather as a purely economic transaction.

Some economists, such as Azar (2003, 2004a, 2004b, 2004c), Azar and Tobol (2008), and Bodvarsson & Gibson (1994, 1997, 1999), have devoted extensive research to the study of restaurant tipping. While significant knowledge has been accumulated regarding why people tip, the theoretical background concerning whether tipping acts as an effective monitoring mechanism remains ambiguous and complex.

Nevertheless, relatively few studies have systematically synthesized the flow of normative theories regarding tipping. To advance future research on restaurant tipping practices, it is essential to reorganize and consolidate the theories adopted by previous studies.

LITERATURE REVIEW

1. History of Tipping

Tipping in business contexts is a fascinating and complex phenomenon.

While the exact origins of tipping remain unclear, one form of tipping is believed to have emerged in

19th-century England, where boxes labeled “To Insure Promptness” were placed in coffee houses and inns, abbreviated as “TIP” (Lynn, 2003). Customers would donate to these boxes to ensure efficient service.

Another tipping tradition developed within the households of Tudor England, where visitors would offer additional payments to the host’s servants in recognition of their extra efforts. This custom, primarily arising in regions with servant classes, spread across Europe throughout the 17th century. However, in the United States, which lacked an established servant class, tipping was not initially common. It was only in the late 1800s that wealthy Americans traveling to Europe began adopting tipping as a way to demonstrate their sophistication and familiarity with European customs (Azar, 2004). Interestingly, European visitors to the U.S. during the 19th century observed that tipping practices were often associated with unskilled laborers, particularly former slaves, contributing to a negative perception of tipping in American society (Lynn, 2006).

Due to widespread opposition to tipping, seen as reinforcing servility, seven U.S. states passed anti-tipping legislation between 1909 and 1918 (Lynn, 2006). Although



forces such as the press, salesmen, and labor unions had fiercely opposed tipping, these laws were repealed by 1926, thus gradually institutionalizing tipping. Today, tipping is ubiquitous in service industries across the U.S., largely serving to supplement the often low base wages of service workers.

2. Classification of Prior Studies on Tipping

Given the widespread popularity of tipping, academic research on the topic remains relatively limited and fragmented across various disciplines such as sociology, organizational behavior, and psychology. Most sociological and organizational studies have focused on how tipping functions within the employee-client exchange relationship, affecting employee perceptions such as satisfaction and autonomy.

Research interest in tipping has notably increased among Western scholars over the past two decades, now focusing primarily on two dimensions: The socio- psychological aspect and the socio-economic aspect.

2.1 Socio-Psychological Aspect

William Foote Whyte (1948), through an extensive study of the restaurant industry, suggested that tipped workers often perceive tipping as a source of social inferiority.

Shamir's (1984) sociological analysis further confirmed that tipping reinforces employees' perception of hierarchical differences.

Butler and Skipper (1980, 1981) found that restaurant employees were more satisfied with tipping when they had greater autonomy at work, whereas managerial monitoring reduced their satisfaction with the tipping system.

Shamir (1983) investigated the relationship between job satisfaction, perceived links between performance and pay, attitudes toward customers, and role conflict between tipped and non-tipped employees. Tipped workers perceived a stronger connection between their performance and compensation and experienced greater role conflict due to their dual accountability to customers and management.

Seligman et al. (1985) conducted field experiments to validate laboratory findings about tipping behavior. For example, when pizza deliveries were late and customers attributed the delay to the delivery worker's fault, they left lower tips compared to delays perceived as beyond the worker's control.

Group size has also been linked to tipping behaviors: studies by Lynn and Latane (1984) and Snyder (1976) found that the larger the party, the smaller the tip per person, a phenomenon explained by the diffusion of responsibility.

Other factors correlated with tipping include customer gender (men tipping more generously), payment method (credit card users tipping more than cash payers), and the customer's bill size (Lynn & Latane, 1984).

Surprisingly, service quality itself was found to be weakly related to tipping behavior; instead, personal interactions, such as servers touching customers lightly, significantly influenced tip amounts (Crusco & Wetzel, 1984; Stephen & Zweigenhaft, 1986).

2.2 Socio-Economic Aspect

Economists have explored tipping primarily through theoretical models, focusing on tipping as an efficient mechanism for monitoring service effort.

Benzion and Karni (1977) developed a model suggesting that tipping mainly occurs among repeat customers, as tipping functions both as a reward and an incentive for maintaining service quality.

Similarly, Pencavel (1977) emphasized that tipping is closely related to customer monitoring and performance-based compensation. Jacob and Page (1980) proposed that optimal monitoring involves a three-way interaction among the owner, employee, and customer. Sisk and Gallick (1985) approached tipping from a contract theory perspective, viewing it as a mechanism to protect buyers from opportunistic sellers when brand reputation alone is insufficient.

Empirical economic research on tipping was then further significantly advanced by Bodvarsson and Gibson (1994, 1997, 1999), who found that the amount of the tip is more strongly correlated with the size of the bill than with service quality or frequency of patronage. Schwartz (1997) argued that tipping could allow businesses to practice price discrimination between customers with varying tipping propensities, thereby increasing overall profitability. Schwer and Daneshvary (2000) studied tipping practices in beauty salons, highlighting that factors such as price, gender, age, and appointment scheduling significantly impact tipping behaviors.

Recent research by Bodvarsson, Luksetich, and McDermott (2003) suggested that tipping is driven more by conscientious evaluations of service transactions than by social customs alone.

2.3 Tipping as a Social Norm

Social norms represent collective attitudes toward what is deemed acceptable or unacceptable behavior (Conlin, Lynn, & O'Donoghue, 2003). Tipping, especially in the presence of others who habitually tip, becomes a socially expected behavior. For instance, when dining with friends who leave tips, individuals often feel compelled to do the same, even if they would not have tipped alone. In contrast, in cultures such as Japan, where tipping is not a social norm, failing to leave a tip is not considered to be embarrassing (Margalioth, Saporiti, & Coloma, 2010).

Similarly, airline stewards and stewardesses are generally not tipped despite providing service similar to that of restaurant servers (Conlin et al., 2003). This underscores the statement that tipping is a highly context-dependent concept and is more enforced by

internalized social expectations rather than by direct external pressure.

3. Influencing Factors on Tipping Behavior

As discussed earlier, one of the primary reasons individuals tip is the psychological discomfort associated with violating social norms.

The pressure to tip is particularly strong in group settings, but is also experienced when dining alone.

A second major motivator for tipping is the expectation of better future service (Conlin et al., 2003). Customers who anticipate revisiting the same establishment may tip generously in hopes of securing superior service during subsequent visits.

Pre-emptive tipping—offering a tip before service is rendered—is another phenomenon (Lynn & Graves, 1996). For example, a customer might tip the manager or server in advance to secure a better table reservation. It is important to distinguish between pre-emptive tipping and bribery: while both involve offering money before service, bribery entails soliciting undeserved favors at the expense of others (Azar, 2002).

4. Tipping Efficiency

Tipping serves as a customer-driven mechanism for incentivizing service quality. Because managers often find it costly and challenging to monitor service directly, they effectively delegate this role to customers. Tipping allows customers to reward servers based on perceived service quality without requiring formal managerial oversight (Lynn, 2001). This informal contract between customers and servers enables market-based corrections for unsatisfactory service, where dissatisfied customers can choose to withhold tips. However, issues such as free-riding arise when customers tip generously even for standard service, potentially leading to distorted incentives.

5. Holiday Tipping

Tipping during holidays often carries additional emotional significance.

Customers may tip to express gratitude, demonstrate generosity, or enhance their self-image (Azar, 2002). Holiday tipping thus reflects both a personal and social affirmation of generosity, with individuals feeling better about themselves as a result (Bodvarson, 2005).

6. Tipping Amount and Worker Performance

Tipping can foster competition among service employees (Bodvarson & Gibson, 1994). Workers may strive to outperform colleagues to secure larger tips. In some establishments, pooled tipping systems distribute tips evenly among workers, promoting teamwork and loyalty.

However, pooled systems also require a high degree of mutual trust among employees.

7. Tipping as a Customer Management Tool

According to Bodvarson and Gibson (1994), customers who leave small or no tips indirectly communicate dissatisfaction to workers, potentially affecting service quality without requiring managerial intervention. In some cases, management may even use tipping patterns as a metric for evaluating employee performance and determining promotions.

RESULTS AND DISCUSSION

1. Connections Across Research Perspectives

Although the primary perspectives found in previous studies are distinct, there are overlapping, evolving, and sometimes confusing linkages among different theoretical backgrounds (Azar, 2004b; Lin, 2007; Conlin, Lynn, & O'Donoghue, 2003; Parrett, 2003).

Economic models fundamentally assume that customers derive no utility from tipping differently than social norms dictate. This assumption further supports the theories of social norms, which suggest that social approval and disapproval regulate behaviour rather than direct monetary incentives. Game theory becomes particularly more relevant in situations where customers make repeated visits rather than being one-time patrons. In repeated interactions, tipping functions as a credible strategy to maintain service quality (Kolstad, 2007).

Azar (2004c) investigated how optimal monitoring intensity changes when employees receive external incentives such as tips. He used a two-stage game model where restaurant management first selects the degree of monitoring, and then servers choose their level of service quality in response. According to Azar (2004c) and Conlin et al. (2003), customer-driven monitoring mechanisms only work effectively when tipping amounts correlate with perceived service quality. This partially supports Arrow's (1971) broader suggestion that social norms arise to compensate for market failures and enhance overall social welfare.

Several findings substantiate Arrow's idea:

- First, although the correlation is weak, there is a positive relationship between service quality and tipping amounts.
- Second, if tipping were entirely due to imitation, tipping culture would not have been as strongly institutionalized; rather, it is sustained by a combination of guilt aversion, altruism, and social pressure.
- Third, tipping introduces variability in worker compensation, transferring some business risk to employees (Holland, 2009).



Both Azar (2004c) and Holland (2009) used economic models based on concepts such as fairness, reciprocity, and guilt avoidance to analyze the role of tipping in mitigating risks and incentivizing service quality.

2. Integrated View of the Relationship Between Tipping and Service Quality
Most studies have found only a modest positive correlation between tipping

percentages and service quality. From the perspective of social norm theory, it is inferred that deviating from expected tipping behavior induces feelings of shame or guilt, motivating individuals to comply (Lin, 2007).

Tipping behavior is influenced not only by preferences for fairness and altruism but also by deeply internalized social norms. Tipping serves both as an expression of gratitude toward workers and as a fulfillment of psychological needs for social approval (Azar, 2005). Parrett (2003) suggested that customers tend to punish poor service with lower tips and reward good service with slightly above-average tips, reinforcing the role of tipping in monitoring service quality. Even so, because tipping occurs within a relatively narrow percentage range, it does not fully adjust to variations in service quality (Azar, 2004a, 2004b; Byun, 2008; Holland, 2009).

Consumers generally prefer to avoid emotional discomfort by maintaining standard tipping ranges, even when they experience either poor or excellent service. They are reluctant to substantially decrease or increase their tipping percentages, trading monetary gains or losses for emotional equilibrium. Furthermore, servers are highly motivated by customer praise and tipping, yet they may experience disappointment if tips fall below their expectations despite seemingly good service.

Thus, a psychological inertia persists in tipping behavior, maintaining existing tipping percentages unless the service experience is exceptionally bad or outstanding.

Tipping patterns reveal that consumers are sensitive not only to service quality but also to the social consequences of their actions, preferring to avoid negative perceptions from servers and fellow diners. Additionally, intrinsic motivations such as empathy for service workers often drive higher tipping percentages among affluent or conscientious customers (Azar, 2003).

3. Implications for Introducing Tipping in South Korea

Traditionally, tipping has not been a common practice in South Korea.

Oftentimes, especially in upscale hotels, service charges, equivalent to 10% of the bill, are automatically included in the payments.

On the other hand, there are cases in high-end Korean and Japanese restaurants where tips are offered as a means of showing appreciation and securing better service. However, this poses a threat to the candid tipping practices that may encourage bribery. This is particularly the case when customers are persuaded that they are entitled to

special treatment in exchange for tips. Nonetheless, the tipping culture can truly reflect gratitude for exceptional service in contexts where service staff are fully compensated by their employers.

Although tipping has not been widespread in Korea, spontaneous tipping behaviors are increasingly observed, particularly in high-end service sectors.

The gradual Westernization of consumer expectations may further popularize tipping as a mechanism for rewarding exceptional service (Park, 2008).

However, the cultural motivations behind tipping in Korea differ significantly from those in Western societies. Confucian values emphasizing social harmony and saving face play a stronger role. Avoiding public embarrassment can lead Korean customers to engage in tipping behavior more readily than Western-style guilt aversion alone would predict.

Comparative studies on tipping motivations between Korean and Western contexts could offer valuable insights. Moreover, given the relatively low minimum wages for restaurant workers in Korea, tipping could contribute to reducing income inequality and improving employee welfare. Tipping may also ease the financial burden on small business owners by supplementing employee incomes through customer contributions.

Nonetheless, differences between tipping and service charge models have significant tax implications: Tips, if voluntarily given, are subject to different tax treatments than mandatory service charges, which are officially recorded income. Thus, encouraging tipping rather than service charges could retain the customer-driven service monitoring function while also improving worker satisfaction.

Conclusion and Limitations

Tipping is a complex, fascinating, and highly consequential phenomenon.

Although management scholars have historically overlooked tipping behavior, significant contributions have been made toward understanding why tipping occurs and its broader impacts on individuals, organizations, and society. The normative aspect of tipping stems from the assumption that people tip to conform to societal expectations. Social norms are reinforced by collective approval and disapproval from society members. The tipping norm is maintained by various emotional forces, including the desire to impress others, empathy for low-wage workers, avoidance of embarrassment, guilt, anxiety, and shame. Behavioral economists' models, which incorporate human emotions into classical economic theories, have significantly advanced our understanding of tipping behavior as a form of social norm compliance.

Another critical topic in restaurant tipping studies is the relationship between tip size and service quality. Assessing whether tipping serves as an effective market mechanism for monitoring service quality and improving social welfare remains vital. Although most



studies show only a weak correlation between tipping percentages and service quality, this finding could result from endogeneity bias in the research design (Bodvarsson, Luksetich, & McDermott, 2003).

Nevertheless, there is sufficient evidence that tipping not only monitors service quality but also compensates for inefficiencies in market operations by aligning incentives between customers and service providers. Research on restaurant tipping has provided valuable insights into applying economic theories of behavioral incentives to hospitality services, and it also offers practical implications for discussions surrounding the expansion of tipping practices in South Korea. The limitation of this paper is that the overall relationship between tips and service quality was derived only through prior research and social norm theory.

Future research would benefit from applying quantitative methods to empirically validate the normative propositions outlined here. Moreover, further studies are needed to examine whether Korean consumers prefer tipping over fixed service charges as a mechanism for recognizing service quality. Given the evolving landscape of hospitality services and consumer expectations, understanding the nuanced motivations behind tipping in different cultural contexts will remain an important topic for future inquiry.

REFERENCES

1. Azar, O. H. (2002). *Is future service a reason for tipping? Theory and evidence* (Working paper). Northwestern University.
2. Azar, O. H. (2003). The implications of tipping for economics and management. *International Journal of Social Economics*, 30(10), 1084–1094. <https://doi.org/10.1108/03068290310492853>
3. Azar, O. H. (2004). The history of tipping from sixteenth-century England to the United States in the 1910s. *Journal of Socio-Economics*, 33(6), 745–764. <https://doi.org/10.1016/j.soccec.2004.09.033>
4. Azar, O. H. (2005). The social norm of tipping: A review. *Journal of Applied Social Psychology*, 35(8), 1632–1650. <https://doi.org/10.1111/j.1559-1816.2005.tb02187.x>
5. Azar, O. H. (2007). Do people tip strategically to improve future service? Theory and evidence. *Canadian Journal of Economics*, 40(2), 515–527. <https://doi.org/10.1111/j.1365-2966.2007.00314.x>
6. Benzion, U., & Karni, E. (1977). Tip payments and the quality of service. In R. Ehrenberg (Ed.),
7. *Essays in labor market analysis* (pp. 37–55). McGraw-Hill.
8. Bodvarsson, Ö. B., & Gibson, W. A. (1994). Gratuities and customer appraisal of

- service: Evidence from Minnesota restaurants. *Journal of Socio-Economics*, 23(3), 287–302. [https://doi.org/10.1016/1053-5357\(94\)90024-8](https://doi.org/10.1016/1053-5357(94)90024-8)
9. Bodvarsson, Ö. B., & Gibson, W. A. (1997). Economics and restaurant gratuities: Determining tip rates. *American Journal of Economics and Sociology*, 56(2), 187–204. <https://doi.org/10.1111/j.1536-7150.1997.tb02550.x>
 10. Bodvarsson, Ö. B., & Gibson, W. A. (1999). An economic approach to tips and service quality: Results of a survey. *Social Science Journal*, 36(1), 137–147. [https://doi.org/10.1016/S0362-3319\(99\)80023-2](https://doi.org/10.1016/S0362-3319(99)80023-2)
 11. Bodvarsson, Ö. B., Luksetich, W. A., & McDermott, S. (2003). Why do diners tip and how do they decide how much? *Journal of Economic Psychology*, 24(4), 673–690. [https://doi.org/10.1016/S0167-4870\(03\)00003-3](https://doi.org/10.1016/S0167-4870(03)00003-3)
 12. Conlin, M., Lynn, M., & O'Donoghue, T. (2003). The norm of restaurant tipping. *Journal of Economic Behavior & Organization*, 52(3), 297–321. [https://doi.org/10.1016/S0167-2681\(03\)00003-1](https://doi.org/10.1016/S0167-2681(03)00003-1)
 13. Crusco, A. H., & Wetzel, C. G. (1984). The Midas touch: The effects of interpersonal touch on restaurant tipping. *Personality and Social Psychology Bulletin*, 10(4), 512–517. <https://doi.org/10.1177/0146167284104013>
 14. Holland, S. J. (2009). Tipping as risk sharing. *The Journal of Socio-Economics*, 38(4), 684–693. <https://doi.org/10.1016/j.socec.2009.03.003>
 15. Kolstad, I. (2007). The evolution of social norms: With managerial implications. *The Journal of Socio-Economics*, 36(1), 58–72. <https://doi.org/10.1016/j.socec.2005.11.042>
 16. Lin, T. C. (2007). Economic behavior of restaurant tipping. *Economics Bulletin*, 4(2), 1–10.
 17. Lynn, M. (2001). Restaurant tipping and service quality: A tenuous relationship. *Cornell Hotel and Restaurant Administration Quarterly*, 42(1), 14–20. <https://doi.org/10.1177/0010880401421002>
 18. Margalioth, Y., Saporiti, A., & Coloma, G. (2010). Tipping customs: The effects of culture and beliefs. *Journal of Economic Behavior & Organization*, 76(3), 395–406. <https://doi.org/10.1016/j.jebo.2010.08.004>
 19. Park, T. S. (2008). Tipping in the tourism industry. *Tourism & Leisure Studies*, 20(3), 167–186.
 20. Seligman, C., Finegan, J. E., Hazlewood, J. D., & Wilkinson, M. (1985). Manipulating attributions for profit: A field test of the effects of attributions on behavior. *Social Cognition*, 3(4), 313–321. <https://doi.org/10.1521/soco.1985.3.4.313>
 21. Star, N. (1988). *The international guide to tipping*. Berkeley Publishing Group.
 - Whyte, W. F. (1948). *Human relations in the restaurant industry*. McGraw-Hill.

ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ



П.АНХМАА

Амиа хорлох гэмт явдал, түүнээс урьдчилан сэргийлэх
зарим асуудал

АМИА ХОРЛОХ ГЭМТ ЯВДАЛ, ҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Магистр, П.Анхмаа

(ОУУБИС. ХЗС)

ankhmaa.p@ulaanbaatar.edu.mn

Товч хураангуй: Сүүлийн жилүүдэд иргэдийн дунд санаа зовинол, сэтгэл түгшүүлсэн үйлдэл ихсэж байгаа нь амиа хорлолт юм. Нийгмийг цочроон улам бүр газар авч буй амиа хорлох гэмт үйлдлийн шалтгаан нөхцлийг судалж, энэ гэмт явдал энгийн үзэгдэл болохоос өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай боловсруулж ашиглан нийгмийн амьдралын хэв маяг, сөрөг үзэгдэл, сэтгэхүйн хар бараан нөлөөллийг арилгахад анхаарах цаг нэгэнт болжээ. Энэхүү гэмт явдлын шалтгаан нөхцлийг судлаж тогтоох ач холбогдолтой болно.

Түлхүүр үг: амиа егүүтгэх, амиа хорлох гэмт явдал, гэмт хэрэг

ОРШИЛ

Хүн төрөлхтөн нийгмийн хөгжлийн олон үе шатыг дамжин өнөөгийн тааламжтай хөгжилд хүрэхдээ өөрийн амьдралыг хялбар болгох аливаа аргыг үргэлж эрэлхийлж, хайсаар ирсэн билээ. Зарим хүмүүс өөрсдийн амьдралдаа тохиолдох асуудлыг амар хялбараар шийдэхдээ хойно дурьдах сөрөг аргыг сонгон авдаг болсон нь нэгэнт тогтоогдсон юм.

Амиа егүүтгэх гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслаж байгаа гэмт үйлдэл юм. Амиа егүүтгэх болон амиа егүүтгэхээр оролдох нь манай улсын хувьд төдийгүй дэлхийн олон оронд нийгэм эдийн засгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ.

Судалгааны зорилго, зорилт: Амиа хорлолтийн шалтгаан нөхцлийг судалж амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх арга боловсруулах. 2013-2018 оны байдлаар судлан дүн шинжилгээ хийж дараагийн 6 жил 2019-2024 тэй харьцуулан судлахаар төлөвлөх, бэлтгэх

Судалгааны арга, онол зүйн үндэслэл: Ангилан системчлэх арга

Энэ бол онолын судалгааны чухал аргын нэг. Энэ арга нь ном зохиол уншиж



судлах явцад хуримтлуулсан бүх материал, судалгааны бусад аргаар бүрдүүлсэн баримт сэлт зэргийг давтагдаж буй ижил төстэй шинжээр нь бүлэглэн нэг хэсэг болгох системчлэх үйлдлүүд юм. Энэ аргын давуу тал бол юмс үзэгдлийг эмхлэн цэгцлэх системчлэх боломж олгодог явдал юм.

Математик статистикийн боловсруулалт хийх аргууд

Судалгааны явцад цуглуулсан материалын тоон үзүүлэлтүүдэд математик статистикийн боловсруулалт хийх энгийн арга бол хувийн жинг олох процентлох, тоон үзүүлэлтийн дундажийг олох эрэмбэлэх, график, диаграмм зохиох гэх мэт аргууд юм.

Судалгааны шинэлэг тал ач холбогдол: Амиа хорлох гэмт үйлдэлээс урьдчилан сэргийлэх арга боловсруулахад энэхүү судалгааны ажлын шинэлэг ач холбогдол оршино.

ӨРНӨЛ

Таны амьд явах эрх таньд болон бусад хүмүүсд ч үнэ цэнэтэй.⁵⁷

Амиа егүүтгэж нас барах, амиа егүүтгэх оролдлого хийх тохиолдол нь анагаах ухаан, философи, нийгэм судлал, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг билээ.

Э.Дюркгейм амиа егүүтгэх тохиолдлыг судалж “Амиа хорлохуй” хэмээх бүтээл туурвисан бөгөөд тэрээр амиа егүүтгэх үйлдлийг нийгмийн харилцаа, түүнд оролцох байдлаар нь 3 ангилсан байдаг.

1. Аминч буюу эгоист амиа егүүтгэл - нийгмээр баримталдаг хэм хэмжээ гажуудан, амьдралд нийцэмгүй хууль, дүрэм, журам олноор батлагдах, нийгмийн халамж дутагдсаны улмаас хувь хүн нийгэм хамт олноос тасран, амьдрал нь утга учиргүй болсон мэт санагдан өөрийгөө амьдралд гарах гарцгүй болсон хэмээн амиа егүүтгэхийг хэлнэ
2. Хамтач буюу альтруист амиа егүүтгэл - хувь хүн өөрөө шийдвэр гаргах, сонголт хийх боломж, эрх чөлөө, бие даасан байдлаа алдан хувийн эрх ашиг, сонирхол нь хамтын эрх ашигт захирагдах болсноос хувь хүн тэсвэрлэшгүй байдалд орж амиа егүүтгэхийг хэлнэ.
3. Аноми амиа егүүтгэл - нийгмийн бүтцийн гэнэтийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлт, уналтын улмаас хүмүүс хуучин үнэт зүйлсийн баримжаагаа алдан, шинэ үнэт зүйл нь бүрдэж амжаагүй завсрын үед нийтийг хамарсан эмх замбараагүй

⁵⁷ Б.Нармандах Хүний эрх УБ 2010., 5-р тал

байдал үүсч, хүмүүс нийгэмд тогтсон хэм хэмжээг мөрдөхийг хүсэхгүй амиа егүүтгэхийг хэлнэ.

Манай улс амиа хорлохыг хуулиараа хориглон амиа хорлосон иргэнд оршуулах газар олгодоггүй байсан цаг саяхан.


Гэтэл дэлхийн улс орнуудыг амиа хорлолтын түвшингээр нь жагсаахад 2018 оны байдлаар гуравхан сая хүн амтай манай улс дэлхийд 3 дугаарт жагсаж байгаа нь харамсалтай юм.

2013-2018 онд амиа хорлосон хэрэг учралын хавтаст хэрэгт хийсэн судалгаагаар, 2013 онд 397, 2014 онд 441, 2015 онд 388, 2016 онд 333 2017 онд 484 мөн 2018 онд 459 хүн амиа хорлосон тохиолдол гарсан бөгөөд тэдгээр тохиолдлыг УЕПГ эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ.


2013-2018 оны хооронд 7-14 насны хүүхэд амиа хорлосон 98 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод хамгийн олон буюу 33 (34.6 хувь), орон нутгаас Хөвсгөл аймагт хамгийн олон буюу 10 (10.2 хувь) нь бүртгэгджээ.

Хүйсийн харьцааны хувьд авч үзвэл, амиа хорлосон нийт тохиолдлын 2124 нь эрэгтэй, 435 нь эмэгтэй байжээ. Энэ нь эрэгтэйчүүд амиа егүүтгэх тохиолдол эмэгтэйчүүдээс 4.8 дахин их байна. Үүнээс холбоотойгоор “хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэргийн талаар дараах судалгааг хийсэн.

Хүснэгт: I Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



Хүснэгт 2 2. Гэмт үйлдэл үйлдэгдсэн гараг, цаг



Хүснэгт 3 Гэмт үйлдэл үйлдэгдсэн газар

Үйлдэгдсэн газар	Хэргийн тоо
Нийтийн тээвэр	1
Авто зам	5
Төрийн бус байгууллага	8
Төрийн байгууллага	10
Олон нийтийн газар	18
Аж ахуйн нэгж	43
Гудамж талбай	52
Гэр орон сууц	232
Бусад газар	90

Хүснэгт 4



Сүүлийн 6 жилд 7-89 хүртэлх насны хүмүүс амиа хорлосон ба дундаж нас нь 13-33 насныхан байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл 605 тохиолдол буюу 29.4 хувь нь 7-25 нас хүртэлх, 1450 буюу 70.6% нь 29-өөс дээш насны амь хохирогчид байна.

Нийт хүн амын 63.6%-г 0-35 насны залуучууд, 14-18 насныхан нийт 279907 байна.

Эдгээр залуусын амиа хорлолтыг криминологийн шинжлэх ухааны гэмт явдлын түвшин тооцох аргаар тооцоолоход 10,000 залуус тутамд 8 хүн амиа хорлож байна.

Хүснэгт:5

$$\frac{221 \times 10000}{279907} = 7.8$$

Сүүлийн 6 жилд амиа хорлогсдын 70.6% нь яг хийж бүтээх насны хүмүүс байгаа боловч цаашдаа бидний ирээдүй болсон өсвөр үеийн дундах амиа хорлох явдал ихсэх хандлагатай байна гэж дараах судалгааны үр дүнд үндэслэн дүгнэж болохоор байна.

2016 онд Монгол Улс дахь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол Улсын хүний хөгжлийн талаарх” суурь судалгааг хийжээ.

Үүнд 16-17 насны сурагчдын дунд явуулсан судалгаагаар сүүлийн 12 сарын хугацаанд амиа хорлох талаар нухацтай бодож байсан гэж хариулсан судалгаанд хамрагсдын 26.1 хувь, амиа хорлохыг завдаж байсан гэж 10,7 хувь нь хариулжээ.²


Монгол Улсын Ерөнхий боловсролын сургууль болон багш нарын тоо



ЕБС-н ахлах 15-18 насны 10000 сурагчдаас авсан анкетын судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлоход хүргэсэн шалтгаан, нөлөөлөл нь тэдний хүмүүжил болон зан байдлын онцлог, амьдарч буй орчин, гэр бүлийн хүчирхийлэл, найз нөхдөн таарамжгүй харилцаа, хайр дурлал зэрэг хүчин зүйлээс хамаарч байгааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт: 7

Асуулт 1 : Та амиа хорлолтын талаарх мэдээллийг хаанаас авсан бэ




Хүснэгт 7-с харахад өсвөр насны хүүхдүүд цахим орчинд хараа хяналтгүй зорчин харах ёсгүй зүйлээ харж, сонсох ёсгүй зүйлээ сонссоор байна. энэ нь өсвөр насны хүүхдийн цаашдын амьдралыг үзэх үзэл, нийгмийн талаарх ойлголт, зан төлөв өсөж төлөвших үйл явцад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байна гэж дүгнэхэд хүргэж байна.

Амиа хорлоход насны байдал нөлөөлдөг бөгөөд хувь хүний насны үечлэл бүрд харилцан адилгүй сэтгэлзүйн тааламжгүй нөлөө үүсч байдаг. Тухайлбал хүүхэд амиа хорлох үйлдэл хийхэд гэр бүлийн хүмүүжлийн өв тэгш бус байдал, бага насны сэтгэлзүйн гэмтэл, амиа хорлосон хүмүүсийг дуурайх (даган дуурайх сэдэл, Вертерийн хамшинж) сэдэл нөлөөлдөг бол багана сандаа хүчирхийлэлд өртөж байсан ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд (14.8%) амиа хорлох эрсдэл өндөр байдаг³ гэсэн судалгаа байна.

Өсвөр насны хүүхдүүд өөрийн гэсэн үзэл бодолтой болж, бие даасан байдлыг аль болохоор гаргахыг оролдон, ахмадын заавар, дэг журамд дургүйцлээ илэрхийлж, тогтворгүй, үгэнд амархан орохгүй, түргэн зантай, өөрийн чадал боломжоо хэтрүүлэн үнэлэх байдалтай, насанд хүрэгчдийг дууриах биеэ тоосон юм шиг зан үйл гаргадаг⁴

Хүснэгт 8



Дээрхи судалгааны дүнг харвал ЕБС-н 10000 сурагчдын 4/1 хувь буюу 2326 нь амиа хорлох талаар бодож байсан байна. Энэ нь өсвөр насны хүүхдүүдэд тавих эцэг эхийн хараа хяналт муу сургуулийн зүгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж харагдаж байна.

Хүмүүс бодит үзэгдэл юмсыг мэдрэхдээ тэдгээрийг буруу тусгах буюу буруу танин мэдэх, тэдгээрийг хувирж өөрчлөгдсөн мэтээр тусгах, хоосон мэдрэхийг мэдрэхүйн эмгэг гэдэг.⁵⁸


⁵⁸ Л.Эрдэнэбаяр Сэтгэц судлал УБ., 2012

Хүснэгт:9

$$\frac{2326 \times 10000}{279907} = 83$$

Нийт сурагчдын дунд амиа хорлолтын түвшинг тогтооход 10000 хүүхэд тутамд 83 нь амиа хорлох талаар бодож байсан нь судалгаанд тусгагдсан.

Хүснэгт:10



Эндээс харахад амиа хорлох оролдлого хийсэн 680 хүүхэд байгаа нь амиа хорлох талаар бодож байсан хүүхдүүдийн 4/1 нь уг бодлоо биелүүлэхээр идэвхитэй үйлдэл хийсэн байгаа нь харамсалтай төдийгүй цаашид анхаарвал зохих асуудал болж байна. Мөн ЕБС-д сурагчдын сэтгэл хөдлөл, тэдэнд тулгамдаж буй асуудлаар зөвлөгөө өгөх, өсвөр насныхны сэтгэл зүйгээр мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулах, түүний ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Өсвөр насны 15,000 орчим сурагчидтай ярилцлага хийж үзэхэд үерхэж буй охид, хөвгүүдийн хооронд үл ойлголцол үүсэх, тохиолдлын бэлгийн харьцаанд орох, гэмт хэрэгт холбогдох, зан төлвийн тогтворгүй байдал, эцэг эхийн анхаарал халамж дутмаг байх, хойд эцэг, эхтэйгээ ойлголцохгүй болох, өөрт тулгамдсан асуудлынхаа талаар эцэг, эхдээ ярьдаггүй, ялгаварлан гадуурхалт, санхүүгийн байдал, өөртөө сэтгэл хангалуун бус байх, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг нь амиа хорлоход хүргэдэг шалтгаан болдог байна.

Өсвөр насны хүүхдүүдийн хувьд эцэг, эхийн зүй бус харьцаа, сурган хүмүүжүүлэгчдийн шударга бус харилцааны улмаас сэтгэл гутралд орж амиа хорлох явдал зонхилсоор байна.

Мөн 10000 сурагч 800 багш нартай ярилцлагын судалгааны аргаар явуулахад


6-8 хувийн сургуулиуд сэтгэл судлаачийн орон тоотой байдаг. Түүнчлэн гадны байгууллагын хөрөнгө оруулалтаар захын хорооллын 20 орчим улсын сургуульд сэтгэл судлаач ажиллаж байгаа ба эдгээр сургуулиудын хүүхдүүд хоорондын маргаан эрс багассан гэж дурьдсан юм.

Эдгээр 20 орчим сургуулиас бусад нь нийгмийн ажилтнаар сэтгэл судлаачийн үүргийг гүйцэтгүүлдэг. Гэвч бодит байдал дээр сурагчид нийгмийн ажилтныг ярилцагч, хамтрагч гэж харахаас илүүтэй дүрэм журмын биелэлтийн шалгагч гэж хардаг байна. Тиймээс сургууль бүрт сэтгэл зүйчийн орон тоог бий болгох хэрэгтэй гэдгийг өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлох гэсэн оролдлого, мөн тэдэнтэй ярилцсан ярилцлагын үр дүн, анкетын болон ярилцлагын судалгааны дүнгээс харагдаж байна.

Амиа хорлох гэмт явдлын шалтгаан, нөхцөл

Амиа хорлох гэмт явдлын шалтгаан нөхцлийг тогтоохоор хэрэг учралын хавтаст хэрэгт баримт бичгийн судалгааг мөн амиа хорлогсдын хувийн байдалд тулгуурласан судалгааг хийхэд дараах дүгнэлтэд хүрэхээр байна.

Хүснэгт.6 Нийгмийн байдлаар нь авч үзвэл




Эдийн засгийн байдал



2013-2018 оны хооронд амиа хорлогсдийн дунд 1267 нь ажилгүй хүмүүс байгаа явдал нь хүнийг амиа хорлоход хүргэхэд эдийн засгийн байдал хүчтэй нөлөөлж хүнийг амиа хорлох үйлдэл хийхэд хүргэж байна.

Муу зуршил (Согтуурах ундаанаас хамааралтай)




Муу зуршил

Амиа хорлогчдын дунд согтууруулах ундаанаас хамааралтай байсан талаар судалгаа явуулахад огт хэрэглэддэггүй 494, Хааяа хэрэглэдэг 1355, Тогтмол хэрэглэдэг 226, шалгаагүй 484 тохиолдол байна.


Гэр бүлийн хүчирхийлэл

Гэрбүлийн хүчирхийлэлтэй байсан талаарх судалгаа явуулахад Хүчирхийлэлтэй байсан 183, Хүчирхийлэлгүй байсан 745, Мэдэхгүй 218, Шалгаагүй 1413 байгаа нь мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдэж байгаа нь харагдаж байна.



Амиа хорлосон арга

Амиа хорлосон аргаар нь шалгаж үзэхэд Эм уусан 35, Боомилсон 2121, Зүссэн 49, Өндрөөс унасан 207, Галт тэрэгний осол 5, Усанд живэх 10, Химийн бодисын хордлого 22, Бусад 110 байна. Үүнээс үзэхэд амиа хорлосон амь хохирогчийн 1811 буюу 88.1% нь өөрийгөө боомилсон байна.



Амиа хорлохын өмнө гэрээслэл бичсэн 379, Бичээгүй 2180 байна.

Зан төлөвийн хувьд



Зан төлөвийн хувьд: Нээлттэй олон найз нөхөдтэй 407, Дуугүй, зожигдуу, найз нөхөд цөөн 610, Огцом ууртай биеэ барихдаа муу 550, Тайван дөлгөөн 552, Сэтгэлийн хөдөлгөөн багатай 240, Сэтгэлийн хөдөлгөөн ихтэй 162, Бусадтай таарамж сайн 334, Бусадтай таарамж муу 68, Зан ааш тогтвортой 173, Зан ааш тогтворгүй 203, Бусад 152 тохиолдол байна. Дээрхи судалгааны үр днгээс харахад амиа хорлох гэмт явдлын шалтгаан нөхцөл ажилгүйдэл, эдийн засаг, буруу зуршил, зан төлөвийн байдал зэрэг нь нөлөөлдөг байна. Үүнээс гадна “хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа нь цашид энэ гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэх төдийгүй амиа хорлолт дунд наснаас залуу үе рүү тэр дундаа өсвөр үе рүү ч орох хандлагатай байна.

Мөн Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4 зүйлд “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэж эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн” үйлдлийг хуульчилж, хүний амьд явах эрхийг хамгаалж өгсөн юм. /2002 оны эрүүгийн хуулийн 95-р зүйл/

2013-2018 оны 6 жилд Эрүүгийн хуулийн 95-р зүйлээр/Бусдыг амиа хорлоход хүргэх/ 2013 онд 323, 2014 онд 288, 2015 онд 181, 2016 онд 243, 2017 онд 470 2018 онд 459 бүртгэгдсэн байна. Мөн 2019 оны эхний 2 сарын байдлаар Эрүүгийн хуулийн /Шинэчилсэн найруулга/ 10.4-р зүйлээр/Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх/ 313 хэрэг бүртгэгдсэн байна.

2013-2017 онд нийт Эрүүгийн хуулийн 95-р зүйлээр /Бусдыг амиа хорлоход хүргэх/1505 хэрэг бүртгэгдсэнээс шийтгэх тогтоол 5, цагаатгах тогтоол 5, мөрдөн

байцаалтанд буцаасан 4, тэнсэн харгалзсан 4, өршөөлд хамрагдсан хэргийг хэрэгсэхгүй болгосон 1 нийт 19 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт: 11 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг



Амиа хорлолтын үр дагавар

Амиа хорлолт гэр бүлийн тогтвортой байдлыг алдагдуулах нөхцөл болох бөгөөд энэ цаашлаад нийгэмд чимээгүй тархаж байна. Амиа хорлолт нь нэг талаас харвал хувь хүн өөрийн сонголтоороо амиа хорлож байгаа боловч цаашлаад гэр бүл, найзууд, сургуулийн орчинд аминч үзэл санаа урган гарсаар байдаг. Энэ нь цаашилбал тодорхой нэг үйл явдал болон энгийн үзэгдэл болтлоо тархахыг хэн ч таашгүй.

Гэрээслэл

Энэ бүхэн миний сонголт намайг мартаарай хэнийг ч үүнд буруутгах хэрэггүй шүү зөвхөн би л буруутай юу ч бүтэхгүй, юу ч бүтээхгүй байснаас “юу ч байхгүй байвал амар юм уу” гэж бодлоо эцэст нь намайг уучлаад санан дурсаж явна биздээ “Ямарч хүн буруугүй өөр хэлэх үг үнэхээр алга миний хүүхдүүд гэр бүл минь уучил уучил. Хүнд байдлаас гарах арга алга. Би өөрийнхөө өмнөөс хүн бүхнээс уучлал хүсье алагхан үрдээ амиа хичээсэнд уучлаарай чи минь ингэж тэнэглэснийг уучлаарай үхэхэд минь ямар ч буруу байхгүй шүү би өөрөө өөрийнхөө алдаанаас болж байгаа юм шүү. Бас өөрийнхөө арчаагүйгээс болсон юм шүү.

Өөрийгөө болон бусдыг хайрла бүх зүйл амин хувийн ашиг сонирхол дээр үндэслэгддэггүй юм. Бидний ард үргэлж хэн нэгэн байдаг.

ДҮГНЭЛТ

Чимээгүй тахлыг эмчлэхийн тулд бид зөвхөн амиа хорлож буй хүмүүс, тэдний гэр бүл найз нөхөд төдийгүй нийгмийн эдийн засгийн том асуудлыг хөндөж болохоор байна. Үүнд; Гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн амьдралын тогтсон хэв маяг, ухамсар сэтгэхүйн нөлөөлөл ордог. Гэмт үйлдэл гарсаны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлэх нь чимээгүй тахлийг эдгээх эм мөн. Амиа хорлолттой тэмцэх оновчтой аргыг боловсруулахад Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох, эрх тэгш байдлыг хангах, гэр бүлийн тогтвортой амьдрал гэрлэгсдийн харилцаа зэргийг оновчтой хуульчилж түүнийг нэг мөр ойлгох тал дээр санал нэгдэх нь олон талын ач холбогдолтой юм.

Судалгааны үр дүнд дараахь дүгнэлтыг гаргаж байна.

1. Залуучуудын амиа хорлох нь ихсэх хандлагатай байна. Энэ нь тэдгээрийн зан төлөв болон бие махбодь сэтгэлзүйн тогтворгүй шинж гэр бүлийн болон найз нөхдийн таарамжгүй харилцаанаас бий болдог.
2. Эдийн засгийн болон нийгмийн хүчин зүйл хүнийг амиа хорлоход хүчтэй нөлөө үзүүлж байна. Мөн ажлын байр байхгүй ажилгүйчүүдийн тоо ихэссээр байгаа нь амиа хорлох нөхцөл, шалтгаан болж цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.
3. Өсвөр насныхан сэтгэхүйн хувьд цахим ертөнцийн хяналтгүй мэдээлэлд автах, цахим ертөнцөд хараа хяналтгүйгээр чөлөөтэй байгаа нь өсвөр насныханы хүмүүжил, зан төлөв, ухамсарт сөрөг нөлөө үзүүлж амиа хорлох, гэмт хэрэг үйлдэх гэх мэт болчимгүй үйлдэл хийхэд нь түлхэц болж байна.
4. Судалгаанд оролцогч өсвөр насныханаас 4/1 хувь нь амиа хорлох талаар бодож тэдгээрийн мөн л 4/1 нь амиа хорлох идэвхтэй үйлдэл хийсэн бөгөөд энэ тоо цаашид өсөх хандлагатай байна. Өсвөр насныхан бол бидний ирээдүй. Ургамал модны цэцэглэлт үндэсээсээ ургадаг шиг хүн нийгмийн хөгжил өсвөр үеийнхнээс эхэлдэг.
5. Сургуулийн орчинд сурагчдыг дэмжих, чөлөөтэй ярилцах, зарим үед тэдэнд зөвлөн туслах чиг үүрэг бүхий нийгмийн ажилтан дүрэм журмын хянагч, шалгагчийн үүргийг гүйцэтгэж үндсэн үүргээ биелүүлдэггүй гэж дүгнэхэд хүрч байна.
6. Монгол Улсын эрүүгийн хуулинд амиа хорлох үйлдлийг гэмт хэрэг гэж

тооцоогүй тул уг үйлдэлээс урьдчилан сэргийлэх ажил хийгдээгүй байна.

Иймд бид судалгааны үр дүн болон дээрхи дүгнэлтийг үндэслэн дараахь саналыг дэвшүүлж байна:

1. Ерөнхий боловсролын болон их дээд сургуульд өдрийгүй засаг захиргааны анхан шатны нэгжийн дэргэд мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох эрх зүйн болон нийгмийн боломжоор хангах ажлыг зохион байгуулах
2. Цахим орчин дахь амиа хорлох арга, амиа хорлоход уриалан дуудах чиглэл бүхий цахим хуудсанд Монгол Улсаас нэвтрэх боломжийг хязгаарлах арга хэмжээ нэн тэргүүнд авах
3. Ялгаварлан гадуурхалт, түүний үр дагаврын нэг болох амиа хорлолтын хор уршигийн талаар сургууль болон, сургалтын орчинд сургалт зохион байгуулах.
4. Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх ажил, амиа хорлохын хор уршгийг тайлбарлах таниулах зорилгоор өсвөр үе, эцэг эхчүүд болон 30-аас дээш насныханд зориулсан сургалт явуулах боломж бий болгох

НОМ ЗҮЙ

1. Б.Нармандах. Хүний эрх. УБ., 2010
2. З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн, Г.Цэцэгдарь, С.Бямбасүрэн, Най.Туяа. Монгол Улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан судалгаа. УБ., 2003-2008.
3. O.Spengler. der Sohnenuntergang in der Abendland.Hbg. 2004.
4. John. M Grohol. L.,2008
5. Mehmet Eskin. YN.,2012
6. Эрүүл Мэндийн Сайдын тушаал. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам. 180 дугаар тушаалын хавсралт УБ., 2014
7. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. УБ., 2014.
8. Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэц. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл УБ.,2019
9. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. Судалгааны тайлан. УБ.,2017
10. Л:Эрдэнэбаяр Сэтгэц судлал УБ., 2012
11. Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл УБ., 2016

НОМЫН САН



Ю.БАДАМХАНД

Номын сангийн хөгжил, чиг хандлага

НОМЫН САНГИЙН ХӨГЖИЛ, ЧИГ ХАНДЛАГА (DEVELOPMENT AND TRENDS OF LIBRARIES)

Доктор, дэд профессор Ю.Бадамханд

(ОУУБИС, Номын сангийн дарга)

badamkhand.yu@ulaanbaatar.edu.mn

Товч утга: Энэхүү илтгэлд номын сангийн хөгжлийн түүх, нийгмийн хөгжлийг даган хувьсан өөрчлөгдөж буй хэв маяг /загвар, дэлхийн номын сангуудын хөгжлийн чиг хандлага, манай улсын зарим их сургуулийн номын сан, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг өөрийн сургуулийн номын санг хөгжүүлэх зорилттой уялдуулан авч үзэж, тулгамдсан зарим асуудлыг хөндөн авч үзлээ.

Abstracts: This paper examines the history of library development, the evolving patterns and models shaped by social progress, and the current trends in library advancement worldwide. It also reviews the present state of selected university libraries in Mongolia and aspects of legal regulation, aligning these observations with the development objectives of the author's own university library and addressing certain pressing challenges in that context.

ОРШИЛ

МЭӨ 3 дугаар мянганы эхний хагаст Ниппур хотын⁵⁹ Шумерын сүмд хэд хэдэн өрөөг эзэлсэн бичиглэл бүхий шавар шахмалууд бүхий агуулах байдаг байжээ. Ийнхүү Египет, эртний Грек зэрэг эртний улсуудын сүмийн дэргэд номын сан, эсвэл архив оршиж байснаар нь номын сангууд анх Эртний Дорнодод гарч ирсэн гэж үздэг.

1960-аад оны үеэс номын санг компьютержуулах, дижитал (цахим) болгох үйл явц эхэлж, 2010 оны эхэн гэхэд номын сангуудад 130 сая орчим нэр төрлийн ном байршиж, 1990-ээд оны сүүлээс номын сангийн технологийн өөрчлөлт, автоматжуулалтад анхаарах болсон.⁶¹

⁵⁹ Ниппур - орчин үеийн Нуффар хот нь өмнөд Месопотами (Ирак Улс) дахь Шумерын ариун хот, шашны төв юм.

⁶⁰ Библиотека. /<https://ru.wikipedia.org/wiki/%D0%91%D0%B8%D0%B1%D0%BB%D0%B8%D0%BE%D1%82%D0%B5%D0%BA%D0%B0>; Харах. В.Түвшинтогтох. Номын сангийн тухай яриа ном.



Орчин үеийн их сургуулийн номын сан, түүний амьдралд эзлэх байр суурийн талаарх эрдэмтэн судлаачдын үзэл бодол /эргэцүүлэл/ өөрчлөгдөж байна. Энэ нь зөвхөн номын сангуудын түвшинд бус, харин нийгэмд аль хэдийн нэвтэрсэн веб үйлчилгээг их сургуулийн номын сангийн үйлчилгээнд амжилттай нэвтрүүлэх, хэрэглэгчдэд ойртуулах⁶¹ ба удирдлагын дэмжлэг, эдийн засгийн хөшүүрэг маш чухал.

ҮНДСЭН ХЭСЭГ

НҮБ-ын олон улсын хөтөлбөр, тунхаглал, олон улсын номын сангийн мэргэжлийн байгууллагын баримтлах гол зүйл нь мэдээллийн нээлттэй байдлын зарчим, хүний мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэх юм.

Их сургуулийн номын сан гэж сургуулийн шууд удирдлагад байдаг номын санг хэлдэг бөгөөд сургалтын үйл явцын гол бүрэлдэхүүн хэсэг мөн. Номын сан хөмрөг, программ, хайлтын систем зэрэг нь нээлттэй, хэрэглэгч ашиглах боломжтой байх нь багш, суралцагсдын санхүүгийн, бусад боломжоос үл хамааран шинэ мэдлэгийг цаг алдалгүй олж авах, тэгш хөгжих боломжийг бүрдүүлж, сургалт судалгааны ажлын үр дүнд шууд нөлөөлдөг.

Номын санч гэдэг ном хүлээн авч, ном гаргадаг ажилтан, “хаалтын цаана сууж байдаг л хүн” гэх ойлголт үеэ өнгөрөөсөн. Сургалтын үйл явцад мэдээллийн дэмжлэг үзүүлэх нь их сургуулийн номын сангийн цорын ганц чиг үүрэг биш юм. Сургалтын үйл ажиллагаанд холимог сургалтын болон бүрэн цахимжсан хөтөлбөрүүд хоёулаа тэргүүлэх ач холбогдолтой болж, багшаас өөрөөс нь дутахааргүй дижитал удирдагч, загвар зохион бүтээгч, технологич зэрэг чухал хэрэгцээт шинэ “албан тушаалууд” бий болж, зарим үүргийг номын сангийн ажилтнууд орлож, их сургуулийн номын сан нь их сургууль хоорондын төсөл,

⁶¹ Сингапур Улсын Үндэсний номын сангийн зөвлөлөөс 2024 онд Хонг Конгийн Хятадын Их Сургууль (СУНК) Францын хэвлэлийн газартай хамтран англи, хятад хэл дээр өгүүллэг хэвлэх боломжтой богино өгүүллэгийн машиныг бий болгон нэвтрүүлсэн Мөн уншигчдад номын сангийн шинэ туршлага, үйлчилгээг бий болгоход хиймэл оюун ухааны (Generative AI-текст, зураг, хөгжим, видео зэрэг одоо байгаа өгөгдөл дээр үндэслэн шинэ контент үүсгэдэг алгоритмууд) шинэлэг тенологийг турших ажлыг тэргүүлж, ChatBook платформын шинэ санаанууд (GenAI дээр суурилсан (прототип), унших чадварыг сайжруулж, уншсаныг хурдан сандаг болгох GenAI мультизагварын хэрэглэгдэхүүн)-ыг хөгжүүлжээ.

судалгааны ажилд⁶² оролцож байна.

Дэлхийн улс орнуудын номын сангийн хөгжлийн түүх, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдын бүтээлд номын сангийн хөгжлийн дараах хэв маяг /загварыг тодорхойлсон байна:

- Library 1.0 буюу идэвхгүй хэрэглэгчидтэй хуучны уламжлалт чиг хандлагатай номын сан;
- Library 2.0 номын сангийн үйлчилгээний үндсэн хэлбэрийг бүрдүүлэх үйл явцад хэрэглэгчдийн идэвхтэй оролцоо тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болсон, гол 4 зарчим: мультимедиа өргөнөөр ашиглах, хэрэглэгчдэд анхаарал хандуулах, хэрэглэгчдэд өөр хоорондоо болон номын санчтай харилцах боломжийг олгох, тэдэнд өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн номын сан, түүний үйлчилгээг өөрчлөх боломжийг олгох (зөвхөн мэдээлэл хайх, олох, ашиглах хэрэгцээ биш).
- Library 3.0 буюу хэрэглэгч хаа байгаагаас үл хамааран ашиглах, тэдний хайлтын даалгавруудыг гүйцэтгэх өргөн боломжтой цахим номын санг хөгжүүлж байна. Library 2.0 загварыг номын сангууд бие даан, өөрсдийн хүчин чармайлтаар нэвтрүүлж болж байсан бол харилцан зохицуулагдах үйлдлүүдийг гүйцэтгэхэд номын сангийн олон тооны мэргэжилтний хамтын ажиллагаа, дэмжлэг шаардлагатай Library 3.0-ыг номын сангууд дангаар чанартай хэрэгжүүлэх боломжгүй юм.
- Library 4.0. “Хиймэл оюун ухаан”-ы технологийн хөгжил, тэр дундаа “Орчны оюун ухаан” (Ambient Intelligence⁶³) -ы технологиудад тулгуурлан хөгжиж байгаа 4.0 интернэтийн чиг хандлагын дагуу хөгжинө. Гол шинж нь: 1) Ubiquity (хаа сайгүй байх буюу хэзээ ч, хаана ч ашиглах боломжтой байх); 2) Identity⁶⁴ - хэрэглэгч нэг бүрийн сонирхолд нийцсэн үйлчилгээний багц өгөх; 3) Connection - хэрэглэгчид бусад хэрэглэгчидтэй холбоотой байх. Номын санч,

⁶² Михаил Шепель (ТИС-ийн Зайны боловсролын институтийн захирал): ОХУ-ын Томск хотын их сургууль 2022 онд “Том их сургуулийн Номын сан” төсөл хэрэгжүүлсэн, Швед Улсын Лундагийн их сургуулийн яг ижил зорилгод зарцуулсанх санхүүжилт Томскийн их сургуулийнхаас 44 дахин их байсан. /Университетская библиотека: приоритетные направления (Их сургуулийн номын сан: тэргүүлэх чиглэлүүд). <https://www.unkniga.ru/biblioteki/vuzbiblio/13699-universitetskaya-biblioteka-prioritetnye-napravleniya.html>

Томск хотод 708 их, дээд сургуулийн 700 номын санд 20 мянган ажилтан 5 сая хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг.

⁶³ AI (орчны оюун ухаан) технологи - орчин тойрны нөхцөл байдлыг хүлээж авч, ухаалгаар, саадгүйгээр хүнтэй харилцан үйлчлэлцэж, тавьсан зорилгод хүрэх боломжийг хамгийн дээд хэмжээнд хүргэх үйлдлүүдийг хийдэг хаа сайгүй байдаг электрон төхөөрөмжүүд болох орчны өөрчлөлтийг хүлээн авч, цугларсан мэдээллийг боловсруулах “үүл”-д дамжуулж, үр дүнг нь хэрэглэгч өөрийн гар утас, компьютер, пад г.м. нь төхөөрөмжид хүлээж авдаг.

⁶⁴ Мөн чанар (identity) гэдэг нь хүн болон юмсын бусдаас ялгаатай чанарыг хэлнэ. Үзэгдлийг танин мэдэхээр нээж оох, ямар нэг юмны дотоод агуулга, ахуй чанар. /Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. 343 дахь тал.



хэрэглэгч, компьютер гурвын харилцан нягт хамтын ажиллагааг шаардана. Энэ юу гэсэн үг вэ гэвэл, мэдээллийг эрэн хайх, цуглуулах, ангилах, боловсруулах, дүн шинжилгээ хийх үйл явцад оролцогчид болох номын санч, хиймэл оюун ухааны технологи хамтдаа нэгэн зэрэг (үүргийг хувааж бус, харилцан бие биеэ нөхөж) оролцож, мэдээллийн арвин баазаас ашиглах нөөцөө хайж олж авах цаг хугацаагаа эрс багасгахын тулд нягт хамтран ажиллаж хайснаа бүтээнэ.⁶⁵ Хамгийн гол нь мэргэшсэн мэргэжилтнүүд (мэдээлэл технологийн инженерээс эхлээд олон нийттэй харилцах менежер хүртэл)-ийн нэгэн зэрэг, тасралтгүй, харилцан үйлчлэл бүхий үйл ажиллагаа хэрэгтэй болно.

Гадаадын зарим орны их сургуулийн номын сангуудын хөгжлийн чиг хандлага, хэрэгжиж буй технологиудыг судлан авч үзэхэд:

1. Герман Улсын их сургуулийн номын сангийн хөгжлийн ерөнхий чиг хандлага нь:

- Номын сангийн барилга, түүний дизайн, дотоод зохион байгуулалт нь уншигчдын тав тухыг дээд зэргээр хангах үүднээс бүтээгдсэн;
- Нэгдмэл орон зайтай (уншлагын танхим ба үйлчилгээний хэсэг хоёр хуваагдаагүй), цонхны дагуу гэрэл сүүдрийг тооцсон ширээний чийдэн, компьютер бүхий ширээнүүд, төлбөргүй интернэт;
- Хаана ч аваачаад байрлуулчих хөдөлгөөнт ширээ (ширээний чийдэн), компьютерыг залгах тогийн олон залгуурууд;
- Уншигч-хэрэглэгчийн ганцаарчилсан кабин (үнэгүй, хэдэн сараар захиалан ашиглах дипломын, бие даалтын ажлаа бичих);
- Нээлттэй номын фонд, хадгалалт нь «тусгай хаалт», ном сэтгүүлийн бар код, камерын хяналтаар бүрэн хамгаалагдсан;

Германы Эрфурт хотын⁶⁶ их сургуулийн номын сан нь тус хотын бусад 6 номын санг өөртөө нэгтгэдэг, дээрх чиг хандлагаар тохижуулагдсан, бичлэг хийх чөлөөтэй, мэдээллийн хэд хэдэн төвтэй. Гэрээр 100 хүртэл номыг 4 долоо хоногоор авч болдог, интернэт багш, оюутнууддаа хязгааргүй, харин хотын бусад оршин суугчид долоо хоногт 6 хүртэл цаг төлбөргүй ашиглаж болно.

- *Польш Улсын их сургуулийн* номын сангийн хөгжлийн стратеги нь номын фондыг цахим хэлбэрт шилжүүлэх бөгөөд ховор, үнэ цэнтэй ном, цуглуулгыг

⁶⁵ Noh Y. Imagining Library 4.0: Creating a Model for Future Libraries / Younghee Noh. The Journal of Academic Librarianship. 2015. № 6. P. 786–797.

⁶⁶ Эрфуртийн их сургууль нь анх 1392 онд үүсгэн байгуулагдаж, 1816 оноос хаагдсан байснаа 1994 онд буцаан шинээр нээжээ. Энэ сургуульд сурч байсан алдартай хүмүүсийн нэг нь Мартин Лютер юм.

[/https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D1%80%D1%84%D1%83%D1%80%D1%82](https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D1%80%D1%84%D1%83%D1%80%D1%82)

цахимжуулж, дараа нь их сургуулийн веб сайтад байршуулдаг;

- Их сургуулиудын хооронд цахим сангийн солилцоо хийгддэг;

- Фондын хадгалалт нь камерын хяналт, «кодчилогдсон хаалт»-аар хамгаалагдсан, чөлөөт сонголттой;

- Хүссэн хүн бүрийг хүлээн авдаг, гэхдээ ном гэрээр олгох, хязгааргүй интернэт ашиглах боломж зөвхөн багш, оюутнуудад олгогдоно.⁶⁷

2. *Финлянд Улсын Хельсинкийн их сургуулийн гол номын сан Кайса* нь орчин үеийн дэвшилтэт шийдэл бүхий орон зай, загвар дизайнтай гадаадын их сургуулийн номын сангуудын тоонд зүй ёсоор тооцогддог, барилга нь долоон давхар, архитектурын ер бусын хэлбэр, шийдэлтэй. Зохион бүтээгчид нь функциональ дизайны зарчмууд буюу зөвхөн уншигчид ажиллах бус, дотоод орон зайн бүх хэсэг «ажиллах» ёстой гэсэн зарчимд суурилж номын сангийн барилга байгууламжийн төслийг боловсруулсан: дотоод заслын нарийн ширийн зүйл бүхэн тодорхой нэг асуудлыг шийдэхэд зориулагдсан, аль болох байгалийн гэрэл нэвтэрдэг; нээлттэй саруулхан орон зайтай; ганцаарчлан ажиллах дуртай хүмүүст зориулсан «чимээгүй» бүс, хөгжилдөх дуртай хүмүүст зориулсан кафе, дэлгүүрүүдийг нэг давхарт байрлуулсан, дээвэр дээр орчныг ажиглан харах тавцантай.

3. *АНУ-ын Чикагогийн их сургуулийн номын сангийн барилга* нь Америкийн их сургуулиудын номын сангийн хамгийн том барилга, байгальд ээлтэй дизайны уламжлалын дагуу зохион бүтээгдсэн шилдэг хийц, орчинтой: өрөөнүүд өдрийн гэрэл нээлттэй нэвтрэх шилэн дээвэртэй нь эрчим хүчийг хэмнэдэг, цэлгэр. Ном хадгалах уламжлалт газар байхгүй, 5 сая гаруй номын фондыг газар доорх тусгай зориулалтын бункерт байршуулсан. Ном олголт нь роботын тусламжтайгаар хийгддэг автоматчилагдсан⁶⁸ тул тэр бүр номын санчтай тааралдахгүй.

Азийн орнуудын номын сангууд (Индонезид хөдөлдөг номын сан) инновацын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж байна.

4. БНХАУ-ын Бээжингийн номын сан нь зочдыг ойролцоох Тунхуй голын урсцыг дагасан 16 метрийн өндөр шаттай дэнжээр алхаж, үргэлжлүүлэн явж

⁶⁷ Польшийн Вроцлав хотын их сургуулийн номын сан нь архитектурын дурсгал болсон 3 барилгатай: үндсэн фонд ба үйлчлүүлэгч; тусгай хэвлэгдэхүүн (ховор, үнэтэй ном, гар бичмэл, хуучны ном, карт, газрын зураг, хөгжмийн нотууд)-ий фонд болон уншигчийн заалнууд, фондын материалыг засварлах, хадгалах хэсгүүд; боловсруулах, автоматжуулах, үйлчилгээ үзүүлэх хэсгүүд, номын сангийн захиргаа, захирлын өрөө, нийтийн үзэсгэлэнгийн заалт, мэдээллийн алба, чөлөөт тавиур бүхий номын дэлгүүр, ганцаарчилсан кабинуд, хурлын заал, музей, төлбөргүй машины зогсоол зэрэг. Фондын бүрэн тексттэй зөвхөн Эрдэм шинжилгээний хэсэгт танилцана, төлбөрт үйлчилгээ үзүүлдэг.

⁶⁸ 5 университетских библиотек будущего, в которых можно побывать уже сегодня. /<https://lala.lanbook.com/5-universitetskih-bibliotek-budushchego-v-kotoryh-mozhno-pobyvat-uzhe-segodnya>; <https://www.ala.org/future/trends>



барилгын гаднах байгалийн сайхныг тольдон харахыг урьдаг. Уншигчдын алжаалаа тайлах боломжтой эдгээр террасын дээр Хятадын гинкго модны навчны хэлбэртэй, дулаан ээсэн таазны хавтангууд байдаг. Энэхүү байгалиар “амьсгалсан” хийцтэй загварыг номын сангийн нүүрстөрөгчийн хийг багасгах технологитой хослуулсан (хамгийн том ууршуулагчтай орон зай) нь Олон улсын номын сангийн холбоо, байгууллагуудын холбоо (IFLA)-ын “2024 оны оны шилдэг нийтийн номын сан” шагналыг⁶⁹ авахад хүргэсэн байна.

Дэлхийн туршлагаас харахад, номын сангийн гол бодлого нь сан хөмрөг хуримтлуулах бус, харин мета (лат. meta -зорилго, эцсийн цэг, хязгаар) мэдээлэл, өөрөөр хэлбэл мэдээллийн талаарх мэдээлэл, цахим мэдээллийг олж авахад чиглэгдэж байна гэж хэлж болохоор байна. Зарим номын сангууд автоматжуулах, компьютержуулах, өргөн их мэдээлэл цуглуулахын тулд өөрийн байрандаа оюутан, багш судлаач, бусад хүмүүсийг татах, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллахын тулд коворкинг (*coworking*) буюу нэг дор цуглаж хамтдаа ажиллах, эсхүл сонирхлоороо нэгдэн цугларах (*hackerspace*) тохь тухтай шинэ маягийн танхим, булан, заал зэрэг нээлттэй орон зайг бий болгож байна.

Номын сангийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Номын сангийн тухай хууль⁷⁰, Соёлын тухай хууль⁷¹, Соёлын өвийг хамгаалах тухай хууль⁷², Хөдөлмөрийн тухай хууль⁷³, Зохиогчийн эрхийн тухай хууль⁷⁴ болон салбарын яамд, байгууллагын бусад эрх зүйн актуудыг мөрдөн ажилладаг.

Монгол Улсын Үндсэн хуульд⁷⁵: “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн” гэж заасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д⁷⁶ “Номын сангийн үйлчилгээг цахимд шилжүүлж, чанар хүртээмжийг

⁶⁹ “Оны шилдэг нийтийн номын сан” шагналыг IFLA-с шинээр бий болж буй нийтийн номын сангуудыг тодруулах зорилгоор дэлхийн хаана ч байсан нээлттэй олгодог. Шалгуур: шинээр баригдсан, томоохон өргөтгөл хийгдэж байгаа, эсвэл өмнө нь номын сангийн зориулалтаар ашиглагдаагүй байранд байрласан байх. Энэ оны IFLA-ийн 89 дэх удаагийн шагнал гардуулах ёслол 2025.08.18-22-ны хооронд Казахстан улсын Астанагийн Конгрессын төвд болох ба ялагч 5000 ам.доллар хүртэнэ. /<https://einfolib.uz/post/open-books-hong-kong-pioner-otkrto-go-dostupa-w-azii>

⁷⁰ Номын сангийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2015. № 04.

⁷¹ Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2021. № 32.

⁷² Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2014. № 23.

⁷³ Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2021. № 31.

⁷⁴ Зохиогчийн эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2021. № 30.

⁷⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 7-р зүйл. / <https://leginfo.mn/mn/detail?lawId=367>

⁷⁶ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг. /<https://leginfo.mn/mn/detail/15406>

дээшлүүлнэ” зорилт тусгагдсан бөгөөд Монголын номын сангуудын консорциумаас зохион байгуулсан (2024.11.22) “Mongolian library update” XI дэх удаагийн зөвлөгөөнөөс Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж, их сургуулийн номын сангийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, номын сангийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг орчин үеийн, олон улсын стандартад нийцүүлэх, номын сангийн мэдээллийн нэгдсэн систем, төлөвлөлтийг “Хамтдаа хөгжих” зарчмаар хэрэгжүүлэх, Library 3.0 (MLC 3.0⁷⁷) зорилт руу шилжих асуудал хэлэлцэгдсэн⁷⁸.

МУИС, АШУИС, ИЗИС, ДХИС, БИС (СЭЗИС шинэ байр баригдаж байгаа) зэрэг их сургуулиудын номын сангууд дэлхийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн автоматжуулалт, цахимжуулалт, шинэ технологиудыг нэвтрүүлэн, цахим номын санг хөгжүүлж, тусдаа байр, тав тухтай орчин нөхцөл, хүний нөөц, төсөв зардлын асуудлыг иж бүрэн шийджээ.

Манай ОУУБИС-ийн Номын сан нь 1995 онд үйл ажиллагаагаа эхэлсэн, энэ хугацаанд номын сангийн орчин нөхцөлийг сайжруулах, үйлчилгээний хүрээг тэлэх, номын фондыг нэмэгдүүлэх олон ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирснээр өдгөө нийт 35000 гаруй номтой, үүлэн технологид суурилсан программ ашигладаг, өдөрт дунджаар 100 шахам уншигчид танхим болон гэрээр ном сурах бичиг олгох, зөвлөн туслах зэрэг үйлчилгээ үзүүлдэг; жилд дунджаар (2021-2024) электрон каталогт 23000 удаагийн хандалт хийж уншигчид ашигладаг, уншлагын 3 танхимтай.

ОУУБИС-ийн Алсын хараа нь “Олон улсын түвшний боловсролыг эзэмшүүлэх Монголын шилдэг хувийн их сургууль болох” бөгөөд стратеги төлөвлөлтийн баримт бичигт⁷⁹ номын санг хөгжүүлэх чиглэлээр 6 төрлийн ажил тусгагдан хэрэгжиж байна.

Бид энэхүү стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нэлээдгүй ажлуудыг төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд номын сангийн орчин нөхцөлийг улам сайжруулж, олон улсын болоод үндэсний томоохон их сургуулиудын номын сангуудын жишигт хүргэх, чөлөөт сонголттой болгох, фондын хадгалалт хамгаалалт, эмх цэгц, программ, цахим номын сан, бүртгэлийн системийг сайжруулах, камержуулалтыг шинэчлэх, орон тоо зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг хөндөн, холбогдох

⁷⁷ MLC 3.0 нь өндөр мэдээллийн нягтрал, багтаамжтай санах ойн технологи.

⁷⁸ Харах. Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан. УИХ-ын Тамгын газар. УБ. 2021 он; Т.Хайдав. Номын сангийн үндсэн ойлголтууд. /file:///D:/Badamkhand/Downloads/8dac9b1b-5a3b-41b3-98a0-2cfedcc2dfdb%20(1).pdf

⁷⁹ “ОУУБИС-ийн 2020-2025 оны стратеги төлөвлөгөө”. ОУУБИС-ийн ерөнхий захирлын 2020.11.10-ны өдрийн А/68 тоот тушаал. /Дүрэм журмын эмхтгэл. ОУУБИС. УБ. 2023. 76 дахь тал.

судалгааг хийж, санал боловсруулан удирдлагын багт танилцуулаад байна. Энэ асуудлаар бусад их сургуулийн номын сангуудын туршлага, үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн хүмүүстэй уулзаж, салбарын яамдын бодлого, холбогдох ном бүтээл, хууль тогтоомж, бусад материалыг судалсан болно.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг их сургууль (Төрийн удирдлагын академи, Монгол Улсын их сургууль, Монгол Улсын багшийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Их засаг их сургууль зэрэг)-дын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн байгууллага, хүмүүс (“Монголын номын санчдын нэгдсэн консорциум”, “Монголын дижитал мэдлэгийн шийдлүүд” ХХК, “И ЭС ЭЙ ЭН” ХХК зэрэг)-тэй уулзаж туршлагыг судалж, ойрын хугацаанд хийж гүйцэтгэх шаардлагатай дараах ажлуудыг онцолж байна. Үүнд:

- Орчин үеийн стандартад нийцсэн байр ашиглалтад оруулах боломжийг судлах ажлын хүрээнд эхний ээлжид заал танхимыг өргөтгөн засварлаж, тохь тухтай, хэрэглэгчдэд ээлтэй орчин, чөлөөт сонголттой болгон тохижуулах, аюулгүй байдал, камержуулалт зэрэг асуудлыг хамтад нь шийдвэрлэх, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлд уламжлан төсөв хөрөнгийг шийдүүлэх. Энэ ажлын хүрээнд Захиргаа, хүний нөөцийн болон Төлөвлөлт, дотоод хяналтын албаны дарга нарт танилцуулан, Дизайны тэнхимтэй хамтран төгсөх ангийн оюутнуудаар тохижилтын зураг төслийг боловсруулж байна.
- БМИУЗ-ийн шалгуур үзүүлэлтийн нэг эрдэмтэн судлаачдын арвин ном бүтээл бүхий веб сайт, мэдээллийн сан платформыг нэвтрүүлж багш, оюутныг мэдээллээр хангах эх сурвалжийг нэмэгдүүлэхийн тулд бусад их сургуулиудын ашиглаж буй олон улсын Springer, Ebsko, Gistori зэрэг сайтууд, үндэсний цахим санг судлан, багш мэргэжилтнүүдийнхээ санал хүсэлтийг авч, багш судлаач, оюутнуудынхаа эрэлт хэрэгцээ, мэргэжлийн баг, орон тоо, төсөв хөрөнгө их шаардлагатай зэргийг харгалзан Монгол Улсын ШУТС-ийн дэргэд үйл ажиллагаа явуулдаг “И ЭС ЭЙ ЭН” ХХК-ны үндэсний цахим номын санг тодорхой төлбөртэйгөөр гэрээлэн авч ашиглуулах саналыг гаргасан.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хуулбар шалгах программыг ихэнх их сургуулиуд нэвтрүүлж (хөгжүүлсэн) буй туршлагыг судлан, багш судлаачдынхаа сургалт судалгааны ажлыг шинэ шатанд гаргах, олны хүртээл болгоход хувь нэмэр оруулах зорилгоор “И ЭС ЭЙ ЭН” ХХК-ны судалгааны ажлын хуулбарлалтын шалгуурын системийг нэвтрүүлэх, үүний тулд санхүүгийн бусад боломжийг тусгасан саналыг боловсруулан танилцуулсан.
- Номын сангийн үүлэн технологид суурилсан Lib4U.net программд

эрдэм шинжилгээ судалгааны ажлыг ангилах, түүвэр хийх зэрэг нэмэлт үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, гэрээт байгууллагатай хамтран ажиллаж байгаа хэдий ч салбарын яамдын бодлого, бусад их сургуулийн номын сангуудын жишиг, KoHa программ ашиглах асуудлыг судлах.

- Номын фонд бүрдүүлэлтийг стандарт, журамд нийцүүлэх⁸⁰ ; номын санчдын орон тоог нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу нэмэгдэл цалин хөлсийг олгох.

ДҮГНЭЛТ

1. Их сургуулийн номын сан нь сургалтын тогтолцооны онцгой бүрэлдэхүүн хэсэг, багш, оюутан, суралцагсад (магистр, докторын)-д мэдлэг олж авах боломжийг олгодог их сургуулийн амин чухал нэгж бөгөөд сургалтын үйл ажиллагаа хувьсан өөрчлөгдөхийн хирээр үүрэг оролцоо нь шинэчлэгдэж, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож байна.
2. Орчин үеийн номын сангуудын хөгжлийн чиг хандлага нь:
 - Мэдээлэл хаа сайгүй (Data Everywhere), Хиймэл оюун ухаан (AI), Блокчэйн технологи (Blockchain) хэрэглэх
 - Хувийн нууцыг хамгаалах өөрчлөлт (Privacy Shifting); Виртуал бодит байдал (Virtual Reality /VR)-ыг сургалтын зориулалтаар ашиглах, Voice Control (Alexa, Siri гэх мэт) дуу хоолойгоор удирдах технологи /төхөөрөмжүүдийг үйлчилгээнд нэвтрүүлэх
 - Эко шийдэлтэй, хэрэглэгчдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн, тав тухтай орчин, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, нээлттэй хандалт, мэдлэгээ хуваалцах, хэрэглэгчийн оролцоог сайжруулах, төсөв хөрөнгө их шаардагдах тул “хамтдаа хөгжих” зарчмаар хөгжиж байна⁸¹ .

3. Техник технологи, мэдээллийн шинэчлэлтийн хурдтай холбоотойгоор

⁸⁰ Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742:2019. F хавсралт. 5 дахь хэсэг: “Жил тутам нэг оюутны сургалтын төлбөрийн 5-аас доошгүй хувийг зөвхөн шинэ ном хэвлэл, сурах бичиг, хэвлэмэл бус материал худалдан авахад зарцуулна. //Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх стандартын эмхтгэл. УБ. 2020 он. 126 дахь тал; “ОУУБИС-ийн номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7.4-т: “ОУУБИС-ийн суралцагчийн (доктор, бакалавр, магистр оюутан) төлбөрийн 1.5%- аас доошгүй хөрөнгийг номын сангийн фонд бүрдүүлэлтэд зориулна”. /Дүрэм журмын эмхтгэл. ОУУБИС. УБ. 2023. 76 дахь тал. 418 дахь тал.

⁸¹ Харах. Библиотека в университете – это ускоритель научных открытий. /<https://lanbook.com/publishing/news/biblioteka-v-universitete-eto-uskoritel-nauchnykh-otkrytiy/>; Интегрированные библиотеки. /https://selskajabiblioteka.blogspot.com/p/blog-page_24.html; Библиотека вуза и библиотека СПО: найдите 10 отличий. /<https://libinform.ru/read/articles/Biblioteka-vuza-i-biblioteka-SPO-najdite-10-otlichij/>



хэвлэмэл ном бүтээлээс “холдох” хандлага бий болсон хэдий ч цаасан номын хэрэглээ ойрын хугацаанд огт буурахгүй, харин ч ховордохын хирээр үнэ цэнэ нь өснө. Учир нь цаасан хэвлэл бол “орлуулшгүй”, сургалтын, соёлын салшгүй хэсэг хэвээр л байх болно.

4. Өнөөгийн оюутан гэртээ эсвэл дотуур байранд бус Номын санд хичээллэхийг илүүд үзэх болсон. Учир нь хичээлийн анги танхимын дараа хоёрдугаарт ордог мэдлэгээ бататгах талбар /талбай нь номын сан байна.

Тиймээс тус их сургуулийн номын санг хамгийн шинэлэг, хамгийн сайн, үнэтэй, загвар дизайнтай гэхээс илүүтэй багш, оюутан суралцагч ажиллахад таатай байдлаар өөрчлөн тохижуулах, цахим номын санг бий болгох, шинэ технологиудыг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэн хөгжүүлэх нь эрхэм болжээ.

5. 2014 онд батлагдан хэрэгжиж буй Монгол Улсын Номын сангийн тухай хуулийн⁸² 10.1-д: “Номын сан нийтийн, сургалтын, хүүхдийн, эрдэм шинжилгээний⁸³ болон бусад төрөлтэй байх бөгөөд номын сангийн үйлчилгээ нь үндсэн ба нэмэлт үйлчилгээ байхаар заасан.

Хууль батлагдсанаас хойш нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч одоог хүртэл их, дээд сургуулийн номын сан тусгайлан зохицуулагдаагүй нь шүүмжлэл дагуулдаг.

Их, дээд сургуулийн номын сан нь нийтийн номын сангуудаас онцлог ялгаатай, эрдэм шинжилгээний номын сантай илүү ижил төстэй үйлчилгээтэй байдаг, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөн буй энэ цаг үед их, дээд сургуулийн номын сангийн статусыг тусгайлан хуульчлах шаардлагатай.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Зохиогчийн эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
3. Номын сангийн тухай хууль
4. Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/.
5. Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
6. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
7. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баримт бичиг

⁸² Номын сангийн тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ. 2015. №04

⁸³ Эрдэм шинжилгээний номын сан нь судалгаа, шинжилгээ, мэдээллийн түшиц газар байж, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий үйлчилгээг үзүүлнэ.

8. Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/30 тоот тушаалаар батлагдсан “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” (MNS 5742:2019)
9. ОУУБИС-ийн ерөнхий захирлын 2020 оны А/68 тоот тушаалаар батлагдсан “ОУУБИС-ийн 2020-2025 оны стратеги төлөвлөгөө”
10. ОУУБИС-ийн ерөнхий захирлын 2022 оны А/106 тоот тушаалаар батлагдсан “ОУУБИС-ийн номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”

Ном бүтээл

11. В.Түвшинтогтох. Номын сангийн тухай яриа
12. Т.Хайдав. Номын сангийн үндсэн ойлголтууд.
13. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. 343 дахь тал.
14. Noh Y. Imagining Library 4.0: Creating a Model for Future Libraries / Younghee Noh. The Journal of Academic Librarianship. 2015. № 6. P. 786–797.

Судалгаа:

15. Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан. УИХ-ын Тамгын газар. УБ. 2021 он.
[/file:///D:/Badamkhand/Downloads/8dac9b1b-5a3b-41b3-98a0-2cfedcc2dfdb%20\(1\).pdf](#)

Интернэт эх сурвалж:

- 16./<https://ru.wikipedia.org/wiki/%D0%91%D0%B8%D0%B1%D0%BB%D0%B8%D0%BE%D1%82%D0%B5%D0%BA%D0%B0>
17. /<https://www.unkniga.ru/biblioteki/vuzbiblio/13699-universitetskaya-biblioteka-prioritetnye-napravleniya.html>
- 18./<https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D1%80%D1%84%D1%83%D1%80%D1%82>
19. /<https://lala.lanbook.com/5-universitetskih-bibliotek-budushchego-v-kotoryh-mozhno-pobyvat-uzhe-segodnya;>
20. <https://www.ala.org/future/trends>
21. /<https://einfo.lib.uz/post/open-books-hong-kong-pioner-otkrto-go-dostupa-w-azii>
22. /<https://lanbook.com/publishing/news/biblioteka-v-universitete-eto-uskoritel-nauchnykh-otkrytiy/>
23. /https://selskajabiblioteka.blogspot.com/p/blog-page_24.html;
23. /[https://libinform.ru/read/articles/Biblioteka-vuza-i-biblioteka-SPO-najdite-10-otlichij/.](https://libinform.ru/read/articles/Biblioteka-vuza-i-biblioteka-SPO-najdite-10-otlichij/)